

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

2020 оны 5 дугаар сар

МОН 49430: Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (АСХХОХ)

Азийн хөгжлийн банкинд зориулан Барилга, хот байгуулалтын яам боловсруулав. Тус байгаль орчны төлөв байдлын үнэлгээ нь зээлдэгчийн баримт бичиг. Энд илэрхийлэх үзэл бодол АХБ-ны Захирлуудын зөвлөл, удирдлага, ажилтнуудын үзэл бодлыг төлөөлөхгүй бөгөөд бүрэн дүүрэн боловсруулагдаагүй байж болно. АХБ-ны вэб хуудсан дах “ашиглах нөхцөл” хэсэгт анхаарлаа хандуулна уу.

ВАЛЮТИЙН ХАНШ

(2019 оны 9 сарын 3)

Валютин нэр	–	Төгрөг (төг)
1.00 төг	=	0.00038 ам.дол.
1.00 ам.дол.	=	2,620 төг

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	-	Азийн хөгжлийн банк
АСХХОХ	-	Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлөр
ГБОМТ	-	Гүйцэтгэгчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ХЦБ	-	Хорио цээрийн бүс
БОНБУ	-	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОМТ	-	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОХТ	-	Байгаль орчны хяналтын тайлан
МУЗГ	-	Монгол Улсын Засгийн газар
ГБМ	-	Гомдол барагдуулах механизм
БОТБУ	-	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
БОВАЖА	-	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
төг	-	Монгол төгрөг
БХБЯ	-	Барилга, хот байгуулалтын яам
ХХААХҮЯ	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
БАХ	-	Бэлчээр ашиглагчдын холбоо
ТОСК	-	Төрийн орон сууцны корпораци
ТХН	-	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТБТТ	-	Төсөлд бэлтгэх техникийн туслалцаа
БОТУ	-	Байгаль орчны түргэвчилсэн үнэлгээ
НШТ	-	Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
ХБББ	-	Хамгааллын бодлогын баримт бичиг (2009)
ам.дол.	-	АНУ-ын доллар

ХЭМЖИХ НЭГЖ

км	-	километр
км ²	-	хавтгай дөрвөлжин километр
кг	-	килограм
га	-	гектар
м	-	метр
м ³	-	куб метр
мг	-	миллиграм
мг/л	-	нэг литрт агуулагдах миллиграм
т	-	тонн метр

Тус тайланд "\$" тэмдэгээр АНУ-ын долларыг илэрхийлнэ.

Азийн хөгжлийн банк тус баримт бичигт улс орны аливаа хөтөлбөр, стратеги боловсруулах, төслийг санхүүжүүлэх эсвэл тодорхой нутаг дэвсгэр, газар нутгийг ямар

нэгэн байдлаар тодорхойлох, иш татахдаа аль нэг нутаг дэвсгэр, газар нутгийн хууль эрх зүйн эсвэл бусад статусын талаар ямар нэгэн дүгнэлт хийгээгүй болно.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

1. Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн (АСХХОХ) I шатлалын техник эдийн засгийн үндэслэл загварыг боловсрууллаа. АСХХОХ нь орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжиж, эхний шатанд авч үзэж буй аймгууд¹ дахь хот, суурин газруудын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах юм. Энэхүү хөтөлбөр нь засгийн газарт сонгогдсон аймгуудад хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй хот байгуулалт, бэлчээрийн уян хатан менежмент, агро-үйлдвэрлэлийн өртгийн тогтвортой сүлжээг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх болно. АСХХОХ нь аймаг бүрт ногоон байгууламж бүхий хот, хөдөөгийн дэд бүтцийг хөгжүүлэх, агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын шат дараалсан багц арга хэмжээг багтааж байгаа бөгөөд хэрэгжүүлэх механизм, бодлогын арга хэмжээ, чадавхийг бэхжүүлэх дэмжлэг дагалдаж байгаа болно. Аймаг, сумыг хөгжүүлэх хөрөнгө оруулалт нь уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эмзэг байдал болон бэлчээрийн доройтлыг багасгахад чиглэнэ.

2. АСХХОХ-өөс дараах 4 үр дүн гарах болно. Үүнд:

(i) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хүлэмжийн хий бага ялгаруулдаг, ард иргэдийг урин дуудсан аймаг сумын төвүүд болно.

(ii) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хүлэмжийн хийг дээд зэргээр бууруулсан, тогтвортой мал аж ахуй бүхий бэлчээрийн менежменттэй болно.

(iii) Хүлэмжийн хий бага ялгаруулдаг, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй өртгийн сүлжээг үүсгэж бэхжүүлнэ

(iv) Байгаль орчинд ээлтэй орон нутгийн хөгжлийн бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

3. АСХХОХ нь Олон шатлалт санхүүгийн зээлийн шугам (ОШСЗШ)-аар санхүүжигдэнэ. Төслийн I шатлал болон энэхүү байгаль орчны төлөв байдлын үнэлгээ нь Увс аймгийн төв Улаангом, Баян-Өлгий аймгийн төв Өлгий, Ховд аймгийн төв Жаргалант, мөн түүнчилэн Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвийг тус тус хамарч байгаа болно.

4. Бүс нутгийн болон хотын эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор сонгосон гурван аймгийн төв болон хоёр сумын төвд:

(i) Хотын нийтийн аж ахуйн үндсэн үйлчилгээ, байгууламж, дэд бүтэц

(ii) ХАА-н бизнесийг хөгжүүлэх, үүнд бэлчээрийн менежментийг сайжруулахад хөрөнгө оруулна

3 аймгийн төв, 2 сумын төвийг сонгосон. Төлөвлөж буй хөрөнгө оруулалтыг доорхи хүснэгтэд нэгтгэж харууллаа. Хот нийтийн аж ахуйн хөрөнгө оруулалт нь үндсэндээ яг аймаг, сумын төвүүдэд очих бол агробизнесийн хөрөнгө оруулалт нь аймаг сумын төвд

¹ Аймаг нь Монгол Улсын засаг захиргааны нэгж бөгөөд нийт 21 аймаг, аймгийн төв байдаг. Сум нь аймаг доторх засаг захиргааны нэгж бөгөөд нийт 304 сум байдаг (аймгийн төвүүдийг оруулахгүйгээр). Нэг сум дунджаар 4000 хүн ам, 5000 км² нутаг дэвсгэртэй.

ойрхон орших газруудад оногдох болно. ХАА-н бизнесийн шинэ байгууламжид хөрөнгө оруулахдаа дэд бүтцээр дэмжинэ.

АСХХОХ-өөс аймаг, сумын төвд төлөвлөж буй хот байгуулалтын хөрөнгө оруулалт

Хотын ба ХАА-н бизнесийн дэд бүтэц	
Гэр хорооллын орон сууцны дахин төлөвлөлт²	Дулааны шугам сүлжээг сайжруулах
Зам, дренаж барих, сайжруулах	Үерээс хамгаалах голын эрэг далангийн бэхэлгээ
Бохир ус зайлуулах сүлжээг сайжруулах, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих буюу өргөтгөх (ХУЦБ)	Ус зайлуулах суваг
Ундны усыг ариутгах, ус түгээх сүлжээг сайжруулах	Лэндфилийг сайжруулах
Цахилгаан хангамжийн өргөтгөл	Сургууль, эмнэлэг, захиргааны барилгыг өргөтгөх
Харилцаа холбооны цамхаг, шилэн кабелийн сүлжээ	

АСХХОХ-өөс аймаг, сумын төвд төлөвлөж байгаа ХАА-н бизнесийн хөрөнгө оруулалт

ХАА-н бизнесийн хөрөнгө оруулалт*	
- Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд³ зориулсан олон нийтэд суурилсан төсөл: - МАА-н үйлдвэрлэл, - хадлангийн талбай, агуулах, - бага оврын усалгаа, - худаг усыг сайжруулах, - жижиг гол дээр гүүр барих	- Агро-парк - Хорио цээрийн бүс - Мах боловсруулах үйлдвэр - Мал эмнэлэг, лабораторийн үйлчилгээ - Судалгааны төв - Бизнес инкубатор төвүүд - Боловсруулах үйлдвэрүүд
Услалтын систем, тэжээлийн аж ахуй	

*хөрөнгө оруулалтыг дээрх хүснэгтэд заасан дэд бүтцээр дэмжинэ

5. Товчоор хэлэхэд АСТБХХОХ-ийг оролцогч байгууллагуудын хамтарсан Гүйцэтгэх ажлын хэсэг (ГАХ) болон Төслийн удирдах хорооны (ТУХ) дэмжлэгтэйгээр Барилга хот байгуулалтын яам гүйцэтгэнэ. БХБЯ-ны дэргэд байгуулагдах Хөтөлбөрийн удирдах нэгж (ТУН) нь ХХААХҮЯ-ны техникийн болон бодлогын дэмжлэгтэйгээр хотын дэд бүтэц, агро-

² Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөлд (ОНОСХШТ), ТА 9030, 2017.

³ Бэлчээр ашиглагчдын бүлэг

үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлнэ. ТУН нь гурван аймаг дахь төслийн нэгжүүдийн (АТН) ажилтнуудын хамт хөтөлбөрийн I шатлалын хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. АТН нь сум дундын хэрэгжүүлэх албатай хамтарч ажиллана. Хөтөлбөрийн Санхүүгийн зуучлалын зээлийн (СЗЗ) хэсгийг Монгол Улсын Хөгжлийн банк (ХБ) хэрэгжүүлнэ.

Үнэлгээний орчин

6. АХБ-ны *Хамгааллын бодлогын баримт бичиг* (АХБ-ХБББ 2009) болон саяхан хэвлэгдсэн *Тэргүүн туршлагын эх сурвалж* удирдамжийн дагуу АСХХОХ нь байгаль орчны хувьд Б зэрэглэлд багтана. Б зэрэглэлийн төслүүд нь болзошгүй сөрөг нөлөөллийн хувьд А зэрэглэлийнхтэй харьцуулахад бага, хугацаа богино, орон нутгийн онцлогтой, нөхөн сэргээгдэх боломжтой бөгөөд нөлөөллийг аймгийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний (БОМТ) дагуу бууруулах боломжтой юм.

7. Хөтөлбөрийн I шатлалд хамрагдаж байгаа төслийн бүрэлдэхүүн нь тусгай хамгаалалттай газар нутагт эсвэл зэрлэг ан амьтдын амьдрах орчны бүсэд багтаагүй буюу тэдгээрийн ойр орчимд бус (ХБББ 2009), мөн энд ховор болон нэн ховордсон ан амьтад байдаггүй тул АСХХОХ-ийн Б ангилал хэвээр байх болно. Орон нутагт очиж шалгах явцад I шатлалаар төлөвлөгдөж буй төслийн бүрэлдэхүүн хэсгүүдээс үзүүлж болох болзошгүй нөлөөллүүд нь ерөнхийдөө богино хугацаанд, барилгын ажилтай уялдаж үүсэх бөгөөд тэдгээрийг урьдчилан сэргийлэх буюу бууруулж болно гэдгийг тогтоосон. АХБ-наас төслийг Б ангилалд багтаасан АСХХОХ-ийн анхны Байгаль орчны түргэвчилсэн үнэлгээг (БОТҮ) Хавсралт А-аас үзнэ үү.

АСХХОХ-ийн үр шим

8. АСХХОХ-ийн I шатлалын цогцолбор ач холбогдол нь зорилтот аймаг болон сумын төвүүдийн дэд бүтцийг олон талаар сайжруулсанаар тэнд оршин суугчдын амьдралын түвшинг бодитойгоор дээшлүүлэхэд орших болно. Амьдралын нөхцөл, гэр бүлийн эрүүл мэндийг дээшлүүлэх ажил хийгдсэнээр аймаг, сумын төвд амьдарч буй иргэдэд хүрч мэдрэгдэх шинж чанаруудыг дараах байдлаар тодорхойлж болно:

1. Аймгийн төвд уламжлалт гэрийг орчин үеийн, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцаар орлуулсанаар байшин доторх агаарын чанар сайжрах болно (жишээ нь нүүрс, мод түлэхтэй харьцуулахад PM2.5 буурах), нүхэн жорлонг халж орчин үеийн бие засах газар, ариутгах татуурга хэрэглэснээр ходоод гэдэсний замын өвчлөл буурах болно.
2. Ундны усны хангамжийг хоолойгоор хүргэх.
3. Шинэ, сайжруулсан бохир ус зайлуулах сүлжээ, цэвэрлэх байгууламж
4. Өргөжүүлж сайжруулсан төвлөрсөн халуун ус, халаалт
5. Сайжруулсан цахилгаан хангамж
6. Хатуу хог хаягдлыг илүү зохион байгуулалттай цуглуулах, цэвэр, сайтар далдалсан хогийн цэг
7. Үерийн хяналт болон борооны ус зайлуулах суваг хоолойг сайжруулах.
8. Сургууль, эмнэлэг, олон нийтийн төв зэрэг байгууламжуудад хүрэх нийтийн аж ахуйн үйлчилгээ сайжирна.

9. Бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулсанаар гадаргын усны чанарт мэдэгдэхүйц ахиц гарна.

10. Уур амьсгалын ногоон санд (УАНС) тусад нь гаргаж өгч буй санхүүжилтийн санал (СС) дахь цаг уурын өөрчлөлтийг бууруулах бүрэлдэхүүн хэсэгт тооцсоноор хот суурины эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах замаар хөрөнгө оруулалтын нийт хугацаанд нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг 1.1 сая тонноор бууруулна.

9. АСХХОХ-ийн хоёр дахь гол ач холбогдол нь аймаг, сумын төвүүдэд орчин үеийн агро-үйлдвэрлэлийн технологи, практикийг нэвтрүүлэх төслийн хөдөө аж ахуйн бүрэлдэхүүн хэсэг байна. Энэ нь агро паркийн цогцолбор байх бөгөөд үүнд хорио цээрийн бүс, лаборатори, мал эмнэлгийн үйлчилгээ, бүс нутгийн судалгааны төвүүд, мал төхөөрөх үйлдвэр, боловсруулах үйлдвэрүүд багтах болно. Малын тэжээл, хадлангийн аж ахуй нь агро паркийг дэмжиж ажиллана. Агро-үйлдвэрлэл ба бэлчээрийн менежментийн бүрэлдэхүүн хэсгүүдийн гол зэрэг нөлөөлөл нь:

1. Мах боловсруулах, савлах, хадгалах орчин үеийн технологи нэвтрүүлэх (НҮБ-ХХАБ 1988, ДЭМБ 1984), хог хаягдлын менежментийг зохистой болгох замаар байгаль орчны бохирдлыг мах боловсруулах өнөөгийн практикийн хэмжээнээс бууруулах.
2. #1-ээс дотоодын болон олон улсын зах зээлд зориулж үйлдвэрлэх махны чанарыг сайжруулснаар урьд өмнө нь хүрч чадахгүй байсан өндөр ашигтай олон улсын зах зээлд гаргах махны экспортоос малчид, экспортлогчдын амьжиргааны орлогыг нэмэгдүүлэх.
3. #2-оос малын ашиг шим нэмэгдсэнээр мал сүргийн тоо толгой буурах ба үүнээс үүдэн бэлчээрийн даац хэтрэх явдлыг багасгаж улмаар бэлчээрийн чанар сайжирна.
4. #3-аас малаас ялгарах метаны хийн (CH_4) ялгарлыг бууруулж, нөхөн сэргээсэн бэлчээрт хүлэмжийн хийн (CO_2) шингээлтийг нэмэгдүүлсэнээр төсөлд хамрагдаж буй Монгол орны баруун аймгуудын хүлэмжийн хийн ул мөрийг эрс бууруулах болно. Тодруулбал, Ногоон Уур амьсгалын Сангаас гаргасан тооцоогоор нөхөн сэргээсэн бэлчээрээр 40 жилийн хугацаанд 113.7 сая тонн хүлэмжийн хийг шингээж авах ба 25 жилийн дараа гэхэд метан хий ялгарал (CH_4) 1.08 сая тонн хүлэмжийн хийтэй тэнцэх хэмжээгээр буурах болно.

10. Хот суурины эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах замаар нүүрсхүчлийн хийн шууд ялгаруулалтыг 1.1 сая тонноор бууруулах ба хөрөнгө оруулалтын нийт хугацаанд 112.3 сая тонныг бууруулна гэж тоцож байна.

Болзошгүй нөлөөлөл – Барилгын ажлын үе шат

11. Хөтөлбөрийн I шатлалд хамрагдаж байгаа төслийн 5 талбай нь тусгай хамгаалалттай газар нутагт эсвэл түүний ойролцоо ямар нэг сөрөг нөлөөлөл үүсгэхгүй (ХБББ 2009).

12. Хот, суурин газар болон хот, суурингийн захаар баригдах ХАА-н бизнесийн бүрэлдэхүүн хэсгүүдээр дэд бүтэц (т: нийтийн аж ахуйн гол шугам [ундны ус, халуун ус, холбоо харилцаа, хаягдал ус], зам, барилга, дренаж, голын эрэг, даланг сайжруулах, усан

хангамжийн суваг)-ийг сайжруулах, шинээр барих үед барилгын ажлын улмаас богино хугацаагаар бий болох төвөг, нөлөөллийг бууруулахад төвлөрнө.

13. Аймаг төв, сумын төвүүдэд хийгдэх барилгын ажлын улмаас үүсэх нийтлэг нөлөө, саад нь дараах байдлаар илэрнэ: нийтийн тээврийн хөдөлгөөнийг хаах, эсвэл багасгах; цахилгаан хангамжийн тасалдал; бизнес болон амралт чөлөөт цагийн үйл ажиллагаа тасалдах; газар шорооны ажил, хүнд даацын ачааны машин, тоног төхөөрөмжийн ашиглалтаас үүсэх сул тоос шороо; тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний улмаас үүсэх хөрсний бохирдол; оршин суугчид болон ажиллагсдын осол, гэмтлийн эрсдэлүүд; замын хөдөлгөөний түгжрэл болон осол, гэмтэл нэмэгдэх; хөрсний элэгдэл, гол горхины урсгалын дагуу лаг тунах; хэсэгчилсэн талбайд түр зуур үүсч болзошгүй ус зайлуулах сувгийн бөглөрөл болон ус халих асуудлууд. Барилгын ажилчдын байрлах хотхоноос хатуу хог хаягдал, ахуйн бохирдол гарч таарах бөгөөд мөн явуулын ажилчдаас үүдэлтэй болзошгүй халдварт өвчин, нийгмийн асуудал гарч болох талтай. Эдгээр богино хугацааны нөлөөлөл, хангамжийн тасалдал нь барилгын ажлын явц дараалал, аймаг сумын төвын хаана хийгдэж байгаа байршил зэргээс хамаараад янз бүрийн хэмжээ түвшинтэй байх болно. I шатлалын барилгын ажлын үед шатанд үүсэх нөлөөлөл, төвгийг дор хураангуйлан танилцуулав.

3 аймгийн төв болон Өмнөговь, Дэлүүн сумдын төвд

Аюулгүй, тогтвортой усан хангамж

14. Төслийн бүх 5 хэсгийн айл өрх, аж ахуйн нэгжүүд ундны усаа ойрхон байдаг ус түгээх цэгээс авдаг бөгөөд гол төлөв гэр, аж ахуйн нэгж рүүгээ өөрсдөө явганаар зөөдөг. Гэр бүлд хүүхдүүд ихэнхдээ ус зөөж авчрах үүрэгтэй байдаг.

15. Дэд бүтцийн барилгын ажил, гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх явцад өрхийн энэхүү үндсэн чухал ажил тасалдахгүй байх нь чухал юм. Өдөр тутмын эсвэл долоо хоногийн усаа зөөх үедээ хүүхэд, эхчүүд барилгын талбайн хажуугаар аюулгүй, чөлөөтэй явах боломжтой байх ёстой. Барилгын талбайн нийт хэсэг болон явган хүний зам хооронд тусгаарласан хамгаалалтын хашлага хийж одоо байгаа явган хүний замыг хамгаална. Хүмүүсийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай тохиолдолд ус зөөхөд зориулсан түр зуурын, хамгаалалттай маршрутыг бий болгох ёстой. Түүнчилэн барилгын ажлаас шалтгаалж гэр хороолол дахь ус түгээх цэгүүдэд ус хүргэх ажилд саад учруулж болохгүй.

Асфальт, бетон зуурмагийн үйлдвэр

16. Асфальт, бетон зуурмагийн түр үйлдвэрийг хот суурин газрын дэд бүтцийн ажилд ашиглах болно. Энэ үйлдвэр нь тухайн газар, орон нутгийн хувьд хүрээлэн буй орчины бохирдлын эх үүсвэр болдог. Элс, бусад агрегат түүхий эд материалын овоолгоос үүсэх салхи, усны элэгдэл (тоос шороо, лаг хурдас) болон зуурмаг үйлдвэрлэх, хүнд даацын тэргээр зөөвөрлөх явцад үүсэх байнгын чимээ шуугиан, хөдөлмөр хамгааллын эрсдэл зэрэг асуудлууд үүснэ. Түүхий эдийг зохисгүй хэрэглэх, хадгалахаас үүдэж цемент дэх бэхжүүлэгч химийн бодис болон асфальт хийх материал дахь нүүрсустөрөгч нь (газрын тос, шингэлэгч зэрэг) хөрсний болон гадаргын усны бохирдол үүсгэж болзошгүй.

17. Түр үйлдвэр байгуулах, ажиллуулах, эцсийн байдлаар буулгаж зөөх ажлыг гүйцэтгэхдээ ийм ажилд хэрэглэдэг сайн туршлагын аргуудыг хэрэгжүүлэх ёстой. Гүйцэтгэгч нь БХБЯ-ны хяналтын дор Дэлхийн Банк (ОУСК)-ийн Байгаль орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдамжийн (ENS 2007) 1) *Цемент, шохой үйлдвэрлэх*, 2) *Барилгын материал*

олборлох, 3) Газрын тосны жижиглэнгийн сүлжээ гэсэн олон улсын дүрэм журмыг баримтлах ёстой. Саяхан батлагдсан АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн (USEPA 2014) Бетон зуурмаг үйлдвэрлэх практикийн журмыг мөн ашиглаж болно.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний тасалдал

18. Аймаг, сумын төвүүдэд дэд бүтэц, шугам сүлжээг засварлах, өргөтгөх ажлын явцад оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдэд түгээх нийтийн үйлчилгээний хангамжид тасалдал үүсэх нь дамжиггүй. Орон нутагт гарах саад бэрхшээлийг багасгахын тулд боломжтой бол тухайн үед нөөц болон туслах төхөөрөмж ашиглах болно.

Улаангом

Нуурын эргийн дагуу үерийн хамгаалалтын даланг сайжруулах

19. Уулнаас буух уруйн үерээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улаангомьн баруун урд байх 5.0км шороон даланг шинэчлэн сайжруулна. Далангийн хойд төгсгөлийн хэсгийг орон нутгийн ундны усан хангамж, усжуулалтад зориулсан жижиг нуур үүсгэхэд ашиглана. Нуурт лаг тунах, даланд элэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд далан дээр ажиллах хэсгүүдийн хооронд лаг шавар шүүгч хөшиг юм уу давхар налуу байрлуулахад онцгой анхаарах хэрэгтэй.

Өмнөговь сумын төв

Хогийн цэгийг нөхөн сэргээх

20. I шатлалаар төсөлд хамрагдаж буй бүх талбай дахь хатуу хог хаягдлын менежментэд нарийвчилсан үнэлгээ хийх ба үүнд одоо байгаа 5 хогийн цэгийг мөн хамруулна. Тус хэрэгцээ шаардлагын үнэлгээгээр одоо байгаа нөхцөл байдал, үүнд: хог хаягдал, физик профиль (хөрс, топографи, газрын доорх ус)-ийн шинж чанар болон АСХХОХ-ийн дараагийн шатлалд засаж залруулах шаардлагатай байгаль орчны аюултай зүйлсийг тодорхойлно. Газрын доорх усны дээж авч, шинжлэн бохирдол байгаа эсэхийг тогтооно. Газрын доорх усны үнэлгээ Өмнөговь суманд нэн чухал, учир нь орон нутгийн удирдлагын шийдвэрээр хог хаягдал салхинд хийсэхээс сэргийлэн, сумын төвийн ундны усны түвшин болон газрын доорх усны гүнийг үл харгалзан, сумын хогийн цэгийн газрыг ухаж, хог хаягдлыг хийж байгаа. Гүний усны түвшин болон усны чанарыг тодорхойлж, хог хаягдлаас болж бохирдоогүй гэдгийг баталгаажуулна.

Өлгий

Үерээс хамгаалах голын эргийн бэхэлгээ

21. Өлгийд үерээс хамгаалах зориулалтаар голын эргийн 1250м хэсгийг засаж тохижуулна. Улаангомд хийгдэх далангийн ажилтай ижлээр энд мөн голын усанд лаг тунах, даланд элэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд далан дээр ажиллах хэсгүүдийн хооронд лаг шавар шүүгч хөшиг юм уу давхар налуу байрлуулахад онцгой анхаарах хэрэгтэй.

Болзошгүй нөлөөлөл – Үйл ажиллагааны үе шат

Дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүд

Гэр хорооллын дахин төлөвлөлт

22. Дээр дурдсанчлан 3 аймгийн төвд орчин үеийн төвлөрсөн халаалт, угаалгын өрөө бүхий гэр хорооллын дахин төлөвлөлт хийх ажлын үр өгөөж нь хамрагдаж буй айл өрхүүдийн амьдралын нөхцөл ихээхэн сайжирна. Гэхдээ барилга байшингийн нягтрал нэмэгдсэнээр амьдралын нөхцөлд үзүүлэх бусад нөлөөллүүд болон асуудлууд үүсч болзошгүй. Нэгж талбайд оногдох гэр бүлийн нягтрал нэмэгдэж, нэг дор амьдрах өрхийн тоо нэмэгдэж болзошгүй нь шинээр баригдаж буй орон сууцны ашиглалт, эзэмшилтэй холбоотой үүсч болох нийгэм, гэр бүлийн асуудлуудад орно. Бусад болзошгүй асуудлууд нь шинэчлэгдсэн, орчин үеийн инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, эрчим хүчний хэмнэлттэй барилгын технологи зэргээс урган гарч болох юм.

Тогтвортой ундны усны хангамж

23. I шатлалын хувьд үүсэж болзошгүй нөлөөлөл бол хэт их хэрэглээнээс шалтгаалж усны хомсдол үүсэх явдал юм. Нэмэлт насос ашиглаж эсвэл худгаас татсан өргөтгөж сайжруулсан усан хангамжийн сүлжээгээр дамжуулан аймаг, сумын төвүүдэд хүргэхээр төлөвлөж буй ундны усан хангамж тогтвортой байх ёстой. Усан хангамжийн эх үүсвэрийг хэмжээ, чанарын хувьд найдвартай байх байдлыг нь тогтоох үүднээс зураг төслийн нарийвчилсан шатанд гүний болон гадаргын уснаас хангах эсэхээс үл хамааран хүртээмжтэй байх эсэхийг нь шалгаж баталгаажуулах шаардлагатай. Уур амьсгалын өөрчлөлтөөс бүс нутгийн усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг харгалзан ундны усны хангамжийн ирээдүйн тогтвортой байдлын талаар мэдэж байх нь чухал болно.

Агаарт бохирдуулах бодис ялгарах

24. I шатлалд үүсч болзошгүй нөлөөлөл нь 3 аймгийн төв (Улаангом, Өлгий, Жаргалант)-д агаарын бохирдол (CO_2 , NO_x ба SO_x) нэмэгдэх явдал. I шатлалд нүүрсээр галладаг дулааны станцуудын шинэчлэлт өргөтгөл нь одоо гарч буй утааны ялгаруулалтыг (CO_2 , NO_x , SO_x) ихэсгэж болзошгүй. Эдгээр дулааны станцууд нь одоогийн байдлаар үндэсний болон олон улсын утааны хийн найрлагын стандартыг хангаж чадахгүй байна. Энэ нь II, III шатлалын төлөвлөлтөөр дээрх 3 дулааны станцын утаа цэвэрлэх технологийг удирдамж (ОУСК-БОЭМХХ-ДЭМБ) дахь үйлдвэрийн утааны хийн найрлагын стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай гэсэн үг юм.

ХАА-н бизнесийн бүрэлдэхүүн хэсэг

i. Тогтвортой усан хангамж

(i) Гадаргуугийн ус

25. ХАА-н бизнесийн бүрэлдэхүүн хэсгийн нөлөөлөл нь зарим ХАА-н бизнесийн хэсгүүдэд усны хомсдол үүсэж болзошгүй бөгөөд улмаар тухайн байршлаас доош орших (урсгалын доорх) ус хэрэглэгчдэд усны хомсдол бий болгох явдал юм. Нөлөөлөл бүх төлөвлөсөн 200 га-гийн ба 500 аг-гийн услалтын системд гарч болзошгүй. Иймд техник-эдийн засгийн тооцоо (бүлэг III)-оор 200 га (сумын төвд), 500 га (аймгийн төв)-д шинэ услалтын систем барьж, тэжээлийн аж ахуй эрхлэхэд шаардлагатай, орон нутгийн голоос

авах 0.126 м³/сек-аас 0.314 м³/сек хүртэл усны хэрэгцээ шаардлагыг I шатлалын зураг төслийн шатанд нарийвчилан тооцоолно.

26. Цаашилбал, голын урсацын 2018 оны мэдээллээс үзэхэд тэжээлийн ургамал тарих 500га талбайд шаардлагатай гэж тооцсон 0.314м³/сек усалгааны усны хэмжээ нь ойролцоо байгаа усны эх үүсвэр болох голын хамгийн бага урсацын 35%-ийг эзэлж байгааг харуулж байна. Эцсийн байдлаар тогтсон голоос суваг татах цэг дээр усалгааны усны хэрэгцээ, голын усны хамгийн бага урсацын хэмжээг нарийвчилсан зураг төслийн үе шатанд баталгаажуулах шаардлагатай. Түүнчлэн Тариалан сумын Тээлийн голын доод хэсгээр байгуулахаар төлөвлөж буй 500 га-гийн услалтын системийн усны тогтвортой хангамжийг үндэсний гидрогеологичоор баталгаажуулах шаардлагатай ба тэнд хийсэн олон нийттэй зөвлөлдөх уулзалтын дүнгээс үзвэл Тээлийн голын доод хэсэг зуны хэдэн сардаа хуурай байдаг гэдгийг тодорхой хэлсэн байна.

(ii) Гүний ус

27. Similar to the irrigation schemes, the availability of sustainable groundwater supplies at the projects sites, and the potential impact of the feasibility estimates of the water demands of planned meat processing facilities and Disease Free Establishments of the Agroparks on available groundwater yield need to be determined at detailed design phase.

(iii) Гидро-геологийн үнэлгээ

28. Иймд I шатлалын нарийвчилсан зураг төслийн үе шатанд хийх гол ажил бол эцсийн байдлаар тогтоосон голоос суваг татах цэг дээрх урсацын хамгийн бага хэмжээг гидрологийн үнэлгээ хийж тодорхойлох, мөн түүнчилэн голоос доош орших хэрэглэгчдийн нийт хэрэглээний хэмжээг тогтоох явдал юм. Ингэж нийлүүлэн тооцох нь төлөвлөж буй усалгаатай тариалангийн болон бусад хэрэглээ, ус ашиглагчдын хувьд голоос усыг тогтвортой авч хэрэглэх хэмжээг тодорхойлох болно. Төслийн ажлын талбайнуудад хийх гидро-геологийн судалгааны нэгэн адилаар агро-паркад ашиглах газрын дорх усны нөөц төслийн нөлөөлөлд өртөх газрын дагуух бусад хэрэглэгчдийн хувьд мөн хангалттай байгаа эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Усны төсвийн мэдээллийн хамт судалж, төслийн хувьд усны тогтвортой нөөц байгаа эсэхийг тодруулна.

ii. Тариалангийн услалтын системээс Увс нуурийн дархан цаазат газарт үүсэх нөлөөлөл

29. Тариалан суманд төлөвлөгдсөн 2 төрлийн услалтын систем дархан цаазт Увс нууранд цутгадаг нэг голоос ус авна. Гэхдээ тухайн голоос авах усны хэмжээ харьцангуй бага, мөн Хархираа-Тээлийн голын мэдээллээс үзвэл тус гол зундаа Увс нуур хүрэхээсээ өмнө хатаж тасардаг тул Увс нууранд үзүүлэх нөлөөлөл бараг байхгүй байхаар байна.

АСХХОХ-ийн бэлэн байгаа байгууламжууд

30. 3 аймгийн төвд "бэлэн байгаа байгууламж" (АХБ-ХБББ 2009 он) нь хаягдал ус цэвэршүүлэх байгууламж (ХУЦБ) ба дулааны станц юм. 3 аймгийн ХУЦБ-ийг I шатлалын хугацаанд хаягдал ус цуглуулах, цэвэршүүлэх системийн ерөнхий сайжруулалтын хүрээнд бүрэн солих юмуу дахин төлөвлөнө. ХУЦБ-ийг анх байгуулах үеийн Зөвлөлтийн технологи тэр үед төлөвлөснийхөө дагуу явагдах боломжгүй болж, улсын эсвэл ОУСК-БОЭААБУ-ийн ажлын болон байгаль орчныг хамгаалах стандартуудын шаардлагыг хангахгүй болсон тул

ХУЦБ-ийг шинэчлэнэ. Иймд ХУЦБ-ийн засаж, *залруулах арга хэмжээ* (ХБББ 2009)-ний үр дүн нь АСХХОХ-ийн I шатлалаар шинээр барих эсвэл бүрэн сайжруулах ХУЦБ байна.

31. Төсөл 3 аймгийн төвийн дулаан (халуун ус)-ны шугам сүлжээг сайжруулахад төвлөрнө. 3 аймгийн одоо байгаа ДС шугам сүлжээг сайжруулахаар төлөвлөж буй ажилд багтаагүй, зөвхөн нэг ДС-д насос солино. I шатлалын нарийвчилсан зураг төслийн шатанд ДС-ийн технологи, ажиллагаа, байгаль орчны хамгааллын менежмент зэргийг нарийвчилан судалж, II шатлалд ДС-ийн засварлах шаардлага бий эсэхийг тогтооно. ДС-ийн компаниудад очиж, зөвлөлдөх уулзалт хийх явцад тэдгээр станциас гарч байгаа ялгарлын хэмжээ улсын, улмаар олон улсын чанарын стандартуудад хүрэхгүй байгаа нь тогтоогдсон. Иймд одоо байгаа ДС-дад шаардлагатай, II шатлалын хугацаанд хэрэгжүүлэх *залруулах арга хэмжээ* I шатлалын нарийвчилсан зураг төслийн шатанд гүйцэтгэнэ.

Хуримтлагдсан болон өдөөгдсөн нөлөөлөл

32. Өмнө дурдсанчилан АСХХОХ-өөс гарах хамгийн гол хуримтлагдах нөлөөлөл бол хотын дэд бүтэц, нийтийн аж ахуйн үйлчилгээг иж бүрэн сайжруулснаар төсөлд хамрагдсан орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшин дээшлэх явдал юм. Түүнчилэн гэр хорооллын дахин төлөвлөлтөөс үүдэж гарах өдөөгдсөн нөлөөлөл нь гэр бүлийн хөгжилд хувь нэмэр оруулсанаар хувь хүний болон гэр бүлийн эрүүл мэндийн байдал дээшилж улмаар гэр хорооллын нийгэм, эдийн засгийг бэхжүүлэх явдал болно.

33. АСХХОХ-өөс үзүүлэх өөр нэг эерэг өдөөгдсөн нөлөө бол ирээдүйд малын тоо толгойг багасгаснаар сэргээн сайжруулсан бэлчээрт CO₂-ийн шингээлтийг нэмэгдүүлэх, малаас ялгарах метаны (CH₄) хийг бууруулах гэсэн хоёр хэлбэрээр уур амьсгалын өөрчлөлтийг багасгахад хувь нэмэр оруулах явдал юм.

34. Төслөөс хуримтлагдан үүсч болзошгүй сөрөг нөлөөлөлд төслийн ус ашиглах бүрэлдэхүүн хэсгүүдийн улмаас усны хомсдол үүсгэх эсвэл одоо байгаа усны хомсдлыг улам нэмэгдүүлэх нөлөөлөл орно. Ус ашиглах бүрэлдэхүүн хэсгүүдэд хотын ундны усны хангамжийн өргөтгөл (гүний ус), шинэ услалтын систем (гадаргуугийн ус) болон мах боловсруулах үйлдвэр (гүний ус) зэрэг ХАА-н бизнесийн төлөвлөгдөж буй хэсгүүд орно.

Дүгнэлт ба зөвлөмж

35. Дэд бүтцийн олон төрлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүтээн байгуулалтын үе шатанд барилга угсралтын ажлаас үүсэх нөлөө саадыг багасгахын тулд барилгын ажилд стандарт практик арга хэмжээ болон нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа барилга угсралтын ажлын үед ахуйн хэрэглээний усыг ус түгээх цэгээс гар аргаар зөөвөрлөх практикийг сайтар анхаарч хамгаалах нь зүйтэй бөгөөд аливаа өрхийн усан хангамж ямар ч үед тасалдахгүй байх ёстой.

36. АСХХОХ-ийн дэд бүтэц, ХАА-н үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүд нь тусгай хамгаалалттай газар нутаг, ан амьтдын амьдрах орчин, ховор эсвэл ховордсон ан амьтанд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Энэ гурван экологийн мэдрэмтгий шинж чанарыг агуулсан Ховд аймгийн Манхан, Мянгад сум дахь байршлуудыг эхний сонголт шигшилтээр хассан, мөн түүнчлэн Увс аймгийн Тариалан сумын Хархираа-Тээлийн гол дээр барихаар төлөвлөж буй хоёр услалтын систем нь Увс нуурын дархан цаазат газарт нөлөөлөхгүй.

37. Төслийн I шатлалын бүрэлдэхүүн хэсгүүдэд хамрагдаж буй орон нутгийн бүх хэрэглэгчдэд усны нөөц хангалттай байх шаардлагын үүднээс төслийн усны хэрэгцээ болон усны эх үүсвэрийн хүртээмжийг ялангуяа услалтын систем (гадаргын ус) болон агро паркийн барилга байгууламжуудтай (гүний ус) онцлон холбож авч үзэх замаар нарийвчлан зурга төслийн үе шатанд тодруулах шаардлагатай.

38. АСХХОХ-т зориулж боловсруулсан аймгуудын БОМТ нь нөлөөллийг бууруулах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөг багтаасан бөгөөд АСХХОХ-ийн байгаль орчны менежментэд шаардагдах байгууллагуудын үүрэг хариуцлага, чадавхын хэрэгцээг зааж өгсөн болно. Төслийн эцсийн бүрэлдэхүүн хэсгээс үүсч болзошгүй нөлөөллийг бүрэн шийдвэрлэж чадахуйц байлгахын тулд БОМТ-г нарийвчилсан зураг төслийн үе шатанд хянаж шинэчилж байх шаардлагатай.

39. АСХХОХ-ийн I шатлалын ТЭЗҮ-ийг төсөлд хамрагдаж буй нутаг орны талаархи олдоц бүхий мэдээлэлтэй хамтруулан авч үзэх нь АСХХОХ -ийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн цар хүрээг тодорхойлоход хангалттай байх болно гэж БОТБҮ-гээр дүгнэж байна. АСХХОХ-ийн нэг буюу хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгийн төлөвлөлтөд мэдэгдэхүйц ноцтой өөрчлөлт гарахгүй, нарийвчилсан зураг төслийн явцад гарч ирэх усны нөөцийн талаархи мэдээлэлд усны хомсдолын асуудал байна гэж тодорхойлогдохгүй мөн хүрээлэн буй орчны болон нийгмийн талаарх шинэ эмзэг асуудал гарч ирэхгүй тохиолдолд АСХХОХ нь байгаль орчины зүгээс В ангилалд хэвээр үлдэх бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОНБҮ) хийгдэх шаардлагагүй болно.

АГУУЛГА

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

3

I.	ТАНИЛЦУУЛГА	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
B.	БОТБУ-ний үндэслэл	Error! Bookmark not defined.
C.	Үнэлгээний орчин	Error! Bookmark not defined.
D.	Тайлангийн бүтэц	20
II.	БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗАХИРГААНЫ ХҮРЭЭ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
A.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	Error! Bookmark not defined.
B.	Байгаль орчны хамгааллын хууль эрх зүйн хүрээ	Error! Bookmark not defined.
C.	АХБ-ны Хамгааллын бодлого	Error! Bookmark not defined.
III.	АСХХОХ-ИЙН ТАЙЛБАР	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
A.	Увс аймаг	Error! Bookmark not defined.
B.	Баян-Өлгий аймаг	Error! Bookmark not defined.
C.	Ховд аймаг	Error! Bookmark not defined.
IV.	НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ТАЙЛБАР	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
A.	Биет орчин	124
B.	Экологийн нөөц	Error! Bookmark not defined.
C.	Нийгэм-эдийн засгийн профиль	168
V.	ОЛОН НИЙТТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
A.	Оролцогч талуудыг тодорхойлох	172
B.	Зөвлөлдөх хэлэлцүүлгийн сэдэв	174
C.	Зөвлөлдөх үйл явц	175
D.	Аймаг, сумын төвд олон нийттэй зөвлөлдөх ажлын үр дүн	176
VI.	БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ТЭДГЭЭРИЙГ БУУРУУЛАХ	180
A.	3 аймгийн төв, 2 сумын төвийн хүртэх үр шим	Error! Bookmark not defined.
B.	Нөлөөлөл ба түүнийг бууруулах	Error! Bookmark not defined.
C.	Хуримтлагдах ба өдөөгдөх нөлөөлөл	191
D.	I шатлалын техник-эдийн засгийн төлөвлөлтийн бэлэн байгаа байгууламжууд	191
E.	Уур амьсгалын өөрчлөлт	192
VII.	ХУВИЛБАРЫН ШИНЖИЛГЭЭ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
VIII.	МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БОЛГОХ БА ГОМДОЛ БАРАГДУУЛАХ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
A.	Мэдээллийг нээлттэй байлгах	193
B.	Гомдол барагдуулах механизм (ГБМ)	194
IX.	ИНСТИТУЦИЙН ЧАДАВХИ БА СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
X.	ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ	198
	ХАВСРАЛТ А: АСХХОХ-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ	199
	ХАВСРАЛТ В: АСХХОХ-Т ХОЛБОГДОХ ҮНДЭСНИЙ ЧАНАРЫН СТАНДАРТУУД	204

Хүснэгт 1. АСХХОХ-өөс аймаг, сумын төвд төлөвлөж буй хотын хөрөнгө оруулалт	18
Хүснэгт 2. АСХХОХ-өөс аймаг, сумын төвд төлөвлөж буй ХАА-н бизнесийн хөрөнгө оруулалт	Error! Bookmark not defined.
Хүснэгт 3. АСХХОХ-т холбогдох хуулийн товчлол	22
Хүснэгт 4. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенциуд	26
Хүснэгт 5. I шатлалаар Улаангом суманд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалт ..	32
Хүснэгт 6. I шатлалаар Өмнөговь суманд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалт ...	44
Хүснэгт 7. Өвс, тэжээлийн агуулахын хэрэгцээ	54
Хүснэгт 8. Лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн жишээ	55
Хүснэгт 9. Агро-паркийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд шаардлагатай усны тооцоо.....	60
Хүснэгт 10. Ээлжлэн тариалалт ба тэжээлийн ургамал тариалах	62
Хүснэгт 11. Тариалангийн улиралд голын урсацаас 3%-ийг цөөрөмд хуримтлуулах санал	69
Хүснэгт 12. Ээлжлэн тариалалт ба тэжээлийн ургамал тариалах	72
Хүснэгт 13. I шатлалаар Өлгий суманд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалт	76
Хүснэгт 14. I шатлалаар Дэлүүн суманд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалт	88
Хүснэгт 15. Өвс, тэжээлийн агуулахын хэрэгцээ	99
Хүснэгт 16. Лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн жишээ	100
Хүснэгт 17. Агро-паркийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд шаардлагатай усны тооцоо.....	102
Хүснэгт 18. Ээлжлэн тариалалт ба тэжээлийн ургамал тариалах	105
Хүснэгт 19. I шатлалаар Жаргалант суманд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалт	110
Хүснэгт 20. Өвс, тэжээлийн агуулахын хэрэгцээ	121
Хүснэгт 21. Лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн жишээ	121
Хүснэгт 22. Агро-паркийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд шаардлагатай усны тооцоо.....	123
Хүснэгт 23. Увс аймгийн Улаангом сумын уур амьсгалын мэдээ	127
Хүснэгт 24. Увс аймгийн Өмнөговь сумын уур амьсгалын мэдээ	127
Хүснэгт 25. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын уур амьсгалын мэдээ.....	128
Хүснэгт 26. Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын уур амьсгалын мэдээ	128
Хүснэгт 27. Ховд аймгийн Жаргалант сумын уур амьсгалын мэдээ.....	129
Хүснэгт 28. Увс аймгийн төв Улаангом сумын агаарын чанар.....	129
Хүснэгт 29. Увс аймгийн Улаангом сумын агаарын чанар	130
Хүснэгт 30. Баян-Өлгий аймгийн төв Өлгий сумын агаарын чанар, 2002-2018	130
Хүснэгт 31. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын агаарын чанар.....	130
Хүснэгт 32. Ховд аймгийн төв Жаргалант сумын агаарын чанар (сүүлийн 17 жил)	131
Хүснэгт 33. Ховд аймгийн Жаргалант сумын агаарын чанар.....	131
Хүснэгт 34. Орчны агаарын чанарын үндэсний ба олон улсын стандартууд.....	132
Хүснэгт 35. Халаагч зуухнаас агаарт ялгарах утааны найрлагын үндэсний ба ДЭМБ-ын стандартууд	132
Хүснэгт 36. Ховд аймгийн Жаргалант сумын орчны дуу чимээ	133
Хүснэгт 37. Увс аймгийн Улаангом сумын орчны дуу чимээ	133
Хүснэгт 38. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын орчны дуу чимээ	134
Хүснэгт 39. Ховд, Увс, Баян-Өлгий аймаг дахь гол, горхи, нуурийн тоо.....	136
Хүснэгт 40. Төслийн ажлын талбайн ойролцоох голуудын урсацын хүрэлцээт хэмжээ (м ³ /сек)	139
Хүснэгт 41. Монгол Улсын гадаргын усны чанарын стандарт	145
Хүснэгт 42. Хархираа гол, түүний цутгалангуудын бактерийн түвшин, Улаангом	147
Хүснэгт 43. Намирын голын урсацын дээд, доод хэсэг дэх бактерийн түвшин, Өмнөговь.....	148

Хүснэгт 44. Ховд голын урсацын дээд, доод хэсэг дэх бактерийн түвшин, Өлгий.....	148
Хүснэгт 45. Чигэртэй голын урсацын дээд, доод хэсэг дэх бактерийн түвшин, Дэлүүн	149
Хүснэгт 46. Буянт голын урсацын дээд, доод хэсэг дэх бактерийн түвшин, Жаргалант ...	149
Хүснэгт 47. АСХХОХ-ийн ажлын талбай дах 5 голын хүнд металлийн агууламж	150
Хүснэгт 48. Хаягдал бохир усан дах хүнд металлийн агууламж.....	151
Хүснэгт 49. АСХХОХ-ийн ажлын талбай дах гүний усны химийн үзүүлэлтүүд	151
Хүснэгт 50. Төслийн ажлын талбай дах гүний усны бактерийн түвшин	152
Хүснэгт 51. Хүнд металлийн талаарх хөрсний чанарын үндэсний стандарт	159
Хүснэгт 52. Нөлөөлөлд өртөх хүмүүс ба орон нутгийн удирдлагатай хийсэн зөвлөлдөх уулзалтуудын тойм.....	173
Хүснэгт 53. Хэлэлцүүлэг хийхэд чиглүүлэгч болгосон байгаль орчны асуудлууд.	175
Хүснэгт 54. Оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлгийн чиглүүлэгч асуултууд ба мэдээлэл авах хүсэлт	175
Хүснэгт 55. Төслийн ажлын 5 талбайд олон нийтээр хэлэлцүүлсэн асуудлын тойм.....	176
Хүснэгт 56. Газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлт (ГЧНШ)-ийн тооцоо.....	181
Зураг 1. I шатлалд хамрагдах баруун 3 аймаг	28
Зураг 2. Улаангом сумын агаарын зураг, 4 (улаан) 9-р багийг тодруулсан.....	30
Зураг 3. Улаангом сумын 4-р баг	30
Зураг 4. Бусад аймгийн төвийг төлөөлөн Улаангом дах хашааны жишээ.....	31
Зураг 5. I шатлалаар Улаангомд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тойм зураг	34
Зураг 6. Өмнөговь сумын төсвийн байгууллагуудын барилга, ариун цэврийн холболтыг сайжруулах төлөвлөгөө	43
Зураг 7. I шатлалаар Өмнөговь суманд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тойм зураг.....	45
Зураг 8. Улаангом сумын хойд хэсэгт барих агро-паркийн байршил	52
Зураг 9. Өмнөговь суманд барих агро-паркийн байршил.....	53
Зураг 10. Улаангом сумаас зүүн өмнө Тариалан суман дах усалгаатай тэжээлийн ургамлын талбай.....	60
Зураг 11. Тариалан суман дах БОАЖЯ-ны ӨУУМ-ын 1, 2-р дэд төслийн агаарын зураг	67
Зураг 12. ӨУУМ-ын 2-р дэд төсөл: 500 га услалтын системийн төлөвлөлтийн зураг.....	67
Зураг 13. Тариалан суманд хэрэгжих ӨУУМ-ын 2-р дэд төсөл.....	68
Зураг 14. Өмнөговь сумын хойно орших усалгаатай тэжээлийн ургамлын талбай.....	70
Зураг 15. Өлгий сумын агаарын зураг, 13-р баг (улаан), 5-р багийг тодруулсан	73
Зураг 16. Өлгий сумын 13-р баг.....	75
Зураг 17. I шатлалаар Өлгий суманд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тойм зураг.....	78
Зураг 18. Дэлүүн сумын төсвийн байгууллагуудын барилга, ариун цэврийн холболтыг сайжруулах төлөвлөгөө	86
Зураг 19. I шатлалаар Дэлүүн суманд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тойм зураг.....	89
Зураг 20. Өлгий сумын төвд барих агро-паркийн байршил.....	97
Зураг 21. Дэлүүн суманд барих агро-паркийн байршил.....	98
Зураг 22. Өлгий сумаас зүүн урагш Буянт суман дах услалтын системийн байршил	103
Зураг 23. Дэлүүн сумын усалгаатай тэжээлийн талбайн байршил.....	106
Зураг 24. Жаргалант сумын агаарын зураг, Алагтолгой (баг)-г тодруулсан.....	108
Зураг 25. Жаргалант сумын Алагтолгой баг	109
Зураг 26. I шатлалаар Жаргалант суманд төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тойм зураг	112
Зураг 27. Жаргалант сумын зүүн тал дах барих агро-паркийн байршил.....	120

Зураг 28. Баруун 3 аймгийн хөрсний төрөл	126
Зураг 29. Жаргалант сумын дуу чимээний түвшин.....	133
Зураг 30. Улаангом сумын дуу чимээний түвшин	134
Зураг 31. Өлгий сумын дуу чимээний түвшин.....	135
Зураг 32. Баруун 3 аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн гадаргын ус.....	137
Зураг 33. Улаангом дах Гашууны голын BOD ₅ ба pH-ийн түвшин	141
Зураг 34. Өмнөговь сум дах Намирын голын шим тэжээлт бодис ба pH-ийн түвшин	142
Зураг 35. Өлгий суман дах Ховд голын голын шим тэжээлт бодис ба pH-ийн түвшин.....	143
Зураг 36. Жаргалант суман дах Буянт голын шим тэжээлт бодис, pH ба BOD ₅ -ийн түвшин	144
Зураг 37. Баян-Өлгий аймгийн Дэлүүн суман дах Чигэртэй голын шим тэжээлт бодис ба pH-ийн түвшин.....	145
Зураг 38. Төсөл хэрэгжих газруудын гүний усны нөөц	152
Зураг 39. Жаргалант сумын 2 байршил дах хөрсний хүнд металийн агууламж	154
Зураг 40. Жаргалант сумын хүнс, барааны зах ба цахилгаан станци дах хөрсний хүнцэлийн агууламж.....	155
Зураг 41. Өлгий сумын бохирдол ихтэй газруудын хөрсний хүнд металийн агууламж	156
Зураг 42. Дэлүүн сумын хөрсний хүнд металийн агууламж	157
Зураг 43. Улаангом сумын хөрсний хүнд металийн агууламж	158
Зураг 44. Улаангом сумын хөрсний хүнцэлийн агууламж	158
Зураг 45. Өмнөговь сумын хөрсний хүнцэлийн агууламж.....	159
Зураг 46. Баруун 3 аймгийн мөнх цэвдэг	161
Зураг 47. Баруун 3 аймгийн ургамалжилтын төрөл.....	162
Зураг 48. Алтай-Саяны эко-системийн байршил.....	163
Зураг 49. Бөхөнгийн тархац нутгийн газарзүйн хүрээ	164
Зураг 50. Баруун 3 аймгийн тусгай хамгаалалттай газар нутаг	165
Зураг 51. Гомдол барагдуулах механизм.....	196

I. ТАНИЛЦУУЛГА

В. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх үндэслэл

40. АСХХОХ нь орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжиж, эхний шатанд авч үзэж буй аймгууд⁴ дахь хот, суурин газруудын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах юм. Энэхүү хөтөлбөр нь засгийн газарт сонгогдсон аймгуудад хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй хот байгуулалт, бэлчээрийн уян хатан менежмент, агро-үйлдвэрлэлийн өртгийн тогтвортой сүлжээг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх болно. АСХХОХ нь аймаг бүрт ногоон байгууламж бүхий хот, хөдөөгийн дэд бүтцийг хөгжүүлэх, агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын шат дараалсан багц арга хэмжээг багтааж байгаа бөгөөд хэрэгжүүлэх механизм, бодлогын арга хэмжээ, чадавхийг бэхжүүлэх дэмжлэг дагалдаж байгаа болно. АСХХОХ-ийн хөрөнгө оруулалт нь уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эмзэг байдал болон бэлчээрийн доройтлыг багасгахад чиглэнэ.

41. АСХХОХ-өөс дараах 4 үр дүн⁵ гарах болно. Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хүлэмжийн хий бага ялгаруулдаг, ард иргэд оршин суухад тавлаг аймаг сумын төвүүд болно.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хүлэмжийн хийг дээд зэргээр бууруулсан, тогтвортой мал аж ахуй бүхий бэлчээрийн менежменттэй болно.
- Хүлэмжийн хий бага ялгаруулдаг, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй өртгийн сүлжээг үүсгэж бэхжүүлнэ.
- Байгаль орчинд ээлтэй орон нутгийн хөгжлийн бодлогыг боловсруулах, чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

42. АСХХОХ нь Олон шатлалт зээлийн горимоор санхүүжигдэнэ. Төслийн 1-р ээлж болон энэхүү байгаль орчинд нөлөөлөх байдлын анхан шатны шинжилгээ нь Увс аймгийн төв Улаангом, Баян-Өлгий аймгийн төв Өлгий, Ховд аймгийн төв Жаргалант, мөн түүнчилэн Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвийг тус тус хамарч байгаа болно.

43. Бүс нутгийн болон хотын эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор сонгосон гурван аймгийн төв болон хоёр сумын төвд:

- Хотын нийтийн аж ахуйн үндсэн үйлчилгээ, байгууламж, дэд бүтэц,
- Агро-үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулна.

Төлөвлөж буй хөрөнгө оруулалтыг доорхи хүснэгтэд нэгтгэж харууллаа. Хот нийтийн аж ахуйн хөрөнгө оруулалт нь үндсэндээ яг аймаг, сумын төвүүдэд очих бол агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт нь аймаг сумын төвд ойрхон орших газруудад хуваарилагдах болно.

⁴ Аймаг нь Монгол улсын засаг захиргааны нэгж бөгөөд нийт 21 аймаг, аймгийн төв байдаг. Сум нь аймаг доторх засаг захиргааны нэгж бөгөөд нийт 304 сум байдаг (аймгийн төвүүдийг оруулахгүйгээр). Нэг сум дунджаар 4000 хүн ам, 5000 км² нутаг дэвсгэртэй.

⁵ Төслийн дотоодын түншүүдтэй хамтарч орон нутагт хийсэн судалгаанаас (2019 оны 11-р сар) (БХБЯ/ALAMGas, ХХААХҮЯ/БАҮХ)

Хүснэгт 1. АСХХОХ-өөс аймаг сумын төвүүдэд төлөвлөсөн хот нийтийн аж ахуйн хөрөнгө оруулал

Хот нийтийн аж ахуйн хөрөнгө оруулалт	
- Гэр хорооллын дахин төлөвлөлт⁶ - Зам засаж сайжруулах, ус зайлуулах дренаж - Бохир ус зайлуулах сүлжээг сайжруулах, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих буюу өргөтгөх - Ундны усыг ариутгах, ус түгээх сүлжээг сайжруулах - Цахилгаан хангамжийг өргөтгөх - Харилцаа холбооны цамхаг, шилэн кабелийн сүлжээ	- Дулаан хангамжийг сайжруулах - Үерээс хамгаалах голын эрэг далангийн бэхэлгээ - Ус зайлуулах суваг - Хог хаягдлын цэгийг сайжруулах - Сургууль, эмнэлэг, захиргааны барилгыг өргөтгөх

Хүснэгт 2. Аймаг сумын төвд төлөвлөж буй агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт

Агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт *	
- Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд⁷ зориулсан олон нийтэд суурилсан төсөл - мал аж ахуй - хадлан тэжээлийн талбай, агуулах сав - бага оврын усалгаа, - худаг усыг сайжруулах - жижиг гол дээр гүүр барих	- Агро парк - хорио цээрийн бүс (ХЦБ) - мал төхөөрөх үйлдвэр - мал эмнэлэг лабораторийн үйлчилгээ - судалгааны төв - бизнес төвүүд - боловсруулах үйлдвэрүүд
Услалтын систем, тэжээлийн аж ахуй**	

*Хөрөнгө оруулалт нь өмнөх хүснэгтэд үзүүлсэн дэд бүтцээр дэмжигдэх болно

**Ховд аймагт услалтын систем, тэжээлийн аж ахуй төлөвлөгдөөгүй
Aimag

44. АСХХОХ-ийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны техникийн болон бодлогын шууд дэмжлэгтэйгээр Барилга хот байгуулалтын яам гүйцэтгэх болно. БХБЯ-аас хотын дэд бүтэц, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд ХХААХҮЯ нь Монголын Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоогоор (БАНХ) дамжуулж агро-үйлдвэрлэл, бэлчээрийн менежментийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлнэ. АСХХОХ-д хоёр яамнаас техник, бодлогын хамтарсан дэмжлэг үзүүлж байгаа нь хоёр өөр томхон төслийн хөрөнгө оруулалтыг амжилттай, тогтвортой хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

⁶ *sensu*, Ulaanbaatar Affordable Green Housing and Resilient Urban Renewal Project (AHURP), TA 9030, 2017.

⁷ Бэлчээр ашиглагчдын бүлэг

С. Үнэлгээний нөхцөл

45. АХБ-ны *Хамгааллын бодлогын баримт бичиг*⁸ (2009) болон саяхан хэвлэгдсэн Тэргүүн туршлагын эх сурвалж удирдамжын⁹ дагуу АСХХОХ нь байгаль орчны хувьд Б зэрэглэлд багтсан хэвээр байна. Б зэрэглэлийн төслүүд нь болзошгүй сөрөг нөлөөллийн хувьд А зэрэглэлийнхтэй харьцуулахад хэмжээ бага, хугацаа богино, орон нутгийн онцлогтой, нөхөн сэргээгдэх боломжтой бөгөөд аймгийн БОМТ-ний¹⁰ дагуу нөлөөллийг бууруулах боломжтой юм. Төслийн байршлыг шалгах явцад санал болгосон хоёр талбай А зэрэглэлийн нөхцлийг бүрдүүлдэг Байгалийн цогцолборт газар болон Байгалийн нөөц газарт багтаж байсан тул төслийн байршлыг шалгах явцад эдгээр талбайг 1-р ээлжээс хассан болно. АХБ-наас төслийг В ангилалд багтаасан АСХХОХ-ийн анхны Байгаль орчинд нөлөөлөх байдлын шуурхай үнэлгээг Хавсралт А-д үзнэ үү.

46 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль тогтоомжийн (2012 он) дагуу АСХХОХ-т уг хуулийг дагаж мөрдөх, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг (БОННУ) хийх шаардлагатай. АСХХОХ-ийн хувьд төсөлд бэлтгэх техникийн туслалцаа дууссаны дараагаар БОННУ-г хийх бөгөөд 1-р ээлжийн цаашдын нарийвчилсан зураг төслийг үндэслэн гүйцэтгэх болно.

1. АСХХОХ –ийн нөлөөллийн ул мөр

47. Хот суурины дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь (дээр буй хүснэгтүүд) бүрэлдэн тогтсон хот суурин газрын хүрээнд, одоо байгаа хот байгуулалтын нөлөөллийн ул мөр дээр хийгдэнэ. Иймд хот суурин газрын хөгжилд учирч болзошгүй байгаль орчны давамгайлах нөлөөллүүд нь ерөнхийдөө дэд бүтцийн барилга, газар шорооны ажлын явцад үүсэх богино хугацааны тасалдал, нөлөөлөл байх болно. Ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, бохир ус цуглуулах цэвэрлэх, хатуу хог хаягдлын менежмент, ус зайлуулах, үерийн хяналтыг сайжруулахаар төлөвлөсөн ажлууд нь хотын орчинд бүхэлдээ эерэг нөлөө үзүүлнэ.

48. Төлөвлөсөн агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт нь (Хүснэгт 2) ихэвчлэн суурин газраас зайтай, бэлчээрийн бүсэд хийгдэх болно. Орчин үеийн агро парк, мал аж ахуй, мал төхөөрөх үйлдвэр, мал эмнэлгийн төвөөс бүрдэх агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт нь Монгол улсын хувьд шинээр хийгдэх бөгөөд иймээс төсөлд хамрагдаж буй бэлчээр нутагт ч шинэлэг арга хэмжээ байх болно. Орон нутагт хийсэн судалгааны явцад зарим агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг экологийн эмзэг бүсээс хассан болно. (VI бүлгийг үзнэ үү).

2. Санхүүгийн зуучлагч

49. АСХХОХ-ийн агро-үйлдвэрлэлийн зарим бүрэлдэхүүн хэсгийг АХБ-ХБББ-т (2009) заасны дагуу Хөгжлийн Банкны Хөрөнгийн удирдлагын корпораци (ХУК), Хас банк, Хаан банк гэсэн гурван хувийн хэвшлийн санхүүгийн зуучлагч (СЗ) хэрэгжүүлнэ. Тусад нь боловсруулж бэлтгэсэн Байгаль орчин, нийгмийн менежментийн системээр (БОНМС) оролцож буй санхүүгийн зуучлагчдад (ОСЗ) хамгааллын чиглэл өгч, дэмжлэг үзүүлэх бөгөөд үүнийг ОСЗ нь өөрсдийн баримталдаг БОНМС-д нэмэлт болгон дагаж мөрдөх болно.

⁸ АХБ. 2009 он Хамгааллын бодлогын баримт бичиг. Манила хот.

⁹ АХБ. 2012 он. Байгаль орчны хамгаалал, Тэргүүн туршлагын эх сурвалж, Төсөл. Манила хот.

¹⁰ 19-р хуудасны 5-р зүүлт тайлбар

3. Үнэлгээний хүрээ

50. Олон шатлалт зээлийн горимын дагуу гурван ээлжээр цуврал хэлбэрээр олгогдох зээлийн төслийн хувьд АСХХОХ нь төслийн түншүүдээ үнэлгээ хийхэд нь чиглэл заавар өгөх, АСХХОХ-ийн дараагийн ээлжийн хамгаалалтын арга хэмжээг хангах зорилгоор Байгаль орчны үнэлгээ ба хяналтын хүрээг (БОҮХХ) боловсруулах шаардлагатай. АСХХОХ-ийн БОҮХХ-г тусад нь боловсруулсан болно.

D. Тайлангийн бүтэц

51. Гурван аймаг, хоёр сумын төвийг багтаасан нэг боть Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг бэлтгэлээ. БОТБҮ-ний энэхүү тайлан нь Хавсралт 1-д тусгасан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, мөн АХБ-ХБББ-ийн (2009) 1-р хавсралтад заасан бүтцийг баримталсан болно. БОТБҮ-ний үр дүнг аймаг, сумын төвд танилцуулна. Агуулгын хувьд давхардал үүсэхээс зайлсхийх, багасгах зорилгоор зарим нийтлэг нөхцөл, үнэлгээний үр дүнг нэгтгэсэн болно. Харин гурван аймаг, харгалзах сумын төвүүдэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) тус тусад нь боловсрууллаа.

БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗАХИРГААНЫ ТОГТОЛЦОО

52. АСХХОХ-ийг Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) гүйцэтгэгчээр ажиллаж, ХХААХҮЯ болон Монгол улсын Хөгжлийн банктai хамтран хэрэгжүүлнэ. Монгол улсын Хөгжлийн банк нь Хөрөнгийн удирдлагын компани (ХУК), Хас банк, Хаан банк гэсэн санхүүгийн зуучлалын гурван байгууллагаар (СЗ) дамжуулан АСХХОХ-ийн агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүнийг хэрэгжүүлэхэд хяналт тавина. БХБЯ-аас хотын дэд бүтэц, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд ХХААХҮЯ, санхүүгийн гурван зуучлагч байгууллага нь хөдөө аж ахуйн бизнес болон бэлчээрийн менежментийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлнэ. АСХХОХ-д хоёр яамнаас техникийн болон бодлогын хамтарсан дэмжлэг үзүүлж байгаа нь хоорондоо адилгүй хоёр томоохон төслийг амжилттай, тогтвортой хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Е. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ

53. Монгол улсад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн (2012) дагуу гүйцэтгэдэг бөгөөд БОАЖЯ-ны зүгээс удирдан зохицуулдаг. БОНУ-ний журмын дагуу бүх төслүүдийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОНЕУ) буюу урьдчилсан үнэлгээ, үүний дараагаар бүрэн хэмжээний байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) эсвэл байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) гэсэн хоёр шатлалтайгаар хийж байна. Анхдагч БОНЕУ-г БОАЖЯ-наас хийх бөгөөд төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний шатлалыг гаргадаг. Томоохон төслүүдийн хувьд БОНЕУ-ээр цааш хийгдэх БОННУ-д тавигдах шаардлагыг тодорхойлдог бол бага зэргийн нөлөөлөлтэй төслүүдэд зөвхөн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах ёстойг тодорхойлж өгдөг.

54. БОНУ-г гүйцэтгэх үйл явцын эхний алхам нь төслийг өмчлөгч нь БОАЖЯ, эсвэл орон нутаг/хотын байгаль орчны газарт хандаж уг төслийн БОНЕУ-г хийлгэх хүсэлт гаргах ба үүнд дараах үндсэн мэдээллийг агуулсан байна: 1) төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт; 2) хэрэгжүүлэх төслийн талаарх техникийн зураг төслийг хавсаргасан *нарийвчилсан* тодорхойлолт; 3) төслийн техник эдийн засгийн үндэслэл. Дээр дурдсанчилан БОНЕУ-нээс дараах боломжит шийдлүүд гарна. Үүнд:

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхгүйгээр төслийг хэрэгжүүлэхийг зөвшөөрөх;
- Тусгай нөхцөлүүдийг хэрэгжүүлэх юм уу эсвэл БОМТ-д заагдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авснаар төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхгүйгээр хэрэгжүүлэхийг зөвшөөрөх;
- Төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай;
- Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, эсвэл хүрээлэн буй орчинд тоног төхөөрөмж, технологийн зүгээс учрах сөрөг нөлөө маш их, газрын менежментийн төсөл байхгүй гэсэн үндэслэлээр төсөл хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх.

55. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (2012) заасны дагуу байгаль орчинд үзүүлэх нөлөө бага төслийн анхдагч БОНЕУ-г тус төсөл хэрэгжих аймаг, нийслэлийн байгаль орчин аялал жуулчлалын газар хийж болно. Аймаг, нийслэлийн БОАЖ-ын газар нь өөрсдийн БОНЕУ буюу ихэвчлэн БОМТ-д заагдсан шаардлагын дагуу үнэлж, зөвшөөрөл олгоно. Энэ арга нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хувьд харьцангуй гэм хор багатай төслийн нөлөөллийн дүгнэлтийг шуурхай гаргахад тустай байдаг.

56. АСХХОХ-ийн өмчлөгч болох БХБЯ-наас төслийн анхдагч БОНЕУ-г хийлгэх хүсэлтийг БОАЖЯ-д гаргана. АСХХОХ-ийн нарийн төвөгтэй байдлыг харгалзаж үзвэл БОНЕУ-нээс БОННУ хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарах болно. Гэхдээ БОНЕУ-г бүрэн хийж дуусгах, цаашид БОННУ хийх явц нь АСХХОХ-ийн 1-р ээлжийн нарийвчилсан зураг төсөлд үндэслэж хийгдэх тул тэр болтол хүлээгдэх ёстой.

57. БОНЕУ-г заавал хийх зарчим нь АХБ-ны БОТБҮ болон ХБББ (2009) дэх байгаль орчны хамгааллын талаар тавигдсан шаардлагыг биелүүлэхэд нэн ач холбогдолтой. Нэн ялангуяа төсөл хэрэгжих газрын байгаль орчны анхдагч суурь мэдээлэл болон тухайн орон нутгаас цуглуулсан мэдээ баримт, БОНЕУ-д ашиглах мэдээллүүд тун чухал байдаг. Эдгээр мэдээлэл нь БОТБҮ-ний чанарыг сайжруулж БОМТ боловсруулах үндсэн хэрэглэгдэхүүн болдог.

F. Байгаль орчныг хамгаалах хууль эрх зүйн тогтолцоо

58. Монгол Улсын Засгийн газар байгаль орчин, байгалийн нөөц баялаг, тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ба бохирдлын менежментийн чиглэлээр тусгайлсан хуулиудыг батлуулан, байгаль орчны стандартыг тогтоосон байдаг. АСХХОХ-т хамааралтай өргөн хүрээг хамарсан хуулиудын холбогдох хэсгүүдийг Хүснэгт 5-д нэгтгэж харуулав. АСХХОХ-ийг хэрэгжүүлэхэд мөрдөх байгаль орчны чанарын болон техникийн холбогдох стандартуудын жагсаалтыг Хавсралт Б-д үзүүлэв. Засгийн газраас эсвэл донор байгууллагаас санхүүжиж буй төслийн БОНЕУ-г БОАЖЯ-наас хийдэг бөгөөд үүний дараа БОНУ хийх эрх бүхий аж ахуйн нэгжээр БОННУ, БОМТ хийлгэх нь монгол улсад үйлчилж буй хамгааллын иж бүрэн цогц шаардлага юм. Хөгжлийн албан ёсны тусламжаар эсвэл АХБ зэрэг донор байгууллагаас хийсэн байгаль орчны хяналт шалгалтыг Засгийн газар хянаж, батлах шаардлагагүй байдаг.

Хүснэгт 2. АСХХОХ-д хамааралтай хууль тогтоомжийн хураангуй

Монгол улсын хууль	Холбогдох зүйл	Хариуцах яам, газар
1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль		БХБЯ
Бодлого, стратеги, хөтөлбөрийн хамрах хүрээ, нөлөөнд өртсөн ард иргэдийн дунд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах	19	
2. Усны тухай хууль		БОАЖЯ
Усны нөөцийн хамгаалалт	22	
Усны нөөцийг бохирдохоос хамгаалах: Хаягдал ус зайлуулах зөвшөөрөлд заасан хэмжээнээс болон хаягдал усны стандартаас хэтэрсэн бохир усыг удаа дараа хаясан нь ус ашиглах эрхийг цуцлах үндэслэл болох	24	
Засгийн газраас ус бохирдуулсаны болон хомсдуулсаны төлбөрийг тогтооно	25	
Ус ашиглах гэрээг цуцлах нөхцөл	29	
Ус ашиглагчийн үүрэг	30	
Ус ашигласны төлбөр	31	
3. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль		БОАЖЯ
Ус бохирдуулагчийг тодорхойлох, бүртгэх	4	
Ус бохирдуулсны төлбөрийн субъект	5	
Ус бохирдуулсны төлбөрийг цуцлах, хөнгөлөх	8	
Хот, суурин газрын усны хангамж ба ус зайлуулах хоолойн сүлжээний үйл ажиллагаа	9	
Усан хангамж, ус зайлуулах хоолойн сүлжээг зохицуулах хорооны үүрэг, бүрэлдэхүүн	9	
Хот, суурин газрын усан хангамж, ус зайлуулах хоолойн сүлжээний үйл ажиллагааны техникийн үзүүлэлт	11	
Тусгай зөвшөөрөл, лиценз	12	
Гэрээ	13	
Үйлчилгээ үзүүлэгчдийн үүрэг	14	

Монгол улсын хууль	Холбогдох зүйл	Хариуцах яам, газар
Үйлчилгээ үзүүлэгч нь хууль зүйн үндэслэлгүйгээр хэрэглэгчийн эрх ашгийг хөндөх, техникийн тодорхойлолт авах өргөдлөөс татгалзах эрхгүй		
Хэрэглэгчийн эрх, үүрэг	15	
Усан хангамж, ариутгах татуургын үйлчилгээг түдгэлзүүлэх нөхцөл	16	
Ус зайлуулах хоолойн шугамыг хамгаалах бүс ба ус зайлуулах хоолойн шугамаас зургаан метрийн дотор барилга, байгууламж барихыг хориглох	17	
Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршлын техникийн шаардлага	18	
4. Газрын тухай хууль		БОАЖЯ, БХБЯ
Газрын эрхийг шилжүүлэх	39	
Газар эзэмшигч нь газар эзэмших сертификатын хугацаа дуусмагц газраа чөлөөлөх	41	
Гэрээний хугацаа дуусахаас өмнө бусдын эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авахад газар өмчлөгчид нөхөн олговор олгох	43	
Тусгай зориулалтаар болон нийтийн эзэмшилд газар ашиглах	46	
Гуравдагч этгээдийн газрыг түр болон дамжин өнгөрөх зориулалтаар ашиглах	48	
Газрыг зохистой ашиглах шаардлага	50	
Газрыг ашиглалтад тавигдах нийгмийн эрүүл мэндийн шаардлага	51	
Хот, суурин газрын зохистой хэрэглээ, хамгаалалт	56	
Газрын эвдрэлийн нөхөн төлбөр	61	
5. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль		БХБЯ
Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-д заасан хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчмыг баримтална. Үндсэн зарчим нь иргэдийн эрх ашгийг эрхэмлэх байна.	5	
Дахин хөгжүүлэх үйл ажиллагааны төрөлд 12.1.3 гэр хорооллын газрыг дахин хөгжүүлэх төрлийг багтаана	12	
Гэр хорооллыг төлөвлөх тухай	17	
Төсөл хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг	23	
Газар эзэмшигч, төсөл гүйцэтгэгч болон холбогдох засаг, захиргааны нэгжийн Засаг дарга оролцсон гурван талт гэрээ байгуулах	24	
Гурван талт гэрээний хугацаа, нөхцлийн дагуу газар эзэмших эрхийг төсөл хэрэгжүүлэгчид шилжүүлэх	25	
6. Газар өмчлүүлэх тухай хууль		БХБЯ
Газар өмчлөгчийн эрх, үүрэг	27	
Газар өмчлөгчийн эрх дуусгавар болох	31	
Газрын эрхийг улсын өмчид дахин авах	32	
Сервитуд тогтоох нөхцөл	33	

Монгол улсын хууль	Холбогдох зүйл	Хариуцах яам, газар
Газрыг хураах	35	
Нүүлгэн шилжүүлэлт хийх нөхцөл	37	
7. Газрын төлбөрийн тухай хууль		БХБЯ
Газар ашигласны төлбөр төлөгчийг тодорхойлох	3	
Газрын төлбөртэй холбоотой субъектууд	4	
Газрын төлбөрөөс чөлөөлөх	8	
Газрын төлбөр төлөгчдийн хүлээх хариуцлага	12	
8. Байгаль орчныг хамгаалах тухай хууль		БОАЖЯ
Байгаль орчныг хамгаалах талаарх иргэний эрх, үүрэг	4	
Байгалийн нөөцийн халдашгүй байдал	6	
Байгаль орчныг бохирдлоос хамгаалах	21	
ААН, байгууллагын эрх, үүрэг	31	
Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр	49, 57	
9. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль		БОАЖЯ
Хөрс хамгаалах арга хэмжээ	6	
Хөрсийг доройтуулсан хохирлын нөхөн төлбөр	9	
10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль		БОАЖЯ
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ БОНУ	8	
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө БОМТ	9	
Төсөл, хөтөлбөрт оролцогчдын хүлээх үүрэг	14	
БОНУ хийх эрх бүхий ААН-ийн эрх, үүрэг	15	
Санхүүгийн байгууллагууд байгаль орчин болон нийгмийн эрүүл мэндэд хор хөнөөлтэй үйл ажиллагааг дэмжсэн төслөөс татгалзах үүрэг хүлээнэ	17	
БОНУ хийх явцад олон нийтийн оролцоог хангах	18	
БОНУ, БОМТ хийлгэлгүйгээр төслийг хэрэгжүүлснээс буюу үнэлгээгээр тавигдсан шаардлагыг зөрчсөний улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх	20	
11. Агаарын тухай хууль		БОАЖЯ
Хувь хүн, албан байгууллагын эрх, үүрэг	9	
Агаарын чанарын өгөгдөл	12	
Агаарын бохирдлыг бууруулах зарчим, арга хэмжээ	13	
Агаарын чанарыг сайжруулах бүс	15	
Агаарын чанарыг сайжруулах бүсэд хориглох үйл ажиллагааны жагсаалт	16	
Агаарт бохирдуулах бодис гаргах	20	
Агаарын чанарыг хамгаалахын тулд барилгын ажилд тавих техникийн шаардлага	21	
12. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль		БОАЖЯ
Агаар бохирдуулагчдын бүртгэл	4	

Монгол улсын хууль	Холбогдох зүйл	Хариуцах яам, газар
Агаар бохирдуулагчийн төлбөрийг тодорхойлох физик хүчин зүйл	6	
Төлбөр	7	
Төлбөрөөс чөлөөлөх болон хөнгөлөх	8	
13. Барилгын тухай хууль		БХБЯ
Барилга барих зөвшөөрөл	7	
Зураг төсөл, барилгын материал, барилгын ажилд тавигдах техникийн шаардлага	11,12, 13	
Барилгын талбайд тавигдах шаардлага	16	
Иргэний болон бусад холбогдох хуулийн дагуу барилгын ажил гүйцэтгэх талбайд сервитут тогтоох	17	
Барилгын төслийн түнш нь зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүйгээр анхны загварыг өөрчлөх эрхгүй болно	37	
14. Амьтны тухай хууль		БОАЖЯ
Амьтан хамгаалах	6	
Амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлөх	37	
15. Ургамал хамгааллын тухай хууль		БОАЖЯ
Ургамал хамгааллын талаар хувь хүн, байгууллагын хүлээх үүрэг	13	
Ургамлын хорио цээр	14	
16. Соёлын өвийг хамгаалах тухай хууль		БСШУЯ
Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан	21	
Түүхийн дурсгалт газарт уул уурхай, хөдөө, аж ахуй, дэд бүтцийн барилгатай холбоотой аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглох	38	
17. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль		Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ)
Барилгын болон үйлдвэрлэлийн талбайн аюулгүй ажиллагааны шаардлагууд	7	
Ажлын багаж, хэрэгслийн аюулгүй ажиллагааны шаардлагууд	9	
Галын аюулгүй байдлын шаардлагууд	13	
Хөдөлмөрийн аюулгүй байдал ба нийгмийн эрүүл мэндийн талаарх ажил олгогчийн үүрэг, хариуцлага	28	
Үйлдвэрлэлийн ослын үед авах арга хэмжээ	29	
Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналт	33	
18. Галын аюулгүй байдлын тухай хууль		Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)
Галын аюулгүй байдлын талаарх хувь хүний эрх, үүрэг	16	
Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага	19	
Галын хяналтын тоног төхөөрөмжийн техникийн шаардлага	23	
19. Хог хаягдлын тухай хууль		БОАЖЯ

Монгол улсын хууль	Холбогдох зүйл	Хариуцах яам, газар
Хатуу хог хаягдалтай холбоотой иргэн, ААН-ийн нийтлэг эрх, үүрэг	9	
Хатуу хог хаягдлыг зайлуулах	11	
Хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх	12	
20. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль		БОАЖЯ
Химийн хорт болон аюултай бодисыг боловсруулахад тавигдах үндсэн шаардлага	13	
Эрсдлийн үнэлгээ	17	
21. Эрүүл ахуйн тухай хууль		ЭМЯ
Хүрээлэн буй орчны эрүүл ахуйн шаардлага	4	
Хот төлөвлөлт, барилга байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлага	5	
Ажлын байранд тавих эрүүл ахуйн шаардлага	6	

59. Монгол Улс байгаль орчны менежменттэй холбоотой хууль эрх зүйн орчинг бүрдүүлдэг олон улсын байгаль орчны гэрээ, конвенцуудад гарын үсэг зурж нэгдсэн. Эдгээр конвенцуудыг дараахь хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Монгол улсын нэгдэж орсон олон улсын холбогдох гэрээ конвенц

Олон улсын гэрээ конвенц	Элссэн он	Хариуцах яам, газар
Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц	1993 (г)	БОАЖЯ
Киотогийн протокол	1999 (а)	БОАЖЯ
Биологийн олон талт байдлын тухай конвенц	1993 (г)	БОАЖЯ
Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенц		
Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц	1996 (а)	БОАЖЯ
Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протокол	1996 (а)	БОАЖЯ
Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай Вашингтоны конвенц	1996 (а)	БОАЖЯ
Органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц	2004 (г)	БОАЖЯ, Гадаад харилцааны яам

(а) нэгдэн орсон; (е) хүчин төгөлдөр болох; (г) соёрхон баталсан.

Г. АХБ-ны хамгааллын бодлого

60. АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичиг (2009), саяхан хэвлэгдсэн Хамгааллын арга хэмжээний тэргүүн туршлагын эмхэтгэлд (2012) байгаль орчны үнэлгээний үндэслэл, хамрах хүрээ, агуулгыг нарийвчлан тодорхойлсон ба эдгээр нь Дэлхийн Банк/Олон улсын санхүүгийн корпорацийн хөгжлийн төслүүдэд зориулсан БОЭМААУ-р дэмжигддэг. Энд ерөнхий болон үйлдвэрлэлийн чиглэлийн олон улсын практик арга хэмжээний удирдамж мөн багтдаг. Төслүүдийг эхлээд байгаль орчны гурван ангиллын (А, В, С) дагуу шалгаж үнэлгээний түвшинг тодорхойлно.

61. Байгаль орчинд ноцтой буюу их хэмжээний нөлөөлөл үзүүлэх, тухайлбал усан цахилгаан станцын далан зэрэг нөхөн сэргээх боломжгүй, олон төрлийг хамарсан, урьд өмнө байгаагүй сөрөг нөлөөлөл үзүүлэх төслүүдийг А ангилалд (Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ шаардлагатай) хамааруулдаг. А ангиллын төслүүдтэй харьцуулахад В ангиллын төслүүдийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага бөгөөд төслийн тухайн нутаг байршлаас хамааралтай, нөхөн сэргээгдэх боломж их тул сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг А ангиллын төслийнхөөс арай хялбар хэрэгжүүлэх боломжтой (Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ шаардлагатай). С ангиллын төслүүд нь байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэй буюу нөлөөлөл үзүүлдэггүй. С ангиллын төслүүдийн хувьд байгаль орчны үнэлгээ хийх шаардлагагүй боловч хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг хянан шалгаж, мэдээлж байх хэрэгтэй. Өмнө дурдсанчилан АСХХОХ нь байгаль орчны нөлөөллийн хувьд В ангилалд хамаарна. Шаардлагатай БОТБУ-ний бүтцийг АХБ-ХБББ-ийн (2009) Хавсралт 1-д заасны дагуу гүйцэтгэнэ.

62. АХБ-ХБББ (2009) нь оролцогч талуудтай зөвшилцөх стратегийг боловсруулахыг шаарддаг бөгөөд энэ нь ажилд утга учиртай оролцох, ил тод байдал, олон нийтийн оролцоо, хүртээмжтэй байх зарчмыг агуулсан, төслийн нөлөөлөлд өртөж байгаа болон эмэгтэйчүүд, ядуучууд зэрэг эмзэг бүлгүүдэд төслийн төлөвлөлтийг боловсруулахад эрх тэгш оролцох боломжийг олгосон байдаг. Талуудын оролцоог дэмжихийн тулд АСХХОХ-д гомдол барагдуулах механизм (ГБМ) байх шаардлагатай. ГБМ нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүст тулгарч буй маргаантай болон санаа зовоож буй асуудлыг эрх бүхий байгууллагад шуурхай хүргэх боломжийг олгоно.

АСХХОХ-ИЙН ТАНИЛЦУУЛГА


63. АСХХОХ-ийн танилцуулгыг инженерийн болон хөдөө аж ахуйн багуудаас эцсийн тайлангийн төсөл¹¹ болон 2019 оны 11-р сард орон нутагт ажилласан техникийн туслалцааны нэг хэсэг болгон бэлтгэсэн болно. АСХХОХ нь:

- Хотын нийтийн аж ахуйн үндсэн үйлчилгээ, дэд бүтцийг сайжруулах
- Агро-үйлдвэрлэлийг хөгжүүлэх гэсэн үндсэн хоёр төрлийн хөрөнгө оруулалтаас бүрдэнэ.

64. Төслийн 1-р ээлж нь Увс аймгийн төв Улаангом, Баян-Өлгий аймгийн төв Өлгий, Ховд аймгийн төв Жаргалант, мөн түүнчилэн Увс аймгийн Өмнөговь болон Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвийг тус тус хамарч байгаа болно. Ховд аймгийн сумын төвүүдээс 1-р ээлжид хамруулаагүй болно.

¹¹ Draft Final Report on ASDIP submitted October 24, 2019, 5 Vols + Annexes

Зураг 1. 1-р ээлжид хамрагдаж буй Монгол улсын баруун гурван аймаг



**Төслийн явцын тайлангаас авав

Төслийн танилцуулгын бүтэц

65. Төслийн танилцуулгад аймгуудыг Увс, Баян-Өлгий, Ховд, түүний бүрэлдэхүүнд багтсан сумд гэсэн бүтэцтэй бэлтгэлээ. Аймгийн хэсэг бүрт эхлээд дэд бүтцийн хэсгүүдийг, дараагаар нь агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцууллаа.

66. Аймгийн төвүүд дэх дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсэг нь (i) гэр хорооллын дахин төлөвлөлт (ii) ус, дулаан, цахилгаан хангамж, бохир ус зайлуулах, харилцаа холбоо, зам, хатуу хог хаягдал гэсэн үндсэн дэд бүтцийг хамарна. Сумын төвүүд дэх дэд бүтэц нь (i) олон нийтийн барилга байгууламжуудыг сэргээн засварлах (ii) эдгээр барилга байгууламжуудад үйлчлэх ус, дулаан, цахилгаан хангамж, бохир ус зайлуулах, зам, хатуу хог хаягдал гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

67. Аймаг болон сумын төвүүдэд байх агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсэг нь (i) бэлчээр ашиглагчдын бүлгийг дэмжих (ii) агро парк (iii) услалтын систем, тэжээлийн аж ахуй байх болно. Дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдээс ялгаатай нь аймаг сумын төвүүдэд байх агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүд ижил байх учраас тэдгээрийг хамтад нь харуулсан. Увс аймгийн Тариалан сум болон Баян-Өлгий аймгийн Буянт суманд зөвхөн услалтын систем, тэжээлийн аж ахуй байх болно.

Н. Увс аймаг

Ерөнхий тойм

68. Увс аймгийн төв Улаангомд болон сонгож авсан Өмнөговь сумын төвд хот суурин газрын дэд бүтцийг сайжруулах, агро-үйлдвэрлэлийн байгууламжийг сайжруулна. Хотын дэд бүтцийг сайжруулах ажлын дийлэнх хэсэг нь аймаг болон сумын төвийн төв хэсэгт хийгдэх бөгөөд агро-үйлдвэрлэлийн ихэнх үйл ажиллагаа нь сумын төвөөс зайтай байх болно. Дэд бүтцийг сайжруулах, агро-үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын цар хэмжээ нь Өмнөговь сумын төвийнхтэй харьцуулахад Улаангом болон түүний эргэн тойронд илүү байх болно.

1. Хотын дэд бүтэц

а. Улаангом

69. Улаангом дахь хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь дараахь 2 үндсэн бүрэлдэхүүнтэй байна:

- Гэр хорооллын байр сууц ба нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулж шинэчлэх;
- Улаангом хотын хэмжээнд нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах цогцолбор ажил нь усан хангамж, бохир ус цуглуулах, цэвэрлэх, цахилгаан, харилцаа холбоо, хатуу хог хаягдлын менежмент, зам, борооны ус зайлуулах, үерийн хамгаалалтаас бүрдэнэ.

і. Улаангом дахь гэр хорооллын дахин төлөвлөлт

70. Зураг 2-т буй Улаангомдын агаарын зураглалд 4 (улаан) ба 9-р (шар) багуудын нутгийг онцолж харуулав. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг 4-р багт хийхээр төлөвлөсөн ба 9-р багийг хувилбар болгон авч үзэж байна. 9-р багийн гэр хорооллын дахин төлөвлөлтийг 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн шатанд тодорхойлох тул 2-р ээлжээр хийгдэх болно. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний шинэчлэлийг 4-р баг дээр сонгосон анхны туршилтын гудамж дагуу гүйцэтгэх болно (Зураг 3). Туршилтын гудамжийг шинэчлэн сайжруулах ба дахин төлөвлөлтөд хамрагдсан талбай руу инженерийн шугам сүлжээг шинээр барих буюу өргөтгөх бөгөөд үүнийг туршилтын гудамж/замын улаан шугамын дагуу байрлуулна.

71. Гэр хорооллын орон сууцны дахин төлөвлөлтийг хийхдээ хувийн хашааг хамруулах бөгөөд орчин үеийн эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалаар баригдах 1-2 давхар жижиг орон сууц байх болно. Орон сууцыг дулаан, бохир ус цуглуулах хоолой, цахилгаанд холбох ба хатуу хог хаягдлыг дахин боловсруулах байгууламж байрлуулна. Ариун цэврийн болон усанд орох өрөө, угаалгын байгууламжаас бүрдэх техникийн хэсэг (ТХ) мөн багтана.

Зураг 2. Улаангомын 4 (улаан) ба хувилбараар авч үзэж буй 9-р (шар) багуудын байршил.




Зураг 3. Улаангот 4-р баг¹²

(а) 4-р баг. Анхны туршилтын гудамжийг цагаан зураасаар харуулав.



(б) Туршилтын гудамж дагуух гэр хорооллын дахин төлөвлөлт



** Схем, дэвсгэр зургийг төслийн архитектор бэлтгэв.

¹² 4-р баг дахь гэр хорооллын дахин төлөвлөлт хийх гудамжны хэсгийн зургийг төслийн архитектор бэлтгэв.

72. Хашаа эзэмшигчид өөрсдийн хашаагаа бүхэлд нь юм уу эсвэл зарим хэсгийг байшин барих эсвэл ТХ-т өгөхөөр солилцох боломжтой. Хашаа эзэмшигчдийн оролцсон зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн явцад тодорхойлсон гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажилд оролцох хувилбарыг дараах байдлаар нэгтгэсэн ба мөн Зураг 3b-д үзүүлэв.

1. Газраа солилцохгүй ч сүлжээнд холбогдсон ТХ-ийг худалдаж авах боломжтой;
2. Газрынхаа нэг хэсгийг жижиг байшин ба ТХ-ээр солилцох;
3. Хашааны газраа хэд хэдэн өрхөд зориулсан байшин, ТХ-р бүрэн солих
4. Оролцох тухай шийдвэр гараагүй байна.

73. Улаангом болон Өлгий, Жаргалантын гэр хорооллын дахин төлөвлөлтөд хашаа өмчлөгчийн оролцоог тогтоох шаардлагатай түвшин байхгүй. Хашаа өмчлөгчид нь сайжруулсан орон сууц, үйлчилгээнд зориулж газраа бүхлээр нт сольж болно, эсвэл огт оролцохгүй байх ч боломжтой. Мөн аймгийн төвүүдийн гэр хорооллын дахин төлөвлөлтөд заавал хамрагдах хашааны тоог зааж өгөхгүй. Хашаа эзэмшигчдийн хамтын ашиг сонирхлын түвшнээс хамаарч дэд бүтцийн ажлын хэмжээ тодорхойлогдоно. Аймгийн төвүүдэд хашаа гэсэн хатуу тодорхойлолтыг хашаалсан газар гэж авч үздэг. Уламжлал ёсоор аймаг сумын удирдлагаас айл өрхөд олгосон газрыг модоор хашаалсан байдгийн жишээг 4-р зурагт үзүүлэв.

Зураг 4. Бусад аймгийн төвүүдийг төлөөлөх Улаангом дахь хашааны жишээ



i. Улаангомд үндсэн дэд бүтэц

74. 1-р ээлжийн санхүүжилтээр Улаангомд төлөвлөсөн хотын дэд бүтэц ба нийтийн аж ахуйн үйлчилгээний хөрөнгө оруулалтыг Хүснэгт 5-д нэгтгэж үзүүлэв. Зураг 5-д дэд бүтцийн сайжруулалтын ажлын схем зургийг харууллаа. 4-р баг болон хувилбараар авч үзэж буй 9-р багийн дахин төлөвлөлт хийгдэх гэр хорооллын нийтийн аж ахуйн үйлчилгээ болон агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг Улаангом дахь дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хүрээнд хийх болно.

Хүснэгт 4. Улаангом дахь 1-р ээлжинд төлөвлөж буй хөрөнгө оруулалт ¹³


Төрөл	Хийгдэх ажил	Тайлбар
Усан хангамж	Усны эх үүсвэр болон түгээлтийн системийг шинэчлэх	Хоёр байршилд насос станцын барилга, насос, хяналт, холбогдох хэрэгсэл, хлоржуулалтын системийг шинэчлэн засварлах. Худгуудыг холбосон хоолойг солих. Шүүрэлт үүссэн ус дамжуулах хоолойг доторлож засварлах
	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулж шинэ хоолой тавих	4 болон 9-р багийн дахин төлөвлөлтөд орох гэр хорооллын хэсгийг замтай зэрэгцээ явж буй одоо байгаа усан хангамжийн сүлжээнд холбох шинэ хоолойг үзлэгийн худгийн хамт барих.
	Агро паркад зориулсан шинэ худаг гаргах, шинэ хоолой тавих	Шинэ агро паркийн зориулалттай талбай дотор төлөвлөсөн цэгт гүний насос, удирдлага, цахилгааны холболт, бага оврын усны нөөцлүүр, худгийн барилга зэргийг багтаасан худаг барих.
Бохир ус зайлуулах	Бохир ус цэвэрлэх байгууламж шинэ байгууламж, бохирын сүлжээ, насосны станцын өргөтгөн шинэчлэх	Шаардагдаж буй нэмэлт хүчин чадалд тохирох бохир ус цэвэрлэх байгууламжийг хотын хойд хэсэгт өмнө нь тогтоосон байршилд шинээр барих. Хотын одоо байгаа бохир ус цуглуулах сүлжээг шинэ БУЦБ руу өөрийн урсгалаар холбох хоолой тавих. Одоо байгаа бохирын насосны станцыг буулгах.
	Хотын суурьшсан хэсэг болон дахин төлөвлөлт хийгдэх гэр хорооллын хэсэгт зориулсан бохир ус цуглуулах сүлжээ	Төслийн байгууламжийг хангах шинэ шугам хоолойг үзлэгийн худгийн хамт барих. Одоо байгаа зарим шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр шинэ хоолойгоор солих. Шугамыг одоо байгаа гудамж/замуудтай зэрэгцээ суурилуулна.
	Агро паркад зориулсан БУЦБ, шугам сүлжээ	Агро паркаас гарах үйлдвэрийн бохир усыг нэвчүүлэх замаар зайлуулах стандартад нийцүүлэн цэвэрлэх хүчин чадал бүхий бохир ус цэвэрлэх байгууламжыг агро паркаас хойш 250 м орчим зайд байгуулах. Энд агро парк дахь төрөл бүрийн байгууламжуудыг шинэ бохир ус цэвэрлэх байгууламжтай холбох бохирын хоолой тавих ажил хамт хийгдэнэ.
Дулаан хангамж	Төрийн өмчит дулааны станцын эргэлтийн насосыг шинэчлэх	Дулааны станцын эргэлтийн насосыг сольж шинэчлэнэ.
	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан дулааны дэд станц	Дулаан хуваарилах дэд станцуудыг өмнө нь төлөвлөсөн байршлуудад суурилуулна. Байшинд хэрэглэх усыг халаах дулааны солилцуур бүхий дэд станцууд нь стандарт тохиргоотой бөгөөд орон сууцны барилга байгууламжийн дулаан, усны хуваарилалтыг хянах зориулалттай. Дэд станцууд нь төрийн мэдэлд байх бөгөөд орон сууцны хорооллын дэд бүтцийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцдаг байгууллага хариуцаж ажиллуулна. Дулаан түгээх болон буцах шугамуудыг ус түгээх шугамын хамт 1500мм-ийн бетонон сувагт байрлуулах ба мөн хавхлагын станцууд, хяналтын худгууд байна. Шугамыг одоо байгаа замуудтай зэрэгцээ суурилуулах.
	Улаангомьн агро паркад зориулсан дулааны станц, хоолойн хамт	Агро паркад зориулсан, нүүрс галлаж ажиллах дулааны шинэ станц. Станцаас агро паркийн байгууламжуудыг хавхлагын станц, үзлэгийн худаг бүхий дулаан болон усан хангамжийн хоолойгоор хангана.
	Улаангомд халуун усны тоолуур тавих	АСХХОХ нь хэрэглээнд суурилсан дулааны тарифыг бий болгох арга хэрэгсэл болгож дулааны тоолуурыг нэвтрүүлэх бөгөөд энэ нь эрчим хүч хэмнэх, барилгын эрчим хүчний хэмнэлтийг сайжруулах хөшүүрэг болно.
Цахилгаан хангамж	Баруун бүсийн нэгдсэн сүлжээнээс авах шинэ тэжээлийн станц болон хуваарилах станцыг шинэчлэх	Сүлжээний ашигтай байдлыг нэмэгдүүлэх, шинээр суурилуулах төхөөрөмжүүдийг одоогийн 10 кВ-ын стандартад нийцүүлэх боломжтой болгох зорилгоор хуваарилах станцыг 6 кВ-аас 10кВ болгож сайжруулна (4, 9-р багийн гэр хорооллын дахин төлөвлөлт хамрагдана). Үүнд шинэ хуваарилагч төхөөрөмж багтаж буй бөгөөд одоо ашиглагдаж буй цэгүүдэд суурилуулна.
	Түгээлтийн шугам, дэд станцын шинэчлэл	Элэгдэж хуучирсан цахилгаан дамжуулах агаарын шугамыг сольж, шинэчилнэ. Шаардлагатай бол шонг солино. Элэгдэж хуучирсан 6кВ/0.4кВ трансформаторуудыг 6кВ/0.4кВ болгож одоо байгаа суурин дээр нь шинэчилнэ. Энэ ажил 2, 3-р ээлжээр үргэлжилж хийгдэнэ.
	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан цахилгаан шугам, дэд станцууд	4-р багийн дахин төлөвлөлтөд хамрагдаж байгаа гэр хороололд, шинэ шон, трансформатор бүхий цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ
	Агро паркад зориулсан цахилгаан шугам, дэд станц	Агро паркийн байгууламжийн найдвартай байдлыг сайжруулах, хүчин чадлыг шаардлагатай хэмжээнд нэмэгдүүлэх зорилгоор хуучин цахилгаан дамжуулах 6кВ агаарын шугам, дэд станцыг солих

¹³ From engineering description of Annex 3, Vol II of ASDIP Final Report

Төрөл	Хийгдэх ажил	Тайлбар
Харилцаа холбоо	Аймгийн төвийн болон Улаангомыг Өмнөговь сумтай холбосон харилцаа холбоог сайжруулах	Шилэн кабелийн хүчийн чадлыг нэмэгдүүлж аймгийн төвөөс авах болон төв рүү өгөх мэдээллийн дамжуулалтыг сайжруулна. Өмнөговь суманд шинэ харилцаа холбооны цамхаг, шилэн кабель суурилуулна.
	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан харилцаа холбоог сайжруулах ажил	Хүчин чадлыг нэмэгдүүлж, сумын төвөөс авах болон өгөх мэдээллийн дамжуулалтыг сайжруулна.
	Агро паркад зориулсан харилцаа холбооны сайжруулалтын ажил	Агро паркад зориулж хүчин чадлыг сайжруулсанаар сумын төвөөс авах болон өгөх мэдээллийн дамжуулалт найдвартай болно
Зам	Агро парк руу шинэ зам тавих	Одоо байгаа замыг хамгийн ойрын засмал замтай холбож ус зайлуулах шугам, гудамжны гэрэлтүүлэгтэй, хучилттай болгож сайжруулах.
Борооны ус зайлуулах дренаж	Хотын нутаг дэвсгэрийн хэмжэнд дренажийг сайжруулах	АСХХОХ-ийн Техникийн туслалцаагаар хийгдсэн борооны ус зайлуулах төлөвлөгөөний дагуу хотын ус зайлуулах байгууламжийг сайжруулах ажлыг уялдуулна
	Дахин төлөвлөлт хийгдэх гэр хороололд дренаж сайжруулах ажил	Борооны усыг дахин төлөвлөлт хийгдсэн гэр хороолол болон түүний ойр орчмоос зэргэлдээ суурин газар руу хүргэхгүйгээр зайлуулахын тулд доторлогоотой суваг, шуудууг барина. Сэргээсэн газруудад ус зайлуулах дренаж ороогүй бөгөөд эдгээр зураг төслийг зохицуулах ёстой.
	Хотын нутаг дэвсгэрээс борооны ус зайлуулах төлөвлөгөө боловсруулах техникийн туслалцаа	Улаангомын хувьд ус зайлуулах урсгалын тооцоо хийх, зураг төслийн шалгуурыг боловсруулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төслүүдийг тодорхойлох, орон нутгийн төлөвлөгчдөд чиглэл өгөх зорилгоор ус зайлуулах иж бүрэн төлөвлөгөөг бэлтгэх.
Үерийн хамгаалалт	Даланг шинэчлэх, нуурт ус тогтоох, халианы схем тооцоо хийх	Аймгаас боловсруулсан төлөвлөгөөний дагуу одоо байгаа 5 км үерийн хамгаалалтын даланг засаж сайжруулан, элэгдэлээс хамгаалах бэхлэгээ хийнэ. Даланд засвар үйлчилгээ хийхэд ашиглах хязгаарласан зориулалт бүхий орц гарц хэлбэрээр ашиглах дугуй-явган хүний зам байх шаардлагатай. Далангийн хойд талд одоо байгаа нуурын эрэгт хамгаалалт хийж, төлөвлөж буй агро паркийн суваг руу гаргах урсгалын хяналтын байгууламжтай холбоно. Амралт зугаалгын (цэцэрлэгт хүрээлэнгийн байгууламжууд) болон хүрээлэн буй орчны (ус намгархаг газар, амьдрах орчин) сайжруулалтыг багтаана. Үерийн үед нуураас халих усыг чиглүүлэх байгууламж мөн багтана.
	Агро парк руу ус татах бетон суваг барих, шороон сувгийг шинэчлэх	Одоо байгаа 2.5км дренажны сувгийг шинэчлэн сайжруулж, үерээс хамгаалах далангийн хойд хэсэгт буй нуурыг агро паркийн дэргэдэх шинэ цөөрөмтэй холбох 2.9 км шинэ суваг барих. Цөөрөм нь үерийн хамгаалалтын далангийн хойд хэсэг дэх нуурын усаар тэжээгдэх ба 1000м³ багтаамжтай байна. Цөөрмийн усыг усжуулалт, малын усан хангамжид ашиглах бөгөөд толгойн байгууламж, шахуургын системтэй байх ба худгаас нийлүүлсэн ундны усны системээс тусад нь хуваарилах хоолой тавина. Ууршилтыг хязгаарлах, цөөрмийг хүйтний улиралд ашиглах хугацааг уртасгах зорилгоор ус нэвчдэггүй, өндөр нягтрал бүхий полиэтилен хальсан бүрээс болон хөвөгч бүрхүүлийн хамт барина.
Хатуу хог хаягдал	Талбайд үнэлгээ хийх, бизнес төлөвлөгөө, хог цуглуулах ажлыг албан журамд оруулах, дахин боловсруулах чиглэлээр техникийн туслалцаа	Байгаль орчинд ээлтэй, тогтвортой хатуу хог хаягдлын менежментийн тогтолцоо бий болгох хөтөлбөрийн эхний үе шатанд зориулсан ТТ: Хөрс, гүний усны чанар, топограф, борооны ус, ус зайлуулах суваг зэрэг одоо байгаа нөхцлийг тогтоох Орон нутагт хатуу хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж эхлэх. Хогийг дахин боловсруулах төлөвлөгөө гаргах, 2, 3-р ээлжийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
	Талбайд анхан шатны цэвэрлэгээ хийх, хашаа барих, хяналтын цэг байгуулах, ус зайлуулах суваг	Эхний шатанд хийгдэх ажлууд: - Одоо байгаа хог хаягдлын талбайг нэгтгэж цаашид ашиглаж талбайг тодорхойлж, хашаа болон хяналтын цэг барих, хамгаалалт гаргах. - Өнөөгийн байдлаар хэрэглэгдэж буй муу дадал зуршлыг засаж залруулахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлэх - Хогийн цэгийг цэвэрлэх ажлыг эхлүүлэх - Хог хаягдлыг зориулалтын битүү чингэлгээр цуглуулах туршилт эхлэх

Зураг 5. 1-р ээлжээр Улаангомд хийгдэх дэд бүтцийн ажлын тойм зураг


а) Ус хангамж болон Бохир усны шугам




b) Дулаан хангамж



с) Цахилгаан хангамж болон мэдээлэл холбооны шугам сүлжээ



d) Үерийн хамгаалал болон далан суваг



75. Улаангом дахь одоо байгаа бохир ус цэвэрлэх байгууламж нь 1986 онд баригдсан механик цэвэрлэх байгууламжын талбай дээр байдаг бөгөөд 1990-ээд оны эхэн дэх эдийн засгийн шилжилтийн үеэс ажиллахаа больсон. Одоогоор маш бага хэмжээний цэвэрлэгээ (BOD-г 25-27% багасгадаг) хийж байна. Зуны аадар борооны үеэр дамжуулах шугам хоолой руу нэвчих уснаас илүүтэйгээр таг хавхлагагүй үзлэгийн худагт дүүрсэн ус цэвэрлэх байгууламжийн ажиллагаанд нөлөөлдөг. Цэвэрлэх байгууламж руу бохир ус дамжуулдаг даралтат шугам болон шүүлтүүр бүхий өргөх төхөөрөмжид засвар, шинэчлэлт хийх шаардлагатай. Даралтат шугам нь хуучин механик цэвэрлэгэх байгууламжийн нэг хэсэг нь байсан тунгаах цөөрмийг хангадаг насос бүхий бага хэмжээний бялхаах сав хүртэл явдаг. Ер нь бүх тоног төхөөрөмж маш муу ашиглалтын нөхцөлд байна. Шинэ БУЦБ барьснаар одоо байгаа байгууламжуудыг ашиглалтаас гаргана.

76. Шинэ БУЦБ-аас гадна барилгажсан хэсгийн бохир ус татуургын одоо байгаа сүлжээний 1.45км хэсгийг Ø400-ийн хоолойгоор шинэчлэн солино. Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулж 4-р баг (Ø200), болон хувилбараар авч үзэж буй 9-р багт (Ø300) бохир ус татуургын өөрийн урсгалын шинэ хоолой тавина.

77. Агро паркаас гарах бохир ус нь зөвхөн ахуйн бохир ус цэвэрлэх зориулалттай хотын цэвэрлэх байгууламжид тохирохгүй тул агро паркын талбайд хоногт 250 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийг барьснаар агро паркаас гарах бохир усыг байгаль орчинд найдвартай байдлаар зайлуулах болно.

78. Шинэ БУЦБ-г хотоос зүүн хойно байх задгай талбайд барихаар аймгийн удирдлагаас тогтоосон. Энэ талбай нь хуурай, элсэрхэг хөрстэй бөгөөд гүний ус нэлээн доор байх шинж тэмдэгтэй. Цэвэрлэгдсэн усыг талбайгаас 300м орчмын зайд байх жижиг горхи руу зайлуулж болох бөгөөд 22 км-ийн зайд байх Увс нуур хүрэлгүй хатах болно. Увс нуур дархан цаазат газар тул шинэ БУЦБ-ийг олон улсын цэвэршүүлсэн бохир усны чанарын стандартыг хангах хэмжээнд төсөллөх ба энэ ажлыг 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслөөр гүйцэтгэнэ.

Дулаан хангамж:

79. Улаангомын барилгажсан хэсгийг хоёр дулааны станцаар хангадаг. Анхны станц нь 1986 онд баригдсан, 1990 оны эдийн засгийн шилжилтийн дараа хувьчлагдаж 2003 онд уураас халуун усны үйлдвэрлэлд шилжсэн. Уг станц нь 39 МВт хүчин чадалтай бөгөөд жилд 12-18 мянган тонн нүүрс хэрэглэдэг. Тус компани нь өөрсдийн эх үүсвэрээр дамжуулах хоолойн хэсгийг хэсэгчлэн засварлаж, сайжруулсан байна. Дулааны станц болон улсын мэдэлд байдаг түгээлтийн шугам сүлжээний зарим хэсгийн ашиглалтыг хувийн компани хариуцдаг. Төрийн өмчит дулааны станц нь 2014 онд ашиглалтад орсон бөгөөд ойролцоогоор 1500 айл өрх, 340 байгууллагыг дулаанаар, айл өрхийн 75 хувь, байгууллагуудын 25 хувийг халуун усаар хангадаг.

80. Улаангомьн дулааны станцууд нь зөвхөн хүйтний улиралд (10-р сарын 1-ээс 5-р сарын 1-ний хооронд) ажилладаг тул бусад үед оршин суугчид, албан байгууллагууд усаа өөрсдөө ихэвчлэн цахилгаан халаагуураар халаадаг. Төрийн өмчийн дулааны станцад холблгдсон шугам сүлжээний зарим хэсэг нь баригдаад 3-10 жил болсон бөгөөд ашиглалтын нөхцөл сайн байна. Халаалтын сүлжээнд холбогдоогүй айл өрхүүд нүүрс, мод, аргал түлж халаадаг энгийн зуух ашигладаг. Арай томхон хэмжээний барилгуудыг нүүрс голчлон ашигладаг тохируулгагүй, нам даралтын шаталтын зуухаар халаадаг.

81. Хоёр дулааны станц ба түгээх сүлжээнүүдийн үйл ажиллагаа хотыг дулаанаар хангах болон төлөвлөгдөж буй АСХХОХ-ийн дагуу хийгдэх өргөтгөлд төслийн нэмэлт оролцоогүйгээр ажиллахад бололцоотой гэж үзэж байна. Төрийн өмчит дулааны станцын эргэлтийн насосыг шинэчлэх шаардлагатай байгаагаас өөрөөр дээрх хоёр станцад ямар нэг арга хэмжээ төлөвлөөгүй байна.

82. Төлөвлөж буй агро парк нь (доороос харна уу) хотын дулаан түгээх сүлжээнээс нэлээд хол зайд байрлах тул тэнд бие даасан, жижиг оврын, нүүрсээр ажилладаг дулааны станц барих нь дулаанаар хангах хамгийн хэмнэлттэй арга болно. Агро паркийн янз бүрийн байгууламжуудыг бетон сувагт байрлуулсан дулаан түгээх хоолойд холбоно. Бие даасан уурын зуух нь агро паркийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн хуваариар ажиллах боломжтой.

83. 4 ба 9-р багийн (дээр үзнэ үү) гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсэд нийтдээ таван дулаан дамжуулах дэд станц барих шаардлагатай бөгөөд эдгээр нь ахуйн хэрэгцээний халуун ус түгээхээс гадна үйлчилгээний хүрээнд буй барилга байгууламжид хүйтэн ус түгээнэ. Хоёр багт байх дэд станцуудын байршлыг Улаангомьн ерөнхий төлөвлөгөөнд өмнө нь тодорхойлсон байдаг бөгөөд энэ нь сүлжээний зураг төсөл хийх болон ашиглалтад тус дөхөм болно. Халуун, хүйтэн ус дамжуулах шугам хоолой нь шинээр баригдах дэд станцуудад холбогдоно. Эдгээр хоолойнуудыг гудамжны дагууд бетонон сувагт зэрэгцүүлж Монгол улсын барилгын стандартын дагуу угсарна.

○ ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ

84. Зөвхөн Улаангом болон Өмнөговь сумын төвд хатуу хог хаягдлыг цуглуулж зайлуулах ажлыг багахан хэмжээгээр хийж гүйцэтгэдэг бөгөөд замбараагүй хаяж, салхинд хийссэн хог их хэмжээний газар нутгийг бохирдуулжээ. Орон нутгийн удирдлагууд хог цуглуулах, хадгалах ажлыг сайжруулахаар төлөвлөж эхэлсэн боловч санхүү хүрэлцэхгүйгээс гадна нөхцөл байдлыг өөрчлөхөд өөр бусад бэрхшээлүүд тулгарч байна.

85. Улаангомьн хувьд хогонд дарагдаж бохирдсон газар нь суурьшлын бүсэд нэлээн ойрхон байна. Ахуйн хог хаягдлаас гадна арилжааны аж ахуйн нэгжүүд хогоо хяналтгүй, замбараагүй хаяж байгаа нь иргэдийн эрүүл мэнд, байгаль орчинд ихээхэн эрсдэл учруулж байна. Зарим газарт хашаа барьж, орох гарах замыг хянаж эхэлсэн боловч хог цуглуулж хаях ажлыг зохион байгуулах, учирч буй нөлөөллийг бууруулахад шаардлагатай тоног төхөөрөмж, ашиглалтад хогонд дарагдсан газар нутгийг цэвэрлэх, багасгахын тулд хийх аливаа ажилд хөрөнгө санхүү дутагдаж байна.

86. Улаангом дахь хог хаягдлын цэг нь хотоос зүүн өмнө 2.5км орчимд байрладаг бөгөөд хяналтгүй үйл ажиллагааны улмаас 74 га талбайг хамарч тэлжээ. Хотын зүгээс стун ойрмогхон хогийн цэгийг хэсэгчлэн хааж, нэвтрэх хаалга, харуулын хэсэг хийжээ. Нөлөөлөлд өртсөн газрын ихээхэн хэсэг нь салхинд хийссэн хог хаягдал бөгөөд тэдгээрийг хурааж хумих, далдлах хүн хүч, тоног төхөөрөмж байхгүй байна. Хотын хувьд хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх нь тогтсон систем байхгүй бөгөөд арилжааны болон аж ахуйн нэгжийн хог хаягдлыг тээвэрлэх, устгах ажлыг холбогдох байгууллагууд өөрсдөө хариуцдаг.

87. Дулааны станцуудын үнсийг хотын хогийн цэгээс тусад нь хаядаг боловч хотын хог хаягдлын нлээн хувийг жижиг зуух, бойлерийн үнс эзэлж байна. Хогийн цэг нь 27 км-ийн зайд байх Увс нуурт цутгадаг голоос 1 км орчмын зайд орших өндөрлөг талбайд байрладаг. Хогийн цэгийн орчимд гадаргад ойр байхуйц гүний ус байгаа шинж тэмдэг үгүй ч хогийн талбайгаас урсах борооны ус гол руу орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй байна. Хогийн цэгийн ажилчид шил, металл гэх мэт дахин боловсруулалт хийх боломжтой хог хаягдлыг ялгаж салгаж эхэлсэн боловч хогийг дахин боловсруулалтад ашиглах хөтөлбөр, төлөвлөгөө байхгүй байна.

88. Улаангом дахь хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулахтай холбоотой өнөөгийн байдал нь түүнийг байгаль орчны стандарт, практик шаардлагыг хангахуйц хэмжээнд хүртэл хурдан хугацаанд шийдвэрлэхэд хэтэрхий томдсон нь асуудал болж байна. АСХХОХ-ийн 1-р ээлж нь Улаангомд өнгөрсөн хугацаанд хяналтгүй хаягдсан хогийг цэвэрлэх, зайлуулах, газар нутгийг нөхөн сэргээх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой менежментийн системтэй болгох эхний үе шат байх болно. Энэ арга хэмжээ нь техникийн туслалцаа болон гүйцэтгэх ажлуудыг хосолсон байх болно.

- Хог хаягдлын төрөл, физик нөхцөл байдал (хөрс, гүний ус, газрын гадарга), одоо байгаа хог хаягдалд үндэслэн тухайн газрыг цаашид ашиглах төлөвлөгөөтэй уялдуулж нөлөөллийг нь арилгах, юм уу багасгах шаардлагатай ямар хор хөнөөл байгаа эсэх зэрэг өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлно. Үүний дүнд хогийн талбайг цэвэрлэх, сайжруулахад зориулсан арга хэмжээний зөвлөмж бэлдэх ба өрөмдлөг, гүний усны дээж авах, усны чанарын анализ хийх ажлууд үүнд орсон байна.
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэж хаях, зардал нөхөх механизм болон чадавхийг хөгжүүлэх хэрэгцээ, үе шаттайгаар цэвэрлэгээ хийх, нөхөн сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг орон нутгийн түвшинд эхлүүлэх
- Цаашид хог хаягдлын талбай болгон ашиглахаар тогтож буй газарт одоо байгаа хогийн талбайг нэгтгэх, эргэн тойронд нь нэвтрэх хяналт, хамгаалалтын цэг бүхий хашаа барих (15 га)
- Гүний усны бохирдол зэрэг нийгмийн эрүүл мэндэд учирч буй аливаа буруу дадал зуршлыг засахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлүүлэх.
- Хог дахин боловсруулж ашиглах чиглэлээр судалгаа хийх, боломжуудыг холбогдох зардал, үр ашгийн хамт тодорхойлж боловсруулах, үүнийг аймаг, бүс нутгийн хөтөлбөртэй уялдуулах
- 2, 3-р ээлжээр төвлөрсөн санхүүжилтээр хийгдэж болох шинэ барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах
- Одоо байгаа хогийн цэгийг цэвэрлэж эхлэх.
- Хотын төв ба гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх хэсэгт 50 ш хогийн сав тавьж 5 ачааны машинаар хатуу хог хаягдлыг цуглуулж ачих туршилтыг эхлүүлэх

89. Хөтөлбөрийн 1-р ээлжээс гарах үр дүн нь барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан 2-р ээлжийн үйл ажиллагааг эхлүүлэх үндэс болно.

90. Улаангом болон бусад аймгуудад хог дахин боловсруулж ашиглах боломжийг харахан судалж үзээгүй байна. Дахин боловсруулсан материалын зах зээл тодорхойгүй байгаа тул хөрөнгө оруулалт нөхөн төлөгдөх эсэхийг мэдэх боломжгүй байна. Дахин боловсруулт хийх материалын дийлэнх хувийг Улаанбаатараас БНХАУ руу илгээдэг боловч Баруун аймгуудын логистикийн байдал маш ялгаатай тул дахин боловсруулалтыг орон нутгийн юмуу бүсийн чанартай хийж гүйцэтгэх нь гадагш тээвэрлэхээс илүү боломжтой байж болох юм

в. Өмнөговь сум

91. Өмнөговь сумын төвийн дэд бүтцийн ажлууд нь Улаангомынхтой ижил төстэй боловч хэмжээ далайцын хувьд бага бөгөөд гэр хорооллын дахин төлөвлөлт байхгүй. Улаангомын нэгэн адил нийт дэд бүтцийн байгууламжууд нь шинээр үүсэх агро-үйлдвэрлэлийн байгууламжуудад үйлчилнэ (дор үзнэ үү).

i. Нийтийн хэрэгцээний барилга байгууламж

92. 1-р ээлжээр хийгдэх хотын дэд бүтэц, үйлчилгээний хөрөнгө оруулалтад сумын төвийн ариун цэврийн болон нийтийн хэрэгцээний барилга байгууламжийн тохижилт зэрэг ажлууд багтах ба эдгээрийг 6-р зурагт үзүүлэв.

Ариун цэврийн байгууламж:

93. Сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг зэрэг олон нийтийн барилга доторх бие засах газар хангалтгүй эсвэл огт байхгүй байна. АСХХОХ нь барилгын гадна хол зайд байрладаг хуучин нүхэн жорлонг шинэчлэн сайжруулах эсвэл шинэ ариун цэврийн байгууламж барих ажлыг санхүүжүүлнэ.

Дотуур байр:

94. Хөдөө орон нутагт боловсрол эзэмшихэд тулгардаг бэрхшээлүүдийн нэг бол сургуулийн дотуур байрны ор дутагдалтай байх явдал юм. АСХХОХ нь шаардлагатай сурагчдын дотуур байрыг барина.

Олон төрлийн зориулалтаар ашиглаж болох барилга байгууламж:

95. Сургуулийн дэргэдэх номын сан, амралт чөлөөт цагийн төв гэх мэт дутагдалтай байгаа асуудлыг шийдвэрлэхэд эдгээр барилгуудыг ашиглана. Төслийн зүгээс олон төрлийн зориулалтаар ашиглаж болох эдгээр барилга байгууламжийг шинээр барих эсвэл сэргээн засварлах замаар байгуулна.

Спорт:

96. АСХХОХ нь олон нийт, оршин суугчдад зориулсан энгийн спортын цогцолборыг барих болно. Энэхүү цогцолборийг барьснаар бага насны хүүхдүүдийн тоглоомын талбайтай болохоос гадна залуучууд илүү зохион байгуулалттай спортоор хичээллэх боломжтой болно.

Ажилчдын орон сууц:

97. Байнгын болон улирлын чанартай ажилтан, ажилчдыг (багш, эмнэлгийн мэргэжилтнүүд г.м.) орон нутагт татах, суурьшуулах зорилгоор тэднийг орон байраар хангах шаардлагатай. Төсөл нь энэ зорилгоор энгийн орон сууцны хороолол барина. Бүх барилга байгууламжуудад эрчим хүч хуримтлуулах баттерей бүхий нарны зайн хавтанг суурилуулах замаар цахилгааны нэмэлт хангамжтай байх болно.

Зураг 6. Өмнөговь сумд төлөвлөж буй ариун цэврийн болон нийтийн хэрэгцээний байгууламж



ii. Өмнөговь сум дахь үндсэн дэд бүтцийн сайжруулалт

98. Өмнөговь сумын төвд хийхээр төлөвлөж буй үндсэн дэд бүтцийн сайжруулах ажлуудыг Хүснэгт 6-д нэгтгэж үзүүлэв. Энэхүү ажлын тоймыг харуулсан агаарын зураглалыг Зураг 7-д тусгав.


Хүснэгт 5. Өмнөговь сумын төвд 1-р ээлжинд хийхээр төлөвлөж буй дэд бүтцийн ажлууд ¹⁴

Төрөл	Хийгдэх ажил	Тайлбар
Усан хангамж	Сумын төвд зориулсан усан сан, шугам хоолой бүхий усан хангамжийн эх үүсвэр	Сумын төвөн барилгажсан хэсгийн ойролцоо байх гүний насос, удирдлага, цахилгааны холболт, бага оврын усны нөөцлүүр, худгийн барилга зэргийг багтаасан худаг
	Сумын төв дэх ус түгээх сүлжээ	Сумын төвийн гол барилга байгууламжуудыг усны худагтай холбох далд хоолой, үзлэгийн худаг
	Агро паркад зориулсан худаг, шугам сүлжээ	Шинэ агро паркийн талбай дотор төлөвлөсөн цэгт гүний насос, удирдлага, цахилгааны холболт, бага оврын усны нөөцлүүр, худгийн барилга зэргийг багтаасан 2 худаг барих.
Бохир ус зайлуулах	Шинэ БУЦБ, бохир усны шугам хоолой	Сургуулийн хойт талд барихаар төлөвлөж буй, сургууль болон олон нийтийн барилга байгууламжаас гарах ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. Сургууль болон бусад олон нийтийн барилгыг шинэ БУЦБ-тай холбох далд хоолой
	Септикийн үйлчилгээнд зориулсан вакуум соруулах машин	Бохир хаягдлыг зайлуулах буюу цэвэрлэх зориулалтын байршилд тээвэрлэж хүргэх вакуум насос, хоолойгоор тоноглогдсон, цаг уурын хүйтэн нөхцөлд ажиллахад зориулагдсан муу усны нүхнээс бохир ус, лагийг соруулж авах машин
	Агро паркад зориулсан бохир усанд анхан шатны цэвэрлэгээ хийх байгууламж	Цэвэрлэсэн усыг хөрс рүү асгах замаар зайлуулах стандартад нийцүүлэн цэвэрлэх хүчин чадал бүхий бохир ус цэвэрлэх байгууламжыг агро паркын ойр орчимд байгуулах. Агро паркийн барилга байгууламжуудаас гарах бохир усыг цэвэрлэх байгууламжид хүргэх бохир усны далд хоолой
Дулаан хангамж	Агро паркад зориулсан шинэ дулааны станц, шугам хоолойн хамт	Агро паркийг дулаан болон халуун усаар хангах нүүрсэн галлагаа бүхий шинэ дулааны станц, Агро паркийн байгууламжуудыг холбох хавхлага, үзлэгийн худаг бүхий шугам хоолой.
Цахилгаан хангамж	Цахилгааны хангамжийг ерөнхийд нь сайжруулах (ус хангамжийн эх үүсвэрийг оролцуулна)	Сумын төвийн дэд станцын тоног төхөөрөмжийг шинэчлэх, цахилгааны шугам кабель, шонг солих. Сумын төвд цахилгаан түгээх хүчин чадал, найдвартай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор кабель, трансформаторыг шинээр солих
	Агро паркад зориулсан шугам, дэд станц	Агро паркын барилга байгууламжуудын цахилгаан хангамжид зориулсан агаарын шугам
Харилцаа холбоо	Сумын төв болон агро паркын харилцаа холбоог сайжруулах	Дэлүүн сум ба агро паркад зориулсан 500 хэрэглэгчийн MSAN станц бүхий холбооны шинэ шилэн кабель
Зам	Өмнөговь, Тариалан сумдыг холбосон шинэ зам	
	Тариалан сумыг авто замын сүлжээтэй холбох шинэ зам	
Хатуу хог хаягдал	Талбайд анхан шатны цэвэрлэгээ хийх, эн тэргүүнд хийх ажлууд, хашаа барих, хяналтын цэг байгуулах	Эхний ээлжинд хийгдэх ажлууд: Одоо байгаа хог хаягдлын талбайг нэгтгэж цаашид ашиглах талбайг тодорхойлж, хашаа болон хяналтын цэг барих, хамгаалалт гаргах. Өнөөгийн байдлаар хэрэглэгдэж буй муу дадал зуршлыг засаж залруулахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлэх Хогийн цэгийг цэвэрлэх ажлыг эхлүүлэх Хог хаягдлыг зориулалтын битүү чингэлгээр цуглуулах туршилт эхлэх

¹⁴ Modified from engineering designs of Annex 3, Vol II, of ASDIP Final Report

Зураг 7. 1-р ээлжээр Өмнөговь сумд хийгдэх дэд бүтцийн тойм зураг

а) Ус хангамж болон Бохир усны шугам




ELECTRICAL LINES FOR UMNUGOBI SOUM

The map displays the Umnugobi Soum area with various infrastructure elements. A red line indicates the planned electrical line route, starting from the top left and extending towards the bottom right. Key locations marked include the School Dormitory, Kindergarten, Sport Complex, and Umnugobi Agropark (5 ha). A new electrical substation (10/0.4 kV, 400 kVA for Agropark) is also indicated. The map includes a scale bar (0 km to 500 m) and a legend for the electrical lines and boundaries.


LEGEND:

- Agropark and Irrigation field boundary (planned)
- Electrical line (existing)
- Electrical line (planned)

с) Мэдээлэл холбооны сүлжээ



d) Хогын цэг



- (i) Хүснэгт 6-д үзүүлсэн байгаль орчны хувьд эмзэг байхуйц зарим дэд бүтцийн талаархи тайлбар (АСХХОХ-ийн Эцсийн тайлангийн II-р боть дахь инженерийн танилцуулгаас иш татав)

Бохир ус зайлуулах

99. Өмнөговь сумын төвд албан ёсны бохир ус цуглуулах, цэвэрлэх, зайлуулах систем байхгүй. Олон нийтийн барилга байгууламж, байшин бүхий хороололд зөвхөн нүхэн жорлонг ашигладаг. Усан хангамжийн системийг сайжруулахтай уялдуулан бохирын шугам сүлжээ тавих ба сургууль, олон нийтийн барилга байгууламжаас гарах ахуйн бохир усыг бага оврын (100 м³/хоног) бохир ус цэвэрлэх байгууламжтай холбоно. Сургуулиас хйош орших талбайд барихаар төлөвлөж буй энэ цэвэрлэх байгууламж нь цэвэрлэсэн усыг гадаргад асгахад нийцэхүйц стандартаар ажиллана.

100. Агро паркаас гарах бохир ус нь зөвхөн ахуйн бохир ус цэвэрлэх зориулалттай сумын цэвэрлэх байгууламжид тохирохгүй тул агро паркын талбайд хоногт 50 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийг барьснаар агро паркаас гарах бохир усыг урьдчилсан байдлаар цэвэрлэж сумын системд нийлүүлэх болно. Агро паркийн байгууламжуудаас гарах бохир усыг жижиг шугам сүлжээгээр цэвэрлэх байгууламжид хүргэнэ.

101. Өмнөговь сумын төвийг вакуум насос, хоолойгоор тоноглогдсон, муу усны нүхнээс бохир ус, лагийг соруулж авах 5м³-ийн багтаамжтай машинаар хангана. Энэ машинаар цуглуулсан бохирыг хүлээж авах, цэвэрлэх, зохистой байдлаар асгаж зайлуулах зориулалтын төхөөрөмжийг сумын БУЦБ-ын төсөлд тусгасан болно.

Дулаан хангмж:

102. Өмнөговь сумын төв дэх хувийн эзэмшлийн, нүүрсээр галладаг уурын зуух нь өвөл халаалтын улиралд ажилладаг ба олон нийтийн барилга байгууламжуудад дулааныг шугам хоолойгоор хүргэдэг. Халаалтын сүлжээнд холбогдоогүй айл өрхүүд нүүрс, мод, аргал түлж халаадаг энгийн зуух ашигладаг. Сумын төв дэх хувийн эзэмшлийн халаалтын системтэй холбогдсон ямар нэг арга хэмжээ АСХХОХ-ийн ээлжид төлөвлөөгүй. Агропарк нь сумын төвийн дулаан түгээх сүлжээнээс нэлээд зайтай байрладаг тул нүүрсээр ажилладаг жижиг оврын уурын зуух барих нь дулаан, халуун усаар хангах хамгийн хэмнэлттэй арга хэрэгсэл юм. Агропаркийн янз бүрийн байгууламжид үйлчлэх бетон суваг дээр дулааны хуваарилах хоолой суурилуулах болно.

Хатуу хог хаягдлыг цуглуулж зайлуулах:

103. Өмнөговь сумын төв дэх хог хаягдал цуглуулж, зайлуулж буй байдал нь Улаангомынхтой ижил төстэй бөгөөд хэдийгээр хэмжээний хувьд бага ч гэсэн асуудлыг байгаль орчны стандарт, практик шаардлагыг хангахуйц хэмжээнд хүртэл хурдан хугацаанд шийдвэрлэхэд дэндүү ахдаж байна. Өмнөговь сумын хог хаягдлын цэг нь сумын төвөөс өмнө зүгт 1.5км орчимд байрладаг бөгөөд хяналтгүй үйл ажиллагааны улмаас 50 га талбайг хамарч тэлжээ. Хогийн цэгийн талбайн ойр хавьд гадаргын ус байхгүй бөгөөд ерөнхийдөө тэгш задгай газар юм. Гүний ус 8-10м-ийн гүнд байх таамаглалтай бөгөөд талбайд очиж үзэх үед тэр хавьд зам, гүүрийн ажил хийж байсан компани хайрга авахаар ухсан хоёр гүн нүхийг хог хаягдлыг булах зориулалтаар ашиглана гэж төлөвлөж байсан. Хогийн цэгт ямар нэг хашаа, харуулын хэсэг байхгүй бөгөөд нөлөөлөлд өртсөн газрын ихээхэн хэсэг нь салхинд хийссэн хог хаягдал байна. Тэдгээрийг хурааж хумих, далдлах хүн хүч, тоног төхөөрөмж байхгүй байна.

104. Сумын төвд хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх тогтсон систем байхгүй, хог хаях асуудал нь оршин суугчдын өөрсдийнх нь үүрэг байдаг. Хог хаягдлын ихэнхи хувийг зуухны үнс эзлэх боловч мал нядалгаанаас гарсан хаягдлыг ахуйн хогтой хамт ил задгай хаяж байна.

105. АСХХОХ-ийн 1-р ээлж нь өнгөрсөн хугацаанд хяналтгүй хаягдсан хогийг цэвэрлэх, зайлуулах, газар нутгийг нөхөн сэргээх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой менежментийн системтэй болгох эхний үе шат байх болно. Энэ арга хэмжээ нь техникийн туслалцаа болон гүйцэтгэх ажлуудыг хосолсон байх болно.

- Хог хаягдлын төрөл, физик нөхцөл байдал (хөрс, гүний ус, газрын гадарга), одоо байгаа хог хаягдалд үндэслэн тухайн газрыг цаашид ашиглах төлөвлөгөөтэй уялдуулж нөлөөллийг нь арилгах, юм уу багасгах шаардлагатай ямар хор хөнөөл байгаа эсэх зэрэг өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлно. Үүний дүнд хогийн талбайг цэвэрлэх, сайжруулахад зориулсан арга хэмжээний зөвлөмж бэлдэх ба өрөмдлөг, гүний усны дээж авах, усны чанарын анализ хийх ажлууд үүнд орсон байна.
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэж хаях, зардал нөхөх механизм болон чадавхийг хөгжүүлэх хэрэгцээ, үе шаттайгаар цэвэрлэгээ хийх, нөхөн сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг орон нутгийн түвшинд эхлүүлэх
- Цаашид хог хаягдлын талбай болгон ашиглахаар тогтож буй газарт одоо байгаа хогийн талбайг нэгтгэх, эргэн тойронд нь нэвтрэх хяналт, хамгаалалтын цэг бүхий хашаа барих (5 га)
- Гүний усны бохирдол зэрэг нийгмийн эрүүл мэндэд учирч буй аливаа буруу дадал зуршлыг засахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлүүлэх.
- Хог дахин боловсруулж ашиглах чиглэлээр судалгаа хийх, боломжуудыг холбогдох зардал, үр ашгийн хамт тодорхойлж боловсруулах, үүнийг аймаг, бүс нутгийн хөтөлбөртэй уялдуулах
- 2, 3-р ээлжээр төвлөрсөн санхүүжилтээр хийгдэж болох шинэ барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах
- Одоо байгаа хогийн цэгийг цэвэрлэж эхлэх.
- Хотын төв ба гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх хэсэгт 50 ш хогийн сав тавьж 5 ачааны машинаар хатуу хог хаягдлыг цуглуулж ачих туршилтыг эхлүүлэх

2. Улаангом ба Өмнөговь, Тариалан сум дахь агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт

106. АСХХОХ-ийн 1-р ээлжээр Улаангом болон Өмнөговь, Тариалан (зөвхөн услалтын систем) сумын төвд дараах гурван төрлийн агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт хийгдэнэ.

- (а) Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд зориулсан олон нийтэд түшиглэсэн төсөл
- (б) Агро парк
- (в) Услалтын систем, тэжээлийн аж ахуй

а. Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд зориулсан олон нийтэд түшиглэсэн төслүүд

107. Мал аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор малчдад зориулсан олон нийтийн бичил төслүүдийг төслөөс санхүүжүүлнэ. Малчид нь дэмжлэг авахын тулд орон нутгийн Бэлчээр ашиглагчдын бүлгийн гишүүн байх ёстой. Бэлчээр ашиглагчдын бүлгийн гишүүд нь ажиллах хүчний болон эсвэл бэлэн мөнгө, эд материал өгөх замаар хувь нэмэр оруулна. Одоогоор бичил төслүүдийн байршил тодорхой болоогүй байна.

108. Санхүүжилтээр дэмжих олон нийтийн бичил төслийн төрлүүдийг дурдвал:

- Хадланд зориулсан хамгаалалттай нутаг: голын ойролцоох бэлчээрийн 15 га газрыг сонгон авч, чулуун хашаагаар хашна. Гадаргуугын усалгаа хийхэд зориулсан сувгийн далан, гол ба хуваарилах сувгийн голдирлыг тогтооно.
- Жижиг тоног төхөөрөмж, ачааны машин: бэлчээрийн менежментийг дэмжих зориулалтаар хөдөө аж ахуйн машин төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглогдсон жижиг оврын трактораар хангана.
- Хадлан, тэжээл хадгалах байр сав
- Мал самнах, ноос хяргах хэрэгсэл, төхөөрөмж, хадгалах байр савны хамт мөн ариутгал угаалгын онгоц.
- Малын хашаанд өвөл хэрэглэх салхи хаах саравч
- Усны худаг: шинээр 6 худаг барьж, хуучин 4 худгийг сэргээн засварлана.
- Мал угаалгын газар.
- Мал услах байгууламж.
 - Жижиг гүүр, голын гарам, шороон зам засах.

б. Агро парк

109. Улаангом болон Өмнөговь суманд байрлах агро паркууд нь хорио цээрийн бүс, мал төхөөрөх үйлдвэр, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээ, судалгаа шинжилгээний төв, бизнес төв, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдээс бүрдэх болно. Агро паркууд Улаангомоос хойд зүгт (Зураг 7), Өмнөговь сумын зүүн өмнө талд (Зураг 8) байрлана. Агро паркуудын барилга байгууламжуудыг дээр дурдагдсан хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалтаар хэсэгчлэн хангах болно.

i. **Хорио цээрийн бүс**

110. Агро паркийн хорио цээрийн бүсэд дараах байгууламж байна:

- Хяналтын лаборатори, үзлэгийн бүс
- Малын өвчнийг хянах зориулалттай хорио цээрийн бүс дэх мал тэжээх цэг


111. Хорио цээрийн бүс нь мал сүрэг хүрч ирэхэд хялбар байхуйц байршилд байх нь зүйтэй бөгөөд усалгааны хэсэг, мөн бүсийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тэжээл үйлдвэрлэх өвс тэжээлийн цэг рүү орж гарах боломжтой байх ёстой (доор үзнэ үү).

Figure 8. Улаангом дахь агро паркийн байршил



** ХАА-н багийн бэлтгэсэн зураг

Зураг 9. Өмнөговь сум дахь агро паркын байршил



** ХАА-н багийн бэлтгэсэн зураг

112. Улаангомьн Хорио цээрийн бүс дэх малын тэжээлийн цэг нь 1000 толгой мал багтаах хүчин чадалтай бөгөөд малын гоц халдварт өвчин гарсан тохиолдолд юм уу экспортын хэрэгцээнд зориулан хоёроос гурван долоо хоног тусгаарлах боломжтой. Бод, бог малд шаардагдах талбайн хэмжээ дунджаар нэг малд 10м² байх тул бүсийн болон тэжээлийн талбай нийтдээ 1га болно. Үүн дээр нэмж хяналт шалгалтын хэсэг, лабораторийн байрт 0.5га, малын хашаа саравчинд 0.5га, өвс, тэжээл хадгалах хашаанд 0.5га, мал төхөөрөх хэсэгт 0.5га, талбайд хөдөө аж ахуйн техник хэрэгслийн зогсоолын талбайд 0.5га-г тус тус гаргана.

113. Хорио цээрийн бүсэд 1000 толгой малыг хоёроос гурван долоо хоног тусгаарлах хугацаанд зарцуулах өвс, тэжээлийн нөөц хангалттай байх болно. 11-р хүснэгтэд өвс, тэжээлийн нийт нөөцийг 2,592 тн тооцсон ба үүнд зуны сүүлчээр нэг удаа хийх хадлангийн хэмжээг багтаасан.

Table 6. Hay and fodder storage requirements

	Өдрийн хэрэгцээ, кг	Малын тоо толгой	Хэрэглэх өдөр	Жилд хэрэглэх давтамж	Нийт хэрэгцээ (кг)
Бог мал	1.5	800	18	12	259,200
Бод мал	7	200	18	12	302,400
Нийт					561,600

** Хүснэгтийг ХАА-н багийн бэлтгэв

114. ХЦБ дэх өвс тэжээлийн цэг нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

- Хорио цээрийн болон тэжээлийн цэгийг тусгаарлах зорилгоор 1га талбайн гадуур 1.5м өндөртэй чулуун хашлага хийнэ
- 5000 м² талбай бүх цас, шуурганаас хамгаалах саравч
- Нийт 500 тоннын багтаамж бүхий өвс хадгалах давхарлагаатай агуулах (хэтрүүлж/замбараагүй хэрэглэхээс сэргийлэх зорилгоор)
- Малд тэжээл тавьж өгөх сав
- Мал услах ус, усан хангамжийн холболт.
- Ойролцоох засмал замтай холбох 2км авто зам
- Хөдөө аж ахуйн техник хэрэгслийн зогсоолын талбай
- Мал эмнэлгийн үзлэгийн төв, лабораторийн байр

115. Өмнөговь суманд мөн малын тэжээлийн цэг байгуулагдах боловч хүчин чадлын хувьд хоёр дахин бага байна. Үүнтэй адил Өмнөговь сумын агро паркийн хүрээнд ХЦБ-ийг нэгтгэнэ. ХЦБ болон тэжээлийн цэг нь 500 тооны малд зориулагдсан, 0.5га талбайтай байна.

116. Улаангомын ХЦБ-д мал эмнэлгийн үйлчилгээ, өвчин эмгэг, чанарын хяналт шинжилгээний үндсэн лабораторийн нэг хэсэг болох үзлэгийн лаборатори, малын хяналтын бүс багтана. Үндсэн лабораторийг агро паркад нэгтгэнэ. 2018 оноос Мал эмнэлгийн газар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас салсан тул шинэ офистой болох шаардлагатай болж байна. Офис болон лабораторийг агро паркийн нэг байранд нэгтгэнэ.

117. Өмнөговь сум дахь лабораторийг мөн сумын төвөөс захдуу байрлах агро парк дахь ХЦБ-ийн хүрээнд нэгтгэх ба үүнд мөн мал эмнэлгийн газар багтана.

118. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарал үүсэл тогтоох, эмнэлзүйн үйлчилгээ, ХЦБ-д явагдах үйл ажиллагаатай холбоотойгоор Улаангом болон Өмнөговь сум дахь мал эмнэлгийн газруудын үйл ажиллагаанд зориулж эмнэлгийн барилга барих, сайтар төлөвлөж тооцсон лаборатори, тоног төхөөрөмж, жижиг хэрэгслээр хангах шаардлагатай. Лабораторийн үндсэн тоног төхөөрөмжийг Хүснэгт 8-д үзүүлэв.

Хүснэгт 7. Лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн жишиг¹⁵.

	Нэр	Зориулалт	Шаардлагатай хэмжээ	
			Улаангом	Өмнөговь
Тоног төхөөрөмж				
1	Термостат	Дээж сорьц, шил хатаах	2 ш	1 ш
2	Автоклав	Багаж хэрэгсэл, шил ариутгах	2 ш	1 ш
3	LC tandem MS	Мах, хүнсний бүтээгдэхүүн дэх антибиотик, пестицид, шавьж устгагч хор зэрэг хорт бодисыг тодорхойлох	1 ш	-
4	NIR спектроскоп	Сүү болон бусад бодис дахь өөх тос, чийгшил, нүүрс ус, чихрийг тодорхойлох	1 ш	1 ш
5	Центрифуг	Төрөл бүрийн биологийн дээжээс тунадас ялгах	2 ш	2 ш
6	pH-хэмжигч	Дээжийн хүчиллэг байдлыг тодорхойлох	2 ш	2 ш
7	Микроскоп	Анализ шинжилгээ хийх	2 ш	2 ш
8	Мал эмнэлгийн төхөөрөмж бүхий машин	Явуулын лабораторийн үйлчилгээ	1 ш	1 ш
9	Эвхдэг хашаа	Мал эмнэлгийн арга хэмжээний үеэр мал хаших	7 ш	7 ш
10	Ариутгалын онгоц	Мал угаах, ариутгах зориулалттай	7 ш	7 ш

¹⁵ Хүснэгтийг төслийн ХАА-н баг бэлтгэв

	Нэр	Зориулалт	Шаардлагатай хэмжээ	
			Улаангом	Өмнөговь
11	Хамгаалалтын юүдэн	Асептик тусгаарлалтын зориулалтаар	1 ш	-

Жижиг хэрэгсэл

1	Хаяг, шошго	Цус болон биологийн бусад дээжид	40,000 ш	40,000 ш
2	Шошго хадгалах хайрцаг	Дээж хийж тээвэрлэх	40 ш	40 ш
3	Биологийн хуруун шил	Цусны дээжид	40,000 ш	40,000 ш
4	Ариутгасан зүү	Цус авах тариурт хэрэглэх	40,000 ш	40,000 ш
5	Зүүний тавиур	Цусны дээж авахад	400 ш	400 ш
6	Бээлий	Халдвараас сэргийлэх	500 box	500 box
7	Лабораторийн хамгаалалтын хувцас	Халдвараас сэргийлэх болон ариутгалын ажилд	1000 ш	1000 ш
8	Галзуу өвчнийг хурдан шалгах лабораторийн иж бүрдэл	Хөдөө орон нутагт туршилт хийхэд	40 ш	40 ш
9	Үхрийн боом өвчнийг хурдан шалгах лабораторийн иж бүрдэл	Хөдөө орон нутагт туршилт хийхэд	40 ш	40 ш

Сургалт, чадавхи бэхжүүлэх арга хэмжээнд зориулж

1	Зөөврийн компьютер	Хөдөө орон нутагт мэдээлэл боловсруулах	1 ш	1 ш
2	Суурин компьютер	Офист мэдээлэл боловсруулах	1 ш	1 ш
3	Дэлгэцийн проектор	Мэдээлэл танилцуулах	1 ш	1 ш
4	Микрофон	Мэдээлэл боловсруулах	1 ш	1 ш
5	Өнгөт хэвлэгч	Мэдээлэл хуваалцах/түгээх	1 ш	1 ш
6	Өргөн дэлгэц	Мэдээлэл хуваалцах/түгээх	1 ш	1 ш

(i) Усны хэрэгцээг

119. Улаангом дахь ХЦБ-ийн усны хэрэгцээг ундны усны хувьд хоногт 2.6м^3 , боловсруулалтад хэрэглэх усыг хоногт 50м^3 -ээр тооцлоо. Мах боловсруулах үйлдвэр

ii. Мах боловсруулах үйлдвэрүүд

120. Улаангомд мах боловсруулах гурван цэг ажилладаг ба хоёр цэгийг барьж байна. Одоо байгаа мах боловсруулах газрууд өдөрт ойролцоогоор 600 толгой мал хүлээн авах хүчин чадалтай боловч тэдгээрийн аль нь ч бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй байна. Энэхүү төсөл нь ХЦБ-ийн ойролцоо мах боловсруулах үйлдвэр байгуулахад нь хувийн хэвшилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх юм. Боловсруулах үйлдвэрийн хүчин чадал нь өдөрт 150 бод, 600 бог мал байх бөгөөд жилд 8 сар ажиллана.

(i) Усны хэрэгцээ

121. Улаангом дахь мах боловсруулах цэгийн усны хэрэгцээг ундны усны хувьд хоногт 105м^3 , мах боловсруулалтад хэрэглэх усыг оруулаад нийтдээ хоногт 210м^3 -ээр тооцлоо.

122. Өмнөговь суманд зохих ёсоор ажилладаг мах боловсруулах үйлдвэр байхгүй. Малыг ил задгай газар нядалдаг. Энэхүү төсөл нь байгаль орчныг хамгаалах талаарх олон улсын стандарт дүрмийн дагуу ажиллах хадгалах, ангилах өрөө бүхий жижиг хэмжээний мах боловсруулах цэг байгуулах юм. Боловсруулах цэгийн хүчин чадал нь өдөрт 150 толгой мал (бод, бог нийлээд) байх бөгөөд жилд 8 сар ажиллана. Боловсруулах цэгийг ХЦБ-ийн ойролцоо, агро паркад байгуулна

(ii) Усны хэрэгцээ

123. Өмнөговь дахь мал төхөөрөх цэгийн усны хэрэгцээг мах боловсруулалтыг оруулахгүйгээр хоногт 30м^3 (мах боловсруулалтад хэрэглэх усыг оруулбал хоногт 60м^3) байхаар тооцлоо.

(iii) 1-р ээлжээр хийгдэх мах боловсруулах, савлах үйлдвэрт тавигдах олон улсын стандарт

124. Улаангом болон Өмнөговь сум, мөн бусад аймаг сумын төвүүдэд байх мах боловсруулах, хадгалах байгууламжийн зураг төслийг хийхдээ ашиглалтын болон байгаль орчныг хамгаалах асуудлын хувьд НҮБ-ын ХХААБ (1988), ДЭМБ-ын (1984) стандартад нийцүүлж гүйцэтгэнэ. 1-р ээлжид хийгдэх бүх мах боловсруулах үйлдвэрүүд олон улсын зах зээлд борлуулж чадахуйц чанартай мах үйлдвэрлэхийн тулд олон улсын үндсэн гол стандартуудыг дагаж мөрдөнө. АСХХОХ-өөр хэрэгжүүлэх мах боловсруулах үйлдвэрүүдэд дараах дөрвөн үндсэн стандартыг мөрдөх болно. Үүнд: (i) CAC / RCP 58-2005; (ii) ISO / FSSC 22000; (iii) HACCP систем; (iv) Исламын бүгд найрамдах Иран улс, Казахстан зэрэг исламын улсуудын хувьд HALAL гэрчилгээ.

Улс орны зах зээл бүр хүнсний бүтээгдэхүүний дотоод хангамжийн сүлжээнд дагаж мөрдөх хүнсний чанар, аюулгүй байдлын талаар өөрсдийн зохицуулалт, стандарттай байдаг ч дэлхийн хэмжээнд хүнсний үйлдвэрлэл, тараах, экспортлох чанар, аюулгүй байдлыг зохицуулж, хангах CAX (Codex Alimentarius Commission), ISO (Олон улсын стандартчиллын байгууллага), OIC (Исламын бага хурлын байгууллага) зэрэг олон улсын байгууллагууд байдаг. Дээрх дөрвөн стандартын хамрах хүрээг дор товч өгөв.

CAC/RCP 58-2005

Улс орны зах зээл бүр хүнсний бүтээгдэхүүний дотоод хангамжийн сүлжээнд дагаж мөрдөх хүнсний чанар, аюулгүй байдлын талаар өөрсдийн зохицуулалт, стандарттай байдаг ч дэлхийн хэмжээнд хүнсний үйлдвэрлэл, тараах, экспортлох чанар, аюулгүй байдлыг зохицуулж, хангах CAX (Codex Alimentarius Commission), ISO (Олон улсын стандартчиллын

байгууллага), OIC (Исламын бага хурлын байгууллага) зэрэг олон улсын байгууллагууд байдаг. Дээрх дөрвөн стандартын хамрах хүрээг дор товч өгөв.

ISO/FSSC 22000

ISO 22000: 2018 буюу "Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" нь хүнсний сүлжээнд багтдаг аливаа байгууллагын хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны шаардлагыг зааж өгдөг. Энэ стандартаар хүнсний аюулгүй байдлын хор хөнөөлийг хянах, хоол хүнсийг хэрэглэхэд аюулгүй байлгах нөхцлийг хангаж чадаж байгаа эсэхийг харуулахын тулд тухайн байгууллага ямар ажил хийх ёстойг тодорхойлдог. ISO 22000 нь хүнсний эрүүл ахуйн CAC/RCP зарчмууд дээр суурилдаг бөгөөд хяналтын байгууллагуудын зүгээс хүнсний аюулгүй байдлын бүх шалгуурыг хангасан эсэхийг баталгаажуулахдаа удирдамж болгох, ISO 22000-ийг үндэсний стандарт шаардлагадаа тусгаж хэрэглэх боломжийг олгодог.

FSSC 22000 буюу "Хүнсний аюулгүй байдлын системийн гэрчилгээ" нь хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад Дэлхийн Хүнсний Аюулгүй Байдлын Ажиллагааны (GFSI) байгууллагаас хүлээн зөвшөөрсөн ISO-д суурилсан хүнсний аюулгүй байдлын менежментийн системийн гэрчилгээ олгох тогтолцооны систем юм. FSSC 22000 систем нь хүнсний аюулгүй байдалд зориулсан менежментийн системийн аргыг ашигладаг ба үүндээ ISO22000 болон ISO-ийн техникийн стандартыг (програмын урьдчилсан нөхцөл) хэрэглэдэг. Мах боловсруулах үйлдвэрүүд ISO/FSSC 22000 стандартын дагуу мах боловсруулах, үйлдвэрлэх дараахь элементүүдийн шаардлагыг харгалзан үзэх шаардлагатай.

- Удирдлагын үүрэг хариуцлага:
- Нөөцийн менежмент:
- Аюулгүй бүтээгдэхүүнийг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог баталгаажуулах, хянах, сайжруулах:

НАССР систем

НАССР систем нь хоол хүнс үйлдвэрлэх, хадгалах, борлуулах бүх үе шатанд тэдгээрийн анхны орц найрлагаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн болох хүртэл нь хяналт тавих шинжлэх ухаанд суурилсан систем юм. Хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлсийн хяналтад түшиглэн болзошгүй аюулыг тодорхойлдог ба эцсийн бүтээгдэхүүнд шинжилгээ хийхээс илүүтэйгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг. Энэ систем нь долоон зарчим ба 12 алхамаас бүрдэнэ. НАССР үзэл баримтлал нь бэлэн бүтээгдэхүүний бэлэн байдлыг хянах, хянах тогтолцоо нь хүнсний аюулгүй байдлын гэрчилгээ авах чадваргүй гэсэн ойлголтыг бий болгосноор дэлхийн стандартад нийцсэн болов. НАССР системийн дагуу мах боловсруулах үйлдвэрүүд дараахь үйл явц, үйл ажиллагааны элементүүдийн шаардлагыг харгалзан үзэх шаардлагатай.

- | | |
|--|--|
| <ul style="list-style-type: none">• Урьдчилсан шаардлага:• НАССР төлөвлөгөөний хамрах хүрээ• Бүтээгдэхүүний тодорхойлолт ба зориулалтын хэрэглээ | <ul style="list-style-type: none">• Аюулын хариуцлага• Баталгаажуулсан Хүнсний аюулгүй байдлын зорилт (ХАБЗ)• Аюултай байдлын хяналтын цэгийг (АБХЦ) тодорхойлох |
|--|--|

- Хүнсний аюулгүй байдлын зорилтын эхний үйл явцыг тогтоох
- Үйлдвэрлэлийн явцын диаграмыг гаргах
- Ажлын байрны тодорхойлолт
- Түүхий эдийн аюулыг тодорхойлох
- Аюулгүй байдлын алхамыг тодорхойлох
- Аюултай байдлын эцсийн хязгаар тогтоох
- АБХЦ-ийн хяналт
- Залруулах арга хэмжээг тохируулах
- НАССР төлөвлөгөөний баталгаажуулалт
- Баримтжуулах ба бүртгэл хөтлөх

ХАЛАЛ гэрчилгээ

Исламын бүгд найрамдах Иран улс, Ирак, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират, Малайз, Индонез, Хятад, Азербайжан, Казахстан зэрэг улсуудын зарим мужууд зэрэг лалын шашинтай орнуудад мах, махан бүтээгдэхүүнийг экспортлохын тулд Исламын шариатын заалтын дагуу мал амьтныг Халал аргаар нядлах ёстой.

Бүх хууль ёсны хуурай газрын амьтдыг САС/GL 24-1997 буюу "Халал" гэсэн нэр томъёог хэрэглэх ерөнхий удирдамж", мөн GS 993/1998 буюу "Исламын хуулийн дагуу мал нядалхад тавигдах шаардлага" -д заасны дагуу нядалж байх ёстой. САС / RCP 58-2005-д заасан дүрэм ба дараах шаардлагыг хангасан байх шаардлагатай.

- Нядалгаа хийх хүн нь исламын нядалгааны дэглэмийн талаар мэдлэгтэй, эрүүл оюун ухаантай, лалын шашинтан байх ёстой.
- Нядлах гэж буй амьтан Исламын хуулийн дагуу хууль ёсны байх ёстой.
- Нядалгаа хийх гэж байгаа амьтан нядалж байх үед амьд байх эсвэл амьд гэж тооцогдсон байх.
- Мал амьтныг нядалж эхлэхээс өмнө "Бисмилла" (Аллахын нэрээр) гэж мөргөх ёстой.
- Нядалгааны хэрэгсэл нь хурц байх ёстой бөгөөд нядалгааны үед малаас салгах ёсгүй.
- Нядалгаагаар мөгөөрсөн хоолой, улаан хоолой, хүзүүний хэсэг дэх гол артери ба венийн судсыг шууд таслах ёстой.

iii. Боловсруулах үйлдвэр, хадгалалт, бизнесийн инкубацийн үйлчилгээ

125. Агро паркийн төлөвлөсөн бусад чиг үүрэг нь жижиг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийг дэмжихэд чиглэнэ. Агро парк нь бизнесийн болон агро үйлдвэрлэлийн боломжуудын маш олон төрлийн санааг хөгжүүлж, үүгээрээ орон нутгийн агро-үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөгөөг дэмжиж туслах болно гэж үзэж байна. Боловсруулах үйлдвэрийн жишээнд сүү цагаан идээний ферм, хүлэмж, хүнсний ногоо боловсруулах, нэхий боловсруулах (арьс боловсруулах бус), ноос боловсруулах үйлдвэр орно.

(i) Усны хэрэгцээ

126. Агро паркад төлөвлөж буй боловсруулах үйлдвэрүүдэд шаардагдах усны хэмжээг Хүснэгт 9-д нэгтгэв.

Хүснэгт 8. Агро паркийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд шаардлагатай усны тооцоот хэмжээ

Ноосны үйлдвэр	Нэхий боловсруулах үйлдвэр	Сүү цагаан идээний ферм	Хүлэмжийн аж ахуй	Хүнсний боловсруулах ногоо
Хэрэглээний ус: 1 т бүтээгдэхүүнд 1.0 м ³ , Ундны ус: 1000 л/хоног	Хэрэглээний ус: 0.1 м ³ /т, ундны ус: 100 л/хоног	Ундны ус: 1м ³ сүүнд 1.5м ³	Хэрэглээний ус: 1.0 л/м ² , ундны ус: 100 л/хоног	1 т бүтээгдэхүүнд 1.0 м ³

iv. Агро паркуудын байгаль орчны менежментийн систем

127. Аймаг, сумын удирдлагаас Улаангом, Өмнөговь дахь агро паркуудад Байгаль орчны менежментийн систем (БОМС) боловсруулах шаардлагатай. БОМС нь орон нутгийн байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалахад чиглэсэн журам, удирдамжаас бүрдэнэ. БОМС-ийг боловсруулахад ТХХТЗ тусалж дэмжих болно. БОМС нь төслийн зээлийн гэрээний нэг хэсэг байна.

с. Усалгаатай талбай, тэжээлийн аж ахуй

i. Улаангом – Тариалан сум

128. Улаангомоос зүүн өмнө зүгт байх Тариалан сумын 500 га тэжээлийн аж ахуйд зориулсан одоо байгаа услалтын системийг сэргээн засварлана (Зураг 10). Энэ нь социалист системийн үед томхон усалгаатай талбай байсан. Газар хүртээмжтэй, одоо байгаа засмал зам болон цахилгаан хангамжид ойрхон орших мөн Улаангомд ойр байршилтайг харгалзан үзээд Тариалан сумын Тээлийн голын сав газар болох Хөх-Үхэртэд 500 га газрыг сонголоо. Услалтын систем нь усыг Тээлийн голоос толгойн барилгаар салаалж, 7.5 км гол сувгийн дагуу өөрийн урсгалаар тариалангийн талбай руу хүргэнэ. Услалтын системийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

- Толгойн барилга, услалтын гол сувгийг шинэчлэн сайжруулж, тоног төхөөрөмж суурилуулна (шлюзийн хаалт г.м.);
- Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулна;
- Сонгосон 500 га талбайд усалгааны схемийг боловсруулахад нь хувийн хэвшилд (хоршоо буюу хувийн компани) санхүүгийн дэмжлэг (хөнгөлөлттэй зээл) үзүүлнэ

Зураг 10. Улаангомоос зүүн урагш орших тариалан сумын усалгаатай тариалангийн талбай



** Map provided by project agricultural team

Талбайн нөхцөл байдал:

129. Услалтын талбайн хөрсний физик, химийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Хөрсний давсжилт бага (0.04%) бөгөөд энэ нь уг хөрс зохих технологийн дагуу газар тариалан эрхлэхэд тохиромжтой гэдгийг харуулж байна. Хөрсөнд агуулагдах гурван үндсэн тэжээл болох азот, фосфор, калийн (N - илрээгүй) түвшин бага байгаа нь органик бус бордоо, түүнчлэн ээлжлэн тариалалтад царгас зэрэг буурцагт ургамал ашиглах шаардлагатайг харуулж байна.

130. Хөрс нь элсэрхэг хүрэн бөгөөд 0.25-0.05 мм-ийн ширхэглэл бүхий хуурай газрын бэлчээрийн хөрс 45.5% ($\pm 3.7\%$); фосфатын (P) түвшин $11.8 \pm 1\text{мг/кг}$; ялзмаг нь 15-20 см. Хөрс нь шүлтлэг (pH 8.14). Ялзмагт найрлагын түвшин бага (0.92%) байгаа нь нь малын өтөг бууцаар хийсэн компост зэрэг органик бордоо зайлшгүй шаардлагатайг илтгэнэ. Эрдэс бодисын ойролцоо найрлага нь: кальци (Ca) = $13.4 \pm 1.5\text{мг} / 100\text{г}$, магни (Mg) = $7 \pm 0.9\text{мг} / 100\text{г}$, кали (K) = $39.4 \pm 2.8\text{мг} / 100\text{г}$ байна. Ca/Mg= 2 байгаа нь хөрсний үржил шимийг органик бус кальци (гипс юм уу шохой), кали дээр суурилсан бордоогоор сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Төлөвлөж буй арга хэмжээ:

131. Тээлийн голоос усыг толгойн барилгаар салаалуулан татаж өөрийн урсгалаар тариалангийн талбайд хүргэх ба хаалт/боолт, усалгааны машин холбосон ил болон далд бетонон сувгаар урсах болно. Услалтын систем дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- Толгойн барилга, ил болон далд байх бетон гол суваг
- Тээлийн голын сав газрын усны хэрэглээний менежментийн төлөвлөгөө

- 5 далавчтай усалгааны машин
- Хөрс, газар тариалангийн ажилд зориулж хөдөө аж ахуйн техник хэрэгслээр тоноглогдсон 2 трактор.
- 1000 тонн багтаамжтай дарш бэлтгэх төхөөрөмж.
- Тэжээл, дарш хадгалах барилга
- Хөдөө аж ахуйн машин механизмын зогсоолд зориулсан гарааш бүхий хашаа
- 500 га талбайд хийх усалгааны схем, усалгааны машин механизмын санхүүжилт

Тариалахаар санал болгож буй ургамал:

132. Услалтын систем болон тэжээлийн аж ахуйн зорилго нь ХЦБ болон малчдыг малын тэжээлээр хангах явдал юм. Усалгаатай талбайд овъёос, арвай, улаан буудай, эрдэнэ шиш, шош/вандуй, царгас зэрэг малын тэжээлд ашиглах үр тариа, буурцагт ургамлыг хамтад нь тарьж ургацыг нь нэгтгэж тэжээл үйлдвэрлэнэ.

133. Санал болгож буй таримал ургамлуудыг хөрсний органик бүтцийг сайжруулах зорилгоор олон наст царгасны тариалалтын хуваарьт үндэслэн таван жилийн хугацаатай эргэлтийн схемээр тариална. Хогийн ургамлыг арилгах, хөрсийг зөөллөх зорилгоор төмсийг тариалангийн эргэлтийн схемд оруулна. Таван жилийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу талбайг Хүснэгт 10-т заасны дагуу 5 ээлжид хуваана. Эхний ээлжинд царгас, дараа нь эрдэнэ шиш тариалах ба үүний дараа улаан буудай, арвайг ээлжинд оруулна. Төмсийг тариалангийн талбайд сүүлчийн ургамлын өмнө тариална. Эргэлтийн хамгийн сүүлийн ургамал нь овъёос байна. Услалтын талбайн шаардлагатай хэмжээг 500 га байна гэж тооцоолсон. Дарш хийхээр төлөвлөж буй ургацын хэмжээ 3100 тонн, хуурай үр тариа 200 тонн байна.

Хүснэгт 9. Ээлжилж тариалах болон малын тэжээлд хэрэглэх ургамал

Тариалах ургамал	Зориулалт	Талбайн хэмжээ (га)	Ургац (т/га)	Нийт ургац (т)
Царгас	дарш	100	2	200
Эрдэнэ шиш	дарш	100	25	2500
Улаан буудай, арвай	Хуурай үр	50	2	100
	тариа			
	дарш	50	4	200
Төмс	Үр тариаг ээлжлэхэд	100	-	-
Овъёос	Хуурай үр	50	2	100
	тариа			
	дарш	50	4	200
Нийт	-	500	-	3300

** Хүснэгтийг төслийн ХАА-н баг бэлтгэв.

(i) Усны хэрэгцээ

134. Тариалан сумын 500 га усалгаатай тэжээлийн аж ахуйд шаардагдах усны хэмжээг 0.315 м3/сек байна гэж тооцов. Усны хэрэгцээ, Тээлийн голын усны тогтвортой, улирлын чанартай хүрэлцээг нарийвчилсан зураг төслийн үе шатанд судалж, эцэслэн тогтооно.

ii. 1-р ээжлийн бүх услалтын системүүдийн байгаль орчны хамгаалал

135. АСХХОХ-ийн бүх услалтын системүүд нь тариалангийн талбайгаас үүдэлтэй бохирдлоос гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн хийц, шийдлүүдтэй байх болно (БОМТ үзнэ үү). Агро паркийн төслийг боловсруулж хэрэгжүүлэхэд шаардлагатай Байгаль орчны менежментийн системийн (БОМС) нэг хэсэг болохын хувьд АСХХОХ-ийн СЗЗ-ээр хувийн хэвшлийнхэнд олгох бүх хөнгөлөлттэй зээлд БОМС-д заасан ХАА-Байгаль орчны аюулгүй байдлыг чанд мөрдөх нөхцөл тавигдсан байна. БОМС-ийг боловсруулах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг болох үүднээс төслийн агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсэгт агро-экологийн өргөн хүрээ бүхий гүнзгийрүүлсэн сургалтыг (онол болон газар дээр нь хяналт хийх г.м.) хамруулсан ба энэ нь АСХХОХ-ийн чадавхийг нэмэгдүүлэх бүрэлдэхүүн хэсэгт орно. Байгаль орчны тусгай хамгаалалтуудыг дараах байдлаар нэгтгэн харуулав.

(i) Хөрс хамгаалах хадгалах

- усалгаатай тэжээлийн талбайнуудаас гарах урсац гол руу буцаж орохоос урьдчилан сэргийлэх, түүнийг цуглуулах зорилгоор нийт талбайн гадуур өвс ургамлаар хучигдсан суваг хонхорыг хийж өгөхөөр зураг төсөлд тусгасан болно. Мөн түүнчилэн хуурай улиралд тариан талбайгаас салхинд хийсэх тоос шорооноос сэргийлэх үүднээс суваг хонхрын налуугаар салхины хамгаалалт болгож мод бут тарина. Усалгааны дараа тариан талбайгаас гарах аливаа урсацыг дээрх мод бут бүхий сувгийг дуslaар услах зориулалтаар сувагт цуглуулна.
- Услалтын систем бүхий тариалангийн талбай, түүний ойр орчмын газрыг үерээс хамгаалах, хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хамгаалалтын болон талбайг захалсан далан, дренаж хийнэ.
- Тариалангийн талбайн эргэн тойронд хамгийн багадаа 25 метр өргөнтэй, үр дүнтэй ажиллаж чадахуйц салхинаас хамгаалах ойн зурвас хийнэ. Хамгаалалтын зурвас нь (i) усалгаатай тариалангийн талбай болон түүний эргэн тойрны газрыг салхины элэгдэлээс хамгаалах үндсэн үүрэгтэй (ii) талбайгаас гарах усны шүүлтүүр болох бөгөөд илүүдэл эрдэс бодис, тариаланд хэрэглэсэн бусад орцыг шингээнэ (iii) амьдрах орчин бий болсоноор биологийн олон янз байдал нэмэгдэж, хортон шавьж, өвчний биологийн хяналтыг нэмэгдүүлнэ. Салхинаас хамгаалах ойн зурваст өндөр, дунд зэрэг, намхан ургадаг жимсний мод, бут сөөг зэрэг модлог ургамлуудыг тарих ба нутгийн малчид, орон нутгийн иргэд жимс, жимсгэнийг нь түүж хурааж хэрэглэж болно.
- Салхинаас хамгаалах бут сөөг бүхий зурвасыг мөн тариалангийн талбай дотор буюу тариалсан ургамлуудын эгнээ хооронд хийх ба хамгийн багадаа 100 га тариалсан талбайд 1 га хамгаалалтын зурвас байхуйц харьцаатай байна.
- Тариалалтыг 5 жилээр ээлжлэх схемээр гүйцэтгэх ба хөрсийг биологийн аргаар суллаж, нягтралыг задалдаг үндэст ургамал оруулж тариална., Хэн хэндээ харилцан ашигтай байхуйцаар бусад тариалан эрхлэгчидтэй хамтран ажиллах схем гаргаж хэрэгжүүлбэл энэхүү ээлжлэн тариалах схем улам үр өгөөжтэй байх болно.

- Сүрэл, хивэг, эрдэнэ шишийн гол гэх мэт тариалсан ургамлын үлдэгдлийг хүчтэй бороо, салхины элэгдэлээс хөрсийг хамгаалахын дэвсгэр материал болгон ашигласнаар хөрсний органик бодисыг баяжуулахын зэрэгцээ ууршилтыг багасгах замаар усны менежментийг сайжруулж болно.
- Нимгэн үеэр хагалгаа хийх, налуугийн хагалгаа зэрэг хөрсөнд бага нөлөөлөх механик аргуудыг тариалалтдаа хэрэглэдэг аж ахуйн нэгж, компанийг нөхцөлт зээлд хамрагдахад нь түлхүү авч үзэх.

(ii) Усыг зүй зохистой хэрэглэх, усны бохирдлыг бууруулах

- Услалтын системийн бүх сувгийг (гол ба туслах суваг, сувгийн ёроол ба налуу) ус үл нэвтрэх мембранаар доторлож нэвчих, шүүрэх замаар ус алдагдахаас сэргийлнэ.
- Ус хэмнэж ажилладаг усалгааны техникийг илүүтэй ашиглах. Үнэлгээнд зөвхөн услалтын технологийг нарийвчлан авч үзээд зогсохгүй мөн усны хэрэглээ, ууршилтыг багасгахад нөлөөлөх тариалалтын цогц арга хэмжээг анхаарч авч үзэх болно.
- Ган болох тохиолдолд усалгааг зөвхөн голын урсац болон тариалсан ургамал гандаж хатаж ширгэхээс сэргийлсэн норм хэмжээнд л явуулна.
- Энэ арга хэмжээний шийдвэрийг Гол мөрний сав газрын зөвлөлөөс гаргах бөгөөд зөвлөл нь ус цаг уурын судалгаа, гидрологи, гидрогеологи, усны чанар болон зэргэлдээ орших усан сангийн байгаль орчны нөхцөл байдлын талаарх мэдээллийг Ус цаг уур орчны шинжилгээний газраас (УЦУОШГ) авч ажиллана.
- Усалгаатай талбайн эргэн тойронд болон дотор талд байгуулах салхинаас хамгаалах ойн зурвасыг дуслын усалгааны системээр усална.
- Усалгааны илүүдэл хэсгийг гол, нуур цөөрөм рүү буцааж оруулахгүй харин тариалангийн талбайн доод хэсэгт байгуулах шингээлтийн дэвсгэр талбай руу ургамалжуулсан суваг/шуудууны сүлжээгээр дамжуулж хүргэх болно. Ингэснээр (i) усалгаатай талбайгаас гарах илүүдэл усыг цуглуулна (ii) илүүдэл эрдэс бодис, тариаланд хэрэглэсэн бусад орцыг шингээгч шүүлтүүр байдлаар ажиллана (фито-цэвэршүүлэлт); (iii) усны нэвчилт, ууршилтыг сайжруулна (iv) хөрсийг тогтворжуулна (v) биологийн олон янз байдалд дэмжлэг үзүүлэх болно.
- Газар тариалангийн ажлын явцад гадаргын болон гүний усыг бохирдуулахгүй байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд гадаргын болон гүний усны хяналт, үнэлгээний системийг УЦУОШГ-аас хэрэгжүүлнэ. Жил бүр Усалгаатай талбайгаас доош орших голын уснаас жил бүр дээж (ургамлын туузнаас гарах, голын эрэг, доошоо уст давхаргын дагуу) авч шинжлэх ба услалтын системээс дээшхи усны чанарын үзүүлэлттэй харьцуулна. Усны чанарын олон жилийн өөрчлөлт, хуримтлагдсан байж болзошгүй бохирдлыг үнэлэхийн тулд бүх мэдээллийг өмнөх жилүүдэд цуглуулсан өгөгдөлтэй харьцуулна. Эхний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг Услалтын системийг ашиглалтад оруулахаас өмнөх жилд гүйцэтгэх ба цаашид суурь мэдээлэл болгож ашиглана.

) Хогийн ургамал, хортон шавьж, өвчний хяналт, менежмент

- Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга туршлагыг хэрэглэдэг аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжийг хөнгөвчилнө. Монгол Улсын Засгийн газар улсын хэмжээнд тэжээл үйлдвэрлэхэд хэрэглэж буй хортон шавьж устгагч

татаасаар олгодог. Харин Монгол орны баруун бүс нутаг нь (i) газар зүйн хувьд өндөрлөг, цаг уурын онцлог байдлаас хамаарч тариалангийн ургамал хортон шавьж, өвчинд өртөх байдал бага; (ii) газар тариаланд хэрэглэдэг химийн бүтээгдэхүүнд маш эмзэг мэдрэмтгий өвөрмөц экосистем, гидрологийн систем, тэдгээртэй холбоо бүхий ан амьтантай (ялангуяа усны амьтан, ургамал) гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрч байна. АСХХОХ-ийн чадавхийг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсэгт органик хогийн ургамал, хортон шавьж, өвчний эсрэг тэмцэх менежмент болон дадлага туршлагыг сургаж түгээх ба ялангуяа урьдчилан сэргийлэх практик туршлагад онцлон анхаарал хандуулах болно.

- Ган болон хүйтэнд тэсвэртэй үр хэрэглэх шаардлага тавигдана. Ижил төстэй цаг уурын нөхцөлд (жишээ нь Орос, Хятад) тариалдаг тэсвэртэй сортын үр, тэр дундаа монголд тариалдаг үрийг илүүтэй авч үзнэ.
- Биологийн бодисыг илүү хэрэглэх байдлыг дэмжих, их хэмжээний бохирдол үүсэхээс сэргийлэхийн тулд ээлжлэн тариалах (хамгийн багадаа 5 жил), хослуулж тариалах төлөвлөгөөг заавал дагаж мөрдөнө. Нэг төрлийн ургамал дагнаж тариалахыг зөвшөөрөхгүй.
- Урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилгоор хэрэглэх биологийн болон химийн бүтээгдэхүүнийг (тухайлбал тэжээлийн ургамлын мөөгөнцрийн өвчинд хэрэглэдэг MULS-ийн боловсруулсан Mycete-ийн суурьтай уусмал, Bordeaux хольц г.м.) зөвхөн Монгол Улсын Органик газар тариалангийн тухай хуульд заагдсан тохиолдолд хэрэглэхийг зөвшөөрөх бөгөөд холбогдох стандартад заасан орцын дагуу хэрэглэх шаардлагатай. Үлдэгдэл химийн молекулыг усалгаатай талбайгаас доош татсан ургамалжуулсан сувгаар шүүнэ.
- Хогийн ургамлыг ихэвчлэн хуурамч үрийн дэвсэг, механик аргаар устгах зэрэг механик аргаар хянана.

(iv) Бордоо ашиглах

- Бордооны орц, хэрэглээ, менежментийг дараах нөхцөл, стандарт шаардлагуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд (i) Олон улсын стандартчиллын байгууллагын бордоо, хөрсний агааржуулагч, ашигтай бодисын шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэх; (ii) Бордоог тогтвортой ашиглах, зохицуулах олон улсын ёс зүйн дүрэм (НҮБ-ХХААНБ, 2019); (iii) Монголын газар тариаланд хэрэглэх бүтээгдэхүүний зах зээлийн зохицуулалтын журам, Стандартчилал, магадлан итгэмжлэлийн тухай хууль (2003); Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (2013), Органик хоол хүнсний тухай хууль (2013).
- Хөрсний найрлага, шинж чанарыг үнэн зөв мэдээлэх, тариалсан ургамалд шаардагдах бордооны хэрэгцээг тодорхойлох, бордоог хэт их хэрэглэхээс зайлсхийхийн тулд найдвартай үнэн зөв шинжилгээг жил бүр хийж байна.
- Хорио цээрийн бүс, мах боловсруулах үйлдвэрийн бохир усыг ашиглах замаар компост бордоо үйлдвэрлэхэд доод тал нь хоёр жил шаардлагатай байдаг тул бордооны хэрэгцээг хангахуйц хэмжээний компост үйлдвэрлэх хүртэл химийн бордоог ашиглахыг зөвшөөрнө. Органик бус бордооны орцын хэмжээг жилд нэг га талбайд 112 кг N.P.K гэж тооцно (500 га талбайд 56 тонн, 200 га талбайд 22.4 тонн).

- Компост бордоог (2 жилийн хадгалалттай малын бууцан бордоо) хангалттай хэмжээгээр гаргаж авсан үед (тооцоогоор 3 дахь жилд) хөрсний бордолтод дээд тал нь нэг га талбайд 60 тн хүртэл хэмжээгээр ашиглана.
- Хөрсний шинжилгээний дүнгийн дагуу хөрсний pH-ийг сайжруулахын тулд шохойжуулалт хийх бөгөөд pH хэмжээг +0.5 -аар нэмэгдүүлнэ.

III. ТАРИАЛАН СУМЫН ТОХИРУУЛГАТАЙ УСЛАЛТЫН СИСТЕМ

Үндэслэл:

Ус цаг уур, орчны шинжилгээний газраас сүүлийн далан жилийн хугацаанд цаг уурын дараах чухал өөрчлөлтүүдийг бүртгэн авчээ. Үүнд:

- Жилийн дундаж температур 2.26°C хэмээр өссөн,
- Хүйтэн өдрийн тоо 15-аар буурч, зуны өдрүүд 19-өөр нэмэгдсэн,
- Баруун бүсийн нутгийн мөсөн голын талбайн хэмжээ 535 км²-аас 375 км² болж багассан,
- Зудын нөхцөл улам хүндэрсэн байна.

136. 2014 оноос хойш БОАЖЯ-наас Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 29 усны сав газарт хэрэгжүүлэх усны нөөцийн нэгдсэн менежментийн төслийг боловсруулсан. БОАЖЯ-ны дараачийн санал нь Өндөр уулын усны менежмент (ӨУУМ) бөгөөд үүгээр мал аж ахуй, бэлчээр, газар тариалан, ахуйн хэрэглээ зэрэг уснаас ихээхэн хамааралтай байдаг эмзэг бүлгийн хүмүүст уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох байдлыг бий болгохыг зорьж байна. ӨУУМ нь Монгол Улсын усны тухай хуульд нийцэж байгаа болно. Тариалан сум дахь ӨУУМ-ийн ТЭЗҮ-ийг боловсруулж дуусч байгаа бөгөөд гол зорилт нь мөсөн голын хайлж урсаж буй их хэмжээний ус болон борооны улирлын үеэр ус хадгалах хүчин чадлыг бий болгох явдал юм.


- Голын урсацыг үргүй алдахаас зайлсхийх;
- Цутгал голын усыг хүлээн авагч усны биет, тухайлбал Увс нуурын эко системийг хадгалах зорилгоор усны урсгалыг зохицуулах,
- Цутгаж орж буй голын урсац гүехэн Увс нуур нуурын усны ууршилтаар алдагдах байдлыг бууруулах;
- АСХХОХ-ийн боловсруулсан газар тариалан, мал аж ахуйн өртгийн сүлжээг дэмжих зорилгоор усны хомсдолтой үед тухайн газар нутгийн усалгааны хэрэгцээг хангах.

137. Энэхүү эко системийн арга нь голын урсацтай зэрэгцээ юм уу ойролцоо байх томхон цөөрөм, нуур бүхий ай савын усны менежментэд тулгуурладаг. БОАЖЯ-ны ӨУУМ-ийн схем нь 4 дэд төслөөс бүрдэх бөгөөд тэдгээр нь голуудын хавар-зуны өндөр урсацын зарим хэсгийг зэргэлдээ орших байгалийн цөөрөмд нөөцлөн хуримтлуулж дараа нь усжуулалтад ашиглана. Дөрвөн дэд төсөл нь Увс, Баян-Өлгий аймагт байрладаг.

138. 11-р зурагт Тариалан сумын төвийн ойролцоо орших ӨУУМ-ийн 1 ба 2-р дэд төсөл мөн эдгээрээс доош Увс нууртай ойролцоо орших төлөвлөж буй 500га усалтын системийг

(ногоон өнгөөр ялгав) харуулав. 12-р зурагт 2-р дэд төсөл болон 500га услалтын системийн талбайг өөр өнцгөөс авсан агаарын зураг, 13-р зурагт 2-р дэд төслийг ойроос харууллаа.

Зураг 11. Тариалан сум дахь БОАЖЯ-ны ӨУУМ-ын 1, 2-р дэд төслийн агаарын зураг




Эх сурвалж: АСХХОХ-ийн Эцсийн тайлангийн III ботиос авав.

Зураг 12. ӨУУМ-ийн 2-р дэд төсөл ба 500 га услалтын системийн схем



Source: Adapted from MET power point presentation of High Mountain Water Management Scheme

Зураг 13. Тарилан сум дахь ӨУУМ-ийн 2-р дэд төсөл



139. Төлөвлөж буй 500га услалтын системийн (Зураг 10) дээхэн хэсэгт байрлаж буй, мөн уг системтэй уялдаж байгаа учраас 2-р дэд төслийг АСХХОХ-ийн 1-р ээлжид нэгтгэж байгаа болно (11,12-р зургуудад үзүүлсэн). 2-р дэд төсөл нь Хархираа-Тээлийн голоос салаалуулж татсан байсан бөгөөд ашиглахгүй орхигдсон 12.5 км урт услалтын суваг, мөн энэ сувгаар ирэх усыг ус хадгалах хоёр цөөрмөөс бүрдэнэ (Зураг 13). Орхигдсон суваг, болон ус хадгалах цөөрмийг урд нь усжуулалтад ашигладаг байсан.

140. Хоёр цөөрмийг дүүргэхийн тулд 4-р сараас 8-р сар хүртэлх урсацын 3%-ийг 12.5 км сувгаар салаалуулж урсган хоёр цөөрөмд хуримтлуулах ба үүнээс дараа нь усалгаанд авч хэрэглэнэ. 11-р хүснэгтийн В, С багануудад 12.5 км сувгийн амнаас дээшхи голын урт хугацааны сарын дундаж урсацын хэмжээ ($\text{м}^3/\text{сек}$), мөн хоёр хадгалах цөөрөмд рүү өгөх 3%-ийн дундаж урсацын ($\text{м}^3/\text{сек}$) харгалзах хэмжээг харуулна. Хүснэгт 11-ээс харахад голоос авахаар тооцож буй 3% -ийн урсацын хэмжээ нь голын урсацтай харьцуулахад харьцангуй бага байна.

141. Усны эх үүсвэр болох тухайн цэгээс дээшхи ус цуглуулах талбай нь 55 км^2 . Усалгааны сувгийн төгсгөл дэх хоёр цөөрмийн багтаамж нь ойролцоогоор 64 сая м^3 орчим байна. Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа бүрэн хийгдэж дууссаны дараа ӨУУМ-ийн 3, 4-р дэд төсөл (зурагт үзүүлээгүй) болон 1-р дэд төслийг (Зураг 11) АСХХОХ-ийн дараачийн ээлжид хамруулж болох юм.

Хүснэгт 10. Голын урсацаас цуглуулах цөөрөм рүү авах улирлын 3%-ийн хэмжээ

A	B	B-2	C	D	E	F	G
Сар	Урсац ($\text{м}^3/\text{сек}$)	Усны нийт эзлэхүүн сараар	Усалгаанд авах 3%-ийн урсац ($\text{м}^3/\text{сек}$) = $b \cdot 3\%$	Цөөрмийг дүүргэх өдрийн тоо ($\sim 40,000 \text{ м}^3$) = $40000 /$ ($C \cdot 3600 \cdot 24$)	Хүрэлцээтэй усны хэмжээ (4-р сар + $40,000 \text{ м}^3$ = урьдчилж дүүргэсэн цөөрөм) (м^3) = $c \cdot 3600 \cdot 24 \cdot n_b$. өдөр	Услах талбай га – 7тн тэжээл/га – 210м3 ус/тн тэжээл: 1470 га	Тайлбар
1	0,20						хөлдсөн
2	0,20						хөлдсөн
3	0,30						хөлдсөн
4	4,84	12 545 280	0,15	3,19	416 358	283	Ургамал ургах улирал
5	7,20	19 284 480	0,22	2,14	578 534	394	
6	14,68	38 050 560	0,44	1,05	1 141 517	777	
7	18,28	48 961 152	0,55	0,84	1 468 835	999	
8	11,28	30 212 352	0,34	1,37	906 371	617	
9	4,76						
10	5,36						

11	2,87						хөлдсөн
12	0,20						хөлдсөн
НИЙТ		149 053 824			4 511 615	3 069	

Source: Adapted from Hydro Fountain Engineering Firm, retained by Uvs government to do analysis

iv. Өмнөговь сум

142. Улаангомоос урагш байх Тариалан сумтай нэгэн адилаар Өмнөговь суманд услалтын систем, тэжээлийн аж ахуй байгуулахаар төлөвлөж байна. Орон нутгийн удирдлагуудын саналд үндэслэж сумын төвөөс хойш 10км-т орших хуучин услалтын талбайг малын тэжээлийн аж ахуйд зориулж сонгов (Зураг 14). Улаангомтой адил усалгаатай талбайгаас сумын төвд байх агро паркийн хорио цээрийн бүс болон малчдад зориулж хадлан бэлтгэнэ.

Зураг 14. Өмнөговь сумаас хойш орших усалгаатай тэжээлийн ургамлын талбай



** Зургийг төслийн ХАА-н баг бэлтгэв

Талбайн нөхцөл

143. Хөрсний физик, химийн шинж чанарт хийсэн дүн шинжилгээ нь энд ээлжлэн тариалах болон хөрсний үржил шимийг сайжруулах зохих технологийн дагуу газар тариалан эрхлэхэд тохиромжтой гэдгийг харуулж байна. Ерөнхийдөө 15 см зузаантай хөнгөн шавранцар хөрс (30.76% нь 0.05-0.01 мм-ийн ширхэглэлтэй хэсэг). Хөрсний химийн нөхцөл дараахь байдалтай байна: ялзмагийн агууламж дунд зэрэг (2.28%); гол эрдэс тэжээлийн түвшин ядуу, тухайлбал: кали - 15.8мг/100г, фосфор - 1.88 мг/100г, азот - 1.01мг/100г, кальци - 26.4 мк/100г, магни - 5.8 мк/100г. Хөрсний шүлтлэг (pH 7.9) нь газар тариалан эрхлэх явцад органик бордоо (малын өтөг бууц) шаардлагатай болохыг харуулна.

Төлөвлөж буй арга хэмжээ

144. Ойролцоох голын усыг толгойн барилгаар салаалуулан татаж өөрийн урсгалаар ба хаалт/боолт бүхий задгай бетонон сувгаар урсгаж 200 га тариан талбайд хүргэнэ. Услалтын системд дараах дэд бүрэлдэхүүн хэсгүүд орно.

- Одоо байгаа толгойн барилга, гол бетонон задгай сувгийг төсвийн хөрөнгө оруулалтаар засаж шинэчлэх
- Ус ашиглалтын менежментийн төлөвлөгөөг төсвийн хөрөнгө оруулалтаар боловсруулах

Г
а
д
а
р
г
у
у
г

Тариалахаар санал болгож буй ургамал

145. Улаангом-Тариалан сумын тариалангийн талбайд төлөвлөсөн 5 жилээр ээлжлэн тариалах төлөвлөгөөг Өмноговь суманд мөн санал болгож байна. Үүнд царгасыг эхний жилд тариалж дараа нь эрдэнэ шиш, улаан буудай, арвайг ээлжлэн тариална. Төмсийг тариалангийн талбайд сүүлчийн ургамлын өмнө тариална. Эргэлтийн хамгийн сүүлийн ургамал нь овъёос байна. Услалтын талбайн шаардлагатай хэмжээг 200 га байна гэж тооцоолсон. Дарш хийхээр төлөвлөж буй ургацын хэмжээ 1240 тонн, хуурай үр тариа 80 тонн байна (Дараах хүснэгтийг үзнэ үү)..

Хүснэгт 11. Ээлжилж тариалах болон малын тэжээлд хэрэглэх ургамал

Тариалах ургамал	Зориулалт	Талбайн хэмжээ (га)	Ургац (т/га)	Нийт ургац (т)
Царгас	Дарш	40	0.8	80
Эрдэнэ шиш	дарш	40	10	1000
Улаан буудай, арвай	Хуурай үр тариа	20	0.8	40
	Дарш	20	1.6	80
	Ээлжлэн тариалалт			
Төмс		40	-	-
Овъёос	Т			
	Хуурай үр тариа	20	0.8	40
	дарш	20	1.6	80
Нийт	-	200	-	1320

** Table provided by project agricultural team

(i) Усны хэрэгцээ

146. Өмноговь сумын 200 га усалгаатай тэжээлийн аж ахуйд шаардагдах усны хэмжээг 0.126 м3/сек байна гэж тооцов

I. Баян-Өлгий аймаг

Тойм

147. Хотын суурь дэд бүтцийг сайжруулах болон агро-үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг Баян Өлгий аймгийн төв Өлгий хот, сонгосон Дэлүүн, Буянт сумдын төвд хийнэ. Дэлүүн сум дахь дэд бүтэц, агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтаас ялгаатай нь Буянт суманд зөвхөн услалтын систем байна. Хотын дэд бүтцийг сайжруулах ажлын дийлэнх хэсэг нь аймаг болон сумын төвийн төв хэсэгт хийгдэх бөгөөд агро-үйлдвэрлэлийн ихэнх үйл ажиллагаа нь төвөөс зайтай байх болно. Эхлээд Өлгий, Дэлүүн суманд төлөвлөсөн хотын дэд бүтцийг дараагаар нь агробизнесийн төлөвлөсөн хөрөнгө оруулалтыг танилцууллаа.

1. Хотын дэд бүтэц

а. Өлгий

148. Өлгий дэх хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь дараахь 2 үндсэн бүрэлдэхүүнтэй байна:

- Гэр хорооллын дахин төлөвлөлт, нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулж шинэчлэх;
- Өлгий хотын хэмжээнд нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах цогцолбор ажил нь усан хангамж, бохир ус цуглуулах, цэвэрлэх, цахилгаан, харилцаа холбоо, хатуу хог хаягдлын менежмент, зам, борооны ус зайлуулах, үерийн хамгаалалтаас бүрдэнэ.

i. Гэр хорооллын дахин төлөвлөлт

149. Өлгий хотын агаарын зураглалыг үзүүлсэн 15-р зурагт 13-р баг (улаан өнгөөр), 5-р багуудыг онцолж харуулав. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг 13-р багт хийхээр төлөвлөсөн ба 5-р багийг хувилбар болгон авч үзэж байна. 5-р багийн гэр хорооллын дахин төлөвлөлтийг 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн шатанд тодорхойлох тул 2-р ээлж болтол хүлээгдэх болно. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний шинэчлэлийг 13-р баг дээр сонгосон туршилтын гудамж/зам дагуу гүйцэтгэх болно (Зураг 16). Туршилтын гудамжийг шинэчлэн сайжруулах ба дахин төлөвлөлтөд хамрагдсан талбай руу инженерийн шугам сүлжээг шинээр барих буюу өргөтгөх бөгөөд үүнийг туршилтын замын улаан шугамын дагуу хийж гүйцэтгэнэ.

150. Гэр хорооллын орон сууцны дахин төлөвлөлт нь хувийн хашааг хамарч хийгдэх бөгөөд орчин үеийн эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалаар баригдах 1-2 давхар жижиг орон сууц байх болно. Орон сууцыг дулаан, бохир ус цуглуулах хоолой, цахилгаанд холбох ба хатуу хог хаягдлыг дахин боловсруулах байгууламж байрлуулна. Ариун цэврийн болон усанд орох өрөө, угаалгын байгууламжаас бүрдэх техникийн хэсэг (ТХ) мөн багтана.

Зураг 15. Өлгийн 13-р баг (улаан) ба 5-р багуудын байршил.



** Зургийг төслийн архитектор бэлтгэв

Зураг 16. Өлгий хотын 13-р баг ¹⁶

(a) 13-р баг дахь туршилтын гудамж (цагаан шугам)



(b) Туршилтын гудамж дагуух гэр хорооллын дахин төлөвлөлт



151. Хашаа эзэмшигчид өөрсдийн хашаагаа бүхэлд нь юм уу эсвэл зарим хэсгийг байшин барих эсвэл ТХ-т өгөхөөр солилцох боломжтой. Хашаа эзэмшигчдийн оролцсон зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн явцад тодорхойлсон гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажилд оролцох хувилбарыг дараах байдлаар нэгтгэсэн ба мөн Зураг 16b-д үзүүлэв.

1. Газраа солилцохгүй ч сүлжээнд холбогдсон ТХ-ийг худалдаж авах боломжтой;
2. Газрынхаа нэг хэсгийг жижиг байшин ба ТХ-ээр солилцох;
3. Хашааны газраа хэд хэдэн өрхөд зориулсан байшин, ТХ-р бүрэн солих
4. Оролцох тухай шийдвэр гараагүй байна.

ii Өлгий хотын үндсэн дэд бүтэц

152. 1-р ээлжээр Өлгий хотын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулахаар төлөвлөсөн цогцолбор ажлуудыг Хүснэгт 13, Зураг 17-д үзүүлэв. Төлөвлөж буй дэд бүтцийн схем зургийг 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн шатанд бэлтгэнэ. Өлгий дэх дэд бүтцийг сайжруулах ажлын хүрээнд 13-р баг болон хувилбараар авч үзэж буй 5-р багуудад гэр хорооллын дахин төлөвлөлт хийх мөн агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт хамаарна.

¹⁶ Bag 13 perimeter plot, pilot road ger development provided by project architect

Хүснэгт 12. Өлгийд хийхээр төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалт¹⁷


Төрөл	Хийгдэх ажил	Тайлбар
Усан хангамж	Усны эх үүсвэр болон түгээлтийн системийг шинэчлэлт	Хотын ус түгээх сүлжээний өмнөд хэсгийн урсгал, даралтын зохицуулалтыг сайжруулах ус нөөцлөх усан сан байгуулна. Үүнд 13-р багийн гэр хорооллыг сайжруулах хэсэг багтсан болно. Ус сувгийн газраас усан сан барих газрыг нөөцөлсөн байна. Усны эх үүсвэрийг шинэ усан сантай шууд холбож, ус хангамжийн сүлжээний өмнөд хэсгийг хангах зориулалттай Ø300 мм хос шугам. Худгийн барилга, насос, хянах удирдлага, холбогдох хэрэгслийг сэргээн засварлах, эдгээр худгуудыг холбосон хоолой, хлоржуулалтын системийг солих
	Агро паркад зориулсан шинэ хоолой	Агро паркийн янз бүрийн байгууламжуудыг хотын усан хангамжийн сүлжээнд холбох зориулалттай үзлэгийн худаг бүхий хоолой
Бохир ус зайлуулах	5, 13-р багийн гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан бохирын насос, шугам хоолой	Төслийн байгууламжуудыг дэмжих зориулалттай үзлэгийн худаг бүхий өөрийн урсгалын бохир усны хоолой. Хоолойг одоо байгаа замуудтай зэрэгцүүлж суурилуулна.
	Агро паркад зориулсан БУЦБ, шугам сүлжээ	Агро паркаас гарах үйлдвэрийн бохир усыг цэвэрлэж, цэвэрлэсэн усаа нэвчүүлэх замаар зайлуулах стандартад нийцүүлэн цэвэрлэх хүчин чадал бүхий бохир ус цэвэрлэх байгууламжийг агро паркийн ойролцоо байгуулах. Агро парк дахь төрөл бүрийн байгууламжуудыг шинэ бохир ус цэвэрлэх байгууламжтай холбох бохирын хоолой.
	Бохир ус цэвэрлэх шинэ байгууламж, холбогдох барилга, төхөөрөмж	Шаардагдаж буй нэмэлт хүчин чадалд тохирох бохир ус цэвэрлэх байгууламжийг өмнө нь тогтоосон байршилд шинээр барих. Хотын одоо байгаа бохир ус цуглуулах сүлжээ болон бохирын насосны станцыг хотын хөгжилтэй уялдуулан өргөтгөх, найдвартай ажиллагааг нэмгэдүүлэх.
Дулаан хангамж	Дулаан дамжуулах сүлжээг шинэчлэх	5-р багт зориулсан дулаан түгээх сүлжээг шинэчилсэнээр хуучирсан хоолойноос болж үүсэж буй системийн алдагдлыг бууруулна. Дулааны сүлжээ нь нийтийн эзэмшилд байх болно.
	5-р багийн гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан дулаан хангамжийн хэсгүүд	Дулаан хуваарилах дэд станцуудыг 5-р багийн гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх хэсгийн 2 байрлалд суурилуулна. Байшинд хэрэглэх усыг халаах дулааны солилцуур бүхий дэд станцууд нь стандарт тохиргоотой бөгөөд орон сууцны барилга байгууламжийн дулаан, усны хуваарилалтыг хянах зориулалттай. Дэд станцууд нь төрийн мэдэлд байх бөгөөд орон сууцны хорооллын Дулаан түгээх болон буцах шугамуудыг ус түгээх шугамын хамт 1500мм-ийн бетонон сувагт байрлуулах ба мөн хавхлагын станцууд, хяналтын худгууд байна. Шугамыг одоо байгаа замуудтай зэрэгцээ суурилуулна.
	13-р багийн гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан дулаан хангамжийн хэсгүүд	5-р багт хийгдэх ажилтай ижил, дулаан хуваарилах дэд станц, дамжуулах хоолойг бетон сувагт тавина.
	Өлгий дэх агро паркад зориулсан дулааны дэд станц	Агро паркад зориулсан, нүүрсэн галлагаа бүхий дулааны шинэ станц. Станцаас агро паркийн байгууламжуудыг хавхлагын станц, үзлэгийн худаг бүхий дулаан болон усан хангамжийн хоолойгоор хангана.
Цахилгаан хангамж	Цахилгаан хангамжийн системийн ерөнхий сайжруулалт	Сүлжээний ашигтай байдал болон найдвартай ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор түгээх системийг одоогийн 10 кВ-ын стандартад нийцүүлэн шинэчлэх. Хуучирсан 6/0.4 kV трансформаторуудыг 10/0.4 kV болгож шинэчилнэ.
	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулж цахилгаан хангамжийг сайжруулах	Overhead distribution lines with new poles and transformers for both Bag 5 and Bag 13, and some buried distribution lines, mostly located within the rehab areas. 5, 13-р багуудад цахилгаан дамжуулах агаарын шугам, шонгуудыг солих. Дахин төлөвлөлтөд орж буй хэсэгт газар доор явах цахилгааны шугам тавих.
	Агро паркад зориулж цахилгаан хангамжийг сайжруулах	Агро паркийн байгууламжид зориулсан агаарын шугам

¹⁷ Modified from engineering description of Annex 3, Vol II of ASDIP Final Report

Төрөл	Хийгдэх ажил	Тайлбар
Харилцаа холбоо	Аймгийн төвийн харилцаа холбоог сайжруулах	Аймгийн төв дэх мэдээлэл дамжуулах хүчин чадлыг сайжруулах, найдвартай байдлыг нэмэгдүүлэх
	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулж харилцаа холбоог сайжруулах	5, 13-р багийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсийн оршин суугчид болон аж ахуйн нэгжүүд, зэргэлдээх газруудад интернет, IP телевиз, утасны үйлчилгээ үзүүлэх
	Агро паркад зориулж харилцаа холбоог сайжруулах	Агро парк дахь аж ахуйн нэгжүүд, зэргэлдээх газруудад интернет, IP телевиз, утасны үйлчилгээ үзүүлэх
Зам	Дренаж болон бусад байгууламж бүхий хотын зам	Аймгийн захиргаанаас боловсруулсан төлөвлөгөөнд тусгагдсан 15.3 км хотын авто замын 6.9 км-ыг сэргээн засварлах ажил нь доорхи 8 хэсгээс бүрдэнэ: - Ховд голын хойд хэсэг дэх одоо байгаа 3.5 км шороон замыг шинэчлэхдээ үерээс хамгаалах далан хэлбэрээр шинэчлэх ба элэгдлийн хамгаалалт, хатуу хучилт гэрэлтүүлэг, явган хүний замтай байна - Цэргийн ангийн ойролцоо бай 420м хотын замыг ус зайлуулах дренаж, явган хүний зам, гэрэлтүүлэгтэй болгож, хучилтыг шинэчлэнэ. - Сумын Засаг даргын Тамгын газар, 3-р сургуулийн хоорондох 540 м хотын гудамжийг ус зайлуулах дренажтай болгож, ус, бохир ус, дулааны шугамыг дахин тавих ба явган хүний зам, гэрэлтүүлэг хийнэ. – Дулааны станц болон “Бүргэдийн үүр” зочид буудлын хоорондхи 310 м хотын гудамжийг ус зайлуулах дренажтай болгож, ус, бохир ус, дулааны шугам, явган хүний зам, гэрэлтүүлэг хийнэ. - Холбооны цамхагийн хажуугаас эхэлж шинэ агро паркийн дэргэдүүр урагш өнгөрөх 1.9 км шороон замыг ус зайлуулах дренаж хоолой, элэгдлийн хамгаалал, асфальт хучилт, гэрэлтүүлэг, явган хүний замтай болгож шинэчлэнэ.
Ус зайлуулах дренаж	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан сайжруулалтын ажлууд	Борооны усыг дахин төлөвлөлт хийгдсэн гэр хороолол болон түүний ойр орчмоос зэргэлдээ суурин газар руу хүргэхгүйгээр зайлуулахын тулд доторлогоотой суваг, шуудууг барина. Дахин төлөвлөлт хийгдэж буй хэсэгт байх ус зайлуулах байгууламжийг оролцуулаагүй
	Агро паркад зориулсан сайжруулалтын ажлууд	Агро паркийн талбайгаас ус зайлуулах зөөх бетонон доторлогоотой суваг.
	Хотын нутаг дэвсгэрээс борооны ус зайлуулах төлөвлөгөө боловсруулах техникийн туслалцаа	Өлгий хотын хувьд ус зайлуулах урсгалын тооцоо хийх, зураг төслийн шалгуурыг боловсруулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төслүүдийг тодорхойлох, орон нутгийн төлөвлөгчдөд чиглэл өгөх зорилгоор ус зайлуулах иж бүрэн төлөвлөгөөг бэлтгэх.
Үерийн хамгаалалт	5-р багийн дагуу үерийн далан (баруун далангийн төсөлтэй ижил байна)	Ховд голын гүүрнээс эхэлж 5-р багийн нутгийн хойд талаар ойролцоогоор 1.25км үргэлжлэх үерийн хамгаалалтын далан. Даланг төсөллөхдөө аймгийн захиргаанаас боловсруулсан чиглэл зургийн удирдамжийн дагуу явган хүний болон дугуйн зам, амарч суух газар зэрэг амралтын байгууламж оруулна.
	Бөхөнгийн хэсэг – үйлдвэрийн бүсийн 3.98км үерийн хамгаалалт	АСХХОХ нь аймгийн захиргаанаас бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу өмнөд аж үйлдвэрийн бүс орчмын үерээс хамгаалах системийн зарим хэсгийг барих ажлыг санхүүжүүлнэ.
	Хотын эргэн тойронд үерээс хамгаалах далан	Аймгийн удирдлагаас бэлтгэсэн үерийн хамгаалалтын далангийн системийг бүрэн барьж дуусгах
Хатуу хог хаягдал	Талбайд анхан шатны цэвэрлэгээ хийх, эн тэргүүнд хийх ажлууд, хог цуглуулах туршилт хийж эхлэх	Эхний шатанд хийгдэх ажлууд: Одоо байгаа хог хаягдлын талбайг нэгтгэж цаашид ашиглаж талбайг тодорхойлж, хашаа болон хяналтын цэг барих, хамгаалалт гаргах. Өнөөгийн байдлаар хэрэглэгдэж буй муу дадал зуршлыг засаж залруулахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлэх Хогийн цэгийг цэвэрлэх ажлыг эхлүүлэх Хог хаягдлыг зориулалтын битүү чингэлгээр цуглуулах туршилт эхлэх

Зураг 17. Өлгий дэх 1-р ээлжийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын тойм зураг


а) ус хангамж, ариутгах тауурга




b) Дулаан хангамж



с) Цахилгаан хангамж болон мэдээлэл холбооны сүлжээ



d) 3am




Total roads with infras / drainage

8.5 km

..... Likely to be dropped / -1.6km / Total 6.9km

е) Үерийн хамгаалал болон далан суваг



(i) **Хүснэгт 13-д үзүүлсэн байгаль орчны хувьд эмзэг байхуйц зарим дэд бүтцийн талаархи тайлбар**

(АСХХОХ-ийн Эцсийн тайлангийн II-р боть дахь инженерийн танилцуулгаас иш татав)

Бохир ус зайлуулах

153. Өлгий дэх 1980-аад онд баригдсан, механик бохир ус цэвэрлэх байгууламж нь ажиллагаагүй болжээ. Аймгийн удирдлагын зүгээс өсөн нэмэгдэж буй хүчин чадлын хэрэгцээг хангахын тулд ердийн тунгаах цөөрмийн тоог нэмэгдүүлсэн байна. Уг байгууламж нь хоногт 2700 м³ ус хүлээн авах зориулалттай боловч өдөрт 3000-3500м³ ус ирж байна. Зуны аадар бороо орох үед мөн ойролцоох ноос угаах үйлдвэр ашиглалтад орсны дараа ирэх усны эзлэхүүн нэмэгдэнэ. Гэр хорооллын хувьд албан ёсны бохирын систем байхгүй, ихэнх оршин суугчид гүний усыг бохирдуулах эрсдэл бүхий нүхэн жорлон ашигладаг.

154. БХБЯ-ны зүгээс АХБ-д хандаж АСХХОХ-ийн 1-р ээлжид шинэ цэвэрлэх байгууламж барих санхүүжилтийг оруулах хүсэлт гаргасан. Шинэ цэвэрлэх байгууламжийг одоо байгаа БУЦБ-ийн ойролцоо байрлуулна. Бохир ус цуглуулж дамжуулах шугам сүлжээний хувьд онц төвөгтэй асуудал байхгүй. Эхний өргөлтийн насос станцыг сэргээн засварлах, насос станцад холбогдсон одоо байгаа даралтат бохир усны шугамыг Ø250 хоолойгоор солих ажлуудыг шинэ БУЦБ-тай хамт нэгэн зэрэг хийх болно.

155. Агро паркаас гарах бохир ус нь зөвхөн ахуйн бохир ус цэвэрлэх зориулалттай хотын цэвэрлэх байгууламжид тохирохгүй тул агро паркаас гарах бохир усыг цэвэрлэхэд тусгайлан зориулагдсан хоногт 250 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий бага оврын цэвэрлэх байгууламжийг барина. 5-р багийн зүүн хэсгийн төгсгөлд өндөржилтийн түвшин бага тул 50м³/цаг-ийн хүчин чадал бүхий өргөлтийн бохир усны насос шаардлагатай.

Дулаан хангамж:

156. Өлгий дэх суурьшлын бүс нь 1990 оны эдийн засгийн шилжилтийн дараа хувьчлагдсан нүүрсээр галладаг ганц дулааны станцаас хангагддаг. Дулааны станц болон түгээх сүлжээг хоёуланг нь хувийн компани эзэмшиж, ашиглалтыг нь хариуцдаг. Бойлерийн тоног төхөөрөмж 1983 онд ашиглалтад орсон боловч түгээлтийн сүлжээг 1955 онд тавьсан гэж компанийн зүгээс мэдэгдэж байгаа. Уг станц нь 4 бойлер бүхий 65 МВт-ын хүчин чадалтай. Тус компани нь өөрсдийн хөрөнгөөр станц болон түгээлтийн сүлжээ хоолойг тогтмол засварлаж ирсэн.

157. Ирэх 20 жилд төлөвлөж буй өсөлтийг хангахын тулд 45 МВт-ын хүчин чадлыг нэмэх шаардлагатай гэсэн компанийн тооцоо бий. Өлгий дэх дулааны станц нь зөвхөн хүйтний улиралд (10-р сарын 1-ээс 5-р сарын 1-ний хооронд) ажилладаг тул бусад үед оршин суугчид, албан байгууллагууд усаа өөрсдөө ихэвчлэн цахилгаан халаагуураар халаадаг. Халаалтын сүлжээнд холбогдоогүй айл өрхүүд нүүрс, мод, аргал түлж халаадаг энгийн зуух ашигладаг. Арай томхон хэмжээний барилгуудыг нүүрс голчлон ашигладаг тохируулгагүй, нам даралтын шаталтын зуухаар халаадаг. Одоо ажиллаж буй дулааны станц нь хотын халаалтын яаралтай хэрэгцээг хангах хүчин чадалтай боловч төвийн хэсэг дэх зарим хуучин, шүүрэлт бүхий хоолойг сольж үр ашгийг нь дээшлүүлэх боломжтой. 1-р ээлжээр Ø500-ийн 1.2 км зэрэгцээ халаалтын хоолой суурилуулах бөгөөд энэ нь дулааны станцын хүчин чадлыг нэмэх ажлыг хойшлуулах болно.

158. Төлөвлөж буй агро парк нь (доороос харна уу) хотын дулаан түгээх сүлжээнээс нэлээд хол зайд байрлах тул тэнд бие даасан, жижиг оврын, нүүрсээр ажилладаг уурын зуух

барих нь дулаанаар хангах хамгийн хэмнэлттэй арга болно. Агро паркийн янз бүрийн байгууламжуудыг бетон сувагт байрлуулсан дулаан түгээх хоолойд холбоно. Бие даасан уурын зуух нь агро паркийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн хуваариар ажиллах боломжтой.

159. 5 ба 13-р багийн (дээр үзнэ үү) гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсэд нийтдээ таван дулаан дамжуулах дэд станц барих шаардлагатай бөгөөд эдгээр нь ахуйн хэрэгцээний халуун ус түгээхээс гадна үйлчилгээний хүрээнд буй барилга байгууламжид хүйтэн ус түгээнэ. Хоёр багт байх дэд станцуудын байршлыг Өлгий хотын ерөнхий төлөвлөгөөнд өмнө нь тодорхойлсон байдаг бөгөөд энэ нь сүлжээний зураг төсөл хийх болон ашиглалтад тус дөхөм болно. Халуун, хүйтэн ус дамжуулах шугам хоолой нь шинээр баригдах дэд станцуудад холбогдоно. Эдгээр хоолойнуудыг гудамжны дагууд бетонон сувагт зэрэгцүүлж Монгол улсын барилгын стандартын дагуу угсарна.

160. Аймгийн удирдлагын зүгээс хуучин нисэх онгоцны буудлын ойролцоо 45-60 ккал/цаг хүчин чадал бүхий шинэ дулааны станц барихад дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Цаашид нэмэлт хүчин чадал шаардлагатай болох ба олон жил ашиглагдсан түгээлтийн сүлжээг сэргээн засварласнаар сүлжээний ашигтай ажиллагааг дээшлүүлж, ойрын хугацааны хэрэгцээг хангах хүчин чадлыг нэмэгдүүлэх болно. Шинэ дулааны станцад зориулсан төсвийг АСХХОХ-ийн 2, 3-р ээлжид тусгасан. Ховд голын хойд хэсэгт байдаг суурьшлын бүсэд дулааны станц барих хүсэлтийг цэвэр ус, бохир ус зайлуулах системийн хамт 2, 3-р ээлжид тусгаж өгсөн. Шинэ дулааны станцын давуу талыг ашиглахын тулд голын хойд хэсэгт байрлах дулаан түгээх сүлжээний тооцоог хийх хэрэгтэй.

Хатуу хог хаягдлыг цуглуулж, зайлуулах

161. Бусад аймаг сумын төвүүдийн нэг адил Өлгий болон Дэлүүн сумын төв дэх хатуу хог хаягдлыг цуглуулах, устгахтай холбоотой өнөөгийн байдал нь түүнийг байгаль орчны стандарт, практик шаардлагыг хангахуйц хэмжээнд хүртэл хурдан хугацаанд шийдвэрлэхэд хэтэрхий ахадсан нь асуудал болж байна. Өлгий дэх хатуу хог хаягдлын цэг нь Ховд голоос хойш орших толгой орчимд байрладаг бөгөөд хяналт, зохицуулалтгүй үйл ажиллагааны улмаас 160 га талбайг хамарч тэлжээ. Энэ нь одоо өмнө талаас өргөжин тэлж буй суурьшлын бүстэй нэлээд ойр болж ирж байна. Хогийн цэг рүү очиход үндсэндээ урдаас ирж буй нэг л замаар явдаг боловч нэвтрэх хяналт болон хогийг төрөлжүүлж хаях зориулалттай газар байдаггүй. Нөлөөлөлд өртсөн газрын ихээхэн хэсэг нь салхинд хийссэн хог хаягдал бөгөөд тэдгээрийг хурааж хумих, далдлах хүн хүч, тоног төхөөрөмж байхгүй байна. Хогийн цэг нь Ховд голоос 1.5 км зайтай өндөрлөг газарт байрладаг боловч хогийн цэг ба голын хооронд томоохон суурин газар байдаг. Хогийн цэгийн орчимд гадаргад ойр байхуйц гүний ус байх шинж тэмдэггүй ч хогийн талбайгаас урсах борооны ус ойролцоох суурьшлын бүс руу орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй байна.

162. Хотын хувьд хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх нь тогтсон систем байхгүй бөгөөд арилжааны болон аж ахуйн нэгжийн хог хаягдлыг тээвэрлэх, устгах ажлыг холбогдох байгууллагууд өөрсдөө хариуцдаг. Дулааны станцуудын үнсийг хотын хогийн цэгээс тусад нь хаядаг боловч хотын хог хаягдлын нлээн хувийг жижиг зуух, бойлерийн үнс эзэлж байна. Хог хаяхтай холбогдсон төлбөр, хураамж цуглуулах механизм байдаггүй.

163. АСХХОХ-ийн 1-р ээлж нь Өлгийд өнгөрсөн хугацаанд хяналтгүй хаягдсан хогийг цэвэрлэх, зайлуулах, газар нутгийг нөхөн сэргээх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой менежментийн системтэй болгох эхний үе шат байх болно. Энэ арга хэмжээ нь техникийн туслалцаа болон гүйцэтгэх ажлуудыг хосолсон байх болно.

- Хог хаягдлын төрөл, физик нөхцөл байдал (хөрс, гүний ус, газрын гадарга), одоо байгаа хог хаягдалд үндэслэн тухайн газрыг цаашид ашиглах төлөвлөгөөтэй

уялдуулж нөлөөллийг нь арилгах, юм уу багасгах шаардлагатай ямар хор хөнөөл байгаа эсэх зэрэг өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлно. Үүний дүнд хогийн талбайг цэвэрлэх, сайжруулахад зориулсан арга хэмжээний зөвлөмж бэлдэх ба өрөмдлөг, гүний усны дээж авах, усны чанарын анализ хийх ажлууд үүнд орсон байна.

- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэж хаях, зардал нөхөх механизм болон чадавхийг хөгжүүлэх хэрэгцээ, үе шаттайгаар цэвэрлэгээ хийх, нөхөн сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг орон нутгийн түвшинд эхлүүлэх
- Цаашид хог хаягдлын талбай болгон ашиглахаар тогтож буй газарт одоо байгаа хогийн талбайг нэгтгэх, эргэн тойронд нь нэвтрэх хяналт, хамгаалалтын цэг бүхий хашаа барих (15 га).
- Хог дахин боловсруулж ашиглах чиглэлээр судалгаа хийх, боломжуудыг холбогдох зардал, үр ашгийн хамт тодорхойлж боловсруулах, үүнийг аймаг, бүс нутгийн хөтөлбөртэй уялдуулах
- Гүний усны бохирдол зэрэг нийгмийн эрүүл мэндэд учирч буй аливаа буруу дадал зуршлыг засахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлүүлэх.
- 2, 3-р ээлжээр төвлөрсөн санхүүжилтээр хийгдэж болох шинэ барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах
- Одоо байгаа хогийн цэгийг цэвэрлэж эхлэх.
 - Хотын төв ба гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх хэсэгт 50 ш хогийн сав тавьж 5 ачааны машинаар хатуу хог хаягдлыг цуглуулж ачих туршилтыг эхлүүлэх.

в. Дэлүүн сум

164. Дэлүүн сумын төвд хийгдэх ажил нь Өлгийнхтэй ижил төстэй боловч хэмжээ далайц бага бөгөөд гэр хорооллын дахин төлөвлөлт байхгүй. Харин олон нийтийн барилга байгууламжуудад сайжруулалт хийгдэнэ. Өлгийтэй нэгэн адил сайжруулагдах дэд бүтэц нь Дэлүүн сумд шинээр үүсэх агро-үйлдвэрлэлийн байгууламжуудад үйлчилнэ.

і. Нийтийн хэрэгцээний барилга байгууламж

165. 1-р ээлжид хамрагдах хотын дэд бүтэц, үйлчилгээний хөрөнгө оруулалтад сумын төвийн ариун цэврийн болон нийтийн хэрэгцээний барилга байгууламжийн тохижилт зэрэг ажлууд багтах ба эдгээрийг Хүснэгт 18-д үзүүлэв.

Ариун цэврийн байгууламж:

166. Сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг зэрэг олон нийтийн барилга доторх бие засах газар хангалтгүй эсвэл огт байхгүй байна. АСХХОХ нь барилгын гадна хол зайд байрладаг хуучин нүхэн жорлонг шинэчлэн сайжруулах эсвэл шинэ ариун цэврийн байгууламж барих ажлыг санхүүжүүлнэ.

Дотуур байр:

167. Хөдөө орон нутагт боловсрол эзэмшихэд тулгардаг бэрхшээлүүдийн нэг бол сургуулийн дотуур байрны ор дутагдалтай байх явдал юм. АСХХОХ нь шаардлагатай сурагчдын дотуур байрыг барина.

Олон төрлийн зориулалтаар ашиглаж болох барилга байгууламж:

168. Сургуулийн дэргэдэх номын сан, амралт чөлөөт цагийн төв гэх мэт дутагдалтай байгаа асуудлыг шийдвэрлэхэд эдгээр барилгуудыг ашиглана. Төслийн зүгээс олон төрлийн зориулалтаар ашиглаж болох эдгээр барилга байгууламжийг шинээр барих эсвэл сэргээн засварлах замаар байгуулна.

Спорт:

169. АСХХОХ нь олон нийт, оршин суугчдад зориулсан энгийн спортын цогцолборыг барих болно. Энэхүү цогцолборийг барьснаар бага насны хүүхдүүдийн тоглоомын талбайтай болохоос гадна залуучууд илүү зохион байгуулалттай спортоор хичээллэх боломжтой болно.

Ажилчдын орон сууц:

170. Байнгын болон улирлын чанартай ажилтан, ажилчдыг (багш, эмнэлгийн мэргэжилтнүүд г.м.) орон нутагт татах, суурьшуулах зорилгоор тэднийг орон байраар хангах шаардлагатай. Төсөл нь энэ зорилгоор энгийн орон сууцны хороолол барина. Бүх барилга байгууламжуудад эрчим хүч хуримтлуулах баттерей бүхий нарны зайн хавтанг суурилуулах замаар цахилгааны нэмэлт хангамжтай байх болно.

Зураг 18. Дэлүүн суманд төлөвлөж буй нийтийн хэрэгцээний болон ариун цэврийн барилга байгууламж



ii Дэлүүн сумын төвийн үндсэн дэд бүтцийг сайжруулах

171. Дэлүүн сумын төвд хийхээр төлөвлөж буй үндсэн дэд бүтцийн сайжруулах ажлуудыг Хүснэгт 14-д нэгтгэж үзүүлэв. Энэхүү ажлын тоймыг харуулсан агаарын зураглалыг Зураг 19-д тусгав.


Хүснэгт 13. Дэлүүн сумын төвд 1-р ээлжинд хийхээр төлөвлөж буй дэд бүтцийн ажлууд ¹⁸

	Хийгдэх ажил	Тайлбар
Усан хангамж	Сумын төвд зориулсан шинэ усан сан, хоолой	Сумын төв болон агро паркад зориулсан гүний насос, удирдлага, бүхий 2 худаг. Сумын төвийн дэд бүтцийн зураг төслийн ТТ-ны нэг хэсэг болж худгийн хамгийн зөв байршлыг баталгаажуулах гидрогеологийн судалгаа хийгдсэн байх ёстой.
	Ус түгээх сүлжээ (агро паркыг оролцуулна)	Нийтийн хэрэгцээний голлох барилга байгууламж болон агро паркад зориулсан усан хангамжийн далд шугам хоолой, үзлэгийн худгийн хамт
Бохир ус зайлуулах	Шинэ бохир ус цэвэрлэх байгууламж, шугам хоолой	Урьдчилсан байдлаар сумын төвөөс зүүн өмнө зүгт байрлуулахаар тоцож буй, сургууль, олон нийтийн барилга байгууламжийн ахуйн бохир усыг нэвчүүлэх замаар зайлуулах стандартад нийцүүлэн цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж
	Септикийн үйлчилгээнд зориулсан вакуум соруулах машин	Бохир хаягдлыг зайлуулах буюу цэвэрлэх зориулалтын байршилд тээвэрлэж хүргэх вакуум насос, хоолойгоор тоноглогдсон, цаг уурын хүйтэн нөхцөлд ажиллахад зориулагдсан муу усны нүхнээс бохир ус, лагийг соруулж авах машин
	Агро паркад зориулсан бохир усанд анхан шатны цэвэрлэгээ хийх байгууламж	Сумын төвийн БУЦБ-д өгч болохуйц стандартын дагуу агро паркаас гарах бохир усанд анхан шатны цэвэрлэгээ хийх байгууламж.
Дулаан хангамж	Шинэ дулааны станц, шугам хоолой	Сумын төв болон агро паркад зориулсан, нүүрс галлаж ажиллах дулааны шинэ станц, хавхлагын станц, үзлэгийн худаг бүхий дулаан болон усан хангамжийн хоолой
Цахилгаан хангамж	Сумын төвд зориулсан бага оврын шинэ дэд станц, 0.4 kV-ын шинэ шугам, цахилгааны тоолуурын хамт (зураг төсөл хийгдсэн)	Сумын төвд цахилгаан түгээх хүчин чадал, найдвартай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор агаарын кабель, трансформаторыг шинээр солих, усан хангамжийн шинэ худгийн насосыг цахилгаанаар хангах трансформатор бүхий өндөр хүчдэлийн шинэ шугмын хамт.
	Агро паркад зориулсан шинэ 10 kV-ийн шугам	Агро паркийн байгууламжуудад зориулсан 400kVA шинэ трансформатор, цахилгаан дамжуулах агаарын шугам
Харилцаа холбоо	Дэлүүн сумын болон агро паркад зориулж 500 хэрэглэгчдэд үйлчлэх MSAN станц, шинэ шилэн кабель тавих	Сумын төвийн оршин суугчид, агро парк дахь бизнест интернет, IP телевиз, утасны үйлчилгээ үзүүлэх
Хог хаягдал	Талбайд анхан шатны цэвэрлэгээ хийх, эн тэргүүнд хийх ажлууд, хог цуглуулах туршилт хийж эхлэх	Эхний ээлжинд хийгдэх ажлууд: Одоо байгаа хог хаягдлын талбайг нэгтгэж цаашид ашиглах талбайг тодорхойлж, хашаа болон хяналтын цэг барих, хамгаалалт гаргах. Өнөөгийн байдлаар хэрэглэгдэж буй муу дадал зуршлыг засаж залруулахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлэх Хогийн цэгийг цэвэрлэх ажлыг эхлүүлэх Хог хаягдлыг зориулалтын битүү чингэлгээр цуглуулах туршилт эхлэх


¹⁸ Modified from engineering designs of Annex 3, Vol II of ASDIP Final report

Figure 18. 1-р ээлжинд дэлүүн суманд хийгдэх дэд бүтцийн ажлын тойм зураг


а) Усан хангамж, ариутгах тауурга, шинэ БУЦБ




б) Дулаан хангамж




с) Цахилгаан хангамж



d) Мэдээлэл холбооны сүлжээ



е) хог хаягдалын цэг



(ii) **Хүснэгт 13-д үзүүлсэн байгаль орчны хувьд эмзэг байхуйц зарим дэд бүтцийн талаархи тайлбар**

(АСХХОХ-ийн Эцсийн тайлангийн II-р боть дахь инженерийн танилцуулгаас иш татав)

Бохир ус зайлуулах

172. Дэлүүн сумын төвд албан ёсны бохир ус цуглуулах, цэвэрлэх, зайлуулах систем байхгүй. Олон нийтийн барилга байгууламж, байшин бүхий хороололд зөвхөн нүхэн жорлонг ашигладаг. Нүхэн жорлон, бохирын нүхэнд ямар төрлийн үйлчилгээ хийх тухай журам дүрэм байхгүй бөгөөд зөвхөн дүүрсэн үед нь битүүлж орхиод өөр газарт шинээр хийдэг байна.

173. Усан хангамжийн системийг сайжруулахтай уялдуулан бохирын шугам сүлжээ тавих ба сургууль, олон нийтийн барилга байгууламжаас гарах ахуйн бохир усыг бага оврын (100 м³/хоног) цэвэрлэх байгууламжтай холбоно. Сумын төвийн зүүн талд орших талбайд барихаар төлөвлөж буй энэ цэвэрлэх байгууламж нь цэвэрлэсэн усыг гадаргад асгахад нийцэхүйц стандартаар ажиллана.

174. Агро паркаас гарах бохир ус нь зөвхөн ахуйн бохир ус цэвэрлэх зориулалттай сумын цэвэрлэх байгууламжид тохирохгүй тул агро паркийн талбайд хоногт 50 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийг барьснаар агро паркаас гарах бохир усыг урьдчилсан байдлаар цэвэрлэж сумын системд нийлүүлэх болно. Агро паркийн байгууламжуудаас гарах бохир усыг жижиг шугам сүлжээгээр цэвэрлэх байгууламжид хүргэнэ.

175. Дэлүүн сумын төвийг вакуум насос, хоолойгоор тоноглогдсон, муу усны нүхнээс бохир ус, лагийг соруулж авах 5м³-ийн багтаамжтай машинаар хангана. Энэ машинаар цуглуулсан бохирыг хүлээж авах, цэвэрлэх, зохистой байдлаар асгаж зайлуулах зориулалтын төхөөрөмжийг сумын БУЦБ-ын төсөлд тусгасан болно.

Дулаан хангамж:

176. Дэлүүн сумын төв дэх хувийн эзэмшлийн, нүүрсээр галладаг уурын зуух нь өвөл халаалтын улиралд ажилладаг ба олон нийтийн барилга байгууламжуудад дулааныг шугам хоолойгоор хүргэдэг. Халаалтын сүлжээнд холбогдоогүй айл өрхүүд нүүрс, мод, аргал түлж халаадаг энгийн зуух ашигладаг. Дэлүүн сумын төв болон агро паркийн дулааны хэрэгцээ нь одоо ажиллаж буй уурын зуухны хүчин чадлаас давж байгаа тул АСХХОХ-ийн 1-р ээлжээр олон нийтийн барилга байгууламж, шинэ агро парсад үйлчлэх зориулалттай 1.5гкал/цаг хүчин чадал бүхий шинэ уурын зуух барина. Дулааны шугам хоолойг ус дамжуулах шугамын хамт газар дор бетон сувагт зэрэгцүүлэн суурилуулна.

Хог хаягдлын менежмент

177. Дэлүүн сумын төв дэх хог хаягдал цуглуулж, зайлуулж буй байдал нь Өлгийтэй ижил бөгөөд хэдийгээр хэмжээний хувьд бага ч гэсэн асуудлыг байгаль орчны стандарт, практик шаардлагыг хангахуйц хэмжээнд хүртэл хурдан хугацаанд шийдвэрлэхэд дэндүү ахдаж байна. Дэлүүн сумын хог хаягдлын цэг нь сумын төвөөс зүүн тийш 2.2км орчимд байрладаг бөгөөд хяналтгүй үйл ажиллагааны улмаас 50 га талбайг хамарч тэлжээ. Хогийн цэгт ямар нэг хашаа, харуулын хэсэг байхгүй бөгөөд нөлөөлөлд өртсөн газрын ихээхэн хэсэг нь салхинд хийссэн хог хаягдал байна. Эдгээрийг дарж хаах, цуглуулж хумих чиглэлээр хийсэн ажил байхгүй. Хогийн цэг нь тал газар байрлах бөгөөд ойролцоо нь ямар нэг ямар нэг гадаргын ус байхгүй. Энэ орчины гүний ус хөрсөнд нэлээн ойр байдаг, гэхдээ хогийн цэг нь суурьшлын хэсэг болон АСХХОХ-өөр төлөвлөж буй агро паркаас нам дор газарт байрлана.

178. Сумын төвд хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх тогтсон систем байхгүй, хог хаях асуудал нь оршин суугчдын өөрсдийнх нь үүрэг байдаг. Сумын төв нь хогийн цэгийг ажиллуулахад ашиглаж болох ачааны машин, урдаа шанага бүхий ачигч машинтай боловч санхүүгийн дэмжлэг хязгаарлагдмал байдаг. Хог хаягдлын ихэнхи хувийг зуухны үнс эзлэх боловч мал нядалгаанаас гарсан хаягдлыг ахуйн хогтой хамт ил задгай хаяж байна.

179. АСХХОХ-ийн 1-р ээлж нь өнгөрсөн хугацаанд хяналтгүй хаягдсан хогийг цэвэрлэх, зайлуулах, газар нутгийг нөхөн сэргээх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой менежментийн системтэй болгох эхний үе шат байх болно. Энэ арга хэмжээ нь техникийн туслалцаа болон гүйцэтгэх ажлуудыг хосолсон байх болно.

- Хог хаягдлын төрөл, физик нөхцөл байдал (хөрс, гүний ус, газрын гадарга), одоо байгаа хог хаягдалд үндэслэн тухайн газрыг цаашид ашиглах төлөвлөгөөтэй уялдуулж нөлөөллийг нь арилгах, юм уу багасгах шаардлагатай ямар хор хөнөөл байгаа эсэх зэрэг өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлно. Үүний дүнд хогийн талбайг цэвэрлэх, сайжруулахад зориулсан арга хэмжээний зөвлөмж бэлдэх ба өрөмдлөг, гүний усны дээж авах, усны чанарын анализ хийх ажлууд үүнд орсон байна.
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэж хаях, зардал нөхөх механизм болон чадавхийг хөгжүүлэх хэрэгцээ, үе шаттайгаар цэвэрлэгээ хийх, нөхөн сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг орон нутгийн түвшинд эхлүүлэх
- Цаашид хог хаягдлын талбай болгон ашиглахаар тогтож буй газарт одоо байгаа хогийн талбайг нэгтгэх, эргэн тойронд нь нэвтрэх хяналт, хамгаалалтын цэг бүхий хашаа барих (5 га)
- Гүний усны бохирдол зэрэг нийгмийн эрүүл мэндэд учирч буй аливаа буруу дадал зуршлыг засахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлүүлэх.
- Гүний усны бохирдол зэрэг нийгмийн эрүүл мэндэд учирч буй аливаа буруу дадал зуршлыг засахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлүүлэх.
- Хог дахин боловсруулж ашиглах чиглэлээр судалгаа хийх, боломжуудыг холбогдох зардал, үр ашгийн хамт тодорхойлж боловсруулах, үүнийг аймаг, бүс нутгийн хөтөлбөртэй уялдуулах
- 2, 3-р ээлжээр төвлөрсөн санхүүжилтээр хийгдэж болох шинэ барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах
- Одоо байгаа хогийн цэгийг цэвэрлэж эхлэх.
- Хотын төв ба гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх хэсэгт 50 ш хогийн сав тавьж 5 ачааны машинаар хатуу хог хаягдлыг цуглуулж ачих туршилтыг эхлүүлэх

2. Өлгий ба Дэлүүн, Буянт сумдын агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт

180. АСХХОХ-ийн 1-р Өлгий болон Дэлүүн, Буянт (зөвхөн услалтын систем) сумын төвд дараах гурван төрлийн агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт хийгдэнэ.

- (а) Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд зориулсан олон нийтэд түшиглэсэн төсөл
- (б) Агро парк
- (в) Услалтын систем, тэжээлийн аж ахуй

а. Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд зориулсан олон нийтэд түшиглэсэн төслүүд

181. Мал аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор малчдад зориулсан олон нийтийн бичил төслүүдийг төслөөс санхүүжүүлнэ. Малчид нь дэмжлэг авахын тулд орон нутгийн Бэлчээр ашиглагчдын бүлгийн гишүүн байх ёстой. Бэлчээр ашиглагчдын бүлгийн гишүүд нь ажиллах хүчний болон эсвэл мөнгө, эд материалын дэмжлэг үзүүлнэ. Одоогоор бичил төслүүдийн байршил тодорхой болоогүй байна.

182. Санхүүжилтээр дэмжих жишиг олон нийтийн бичил төслийн төрлүүдийг дурдвал:

- Хадланд зориулсан хамгаалалттай нутаг: голын ойролцоох бэлчээрийн 15 га газрыг сонгон авч, чулуун хашаагаар хашна. Гадаргуугын усалгаа хийхэд зориулсан сувгийн далан, гол ба хуваарилах сувгийн голдирлыг тогтооно.
- Жижиг тоног төхөөрөмж, ачааны машин: бэлчээрийн менежментийг дэмжих зориулалтаар хөдөө аж ахуйн машин төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглогдсон жижиг оврын трактораар хангана.
- Хадлан, тэжээл хадгалах байр сав
- Мал самнах, ноос хяргах хэрэгсэл, төхөөрөмж, хадгалах байр савны хамт мөн ариутгал угаалгын онгоц.
- Малын хашаанд өвөл хэрэглэх салхи хаах саравч
- Усны худаг: шинээр 6 худаг барьж, хуучин 4 худгийг сэргээн засварлана.
- Мал угаалгын газар.
- Мал услах байгууламж.
- Жижиг гүүр, голын гарам, шороон зам засах.

б. Агра парк


183. Өлгий хот, Дэлүүн суманд байрлах агро паркууд нь хорио цээрийн бүс, мал төхөөрөх газар, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээ, судалгаа шинжилгээний төв, бизнес инкубацийн төв, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдээс бүрдэх болно. Агро парк нь Өлгийн яг чанх урд (Зураг 16), Дэлүүн сумын яг зүүн өмнө талд байрлана (Зураг 17). Дээр танилцуулсан хот суурины төвүүдэд төлөвлөж буй дэд бүтцээр агро паркыг хэсэгчлэн хангах болно.

и. Хорио цээрийн бүс

184. Хорио цээрийн бүсэд дараах байгууламж байна:


- Хяналтын лаборатори, хяналтын бүс.
- Малын өвчнийг хянах зориулалттай хорио цээрийн бүс дэх мал тэжээх цэг.

Figure 19. Өлгий хотоос урагш орших агро паркын байршил



185. Хорио цээрийн бүс нь мал сүрэг хялбар хүрч ирэхээр байршилд байх нь зүйтэй бөгөөд усалгааны хэсэг, мөн бүсийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тэжээл үйлдвэрлэх өвс тэжээлийн цэг рүү орж гарах боломжтой байх ёстой (доор үзнэ үү).

Figure 20. Дэлүүн сум дахь агро паркын байршил



186. Өлгий дэх хорио цээрийн бүсийн малын тэжээлийн цэг нь 1000 толгой мал багтаах хүчин чадалтай бөгөөд малын гоц халдварт өвчин гарсан тохиолдолд юм уу экспортын хэрэгцээнд зориулан хоёроос гурван долоо хоног тусгаарлах боломжтой. Бод, бог малд шаардагдах талбайн хэмжээ дунджаар нэг малд 10м² байх тул бүсийн болон тэжээлийн талбай нийтдээ 1га болно. Үүн дээр нэмж хяналт шалгалтын хэсэг, лабораторийн байрт 0.5га, малын хашаа саравчинд 0.5 га, өвс, тэжээл хадгалах хашаанд 0.5га, бой хийх бүсэд 0.5га, талбайд хөдөө аж ахуйн техник хэрэгслийн зогсоолын талбайд 0.5га-г тус тус гаргана.

187. Хорио цээрийн бүсэд 1000 толгой малыг хоёроос гурван долоо хоног тусгаарлах хугацаанд зарцуулах өвс, тэжээлийн нөөц хангалттай байх болно. 20-р хүснэгтэд өвс, тэжээлийн нийт нөөцийг 2,592 тн тооцсон ба үүнд зуны сүүлчээр нэг удаа хийх хадлангийн хэмжээг тооцсон болно.

Table 14. Өвс тэжээл хадгалах хэрэгцээ

	Өдрийн хэрэгцээ, кг	Малын тоо толгой	Хэрэглэх өдөр	Жилд хэрэглэх давтамж	Нийт хэрэгцээ (кг)
Бог мал	1.5	800	18	12	259,200
Бод мал	7	200	18	12	302,400
Нийт					561,600

** Хүснэгтийг төслийн ХАА-н баг бэлтгэв.

188. ХЦБ дэх өвс тэжээлийн цэг нь дараах онцлог бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна:

- Хорио цээрийн 1га талбай болон тэжээлийн цэгийг тусгаарлах зорилгоор талбайн гадуур 1.5м өндөртэй чулуун хашлага хийнэ
- 5000м² талбай бүхий цас, шуурганаас хамгаалах саравч
- Нийт 500 тоннын багтаамж бүхий өвс хадгалах давхарлагаатай агуулах (хэтрүүлж/замбараагүй хэрэглэхээс сэргийлэх зорилгоор)
- Малд тэжээл тавьж өгөх сав
- Мал услах ус, усан хангамжийн холболт
- Ойролцоох засмал замтай холбох 2 км авто зам
- Хөдөө аж ахуйн техник хэрэгслийн зогсоолын талбай
- Мал эмнэлгийн үзлэгийн төв, лабораторийн байр

189. Дэлүүн суманд мөн малын тэжээлийн цэг байгуулагдах боловч хүчин чадлын хувьд хоёр дахин бага байна. Түүнчилэн ХЦБ-ийг Дэлүүн сумын агро парсад нэгтгэнэ. ХЦБ болон тэжээлийн цэг нь 500 тооны малд зориулагдсан, 0.5га талбайтай байна.

190. Өлгийн ХЦБ-д мал эмнэлгийн үйлчилгээ, өвчин эмгэг, чанарын хяналт шинжилгээний үндсэн лабораторийн нэг хэсэг болох үзлэгийн лаборатори, малын хяналтын бүс багтана. Үндсэн лабораторийг агро парсад нэгтгэнэ. 2018 оноос Мал эмнэлгийн газар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас салсан тул шинэ офистой болох шаардлагатай болж байна. Офис болон лабораторийг агро паркийн нэг байранд нэгтгэнэ.

191. Дэлүүн сум дахь лабораторийг мөн сумын төвийн захад байрлах агро парк дахь ХЦБ-ийн хүрээнд нэгтгэнэ (дор үзнэ үү). Үүнд мөн мал эмнэлгийн газар орно.

192. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарал үүсэл тогтоох, эмнэлзүйн үйлчилгээ, ХЦБ-д явагдах үйл ажиллагаатай холбоотойгоор Өлгий болон Дэлүүн сум дахь мал эмнэлгийн газруудын үйл ажиллагаанд зориулж эмнэлгийн барилга барих, сайтар төлөвлөж тооцсон лаборатори, тоног төхөөрөмж, жижиг хэрэгслээр хангах шаардлагатай. Лабораторийн үндсэн тоног төхөөрөмжийг хүснэгт16-д үзүүлэв.

Table 15. Лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн жишээ

	Нэр	Зориулалт	Шаардлагатай хэмжээ	
			Өлгий	Дэлүүн
Тоног төхөөрөмж				
1	Термостат	Дээж сорьц, шил хатаах	2 ш	1 ш
2	Автоклав	Багаж хэрэгсэл, шил ариутгах	2 ш	1 ш
3	LC tandem MS	Мах, хүнсний бүтээгдэхүүн дэх антибиотик, пестицид, шавьж устгагч хор зэрэг хорт бодисыг тодорхойлох	1 ш	-
4	NIR спектроскоп	Сүү болон бусад бодис дахь өөх тос, чийгшил, нүүрс ус, чихрийг тодорхойлох	1 ш	1 ш
5	Центрифуг	Төрөл бүрийн биологийн дээжээс тунадас ялгах	2 ш	2 ш
6	pH-хэмжигч	Дээжийн хүчиллэг байдлыг тодорхойлох	2 ш	2 ш
7	Микроскоп	Анализ шинжилгээ хийх	2 ш	2 ш
8	Мал эмнэлгийн төхөөрөмж бүхий машин	Явуулын лабораторийн үйлчилгээ	1 ш	1 ш
9	Эвхдэг хашаа	Мал эмнэлгийн арга хэмжээний үеэр мал хаших	7 ш	7 ш
10	Ариутгалын онгоц	Мал угаах, ариутгах зориулалттай	7 ш	7 ш
11	Хамгаалалтын юүдэн	Асептик тусгаарлалтын зориулалтаар	1 ш	-
Жижиг хэрэгсэл				
1	Хаяг, шошго	Цус болон биологийн бусад дээжид	40,000 ш	40,000 ш
2	Шошго хадгалах хайрцаг	Дээж хийж тээвэрлэх	40 ш	40 ш
3	Биологийн хуруун шил	Цусны дээжид	40,000 ш	40,000 ш
4	Ариутгасан зүү	Цус авах тариурт хэрэглэх	40,000 ш	40,000 ш
5	Зүүний тавиур	Цусны дээж авахад	400 ш	400 ш
6	Бээлий	Халдвараас сэргийлэх	500 хайрцаг	500 хайрцаг
7	Лабораторийн хамгаалалтын хувцас	Халдвараас сэргийлэх болон ариутгалын ажилд	1000 ш	1000 ш
8	Галзуу өвчнийг хурдан шалгах	Хөдөө орон нутагт шинжилгээ хийхэд	40 ш	40 ш

	Нэр	Зориулалт	Шаардлагатай хэмжээ	
			Өлгий	Дэлүүн
	лабораторийн иж бүрдэл			
9	Үхрийн боом өвчнийг хурдан шалгах лабораторийн иж бүрдэл	Хөдөө орон нутагт шинжилгээ хийхэд	40 ш	40 ш

Сургалт, чадавхи бэхжүүлэх арга хэмжээнд зориулж

1	Зөөврийн компьютер	Хөдөө орон нутагт мэдээлэл боловсруулах	1 ш	1 ш
2	Суурин компьютер	Офист мэдээлэл боловсруулах	1 ш	1 ш
3	Дэлгэцийн проектор	Мэдээллийг танилцуулах	1 ш	1 ш
4	Микрофон	Мэдээлэл боловсруулах	1 ш	1 ш
5	Өнгөт хэвлэгч	Мэдээлэл хуваалцах/түгээх	1 ш	1 ш
6	Өргөн дэлгэц	Мэдээлэл хуваалцах/түгээх	1 ш	1 ш

(i) Усны хэрэгцээ

193. Өлгий дэх ХЦБ-ийн усны хэрэгцээг ундны усны хувьд хоногт 2.6м^3 , боловсруулалтад хэрэглэх усыг хоногт 50м^3 -ээр тооцлоо.

ii. Мах боловсруулах үйлдвэр

194. Өлгийд Халал стандартыг ашигладаг мах боловсруулах цех бүхий хоёр төхөөрөх газар байдаг бөгөөд хоёулаа түүхий махыг Хятад, Иран руу экспортлох гэрээ байгуулжээ. Эдгээр газрууд өдөрт ойролцоогоор 600 толгой мал хүлээн авах хүчин чадалтай боловч аль нь ч бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй байна. Энэхүү төсөл нь ХЦБ-ийн ойролцоо мах боловсруулах үйлдвэр байгуулахад хувийн хэвшилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх юм. Үйлдвэрийн хүчин чадал нь өдөрт 150 бод, 600 бог мал байх бөгөөд жилд 8 сар ажиллана. Мах боловсруулах байгууламжийн зураг төслийг ашиглалт болон байгаль орчныг хамгаалах асуудлын хувьд НҮБ-ын ХХААБ (1988), ДЭМБ-ын (1984) стандартад нийцүүлсэн байх болно.

(i) Усны хэрэгцээ

195. Өлгий дэх мал төхөөрөх үйлдвэрийн усны хэрэгцээг ундны усны хувьд хоногт 105м^3 , мах боловсруулалтад хэрэглэх усыг оруулаад нийтдээ хоногт 210м^3 -ээр тооцлоо.

196. Дэлүүн суманд зохих ёсоор ажилладаг мах боловсруулах байгууламж байхгүй. Малыг ил задгай газар нядалдаг. Энэхүү төсөл нь олон улсын хүрээлэн буй орчны стандартын дагуу ердийн мах боловсруулах үйлдвэр байгуулна. Үйлдвэрийн хүчин чадал нь өдөрт 150 толгой мал (бод, бог нийлээд) байх бөгөөд жилд 8 сар ажиллана. Мах боловсруулах үйлдвэрийг ХЦБ-ийн ойролцоо, агро паркад байгуулна (доор буй зургийг харна уу).

(ii) Усны хэрэгцээ

197. Дэлүүн суман дахь мах боловсруулах үйлдвэрийн усны хэрэгцээг мах боловсруулалтыг оруулахгүйгээр хоногт 30м^3 (мах боловсруулалтад хэрэглэх усыг оруулбал хоногт 60м^3) байхаар тооцлоо.

(iii) Мах боловсруулах үйлдвэрийн зураг төслийн стандарт

198. Өлгий болон Дэлүүн сум дахь мах боловсруулах, хадгалах байгууламжийн зураг төслийг дээр Улаангом, Өмнөговь сумын тайлбарт дурдсанчилан ашиглалтын болон байгаль орчныг хамгаалах асуудлын хувьд НҮБ-ын Хүнс ХАА-н байгууллага (1988), ДЭМБ (1984) болон бусад олон улсын стандартад нийцүүлсэн байх болно.

iii. Боловсруулах үйлдвэр, хадгалалт, бизнесийн инкубацийн үйлчилгээ

199. Агро паркийн төлөвлөсөн бусад чиг үүрэг нь жижиг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийг дэмжихэд чиглэнэ. Агро парк нь бизнесийн болон агро үйлдвэрлэлийн боломжуудын маш олон төрлийн санааг хөгжүүлж, үүгээрээ орон нутгийн агро-үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөгөөг дэмжиж туслах болно гэж үзэж байна. Боловсруулах үйлдвэрийн жишээнд сүү цагаан идээний ферм, хүлэмж, хүнсний ногоо боловсруулах, нэхий боловсруулах (арьс боловсруулах бус), ноос боловсруулах үйлдвэр орно.

(i) Усны хэрэгцээ

200. Агро паркад төлөвлөж буй боловсруулах үйлдвэрүүдэд шаардагдах усны хэмжээг Хүснэгт 17-д нэгтгэв.

Table 16. Агро паркийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд шаардлагатай усны тооцоот хэмжээ

Ноосны үйлдвэр	Нэхий боловсруулах үйлдвэр	Сүү цагаан идээний ферм	Хүлэмжийн аж ахуй	Хүнсний ногоо боловсруулах
Хэрэглээний ус: 1 т бүтээгдэхүүнд 1.0 м ³ , Ундны ус: 1000 л/хоног	Хэрэглээний ус: 0.1 м ³ /т, ундны ус: 100 л/хоног	Ундны ус: 1м ³ сүүнд 1.5м ³	Хэрэглээний ус: 1.0 л/м ² , ундны ус: 100 л/хоног	1 т бүтээгдэхүүнд 1.0 м ³

iv. Байгаль орчны менежментийн систем

201. Аймаг, сумын удирдлагаас Өлгий болон Дэлүүн сум дахь агро паркуудад Байгаль орчны менежментийн систем (БОМС) боловсруулах шаардлагатай. БОМС нь орон нутгийн байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалахад чиглэсэн журам, удирдамжаас бүрдэнэ. БОМС-ийг боловсруулахад ТХХТЗ тусалж дэмжих болно. БОМС нь төслийн зээлийн гэрээний нэг хэсэг байна.

с. Усалтын систем, тэжээлийн аж ахуй

i. Өлгий / Буянт сум

202. Ашиглалтгүй орхигдсон усалтын систем, тэжээлийн аж ахуйг сэргээн шинэчлэнэ. Газар хүртээмжтэй, одоо байгаа засмал зам болон цахилгаан хангамжид ойрхон байршилтайг харгалзан үзээд Буянт сумын нутагт 500га талбайг сонголоо. Усалтын системийн шинэчлэлийг гурван хэсэг болгож хэрэгжүүлнэ:

- Толгойн барилга, усалтын гол сувгийг шинэчлэн сайжруулж, тоног төхөөрөмж суурилуулна (шлюзийн хаалт г.м.). Усалгаа өөрийн урсгалаар хийгдэнэ.
- Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулна.
- Сонгосон 500га талбайг 230га , 270га болгон хуваасан хоёр хэсэгт усалгааны схемийг боловсруулахад нь хувийн хэвшилд (хоршоо буюу хувийн компани) санхүүгийн дэмжлэг (хөнгөлөлттэй зээл) үзүүлнэ.

203. Сонгосон талбай нь социалист системийн үед усалгаатай талбай байсан. Өлгий хотоос ирэхэд ойрхон бөгөөд шаардлагатай дэд бүтцүүд тухайлбал усалтын гол суваг, толгойн барилгад хялбар холбогдох боломжтой. Усалтын системийн толгойн барилга, усалгааны суваг болон 500га нийт талбайг Зураг 22-т үзүүлэв.

Figure 21. Өлгий - Буянт сумын нутагт орших усалгаатай тэжээлийн ургамлын тариалангийн талбай



Талбайн нөхцөл:

204. Услалтын талбайн хөрсний физик, химийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Хөрсний давсжилт бага (0.05%) бөгөөд энэ нь уг хөрс зохих технологийн дагуу газар тариалан эрхлэхэд тохиромжтой гэдгийг харуулж байна. Хөрсөнд агуулагдах гурван үндсэн тэжээл болох азот, фосфор, калийн ($N=0.91\text{мг}/100\text{г}$) түвшин бага байгаа нь органик бус бордоо, түүнчлэн ээлжлэн тариалалтад царгас зэрэг буурцагт ургамал ашиглах шаардлагатайг харуулж байна.

205. Хөрс нь хөнгөн хүрэн шавранцар бөгөөд 0.01-0.25мм-ийн ширхэглэл бүхий хуурай газрын бэлчээрийн хөрс $61.4\%\pm 3.7\%$; фосфатын (P) түвшин $19.7\pm 1\text{мг}/\text{кг}$; ялзмаг нь 15-20см-ийн зузаанд. Хөрсний pH 8.16 ± 0.2 буюу шүлтлэг байгаа нь малын өтөг бууцаар хийсэн компост зэрэг органик бордоо хэрэглэж шүлтлэгийг хэвийн болгох зайлшгүй шаардлагатайг илтгэнэ. Ялзмагт найрлагын түвшин хангалттай ($2.07\%\pm 0.1$) байгаа нь тариалан эрхлэхэд тохиромжтойг харуулна. Эрдэс бодисын найрлага болох кальци (Ca)= $17.89\pm 1.3\text{мг}/100\text{г}$, магни (Mg)= $5\pm 0.6\text{мг}/100\text{г}$, кали (K)= $29.3\pm 2.3\text{мг}/100\text{г}$ мөн түүнчилэн $\text{Ca}/\text{Mg}=3.9$ байгаа нь хөрсний үржил шимийг органик бус кальци (гипс юм уу шохой), кали дээр суурилсан бордоогоор сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Услалтын системийн ашиглалт:

206. Ойролцоох голоос усыг толгойн барилгаар салаалуулан татаж ил болон далд бетонон сувгаар өөрийн урсгалаар тариалангийн талбайд хүргэх ба хаалт/боолт, усалгааны машин ажиллана. Услалтын систем дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- Толгойн барилга, ил болон далд байх бетон гол суваг
- Тээлийн голын сав газрын усны хэрэглээний менежментийн төлөвлөгөө
- 5 далавчтай усалгааны машин
- Хөрс, газар тариалангийн ажилд зориулж хөдөө аж ахуйн техник хэрэгслээр тоноглогдсон 2 трактор.
- 1000 тонн багтаамжтай дарш бэлтгэх төхөөрөмж.
- Тэжээл, дарш хадгалах барилга
- Хөдөө аж ахуйн машин механизмын зогсоолд зориулсан гарааш бүхий хашаа
- 500 га талбайд хийх усалгааны схем, усалгааны машин механизмын санхүүжилт

(i) Усны хэрэгцээ

207. Өлгий/Буянт сумын услалтын систем бүхий нийт 500га тэжээлийн талбайн усалгаанд шаардагдах нийт усны хэмжээг 0.315 м³/сек байхаар тоцлоо.

Тариалах ургамал

208. Услалтын систем болон тэжээлийн аж ахуйн зорилго нь ХЦБ болон малчдыг малын тэжээлээр хангах явдал юм. Усалгаатай талбайд овъёос, арвай, улаан буудай, эрдэнэ шиш, шош/вандуй, царгас зэрэг малын тэжээлд ашиглах үр тариа, буурцагт ургамлыг хамтад нь тарьж ургацыг нь нэгтгэж тэжээл үйлдвэрлэхэд оршино. Санал болгож буй таримал ургамлуудыг хөрсний органик бүтцийг сайжруулах зорилгоор олон наст царгасны тариалалтын хуваарьт үндэслэн таван жилийн хугацаатай эргэлтийн схемээр тариална. Хогийн ургамлыг арилгах, хөрсийг зөөллөх зорилгоор төмсийг тариалангийн эргэлтийн схемд оруулна. Таван жилийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу талбайг Хүснэгт 22-т заасны дагуу 5 ээлжид хуваана. Эхний ээлжинд царгас, дараа нь эрдэнэ шиш тариалах ба үүний дараа улаан буудай, арвайг ээлжинд оруулна. Төмсийг тариалангийн талбайд сүүлчийн ургамлын өмнө тариална. Эргэлтийн хамгийн сүүлийн ургамал нь овъёос байна. Услалтын талбайн шаардлагатай хэмжээг 500га байна гэж тооцоолсон. Дарш хийхээр төлөвлөж буй ургацын хэмжээ 3100 тонн, хуурай үр тариа 200 тонн байна.

Table 17. Crop rotation and production for feedlot


Тариалах ургамал	Зориулалт	Талбайн хэмжээ (га)	Ургац (т/га)	Нийт ургац (т)
Царгас	дарш	100	2	200
Эрдэнэ шиш	дарш	100	25	2500
Улаан буудай, арвай	Хуурай үр тариа	50	2	100
	дарш	50	4	200
Төмс	Үр тариаг ээлжлэхэд	100	-	-
Овъёос	Хуурай үр тариа	50	2	100

Тариалах ургамал	Зориулалт	Талбайн хэмжээ (га)	Ургац (т/га)	Нийт ургац (т)
	дарш	50	4	200
Нийт	-	500	-	3300

ii. Дэлүүн сум

209. Орон нутгийн удирдлагуудын саналд үндэслэж сумын төвөөс баруун урагш 5км-т орших хуучин услалтын талбайг хадланд зориулж дахин ашиглахаар тогтов (Зураг 23). Өлгийтэй адилаар усалгаатай талбайгаас агропаркийн ХЦБ болон малчдад зориулж хадлан бэлтгэнэ.

Figure 22. Дэлүүн сум дахь усалгаатай тэжээлийн ургамлын тариалангийн талбай



Талбайн хөрсний үзүүлэлт

210. Ерөнхийдөө 15 см-аас багавтар зузаантай хөнгөн шавранцар хөрс (51.8% нь 0.05-0.25 мм-ийн ширхэглэлтэй хэсэг). Хөрсний химийн нөхцөл дараахь байдалтай байна: ялзмагийн агууламж дунд зэрэг (1.43%); гол эрдэс тэжээлийн түвшин ядуу, тухайлбал: кали – 24.17мг/100г, фосфор – 2.27мг/100г, азот – 0.12мг/100г, кальци – 11.33мг/100г, магни – 5.5мг/100г. Хөрсний шүлтлэг рН 7.7

Төлөвлөж буй арга хэмжээ

211. Ойролцоох голын усыг толгойн барилгаар салаалуулан татаж өөрийн урсгалаар хаалт/боолт бүхий задгай бетонон сувгаар урсгаж 200га тариан талбайд хүргэнэ. Услалтын системд дараах дэд бүрэлдэхүүн хэсгүүд орно.

- Одоо байгаа толгойн барилга, гол бетонон задгай сувгийг төсвийн хөрөнгө оруулалтаар засаж шинэчлэх
- Ус ашиглалтын менежментийн төлөвлөгөөг төсвийн хөрөнгө оруулалтаар боловсруулах
- Гадаргуугийн усжуулалтын хуваарилах бетон суваг барих ажлыг санхүүгийн зуучлагчаас санхүүжүүлэх

(i) Усны хэрэгцээ

212. Дэлүүн сумын 200га усалгаатай тэжээлийн аж ахуйд шаардагдах усны хэмжээг 0.126м³/сек байна гэж тооцов.

Ж. Ховд Аймаг

Ерөнхий тойм

213. Ховд аймгийн төв Жаргалантад хотын суурь дэд бүтцийг сайжруулах болон агро-үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг хийх болно. Хотын дэд бүтцийг сайжруулах ажлын дийлэнх хэсэг нь аймгийн төвийн төв хэсэгт хийгдэх бөгөөд агро-үйлдвэрлэлийн ихэнх үйл ажиллагаа нь төвөөс зайтай байх болно. Жаргалантад төлөвлөсөн хотын дэд бүтцийг тайлбарласны дараагаар агробизнесийн төлөвлөсөн хөрөнгө оруулалтыг танилцуулах болно.

1. Хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалт


214. Жаргалант дахь хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь дараахь 2 үндсэн бүрэлдэхүүнтэй байна:

- Гэр хорооллын дахин төлөвлөлт, нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулж шинэчлэх;
- Жаргалантын хэмжээнд нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах цогцолбор ажил нь усан хангамж, бохир ус цуглуулах, цэвэрлэх, цахилгаан, харилцаа холбоо, хатуу хог хаягдлын менежмент, зам, борооны ус зайлуулах, үерийн хамгаалалтаас бүрдэнэ.

а. Гэр хорооллын дахин төлөвлөлт

215. Жаргалантын төвийн агаарын зураглалд (Зураг 24) гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх Алагтолгой багийн байршлыг тодотгож харуулав. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний шинэчлэлийг Алагтолгой баг дээр сонгосон туршилтын гудамж дагуу гүйцэтгэнэ (Зураг 25а). Туршилтын гудамжийг шинэчлэн сайжруулах ба дахин төлөвлөлтөд хамрагдсан талбай руу инженерийн шугам сүлжээг шинээр барих буюу өргөтгөх бөгөөд үүнийг туршилтын гудамж/замын улаан шугамын дагуу хийж гүйцэтгэнэ

Figure 23. Жаргалантын Алагтолгой багийн байршил.



**** Зургийг төслийн архитектор бэлтгэв**

216. Гэр хорооллын орон сууцны дахин төлөвлөлт нь хувийн хашаанд хийгдэх бөгөөд орчин үеийн эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалаар баригдах 1-2 давхар жижиг орон сууц байх болно. Орон сууцыг дулаан, бохир ус цуглуулах хоолой, цахилгаанд холбох ба хатуу хог хаягдлыг дахин боловсруулах байгууламж байрлуулна. Ариун цэврийн болон усанд орох өрөө, угаалгын байгууламжаас бүрдэх техникийн хэсэг (ТХ) мөн багтана.

Figure 24. Жаргалант сумын Алагтолгой баг¹⁹

(a) Алагтолгой баг дахь туршилтын төслийн гудамж (цагаан шугам)



(b) Туршилтын төслийн гудамж дагуух гэр хорооллын дахин төлөвлөлт



217. Хашаа эзэмшигчид өөрсдийн хашааны тодорхой хэсгийг ТХ-т гаргаж өгөх боломжтой. Хашаа эзэмшигчдийн оролцсон зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн явцад тодорхойлсон гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажилд оролцох хувилбарыг дараах байдлаар нэгтгэсэн ба Зураг 25б-д үзүүлэв.

1. Газраа солилцохгүй ч шугам сүлжээнд холбогдсон ТХ-ийг худалдаж авах боломжтой;
2. Газрынхаа нэг хэсгийг жижиг байшин ба ТХ-ээр солилцох;
3. Хашааны газраа хэд хэдэн өрхөд зориулсан байшин, ТХ-р бүрэн солих
4. Оролцох тухай шийдвэр гараагүй байна.

b. Хотын дэд бүтцийг сайжруулах

218. 1 ба 2-р ээлжээр Жаргалант хотын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулахаар төлөвлөсөн цогцолбор ажлуудыг Хүснэгт 19-д үзүүлэв. Дэд бүтцийн сайжруулалтын ажлын тоймыг Зураг 26-д харууллаа. Төлөвлөж буй дэд бүтцийн схем зургийг 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн шатанд бэлтгэнэ. Дэд бүтцийг сайжруулах ажилд Алагтолгой багийн гэр хорооллын дахин төлөвлөлт, мөн агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт багтана (доор үзнэ үү).

¹⁹ 13-р багийн байршил, туршилтын төсөл хийгдэх гудамжны зургийг төслийн архитектор бэлтгэв.

Table 18. Жаргалантад 1-р ээлжээр төлөвлөж буй хөрөнгө оруулалт²⁰


Төрөл	Хийгдэх ажил	Тайлбар
Усан хангамж	Усны эх үүсвэр болон насосны станц, хлоржуулах системийг шинэчлэх	Худгийн барилга байгууламж, насос, хяналт, цахилгаан хангамж, хяналтын кабель утсыг сэргээн засварлах; Ус олборлолт болон тоног төхөөрөмжийн ажиллагааг хянаж, удирдах боломжтой байхын тулд урсгал, даралтыг хянах төхөөрөмжийг зохих SCADA программ бүхий удирдлагаар сольж шинэчлэх; Шаардлагатай бол барилгуудыг холбосон хоолойг сольж, хашааг дахин барьж, хяналт хамгаалалтыг сэргээнэ.
	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулж шинэ хоолой тавих	Дахин төлөвлөлт хийгдэх гэр хорооллын хэсгийг замтай зэрэгцээ явж буй одоо байгаа усан хангамжийн сүлжээнд холбох шинэ хоолой, үзлэгийн худгийн хамт
	Агро паркад зориулсан шинэ хоолой тавих	Агро паркийг одоо байгаа усан хангамжийн сүлжээнд холбох шинэ хоолой, үзлэгийн худгийн хамт
	Мал эмнэлгийн байгууламжид зориулсан худаг	Мал эмнэлгийн байгууламжид зориулсан гүний насос, удирдлага, цахилгааны холболт, бага оврын усны нөөцлүүр, худгийн барилга зэргийг багтаасан худаг барих.
Бохир ус зайлуулах	Одоо байгаа бохир ус цэвэрлэх байгууламж, насосны станцыг өргөтгөх, холбогдох барилга, төхөөрөмж	Одоо байгаа бохир ус цэвэрлэх байгууламжийг хоёрдогч цэвэршүүлэх стандартын түвшинд хүргэх, 2040 он гэхэд хоногт 3000 м3 ачаалалтай байхаар төлөвлөж байгаа бөгөөд үүнд бүх үндсэн тоног төхөөрөмжийг солих, ус нэвчилтийг зогсоох зорилгоор хоолой болон ус хадгалах савыг засварлах, хлоржуулалтын систем, цэвэрлэсэн ус зайлуулах системийг шинэчлэх ажил орно. Алслагдсан цэгээс бохир ус хаягдлыг хүлээн авах байгууламж нэмнэ. Одоо ажиллаж байгаа ЦБ-ын талбайд хийгдэнэ.
	Бага тахилт, Алагтолгой багуудийн гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан бохирын шугам хоолой	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан өөрийн урсгалынбохир ус цуглуулах хоолой, үзлэгийн худгийн хамт. Шугамыг одоо байгаа замуудтай зэрэгцээ суурилуулна.
	Агро паркад зориулсан БУЦБ, шугам сүлжээ	Цэвэрлэх байгууламжийн зураг төслийг гүйцэтгэхдээ агро паркаас гарах үйлдвэрлэлийн бохир усыг саармагжуулахаар тооцох ёстой бөгөөд ингэснээр агро паркын цэвэрлэх байгууламжаас хаягдах усыг ахуйн бохир усыг цэвэрлэх зориулалтаар төлөвлөсөн хотын цуглуулах шугам болон цэвэрлэх байгууламжид аюулгүй байдлаар нийлүүлэх болно.
Дулаан хангамж	Төрийн өмчийн дулааны станцын эргэлтийн насосыг шинэчлэх	2, 3-р ээлжийн томоохон шинэчлэх төсөл хэрэгжих хүртэл хүчин чадлыг нь сайжруулахын тулд төрийн өмчийн дулааны станцын дулаан хуваарилах насосыг шинэчлэх
	Бага тахилт, Алагтолгой багуудийн гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан дулааны байгууламжууд	Урд өмнө хийгдсэн төлөвлөлтийн дагуу АСХХОХ-ийн дахин төлөвлөлт хийгдэх гэр хороололд зориулсан дулаан түгээх болон буцах шугамуудыг ус түгээх шугамын хамт 1500мм-ийн бетонон сувагт байрлуулах ба мөн хавхлагын станцууд, хяналтын худгууд байна. Шугамыг одоо байгаа замуудтай зэрэгцээ суурилуулна.
	Агро паркад зориулсан дулааны байгууламжууд	Агро паркад зориулсан дулаан хуваарилах дэдстанц болон хавхлагын станц, хяналтын худаг бүхий дулаан түгээх болон буцах шугамуудыг ус түгээх шугамын хамт 1500мм-ийн бетонон сувагт байрлуулах. Хэрэглээнийх усыг халаах дулааны солилцуур бүхий дэд станцууд нь стандарт тохиргоотой бөгөөд барилга байгууламжийн дулаан, усны хуваарилалтыг хянах зориулалттай.
Цахилгаан хангамж	Аймгийн төвийн цахилгаан хангамжийн системийн ерөнхий сайжруулалт	Төв хуваарилах станцыг шинэчилж, үр ашгийг дээшлүүлэх 6kV-ээс 10kV болгож өргөтгөх бэлтгэл ажил. Элэгдэж хуучирсан 6/0.4kV-ийн 35 трансформаторуудыг шинэчлэх
	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулж цахилгаан хангамжийг сайжруулах	АСХХОХ-ийн гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан дэд станцууд
	Агро паркад зориулж цахилгаан хангамжийг сайжруулах	Төв хуваарилах станцаас агро парк руу татах агаарын шугам, агро парк дахь бүрэлдэхүүн хэсгүүдийг хангах 10/0.4 kV дэд станц

²⁰ АСХХОХ-ийн Эцсийн тайлангийн II боть, Хавсралт 3 дахь инженерийн шийдлээс тодотгож авсан болно..


Төрөл	Хийгдэх ажил	Тайлбар
Харилцаа холбоо	Аймгийн төвийн харилцаа холбоог сайжруулах	Аймгийн төвөөс авах болон төв рүү өгөх мэдээллийн дамжуулалт найдвартай болгох, хүчин чадлыг сайжруулах зорилгоор кабель солих
	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулж харилцаа холбоог сайжруулах	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсийн оршин суугчид болон аж ахуйн нэгжүүд, зэргэлдээх газруудад интернет, IP телевиз, утасны үйлчилгээ үзүүлэх
	Агро паркад зориулж харилцаа холбоог сайжруулах	Агро парк дахь аж ахуйн нэгжүүд, зэргэлдээх газруудад интернет, IP телевиз, утасны үйлчилгээ үзүүлэх
Зам	Хотын төв, гэр хороолол, агро паркад зориулсан шинэ зам	Гэр хорооллын 2.2км шороон замуудыг хатуу хучилттай болгох ба гэрэлтүүлгийг сайжруулж, явган хүний зам гаргана. Агро паркыг хамгийн ойр орших хучилттай замд холбох гэрэлтүүлэг, явган хүний зам бүхий 0.2км хатуу хучилттай зам
Дренаж	Жаргалант сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэх дренажийг шинэчлэх ажлууд	Борооны усыг дахин төлөвлөлт хийгдсэн гэр хороолол болон түүний ойр орчмоос зэргэлдээ суурин газар руу хүргэхгүйгээр зайлуулахын тулд доторлогоотой суваг, шуудууг барина. Дахин төлөвлөлт хийгдэх газруудад ус зайлуулах байгууламжийг багтаахгүй бөгөөд эдгээр зураг төслийг зохицуулах ёстой. Ус зайлуулах байгууламжийг аль болох одоогийн замуудтай зэрэгцээ байгуулна. Эдгээр ажлууд нь ус зайлуулах дренажны шугамын мастер төлөвлөгөөг боловсруулж, батлуулсаны дараа 1-р ээлжид эхэлж цааш 2, 3-р ээлжид үргэлжлүүлэн хийгдэнэ.
Үерийн хамгаалал	Ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэх хотын төвийг үерээс хамгаалах суваг, ус тогтоох цөөрөм	Үерийн хамгаалалтыг далан болон цөөрөмтэй нэгтгэснээр дренажаар ирсэн усыг усжуулалтын хэрэгцээнд дахин ашиглах зориулалт бүхий үерийн хамгаалалтын сувгийг хотын өмнөд болон зүүн захад үе шаттайгаар барих
Хатуу хог хаягдал	Талбайд анхан шатны цэвэрлэгээ хийх, эн тэргүүнд хийх ажлууд, хашаа барих, хяналтын цэг байгуулах	Эхний шатанд хийгдэх ажлууд: - Одоо байгаа хог хаягдлын талбайг нэгтгэж цаашид ашиглаж талбайг тодорхойлж, хашаа болон хяналтын цэг барих, хамгаалалт гаргах. - Өнөөгийн байдлаар хэрэглэгдэж буй муу дадал зуршлыг засаж залруулахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлэх - Хогийн цэгийг цэвэрлэх ажлыг эхлүүлэх - Хог хаягдлыг зориулалтын битүү чингэлгээр цуглуулах туршилт эхлэх

Figure 25. 1-р ээлжээр Жаргалантад хийгдэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тойм зураг


a) Усан хангамж ариутгах татуурга




b) Дулаан хангамж



с) Цахилгаан хангамж



d) Үерийн хамгаалалт



(i) **Хүснэгт 18-д үзүүлсэн байгаль орчны хувьд эмзэг байхуйц зарим дэд бүтцийн талаархи тайлбар**

(АСХХОХ-ийн Эцсийн тайлангийн II-р боть дахь инженерийн танилцуулгаас иш татав)

Бохир ус зайлуулах:

219. Жаргалант хотын механик цэвэрлэх байгууламж нь 1987 онд баригдсан ба 2012 онд шинэ агаар үлээгч төхөөрөмж, насос, хлоржуулалтын системээр тоноглогдсон. Цэвэрлэх байгууламжийн тооцоот хүчин чадал нь хоногт 7,200 м³ бөгөөд одоогийн байдлаар хүлээж авсан хамгийн их хэмжээ нь 4800 м³/хоног боловч байгууламжийн цэвэрлэгээний түвшин нь ердийн ашиглалтын үед 50% -60% байдаг гэсэн мэдээ бий. БУЦБ-аас гарсан усыг Буянт голын нэг салаа болох жижиг голоос 300 м-ийн зайд байрладаг доторлогоогүй тунгаах цөөрөм рүү урсгадаг.

220. Жаргалантын цэвэрлэх байгууламжид цэвэрлэгдсэн усыг зайлуулж хаях талаарх үндэсний болон олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн засвар, шинэчлэлт хийх шаардлагатай байгаа боловч одоогоор аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх хөтөлбөрт тусгагдаагүй байна. Цэвэрлэх байгууламжид шаардлагатай засвар шинэчлэлтийн ажлуудыг тодорхойлохын тулд 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн шатанд нарийвчилсан дүн шинжилгээ, сайжруулалтын зураг төслийг боловсруулна. Гэхдээ эдгээр засвар шинэчлэлтийн ажлууд нь цэвэрлэгээний түвшин байгаль орчны шаардлагыг хангахын зэрэгцээ 2045 он хүртэл бохир усыг зохих ёсоор цэвэрлэх хүчин чадалтай байх ёстой. 1-р ээлжээр хийгдэх шинэ цэвэрлэх байгууламжийн зэрэгцээ одоо байгаа бохирын насос станцыг шинэчлэх, хотын бохир ус цуглуулах сүлжээг шинэ БУЦБ-тай холбох даралтат шугамыг шаардлагатай.

221. Агро паркаас гарах бохир ус нь зөвхөн ахуйн бохир ус цэвэрлэх зориулалттай хотын цэвэрлэх байгууламжид тохирохгүй тул агро паркаас гарах бохир усанд анхан шатны цэвэрлэгээ хийх зориулалт бүхий хоногт 250 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламж барина. Энэ арга хэмжээ нь агро паркийн бохир усыг хотын цэвэрлэх цэвэрлэх байгууламжийн ашиглалтад нөлөөлөхгүйгээр бохир ус цуглуулах системээр дамжуулан зайлуулах боломж бүрдүүлнэ. Гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх Тахилт, Алагтолгой багууд болон хотын бусад гэр хорооллыг хотын бохир ус цуглуулах сүлжээнд холбох зориулалтаар даралтат бохирын шугам тавих шаардлагатай болно.

Дулаан хангамж:

222. Жаргалантын барилгажсан хэсгийн дулааныг нүүрсээр ажилладаг дулааны хоёр цахилгаан станцаар хангадаг. 1990 оны эдийн засгийн шилжилтийн дараа хувьчлагдсан анхны станц нь хотын хойд хэсэгт үйлчилдэг. Хувьчилж авсан компани нь өөрсдийн санхүүгийн эх үүсвэрээр түгээх сүлжээг хэсэгчлэн засварлаж, сайжруулсан. Төрийн өмчит дулааны станц нь 2014 онд ашиглалтад орсон бөгөөд Жаргалант сумын 50 орчим хувь буюу 1600 айл, 24 байгууллага, 25 аж ахуйн нэгжийг дулаанаар хангаж байна. Уг үйлдвэр нь 3 бойлороор 14 МВт үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд одоо бараг бүрэн хүчин чадалд тултал ажилладаг байна. Аймгийн удирдлагаас тус станцын хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлэх шинэчлэл хийх санал тавьсан.

223. Төрийн өмчийн станц нь 6100-6200 ккал/кг шаталтын үзүүлэлт бүхий нүүрсээр 80%-85%-ийн үр ашигтай ажиллах зураг төсөлтэй боловч нүүрсний чанар муу, шаталтын үзүүлэлт нь 4200 ккал/кг байгаа тул одоогийн байдлаар дөнгөж 55%-ийн үр ашигтай ажилладаг бөгөөд утааны найрлага нь стандартын шаардлагыг хангадаггүй. Энэ станц

нүүрсээ Ховд дахь дулааны станцыг эзэмшиж ажиллуулдаг хувийн компанийн эзэмшдэг Хөсөргийн уурхайгаас авдаг бөгөөд энэ нь тус станцын нүүрсээ авах цорын ганц эх үүсвэр юм.

224. Төрийн өмчийн дулааны станцад холбогдсон дулааны шугам сүлжээнүүдийн дийлэнх хэсэг нь харьцангуй шинэ, сайн ажиллаж байгаа боловч 1960-аад онд баригдсан зарим хуучин хэсгүүд бий. Ховдын дулааны станц нь зөвхөн хүйтний улиралд (10-р сарын 1-ээс 5-р сарын 1-ний хооронд) ажилладаг тул бусад үед оршин суугчид, албан байгууллагууд усаа өөрсдөө ихэвчлэн цахилгаан халаагуураар халаадаг.

225. Халаалтын сүлжээнд холбогдоогүй айл өрхүүд нүүрс, мод, аргал түлж халаадаг энгийн зуух ашигладаг. Арай томхон хэмжээний барилгуудыг нүүрс голчлон ашигладаг тохируулгагүй, нам даралтын шаталтын зуухаар халаадаг.

226. Жаргалантад халаалтын хүчин чадлыг нэмэх шаардлагатай байна. Одоо байгаа төрийн өмчийн дулааны станц нь зэрэглэл багатай нүүрснээс шалтгаалж төсөллөсөн чадалдаа хүрч ажиллаж чадахгүй байгаа тул энэ асуудлыг шийдтэл үйлдвэрийг өргөтгөх төлөвлөгөө гаргах нь үндэслэлгүй юм. Энэ асуудлыг нэг бол зуухыг зэрэглэл багатай нүүрс шатаах хэмжээнд тохируулж өөрчлөх, эсвэл нүүрс авах эх үүсвэрийг өөрчлөх замаар хийх боломжтой бөгөөд АСХХОХ нь хувилбаруудыг тодорхойлж, шийдлийг санал болгох зорилгоор техникийн тусалцааны судалгаа хийнэ.

227. 1-р ээлжээр одоо ажиллаж байгаа төрийн өмчийн станцын эргэлтийн насос системд зориулагдсан зарим нэг багавтар шинэчлэлийг санхүүжүүлэх бөгөөд энэ нь дахин төлөвлөлт хийгдэх гэр хорооллыг оролцуулан өргөтгөх түгээлтийн сүлжээний хүчин чадлыг сайжруулах болно. Агро паркийг дулаанаар хангах шинэ дулааны дэд станц шаардлагатай бөгөөд Ø150 голчтой усан хангамжийн хоолой, Ø200 голчтой дулааны шугам хоолойг бетон сувагт зэрэгцүүлэн суурилуулж шинэ дэд станцыг хотын дулаан түгээх сүлжээнд холбоно.

Тахилт болон Алагтолгой багууд дахь гэр хорооллын дахин төлөвлөлт хийх бүсэд ахуйн халуун ус болон цэвэр ус дамжуулах дулаан хуваариалах дэд станц барих шаардлагатай. Дэд станцын байршлыг Ховд хотын ерөнхий төлөвлөгөөнд өмнө нь тогтоосон байсан бөгөөд энэ нь хоолойн холболтын зураг төсөл хийх болон ашиглалтыг хялбар дөхөм болгоно. Эдгээр хоолойнуудыг одоо байгаа гудамжны дагууд далд тавьсан бетонон сувганд Монгол улсын барилгын стандартын дагуу угсарч суурилуулна.

Хатуу хог хаягдал

228. Өлгий, Улаангомтой нэг адил Жаргалант хатуу хог хаягдлын менежментийн өнөөгийн байдал нь түүнийг байгаль орчны стандарт, практик шаардлагыг хангахуйц хэмжээнд хүртэл хурдан хугацаанд шийдвэрлэхэд хэтэрхий ахадсан нь асуудал болж байна. Бусад аймгуудтай харьцуулахад Жаргалантад зарим нэг ажил хийж эхэлсэн бөгөөд гэхдээ бусад аймгийн төвүүдийн хогийн цэгийн хэмжээ харьцангуй том юм.

Жаргалантын хогийн цэг нь суурьшлын бүсийн зүүн өмнөд хэсэгт нэлээн ойрхон зайд байрладаг бөгөөд хяналтгүй үйл ажиллагааны улмаас 280 га талбайг хамарч тэлжээ. Хотын зүгээс хогийн цэгийг хэсэгчлэн хааж, нэвтрэх хаалга, харуулын хэсэг бүхий 600 м хашаа барьсан боловч АСХХОХ-ийн багийн ажилтнууд тус талбайд очиж үзэхэд хогийг хашааны гадна талд хаяж асгасан нь ажиглагдсан. Нөлөөлөлд өртсөн газрын ихээхэн хэсэг нь салхинд хийссэн хог хаягдал бөгөөд тэдгээрийг хурааж хумих, далдлах хүн хүч, тоног төхөөрөмж байхгүй байна.

229. Хатуу хог хаягдлыг цуглуулах, устгах ажлыг хариуцдаг Жаргалант сумын удирдлагаас хотыг нийтэд нь хамарсан албан ёсны хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх системийг төлөвлөж байгаа боловч хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц хомс байна. Зарим нэг зохион байгуулалттай хийгддэг ажил бий боловч арилжааны болон аж ахуйн нэгжийн хог хаягдлыг тээвэрлэх, устгах ажлыг холбогдох байгууллагууд өөрсдөө хариуцдаг.

230. Дулааны станцуудын үнсийг хотын хогийн цэгээс тусад нь хаядаг боловч хотын хог хаягдлын нлээн хувийг жижиг зуух, бойлерийн үнс эзэлдэг. Хогийн цэг нь хотын суурьшлын бүсээс зүүн өмнөд хэсэгт өндөрлөг талбайд байрладаг. Хогийн цэгийн орчимд гадаргад ойр байхуйц гүний ус байгаа шинж тэмдэг үгүй хэдий ч хогийн талбайгаас урсах борооны ус хөрсөнд шингэх замаар бохирдлыг дамжуулах боломжтой. Аймгийн зүгээс хогийн талбайгаас гарах усыг ойролцоох задгай газар руу зөөж урсах доторлогоотой сувгийг талбайн доод ирмэгийн дагуу барьжээ.

Сумын удирдлага Жаргалантад хог дахин боловсруулах чиглэлээр хийх хөтөлбөр хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа боловч нарийвчилсан төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэргүй байна. Хатуу хог хаягдал ашигласны төлбөрийг аймгийн удирдлагаас тогтоодог бөгөөд хураамжийн орлогыг ашиглалтын зардлыг нөхөх эсвэл томхон шинэчлэлтийн ажилд шууд зарцуулдаггүй байна.

231. АСХХОХ-ийн 1-р ээлж нь Жаргалантад өнгөрсөн хугацаанд хяналтгүй хаягдсан хогийг цэвэрлэх, зайлуулах, газар нутгийг нөхөн сэргээх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой менежментийн системтэй болгох эхний үе шат байх болно. Энэ арга хэмжээ нь техникийн туслалцаа болон гүйцэтгэх ажлуудыг хосолсон байх болно. Тухайлбал:

- Хог хаягдлын төрөл, физик нөхцөл байдал (хөрс, гүний ус, газрын гадарга), одоо байгаа хог хаягдалд үндэслэн тухайн газрыг цаашид ашиглах төлөвлөгөөтэй уялдуулж нөлөөллийг нь арилгах, юм уу багасгах шаардлагатай ямар хор хөнөөл байгаа эсэх зэрэг өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлно. Үүний дүнд хогийн талбайг цэвэрлэх, сайжруулахад зориулсан арга хэмжээний зөвлөмж бэлдэх ба өрөмдлөг, гүний усны дээж авах, усны чанарын анализ хийх ажлууд үүнд орсон байна.
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэж хаях, зардал нөхөх механизм болон чадавхийг хөгжүүлэх хэрэгцээ, үе шаттайгаар цэвэрлэгээ хийх, нөхөн сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг орон нутгийн түвшинд эхлүүлэх.
- Цаашид хог хаягдлын талбай болгон ашиглахаар тогтож буй газарт одоо байгаа хогийн талбайг нэгтгэх, эргэн тойронд нь нэвтрэх хяналт, хамгаалалтын цэг бүхий хашаа барих (15 га).
- Гүний усны бохирдол зэрэг нийгмийн эрүүл мэндэд учирч буй аливаа буруу дадал зуршлыг засахад чиглэсэн эн тэргүүний ажлуудыг эхлүүлэх.
- Хог дахин боловсруулж ашиглах чиглэлээр судалгаа хийх, боломжуудыг холбогдох зардал, үр ашгийн хамт тодорхойлж боловсруулах, үүнийг аймаг, бүс нутгийн хөтөлбөртэй уялдуулах
- 2, 3-р ээлжээр төвлөрсөн санхүүжилтээр хийгдэж болох шинэ барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах
- Одоо байгаа хогийн цэгийг цэвэрлэж эхлэх.
- Хотын төв ба гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх хэсэгт 50 ш хогийн сав тавьж 5 ачааны машинаар хатуу хог хаягдлыг цуглуулж ачих туршилтыг эхлүүлэх

2. Жаргалант дахь агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт

232. АСХХОХ-ийн 1-р ээлжээр Жаргалантад агро-үйлдвэрлэлийн барилга байгууламжийг барих бөгөөд сумын төвийг хамрахгүй. Мөн Ховд аймгийн хөрөнгө оруулалтад услалтын систем, тэжээлийн аж ахуй хамрагдахгүй болно. Жаргалантад дараах гурван төрлийн агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт хийгдэнэ. Үүнд:

- (а) Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд зориулсан олон нийтэд түшиглэсэн төсөл
- (б) Агро парк
- (в) Услалтын систем, тэжээлийн аж ахуй

А. Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд зориулсан олон нийтэд түшиглэсэн төслүүд

233. Мал аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор малчдад зориулсан олон нийтийн бичил төслүүдийг төслөөс санхүүжүүлнэ. Малчид нь дэмжлэг авахын тулд орон нутгийн Бэлчээр ашиглагчдын бүлгийн гишүүн байх ёстой. Бэлчээр ашиглагчдын бүлгийн гишүүд нь ажиллах хүчний болон эсвэл мөнгөн ба эд материалын дэмжлэг үзүүлнэ. Одоогоор бичил төслүүдийн байршил тодорхой болоогүй байна.

234. Санхүүжилтээр дэмжих олон нийтийн жишиг бичил төслийн төрлүүдийг дурдвал:

- Хадланд зориулсан хамгаалалттай нутаг: голын ойролцоох бэлчээрийн 15 га газрыг сонгон авч, чулуун хашаагаар хашна. Гадаргуугын усалгаа хийхэд зориулсан сувгийн далан, гол ба хуваарилах сувгийн голдирлыг тогтооно.
- Жижиг тоног төхөөрөмж, ачааны машин: бэлчээрийн менежментийг дэмжих зориулалтаар хөдөө аж ахуйн машин төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглогдсон жижиг оврын трактораар хангана.
- Хадлан, тэжээл хадгалах байр сав
- Мал самнах, ноос хяргах хэрэгсэл, төхөөрөмж, хадгалах байр савны хамт мөн ариутгал угаалгын онгоц.
- Малын хашаанд өвөл хэрэглэх салхи хаах саравч
- Усны худаг: шинээр 6 худаг барьж, хуучин 4 худгийг сэргээн засварлана.
- Мал угаалгын газар.
- Мал услах байгууламж.
- Жижиг гүүр, голын гарам, шороон зам засах.

б. Агро парк

235. Жаргалантын агро парк нь хорио цээрийн бүс, мал төхөөрөх үйлдвэр, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээ, судалгаа шинжилгээний төв, бизнес төв, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдээс бүрдэх ба Жаргалантын яг зүүн талд байрлана (Зураг 27). Агро паркийг Жаргалантад хийхээр төлөвлөж буй хотын дэд бүтэцээр үйлчилж хангах болно.

i. **Хорио цээрийн бүс**

236. Хорио цээрийн бүсэд дараах байгууламж байна:

- Хяналтын лаборатори, үзлэгийн бүс
- Малын өвчнийг хянах зориулалттай хорио цээрийн бүс дэх мал тэжээх цэг.

Figure 26. Жаргалант дахь агро паркийн байршил



237. Хорио цээрийн бүс нь 1000 толгой мал багтаах хүчин чадалтай бөгөөд малын гоц халдварт өвчин гарсан тохиолдолд юм уу экспортын хэрэгцээнд зориулан хоёроос гурван долоо хоног тусгаарлах боломжтой. Бод, бог малд шаардагдах талбайн хэмжээ дунджаар нэг малд 10м² байх тул бүсийн болон тэжээлийн талбай нийтдээ 1га болно. Үүн дээр нэмж хяналт шалгалтын хэсэг, лабораторийн байрт 0.5га, малын хашаа саравчинд 0.5га, өвс, тэжээл хадгалах хашаанд 0.5га, мал төхөөрөх хэсэгт 0.5га, талбайд хөдөө аж ахуйн техник хэрэгслийн зогсоолын талбайд 0.5га-г тус тус гаргана.

238. Хорио цээрийн бүсэд малыг хоёроос гурван долоо хоног тусгаарлах хугацаанд зарцуулах өвс, тэжээлийн нөөц хангалттай байх болно. 25-р хүснэгтэд өвс, тэжээлийн нийт нөөцийг 2,592 тн гэж тооцсон ба үүнд зуны сүүлчээр нэг удаа хийх хадлангийн хэмжээг оруулсан болно.

Table 19. Өвс тэжээл хадгалах хэрэгцээ, Жаргалант

	Өдрийн хэрэгцээ, кг	Малын тоо толгой	Хэрэглэх өдөр	Жилд хэрэглэх давтамж	Нийт хэрэгцээ, кг
Бог мал	1.5	800	18	12	259,200
Бод мал	7	200	18	12	302,400
Нийт					561,600

** Хүснэгтийг төслийн ХАА-н баг бэлтгэв

40.239.ХЦБ дэх өвс тэжээлийн цэг нь дараах онцлог зүйлүүдээс бүрдэнэ:

- Хорио цээрийн болон тэжээлийн цэгийг тусгаарлах зорилгоор 1га талбайн гадуур 1.5м өндөртэй чулуун хашлага хийнэ
- 5000 м2 талбай бүх цас, шуурганаас хамгаалах саравч
- Нийт 500 тоннын багтаамж бүхий өвс хадгалах давхарлагаатай агуулах (хэтрүүлж/замбараагүй хэрэглэхээс сэргийлэх зорилгоор)
- Малд тэжээл тавьж өгөх сав
- Мал услах ус, усан хангамжийн холболт.
- Ойролцоох засмал замтай холбох 2км авто зам
- Хөдөө аж ахуйн техник хэрэгслийн зогсоолын талбай
- Мал эмнэлгийн үзлэгийн төв, лабораторийн байр

240. Жаргалант дахь ХЦБ-д мал эмнэлгийн үйлчилгээ, өвчин эмгэг, чанарын хяналт шинжилгээний үндсэн лабораторийн нэг хэсэг болох үзлэгийн лаборатори, малын хяналтын бүс багтана. Мал, амьтны гаралтай өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эмнэлзүйн үйлчилгээ, хорио цээрийн бүсэд хийх үйл ажиллагаа зэргийг зохих ёсоор хийж гүйцэтгэхэд нь зориулж Жаргалант дахь Мал эмнэлгийн газрыг тоног төхөөрөмж, лабораторийн хэрэгсэл бүхий зориулалтын барилгаар хангах шаардлагатай.

241. 2018 оноос Мал эмнэлгийн газар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас салсан тул шинэ офистой болох шаардлагатай болж байна. Офис болон лабораторийг агро паркийн нэг байранд нэгтгэнэ (дор агро паркыг үзнэ үү). Лабораторийн үндсэн тоног төхөөрөмжийг 21-р хүснэгтэд үзүүлэв.

Table 20. Лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн жишиг

	Нэр төрөл	Зориулалт	Шаардлагатай хэмжээ
Тоног төхөөрөмж			
1	Термостат	Дээж сорьц, шил хатаах	2 ш
2	Автоклав	Багаж хэрэгсэл, шил ариутгах	2 ш
3	LC tandem MS	Мах, хүнсний бүтээгдэхүүн дэх антибиотик, пестицид, шавьж устгагч хор зэрэг хорт бодисыг тодорхойлох	1 ш
4	NIR спектроскоп	Сүү болон бусад бодис дахь өөх тос, чийгшил, нүүрс ус, чихрийг тодорхойлох	1 ш
5	Центрифуг	Төрөл бүрийн биологийн дээжээс тунадас ялгах	2 ш
6	pH-хэмжигч	Дээжийн хүчиллэг байдлыг тодорхойлох	2 ш

	Нэр төрөл	Зориулалт	Шаардлагатай хэмжээ
7	Микроскоп	Анализ шинжилгээ хийх	2 ш
8	Мал эмнэлгийн төхөөрөмж бүхий машин	Явуулын лабораторийн үйлчилгээ	1 ш
9	Эвхдэг хашаа	Мал эмнэлгийн арга хэмжээний үеэр мал хаших	7 ш
10	Ариутгалын онгоц	Мал угаах, ариутгах зориулалттай	7 ш
11	Хамгаалалтын юүдэн	Асептик тусгаарлалтын зориулалтаар	1 ш
Жижиг хэрэгсэл			
1	Хаяг, шошго	Цус болон биологийн бусад дээжид	40,000 ш
2	Шошго хадгалах хайрцаг	Дээж хийж тээвэрлэх	40 ш
3	Биологийн хуруун шил	Цусны дээжид	40,000 ш
4	Ариутгасан зүү	Цус авах тариурт хэрэглэх	40,000 ш
5	Зүүний тавиур	Цусны дээж авахад	400 ш
6	Бээлий	Халдвараас сэргийлэх	500 box
7	Лабораторийн хамгаалалтын хувцас	Халдвараас сэргийлэх болон ариутгалын ажилд	1000 ш
8	Галзуу өвчнийг хурдан шалгах лабораторийн иж бүрдэл	Хөдөө орон нутагт шинжилгээ хийхэд	40 ш
9	Үхрийн боом өвчнийг хурдан шалгах лабораторийн иж бүрдэл	Хөдөө орон нутагт шинжилгээ хийхэд	40 ш
Сургалт, чадавхи бэхжүүлэх арга хэмжээнд зориулж			
1	Зөөврийн компьютер	Хөдөө орон нутагт мэдээлэл боловсруулах	1 ш
2	Суурин компьютер	Офист мэдээлэл боловсруулах	1 ш
3	Дэлгэцийн проектор	Мэдээллийг танилцуулах	1 ш
4	Микрофон	Мэдээлэл боловсруулах	1 ш
5	Өнгөт хэвлэгч	Мэдээлэл хуваалцах/түгээх	1 ш
6	Өргөн дэлгэц	Мэдээлэл хуваалцах/түгээх	1 ш

(i) Усны хэрэгцээ

242. Жаргалант дахь ХЦБ-ийн усны хэрэгцээг ундны усны хувьд хоногт 2.6м^3 , боловсруулалтад хэрэглэх усыг хоногт 50м^3 -ээр тооцлоо

ii. Мах боловсруулах үйлдвэр

243. Жаргалантад мах боловсруулах гурван үйлдвэр ажилладаг. Одоо байгаа үйлдвэрүүд өдөрт ойролцоогоор 600 толгой мал хүлээн авах хүчин чадалтай боловч тэдгээрийн аль нь ч бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй байна. Энэхүү төсөл нь ХЦБ-ийн ойролцоо мах боловсруулах үйлдвэр байгуулахад нь хувийн хэвшилд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Боловсруулах үйлдвэрийн хүчин чадал нь өдөрт 150 бод, 600 бог мал байх бөгөөд жилд 8 сар ажиллана. Мах боловсруулах, хадгалах байгууламжийн зураг төслийг үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах асуудлын хувьд НҮБ-ын Хүнс ХАА-н байгууллага (1988), ДЭМБ-ын (1984) стандартад нийцүүлсэн байх болно.

Усны хэрэгцээ

244. Жаргалант дахь мах боловсруулах үйлдвэрийн усны хэрэгцээг ундны усны хувьд хоногт 105м^3 , мах боловсруулалтад хэрэглэх усыг оруулаад нийтдээ хоногт 210м^3 -ээр тооцлоо.

(iii) Мах боловсруулах үйлдвэрийн зураг төслийн стандарт

245. Жаргалант дахь мах боловсруулах, хадгалах байгууламжийн зураг төслийг дээр Улаангом, Өмнөговь сумын тайлбарт дурдсанчилан ашиглалтын болон байгаль орчныг хамгаалах асуудлын хувьд НҮБ-ын Хүнс ХАА-н байгууллага (1988), ДЭМБ (1984) болон бусад олон улсын стандартад нийцүүлсэн байх болно.

iii. Боловсруулах үйлдвэр, хадгалалт, бизнесийн инкубацийн үйлчилгээ

246. Агро паркийн төлөвлөсөн бусад чиг үүрэг нь жижиг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийг дэмжихэд чиглэнэ. Агро парк нь бизнесийн болон агро үйлдвэрлэлийн боломжуудын маш олон төрлийн санааг хөгжүүлж, үүгээрээ орон нутгийн агро-үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөгөөг дэмжиж туслах болно гэж үзэж байна. Боловсруулах үйлдвэрийн жишээнд сүү цагаан идээний ферм, хүлэмж, хүнсний ногоо боловсруулах, арьс шир боловсруулах, ноос боловсруулах үйлдвэр орно.

Усны хэрэгцээ

247. Агро паркад төлөвлөж буй боловсруулах үйлдвэрүүдэд шаардагдах усны хэмжээг дараах Хүснэгт 22-т нэгтгэв.

Table 21. Агро паркийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд шаардлагатай усны тооцоот хэмжээ

Ноосны үйлдвэр	Нэхий боловсруулах үйлдвэр	Сүү цагаан идээний ферм	Хүлэмжийн аж ахуй	Хүнсний ногоо боловсруулах
Хэрэглээний ус: 1 т бүтээгдэхүүнд 1.0 м^3 , Ундны ус: 1000 л/хоног	Хэрэглээний ус: $0.1\text{ м}^3/\text{т}$, ундны ус: 100 л/хоног	Ундны ус: 1 м^3 сүүнд 1.5 м^3	Хэрэглээний ус: $1.0\text{ л}/\text{м}^2$, ундны ус: 100 л/хоног	1 т бүтээгдэхүүнд 1.0 м^3

iv. Байгаль орчны менежментийн систем

248. Аймаг, сумын удирдлагаас Өлгий болон Дэлүүн сум дахь агро паркуудад Байгаль орчны менежментийн систем (БОМС) боловсруулах шаардлагатай. БОМС нь орон нутгийн байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалахад чиглэсэн журам, удирдамжаас бүрдэнэ. БОМС-ийг боловсруулахад ТХХТЗ тусалж дэмжих болно. БОМС нь төслийн зээлийн гэрээний нэг хэсэг байна.

НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨЖ БУЙ ОРЧНЫ ТОДОРХОЙЛОЛТ

249. Монгол орны гео-физикийн орчин маш олон янз байх бөгөөд өндөр уул, уулын тайга, ойт хээр, тал хээр, хагас цөлөрхөг тал, цөл гэсэн 6 бүсэд хуваагддаг. Нутгийн хойд хэсгийг ой, уулархаг нутаг, өмнөд хэсгийг цөл, цөл хээр, нам дор тал бүхий хээр эзэлдэг. Нутгийн баруун хэсгийн ихэнхийг Монгол Алтай, Хангайн мөнх цас, мөсөн гол бүхий өндөр уулс эзэлдэг бол зүүн хэсгээрээ өргөн уудам тал нутагтай. Нийт нутгийн 81 орчим хувь нь далайн түвшнээс 1000м-ээс дээш өргөгдсөн, дундаж өндөр нь 1580 метр. Хамгийн өндөр цэг нь Баян-Өлгий аймаг дахь 4374 м өндөр Алтай Таван богд, хамгийн нам дор цэг нь 560 метрт орших Дорнод аймгийн Хөх нуурын хотгор болно.

3. Газар зүй, байр зүй

250. Аймаг, сум хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төслийн хамрах хүрээ нь баруун гурван аймгийн төв Баян-Өлгий аймгийн төв Өлгий, Ховд аймгийн төв Жаргалант, Увс аймгийн төв Улаангом мөн Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум, Увс аймгийн Өмнөговь сумд болно.

251. Монгол орны баруун хэсэгт Хятад улстай хиллэх өмнөд хилийн дагуу сунаж тогтсон Алтайн нуруу зонхилох бөгөөд, Их нууруудын хотгор руу доошлоно. Монгол орны зүүн хэсэгт жигдхэн үргэлжлэх тал хээр нутаг давамгайлдаг.

а. Увс аймаг

252. Улаангом хот нь Увс нуурын баруун хэсэгт, далайн төвшнөөс дээш 939 м өндөрт 34 км² нутаг дэвсгэрийг эзэлж, Улаанбаатар хотоос 1333 км зайтай оршдог. Увс аймагт Цагаан дэглий, Мөст, Цагаан шувуут зэрэг мөх цаст уулс, загасаар элбэг Увс, Хяргас, Ачит, Үүрэг зэрэг том, жижиг 40 гаруй давст болон цэнгэг уст нууруудаас гадна өтгөн ой, уудам хээр бий. Монгол орны баруун хэсэгт орших Увс аймаг нь Ханхөхий, Хархираа, Түргэн зэрэг уул нурууд байхаас гадна Увс нуурын хотгорт элсэн говь бий. Хамгийн өндөр уул нь 4116 м өндөр Хархираа уул. Хархираа, Түргэний уулс нь харьцангуй залуу, атираат уулс юм. Увс нуурын хотгорын хамгийн нам дор газар нь далайн түвшнээс 758.9 м-т байдаг бол аймгийн харин хамгийн өндөр цэг нь Хархираа-Түргэний оргил 4126 м өндөр юм.

б. Баян-Өлгий аймаг

253. Өлгий төвтэй Баян-Өлгий аймгийн нийт нутгийн 95% нь далайн түвшнээс дээш 1600 м өндөр, Монгол улсын хамгийн өндөрт орших аймаг бөгөөд хамгийн өндөр болох Хүйтэн уул нь 4373 м өндөр. Орос, Казахстан Хятад, Монгол улсуудыг дамнан тогтсон Алтайн нуруу нь Европ, Зүүн Азийн соёлын хоорондох байгалийн хил болдог. Алтайн уулс бол Монголын хамгийн өндөр хэсэг бөгөөд эдгээр уулсын сүүдэрт мөсөн голууд элбэг бий. Нэлээн хэдэн нуур, гол түүн дотор Монгол орны хамгийн урт нь болох Ховд гол Алтайн уулсаас хайлсан цасны усаар тэжээгддэг. Таван богд ууланд цэнгэг устай 3 том нуур байдаг нь Ховд гол эх авдаг Хурган, Хотон, Даян нуур. Өөр нэг том нуур бол зүүн өмнөд хэсэгт орших Толбо нуур бөгөөд Ховд хүрэх зам дагуу нэлээн хэдэн км үргэлжилж тогтсон. Хамгийн том нуур бол Увс аймгийн хил дээр орших Ачит нуур. Энэ нуур зэгсэн шугуй ихтэй “Дэвэлийн арал” байгалийн нөөц газрын хойд хэсэг бөгөөд маш олон тооны шувууд амьдардаг. Гол мөрний хөндийгөөс алслагдсан Баян-Өлгий нь ихэнхдээ хуурай, бага зэрэг талархаг хээр бүхий уулархаг нутагтай.

с. Ховд аймаг

254. Жаргалант төвтэй Ховд аймаг нь Монгол Алтайн нуруу, Их нууруудын хотгор, Алтайн хойд говийн нутгийг хамарсан өргөн уудам газар нутагтай. Баруун талаараа БНХАУ-тай, баруун хойд талаараа Баян-Өлгий, зүүн болон зүүн хойд талаараа Завхан, урд талаараа Говь-Алтай аймагтай хиллэдэг. Хилийн нийт урт нь 1522 км. Хойноос урагш 453 км, зүүнээс баруун тийш 249 км бөгөөд далайн түвшнээс дээш 2230 орчим метрийн өндөрт байрладаг. Ховд аймаг нь Цамбагарав, Дарви, Баатар, Хөх Сэрхийн нуруу, Мөнх хайрхан, Жаргалант, Сутай, Мянган угалзат, Алтан Хөхий зэрэг олон тооны мөнх цасан оргилт нуруудтай бөгөөд аймгийн нутаг дэвсгэрийн 20 хувийг говь цөлийн бүс эзэлдэг.

4. Геолги

255. Баруун гурван аймаг дахь төслийн хамрах талбай нь Монгол Алтайн өндөр уулын бүсэд байрлана. Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц нь Палеозойн болон Мезозойн эринд Монгол, Сибирийн тавцан мөргөлдсөнөөс үүсэлтэй чулуулгийн хагарал нь Кембрийн үеэс бүрэлдэн тогтож эхэлсэн. Уулын өндөрлөг оргил хэсгээр боржин чулуун бүтэц давамгайлдаг.

256. Алтайн нуруу нь ихэнхдээ гранит-гранодиорит, боржин чулуу зэргээс бүрдэх интрузив бүтэцтэй палеозойн чулуулгаас тогтдог. Ховд аймагт габбро, боржин чулуу, диорит, гранодиорит чулуулгийн ордууд, мөн Бодончын хавцал уулын доор үелж тогтсон метаморф массивууд олдсон. Ховд аймгийн уулс нь Кембрийн эхин үеийн тунамал чулуулгаас тогтдог бол аймгийн өмнөд хэсэгт дөрөвдэгчийн үеийн тунамал чулуулаг өргөн тархсан байдаг. Ховд аймаг нь нүүрс (Хөндлөн), гялтгануур (Бодонч), болор (Оошигийн Ус, Цагаантолгой) зэрэг эрдэсийн болон барилгын материалын нөөц ихтэй.

257. Монгол Улсын гео-морфологийн зураглалаас үзэхэд газар нутаг нь ерөнхийдөө атриат уул, нам уул ба ухаа толгод, гуу жалга, уулын бэл хормой, мөсөн голын хөндий, хурц ховил бүхий уулын хяр, аллювийн нуурын хөндий, деллюв – проллювалын болон уулын голын хөндийгөөс тогтоно.²¹


5. Хөрс

²¹ Монгол улсын ЗГ 2007. БОУ. Улаанбаатар

258. Төсөлд хамрагдаж буй нутаг болох Монгол орны баруун бүсэд дараах хөрсний төрлийг тодорхойлсон байна (Зураг 28).

- Уулын тундрын охро, хүлрэнцэр, криотурбацид (эвдэрсэн) орсон хөрс нь ихэвчлэн Алтайн нурууны 3000-3200 м-ээс дээш тархсан. Хөрсний гадаргыг ихэвчлэн элс, хайрга, нүцгэн чулуу бүрхдэг. Сийрэг ургамалжилттай газарт хөрс нь нягт бөгөөд мөстлөгийн элс, хайрга, хайрга чулуу зэрэг тунамал чулуулгаас бүрддэг. Хөрс нь маш чулуурхаг бөгөөд гүн рүүгээ чулуулгийн агууламж 80% хүртэл нэмэгддэг.
- Уулын нуга, нуга тал хээрийн хөрс нь Монгол-Алтайн хойд хэсгийн чийглэг хэсэгт болон Алтайн нурууны гүнд тархсан байна.
- Хөрс бүрдүүлэгч нь элюви-дэлювийн тунамал хайрга болон мөстлөгийн тунамал чулуулаг юм. Ийнхүү хөрсний агуулга нь бутармал чулуурхаг шинж чанартай тул ургамлын үндэс чулуулгийн хоорондхи хөрсөнд нэвтрэх боломжтой болдог. Мөстлөгийн тунамал чулуулаг ихтэй тул том бул чулуулаг бүхий хүнд шавранцар хөрс ихтэй, ялангуяа 70 см-ээс доош гүнд ихэвчлэн эдгээр бул чулуу тааралддаг.
- Уулын хээрийн хөрс нь Алтайн нурууны бүсэд 2400м - 2500м хүртэл, 2900м - 3000 м хүртэл өндөрт тархсан байна. Хөрсний гадаргуу нь сийрэг ургамлын бүрхэвчээр бүрхэгдсэн хайрган суурьтай. Хөрсний гадаргуугаас 40-50 см гүнд элсэрхэг, хайргархаг, чулуурхаг хөрстэй.
- Уулын цөлийн хээр, цөлийн хөрс нь Алтайн нурууны өмнөд хэсгээр 1500м - 1600м хүртэл болон 2400м-2500м-ийн өндөрт тархсан байдаг. Хөрс нь хагас цөлийн хүрэн хөрс, цөлийн саарал хүрэн хөрс болно.

Figure 27. Баруун аймгууд дахь хөрсний төрөл



6. Цаг уур

а. Увс аймаг

259. Увс аймгийн дундаж хур тунадас 135.3мм. Агаарын даралт 1-р сард 923.9hPa, 7-р сард 901.9 hPa байдаг. Увс аймагт жилийн дундаж хур тунадас 135.3мм байна. Агаарын даралт 1-р сард 923.9 hPa, 7-р сард 901.9 hPa байна. Увс, Хяргас нуурын хотгорт дэлхийн хойд хагас бөмбөрцгийн өндөр даралтын бүс үүсдэг. Нэгдүгээр сарын дундаж температур -17-с -25,5 хэм, 7-р сарын дундаж температур 16.5 хэм байна. Салхины дундаж хурд 4.5м /сек. Тавдугаар сар бол жилийн хамгийн салхитай сард тооцогддог. Салхины хурд 5-р сард 2.3м/сек ч хүрдэг. Температур хамгийн ихдээ +35 хэм хүртэл, хамгийн багадаа -40 хэм хүрдэг. Хавар, намрын улирал харьцангуй урт, 120-160 хоног үргэлжилдэг. Увс аймгийн Улаангом хотын төв орчмын агаарын жилийн дундаж температур -3.8 хэм, 1-р сарын дундаж -33 хэм, долоодугаар сарын дундаж +19.2 хэм байна. Улаангом бол Монгол орны хамгийн хүйтэн өвөл болдог газруудын нэг бөгөөд бүртгэгдсэн хамгийн бага температур -50 хэм, хамгийн их температур нь + 36.4 хэм байв.

Table 22. Улаангомьн цаг уурын үзүүлэлтүүд, Увс аймаг

	January	February	March	April	May	June	July	August	September	October	November	December
Avg. Temperature (°C)	-31.1	-29.1	-17.8	0.4	11.3	17.2	18.8	16.5	10.3	1	-10.6	-25.7
Min. Temperature (°C)	-36.3	-35	-24.3	-5.7	3.6	10	12.2	9.7	3.3	-5.2	-15.5	-30.4
Max. Temperature (°C)	-25.8	-23.1	-11.3	6.6	19	24.5	25.4	23.3	17.3	7.3	-5.6	-20.9
Avg. Temperature (°F)	-24.0	-20.4	-0.0	32.7	52.3	63.0	65.8	61.7	50.5	33.8	12.9	-14.3
Min. Temperature (°F)	-33.3	-31.0	-11.7	21.7	38.5	50.0	54.0	49.5	37.9	22.6	4.1	-22.7
Max. Temperature (°F)	-14.4	-9.6	11.7	43.9	66.2	76.1	77.7	73.9	63.1	45.1	21.9	-5.6
Precipitation / Rainfall (mm)	2	2	3	5	6	26	37	23	14	6	8	5

Source: long term data of Uvs Aimag meteorological department and climate data of en.climate-data.org

260. Увс аймгийн Улаангом хотын төв орчмын агаарын жилийн дундаж температур -3.8 хэм, 1-р сарын дундаж -33 хэм, долоодугаар сарын дундаж +19.2 хэм байна. Улаангом бол Монгол орны хамгийн хүйтэн өвөл болдог газруудын нэг бөгөөд бүртгэгдсэн хамгийн бага температур -50 хэм, хамгийн их температур нь + 36.4 хэм байв.

Table 23. Өмнөговь сумын цаг уурын үзүүлэлтүүд, Увс аймаг

Month	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	Jul	Aug	Sep	Oct	Nov	Dec	Average
Average air temperature °C	-22.92	-18.68	-6.87	3.49	9.94	16.31	18.25	15.71	8.91	0.44	-10.09	-18.99	-0.56
Max air temp, °C	-15.87	-10.38	1.23	10.87	17.13	23.04	24.74	22.37	16.14	7.54	-3.14	-12.40	6.80
Min air temperature, °C	-28.60	-25.60	-14.18	-3.50	3.07	9.70	12.07	9.45	2.04	-5.76	-15.79	-24.37	-6.97
Precipitation, мм	1.46	1.34	2.19	7.31	10.58	24.90	32.06	33.46	7.42	4.41	2.95	1.72	11.35

261. Улаангомоос өмнө зүгт 110 км-т орших Өмнөговь сумын төв газарзүйн байршлын хувьд Увс нуураас алслагдсан тул уур амьсгал нь аймгийн төвийнхөөс харьцангуй зөөлөн. Хүйтэн нутагт нуур нь өвөл, хаврын улиралд маш хүйтэн уур амьсгал үүсэхэд нөлөөлдөг гол хүчин зүйл болдог. Өмнөговийн агаарын жилийн дундаж температур -0.56 хэм байгаа нь Улаангомын агаарын жилийн дундажаас 25 хэмээр ялгаатай байна.

в. Баян-Өлгий

262. Уулархаг нутгаар жилд 200мм-400мм (7.8-15.7-д) бороо ордог бол харин Ховд голын хөндийн нам дор хэсэгт 100мм-200мм (3.9-7.8 д) бороо ордог. Жилийн дундаж температур нь Таван Богд ууланд -4 хэм (+ 25°F), Өлгий хотод 0 хэм (+32°F) байдаг бөгөөд Өлгий хотод агаарын температур 7-р сард +14.5 хэм (+57°F) 1-р сард -17.8 хэмийн (+2°F) хооронд хэлбэлздэг. Өлгий нь Улаанбаатараас өндөрт оршдог боловч хуурай агаар, голын өргөн хөндий нь өвлийн улиралд хотын агаарыг 5-6 хэм дулаан болгодог. Жилд орох борооны талаас илүү хувь нь 6, 7-р сард ордог бол зарим уулархаг нутгаар өвлийн улиралд 1 метрээс зузаан цас ордог. Гол, нуурууд 10-р сараас 5-р сард ихэвчлэн хөлддөг.

Table 24. Баян-Өлгий аймгийн Өлгий хотын цаг уурын үзүүлэлтүүд

Month	Jan	Feb	Mar	April	May	Jun	Jul	Aug	Sep	Oct	Nov	Dec	Year
Record high °C	4.2	-0.2	16.8	23.2	29.3	31.6	32	32.3	26.5	20.9	12.8	8.5	32.3
Average high °C	-10.7	-6.9	1.2	9	16.1	21.2	22.6	21.2	15.5	6.9	-2.4	-15	7.04
Daily mean °C	-17.1	-14.7	-6.7	1.7	9.3	14.6	16.3	14.5	8.6	0.1	-8.5	-15	0.26
Average low °C	-22.9	-21.1	-13.6	-5.1	3	8.3	10.4	8.6	2.7	-4.9	-13.7	-20.2	5.6
Record low °C	-37.6	-40.2	-3.4	-20.8	-10	-2.3	0.6	-3	-16.5	-23.5	-32.9	-3.6	-40.2
Precipitation, mm	0.6	0.5	1.3	4.5	10.6	25	34	20	12.5	3	0.7	1	113.7

263. Өлгий нь Улаанбаатараас өндөрт оршдог боловч хуурай агаар, голын өргөн хөндий нь өвлийн улиралд хотын агаарыг 5-6 хэм дулаан болгодог. Жилд орох борооны талаас илүү хувь нь 6, 7-р сард ордог бол зарим уулархаг нутгаар өвлийн улиралд 1 метрээс зузаан цас ордог. Гол, нуурууд 10-р сараас 5-р саруудад ихэвчлэн хөлддөг.

Table 25. Tab. 26 - Дэлүүн сумын цаг агаарын үзүүлэлтүүд, Баян-Өлгий аймаг

Month	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	Jul	Aug	Sep	Oct	Nov	Dec	Average
Average air temperature °C	-21.74	-16.54	-7.42	0.80	6.88	12.83	14.98	13.10	6.63	-1.59	-10.96	-18.99	-1.83
Max air temp, °C	-15.63	-9.69	-0.18	7.68	13.39	19.28	21.41	19.81	13.66	4.94	-4.79	-13.24	4.72
Min air temperature, °C	-26.96	-22.89	-14.59	-6.09	0.15	6.35	8.36	6.10	-0.48	-7.65	-16.32	-23.88	-8.16
Precipitation, мм	0.68	0.61	1.67	4.72	9.57	26.44	23.83	18.92	8.05	2.73	1.09	1.97	8.68

264. Дэлүүн сум нь далайн түвшнээс харьцангуй өндөр буюу 2140м-2300м-т оршдог тул жилийн турш уур амьсгал нь хүйтэн буюу дунджаар -1.83 хэм байдаг. 12, 1, 2-р саруудад хамгийн хүйтэн байх бөгөөд агаарын дундаж сарын температур -18.99-аас -21.74 хэмийн хооронд хэлбэлздэг. 4-р сараас эхлэн агаарын дундаж температур 0 хэмээс дээшилсээр 6, 7, 8-р саруудад дулаахан байх ба 9-р сарын эцсээр 0 хэмээс доошилдог.

с. Ховд аймаг

265. Ховд аймаг нь эх газрын уурын уур амьсгалтай. Зун +40 хэм хүрч халдаг боловч өвөл -30 хэм хүртэл буурдаг. Харьцангуй хуурай. Хур тунадасны дундаж хэмжээ 120мм-140мм, 1-р сарын дундаж температур -17 хэм (-25.5), 7-р сарын дундаж температур +16.5 хэм, салхины хурд 4.5м/сек хүрнэ, хамгийн хүйтэн улиралд агаарын температур -40 хэм хүртэл буурч, хамгийн дулаан улиралд +35 хэм хүрч, бүртгэгдсэн салхины хамгийн дээд хурд 1.0м/сек байв. Хавар, намрын улирал харьцангуй урт бөгөөд тус бүр 120-160 хоног байна.

Table 26. Жаргалантын цаг агаарын үзүүлэлтүүд, Ховд аймаг

	January	February	March	April	May	June	July	August	September	October	November	December
Avg. Temperature (°C)	-23	-19.6	-7.1	3.9	11.9	17.2	18.6	16.8	10.9	2.3	-8.9	-19.4
Min. Temperature (°C)	-29.8	-27.1	-14.6	-3.4	4.7	10.4	12.4	10.1	4	-4.5	-15.6	-25.7
Max. Temperature (°C)	-16.2	-12	0.4	11.2	19.2	24	24.8	23.5	17.8	9.1	-2.2	-13
Avg. Temperature (°F)	-9.4	-3.3	19.2	39.0	53.4	63.0	65.5	62.2	51.6	36.1	16.0	-2.9
Min. Temperature (°F)	-21.6	-16.8	5.7	25.9	40.5	50.7	54.3	50.2	39.2	23.9	3.9	-14.3
Max. Temperature (°F)	2.8	10.4	32.7	52.2	66.6	75.2	76.6	74.3	64.0	48.4	28.0	8.6
Precipitation / Rainfall (mm)	1	0	2	6	11	22	37	24	9	3	2	2

7. Агаарын чанар

266. Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр 2000 (NEAP) нь Монгол орны өмнө тулгарч буй байгаль орчин, байгалийн нөөцийн тулгамдсан асуудлын нэг нь агаарын бохирдол гэж үзсэн. Улаанбаатар зэрэг томоохон төв суурин газруудын агаарын бохирдлын гол эх үүсвэрүүдэд (i) тээврийн хэрэгслийн утаа; (ii) бойлер ба цахилгаан станцаас ялгаруулж буй утаа; (iii) өрхийн халаалтын зууханд нүүрс, мод болон/эсвэл хог/хуванцар шатааснаас ялгарах утаа; (iv) хуурай газар, элэгдэлд орсон хөрс, шороон зам; (v) ойн түймэр; (vi) хатуу хог хаягдлыг зайлуулах цэгүүд орж байна. Гурван аймгийн агаарын чанарыг дараах хүснэгтээр харуулав.

Table 27. Улаангом дахь агаарын чанар, Увс аймаг 2002-2018

№	Агаарын чанарын элемент/AL *	Хэмжих нэгж	Он / Жилийн дундаж агууламж																
			2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	SO2/20	мкг/м³	-	-	-	-	-	-	3	3	4	3	3	4	4	4	6	7	6
2	NO2/40		-	-	-	-	-	-	26	27	25	27	31	33	35	35	32	26	24
3	TSP/100		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	78	64	64	68	61

Remarks: *-Acceptable max level of pollutants (mean annual) by National Standard on Air Quality MNS4585:2016

Table 28. Улаангом дахь агаарын чанар, Увс аймаг

(АСХХОХ-т зориулж авсан эх өгөгдөл, 2019-9-24)

Д/Д	Агаарын дээж авсан байршил	Дээж авсан цаг	SO ₂ µg/m ³	NO ₂ µg/m ³	PM10*** µg/m ³
1	Аймгийн байгаль орчны газар	08:00	3	36	-
2	Аймгийн байгаль орчны газар	20:00	8	47	-
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016			450*	200*	100**

Remarks: *-Acceptable max level of SO₂ and NO₂ (mean 20 min) and

** -Acceptable max level of PM₁₀ for 24 hours by National Standard on Air Quality MNS4585:2016

*** - no equipment is available to measure dust in Aimag Met department

Table 29. Өлгий дэх агаарын чанар, Баян-Өлгий аймаг 2002-2018

№	Агаарын чанарын элемент/AL *	Хэмжих нэгж	он/ жилийн дундаж агууламж																
			2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	SO2/20	мкг/м³	2	2	1	0.0	0.0	1	3	5	3	6	12	13	12	7	5	8	9
2	NO2/40		8	6	3	2	2	3	8	19	18	24	29	30	29	23	15	13	19
3	TSP/100		-	-	-	-	-	-	-	93	172	139	157	184	111	260	340	481	744

Remarks: *-Acceptable max level of pollutants (mean annual) by National Standard on Air Quality MNS4585:2016

Table 30. Дэлүүн сум дахь агаарын чанар, Баян-Өлгий аймаг

(АСХХОХ-т зориулж авсан эх өгөгдөл, 2019-9-24)

Д/Д	Агаарын дээж авсан байршил	Дээж авсан цаг	SO ₂ µg/m ³	NO ₂ µg/m ³	PM10*** µg/m ³
1	Аймгийн байгаль орчны газар	08:00	2	15	-
2	Аймгийн байгаль орчны газар	20:00	0	21	-
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016			450*	200*	100**

Remarks: *-Acceptable max level of SO₂ and NO₂ (mean 20 min) and

** -Acceptable max level of PM₁₀ for 24 hours by National Standard on Air Quality MNS4585:2016

*** - no equipment is available to measure dust in Aimag MET department

Table 31. Жаргалант дахь агаарын чанар, Ховд аймаг (Сүүлийн 17 жилд)

№	Агаарын чанарын үзүүлэлт/AL*	Хэмжих нэгж	Он/ Жилийн дундаж агууламж																
			2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	SO ₂ /20	мкг/м ³	-	-	2	4	6	5	4	2	4	4	9	8	9	6	9	9	9
2	NO ₂ /40		-	-	29	34	53	51	32	13	16	16	28	29	31	28	31	32	29
3	TSP/100		-	-	-	-	-	-	-	120	133	325	388	280	246	120	173	195	193

Remarks: *-Acceptable max level of pollutants (mean annual) by National Standard on Air Quality MNS4585:2016

Table 32. Жаргалант дахь агаарын чанар, Ховд аймаг

(АСХХОХ-т зориулж авсан эх өгөгдөл, 2019-9-24)

No.	Location of air sampling	Sampling time	SO ₂ µg/m ³	NO ₂ µg/m ³	PM ₁₀ µg/m ³
1	Aimag MET office	08:00 AM	11	4	38
2	Aimag MET office	08:00 PM	4	34	31
National Air quality standard MNS 4585:2016			450*	200*	100**

Source:Khovd Meteorological department

Remarks: *-Acceptable max level of SO₂ and NO₂ (mean 20 min) and

** -Acceptable max level of PM₁₀ for 24 hours by National Standard on Air Quality MNS4585:2016

267. Сумдын түвшинд агаарын чанарын талаарх өгөгдөл, агаарын чанарын станцын аль аль нь байдаггүй. Тиймээс Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумдын агаарын чанарын тухай мэдээлэл алга байна. Агаарын чанарын талаарх үндэсний болон олон улсын (ДЭМБ) стандартыг 34-р хүснэгтэд нэгтгэн харуулав. Үүн дээр нэмж үндэсний болон ДЭМБ-ын үйлдвэрээс агаарт ялгаруулах хийн найрлагын стандартуудыг мөн харууллаа.

Table 33. Орчны агаарын чанарын олон улсын болон үндэсний стандарт

Parameter	MNS 4585:2007		EHS Guidelines. World Health Organization (WHO). Air Quality Guidelines Global Update, 2005)	
SO ₂	24-hour	20	24-hour	125 (Interim target-1)
				50 (Interim target-2)
				20 (guideline)
	10 minute	500	10 minute	500 (guideline)
NO ₂	1-year	30	1-year	40 (guideline)
	24-hour	40	24-hour	-
	20-min	85	1-hour	200 (guideline)
PM ₁₀	1-year	50	1-year	70 (Interim target-1)
				50 (Interim target-2)
				30 (Interim target-3)
				20 (guideline)
	24-hour	100	24-hour	150 (Interim target-1)
PM _{2.5}	1-year	25	1-year	35 (Interim target-1)
				25 (Interim target-2)
				15 (Interim target-3)
				10 (guideline)
	24-hour	50	24-hour	75 (Interim target-1)
CO				50 (Interim target-2)
				37.5 (Interim target-3)
				25 (guideline)
CO	Average in 1 hour	30g/m3	No standard	

Interim targets are provided in recognition of the need for a staged approach to achieving the recommended guidelines.

Table 34. Халаагч зуухнаас агаарт гарах утааны найрлагын Үндэсний болон ДЭМБ-ын стандарт

Үзүүлэлт	Агууламж (mg/Nm ³)			
	MNS 6298:2011		WHO EHS Guidelines*	
SO ₂	mg/m ³	SO ₂	mg/m ³	SO ₂
NO _x	mg/m ³	NO _x	mg/m ³	NO _x
PM	mg/m ³	PM	mg/m ³	PM
Dry Gas Excess O ₂ content	-	-	%	6

* Small Combustible Facilities Emission Guidelines (3MWth-50MWth) – for Boilers using solid fuel
NWth-Megawatt thermal Nm³ is at one atmospheric pressure, 0°C.

8. Чимээ шуугиан

268. Байгаль орчны судалгааны явцад 2019 оны 9-р сарын 16-25-ны хооронд дуу чимээний түвшинг 24 цагаар гурван цаг тутамд хэмжсэн (аймгийн төв тус бүрт нийт 8 хэмжилт хийсэн). Гурван аймгийн төвд хэмжсэн дуу чимээний түвшинг дараах хүснэгт, графикт нэгтгэв.

Table 35. Ambient noise in Jargalant of Khovd Aimag

No	Огноо	Цаг	Хэмжилт, dB	MNS 4585:2007
1	9/16/2019	21:30	49.2	60
2	9/17/2019	00:30	47.0	45
3	9/17/2019	03:30	41.3	45
4	9/17/2019	6:30	34.0	45
5	9/17/2019	9:30	50.2	60
6	9/17/2019	12:30	45.4	60
7	9/17/2019	14:30	47.8	60
8	9/17/2019	18:30	56.8	60
9	9/17/2019	21:30	50.7	60

Figure 28. Жаргалант дахь дуу чимээний түвшин, Ховд аймаг




Table 36. Улаангом дахь орчны дуу чимээ, Увс аймаг

No	Огноо	Цаг	Хэмжилт, dB	MNS 4585:2007
1	9/22/2019	15:30	56.4	60
2	9/22/2019	18:30	61.0	60
3	9/22/2019	21:30	58.4	60
4	9/22/2019	00:30	40.0	45
5	9/22/2019	03:30	35.3	45

No	Огноо	Цаг	Хэмжилт, dB	MNS 4585:2007
6	9/23/2019	06:30	45.2	45
7	9/23/2019	09:30	50.3	60
8	9/23/2019	12:30	64.4	60
9	9/23/2019	15:30	61.1	60

Figure 29. Улаагом дахь дуу чимээний түвшин, Увс аймаг





Table 37. Өлгий дэх орчны дуу чимээ, Баян-Өлгий аймаг

No	Огноо	Цаг	Хэмжилт, dB	MNS 4585:2007
1	9/20/2019	09:00	58.8	60
2	9/20/2019	12:00	64.7	60
3	9/20/2019	15:00	63.0	60
4	9/20/2019	18:00	58.8	60
5	9/20/2019	21:00	71.5	60
6	9/21/2019	00:00	41.1	45
7	9/21/2019	3:00	41.2	45
8	9/21/2019	6:00	40.3	45
9	9/21/2019	9:00	51.5	60

Figure 30. Өлгий дэх дуу чимээний түвшин



269. Монгол улсын MNS4585: 2007 стандарттай харьцуулахад дуу чимээний түвшин Баян-Өлгий аймгийн Өлгий хотод 21.00 цагт 71.5 дБА үзүүлэлттэй байсан нь урьдчилан сэргийлэх түвшнээс 11.5 дБА их буюу хэмжилт хийсэн 3 аймгийн төвийн хувьд хамгийн их нь байлаа. Өлгийд хийсэн 8 хэмжилтийн 3 тохиолдолд дуу чимээний түвшин зөвшөөрөгдөх хэмжээнээс (3-11.5 дБ-ээр өндөр) давсан байна. Увс аймгийн Улаангом хотод хийсэн 8 хэмжилтийн 50% буюу 4 үзүүлэлт нь зөвшөөрөгдөх түвшнээс давсан байв. Харин Ховд аймгийн Жаргалант дахь 8 хэмжилтийн үзүүлэлт зөвшөөрөгдөх хэмжээнд байлаа.

270. Төсөлд хамрагдах бүсэд дуу чимээ нь салхи, тээврийн хэрэгсэл, машин механизмын чимээний хослолоос үүдэж гарч байна. Дуу чимээний түвшинг түүний үргэлжлэх хугацаагаар тодорхойлно. Тиймээс төслийн барилгын ажлын үе шатанд дуу чимээг бууруулах төлөвлөгөө нь дуу чимээний үргэлжлэх хугацаанд анхаарах ёстой.

271. Байгаль орчны шинжилгээний баг Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум, Увс аймгийн Өмнөговь суманд газар дээр нь очиж ажиллахдаа эдгээр суурин газрууд нам тайван, аймгийн төвтэй харьцуулбал тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бага байгааг ажигласан бөгөөд эдгээр нь харин хот суурин газруудад чимээ шуугианы гол эх үүсвэр болж байна. Тиймээс сумын төвүүдэд дуу чимээний хэмжилт хийгээгүй болно.

9. Усны нөөц

272. Монгол Улс гадаргын болон газрын доорх усны нөөц сайтай. Нийт урт нь 67,000 км болдог 3000 гаруй мөрөн гол горхи бий. Түүнчлэн 3000 гаруй том, жижиг нуур, 6900 булаг, 190 мөсөн гол, 250 халуун рашаан байдаг. Баруун бүс нутаг усны нөөцөөр харьцангуй баялаг юм.

273. Их нууруудын хотгор бол Алтай, Хангай, Тагнын уул нуруугаар эмжээрлэгдсэн Монгол орны баруун, баруун хойд хэсэгт орших хагас хуурай хуурай хотгор юм. Нийтдээ 100,000 гаруй км² талбайтай бөгөөд далайн түвшнээс дээш 750-2000 м хүртэл өндөрт байдаг. Энд Увс нуур, Хар-Ус нуур, Хяргас нуур, Хар нуур, Айраг нуур, Дөргөн нуур зэрэг зургаан томоохон нуур, мөн цөөнгүй хэдэн жижиг нуурууд бий. Томхон голууд нь Ховд, Завхан, Тэс, Буянт, Хархираа, Түргэн юм. Их нууруудын хотгор нь Монгол орны гол цэнгэг уст сав газар бөгөөд ерөнхийдөө цөл хээрийн дунд орших өргөн үргэлжлэх зэгсэн шугуй бүхий хоорондоо холбогдсон гүехэн нууруудын системээс бүрддэг Төв Азийн зарим чухал ус намгархаг газар энд бий.

274. Усны нөөц бол Монгол Улсын хамгийн үнэ цэнэтэй баялаг бөгөөд хамгаалалт, менежмент зайлшгүй шаардлагатай. Тооцооноос авч үзвэл Монгол орны усны нийт нөөц нь 599 км³, үүнээс 500 км³ нь нуурын ус, 62.9 км³ - мөсөн гол, 34.6 км³ нь гол мөрөн, тэдгээрийн газар доорх сав газарт байдаг.²²

275. Монгол орны баруун хэсгийн усны нөөцийг гадаргын ус (гол, булаг, нуур), газрын доорхи уснаас бүрддэг. Төслийн хамарч буй нутаг орон нь Төв Азийн гадагш урсгалгүй сав газарт байрладаг. Гадаргын усны хамгийн сүүлийн тооллогыг 2017, 2018 онд хийсэн байна. Доорх хүснэгтэд Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн усны нөөцийн тооллогын мэдээллийг нэгтгэв.

Table 38. Tab. 39 - Ховд, Увс, Баян-Өлгий аймаг дахь гол горхи, нуурын тоо

Аймаг	Гол		Горхи		Рашаан		Нуур	
	Нийт	Ширгэсэн	Нийт	Ширгэсэн	Нийт	Ширгэсэн	Нийт	Ширгэсэн
Баян-Өлгий	421	0	979	0	27	0	1249	0
Ховд	208	8	485	117	25	2	119	0
Увс	215	0	555	0	36	0	78	29

Source: Aimag Environmental Departments of Bayan-Ulgii, Khovd and Uvs 2019.

276. Ховд аймаг нь Ховд, Буянт, Булган, Чоно харайх, Цэнхэр зэрэг томоохон голуудтай. Мөн Хар-Ус, Хар, Дөргөн зэрэг томоохон нуур, Нэвтийн, Булганы, Индэртийн зэрэг рашаан бий. Цэцэг, Хөх сэрх, Бөөрөг, Шавагт, Холбоо, Хөх нуур зэрэг болор тунгалаг цэнгэг нуурууд болон 300 гаруй гол, горхи байдаг.

277. Увс аймаг мөн гадаргын ус ихтэй бөгөөд Увс, Хяргас, Айраг, Ачит, Үүрэг, Дөрөө зэрэг нуур мөн Тэс, Ховд, Хархираа, Түргэн, Хангилцаг, Туруун, Завхан зэрэг томоохон гол мөрөн байдаг. Зөвхөн Увс нуур руу цутгадаг 38 гол, горхи бий.


278. Баян-Өлгий аймагт Даян, Хотон, Ачит, Хорго, Толбо, Ачит зэрэг цэнгэг устай нууруудыг багтаасан 80 орчим том, жижиг нуурууд бий. Эдгээр нуурын зарим нь загас олборлох нөөцтэй. Тус аймагт Ховд, Цагаан, Согоог, Ёлт, Сагсай, Булган, Ганц мод, Бөхмөрөн зэрэг 100 гаруй гол мөн 200 гаруй горхи булаг байдаг.

²² Монгол Улсын Засгийн Газар 2007 БОУ Улаанбаатар.

а. Төслийн нутаг дахь голууд

279. Төсөлд хамрагдах нутаг дэвсгэр дэх голууд нь Алтайн нуруунаас эх авдаг тул голын дээд ба дунд хэсгүүд нь нарийн хөндий, хавцлуудтай. Иймээс энэ хэсэгт үерлэх талбай үүсдэггүй, шууд доошоо урсдаг. Аллювийн нугын хөрс нь үерийн усанд автсан нугын чийглэг нөхцөлд үүсдэг ба мөн усны эх үүсвэрийн нэг нь мөнх цэвдэг юм. Хөрсний ус нь ихэвчлэн 90-160 см гүнд илрэх бөгөөд хөрс нь 100% ургамлын бүрхэвчтэй байх тул ялзмаг давамгайлдаг. Төслийн бүс дэх томоохон голуудын тухай тайлбарыг доор үзүүлэв.

Figure 31. Fig. 32 - Баруун аймгууд дахь төслийн талбайн гадаргын ус



i. Ховд голын систем

280. Ховд гол 516 км урт, ерөнхий өргөн нь 100м-120м. Монгол-Алтайн уулын хамгийн өндөр оргил болох Таван богдын зүүн урд мөсөн голоос эх авдаг ба голын урсцын үндсэн эх үүсвэр нь мөс, цасны хайлсан ус юм. Нийт ус ус хураах талбай 58000 км² Цагаан, Согоот, Сагсай, Буянт зэрэг үндсэн цутгал голуудтай. Толбо, Даян, Ачит нуурууд илүүдэл усаа Ховд голд өгдөг. Ховд голын ус нь Хар-Ус, Далай нуураар дайран цаашаа Чонохарайхын голыг Хар нууртай холбодог. Голын жилийн дундаж урсац нь дээд хэсэгтээ (Өлгийд) 60.1м³/сек, дунд хэсэгтээ 63м³/сек (Баяннуурт), Хар-Ус нуурт (Мянгад) цутгах үед 90м³/сек байна. Үнэмлэхүй хамгийн их урсац нь 2002 оны 5-р сарын 5-ны өдөр 284м³/сек, хамгийн бага урсац 1983 оны 5-р сарын 25-ны өдөр (Өлгийд) -14.2м³/сек байв. 1993 онд Баяннуурын хэмжих цэг дээр усны түвшин 6м хүрчээ.

i. Буянт Ховд голын систем

281. Буянт голын урт 171км. Монгол-Алтайн нурууны салбар Хөх Сэрхийн нуруунаас гаралтай энэ гол Ховд хотын хойд хэсэг дундуур урсдаг. Буянт гол нь Хар ус нуур руу урсдаг Ховд голын цутгал юм. Голын урсац 6 м³/сек-ээс бага үед голын ус Ховд гол руу хүрдэггүй. Ховд дахь хэмжих цэгээс доошхи голын жилийн дундаж урсац нь 5.9м³/сек.

ii. Kharkiraa River System.

282. Төв Азийн гадагш урсгалгүй ай савд оршдог Увс нуурт цутгадаг Хархираа гол нь далайн түвшнээс 3,078 м өндөрт байх мөнх цас, мөсөн голоос эх авдаг бөгөөд түүнээс салаалдаг Гашуун гол Увс аймгийн Улаангомоор дайрч урсдаг. Хархираа голын урт нь 126.5 км, ус хураах ай сав нь 3332.7 км². Голын дээд хэсгийн дундаж өргөн нь 10-30м, гүн нь 0.25-0.5м, урсгалын хурд 1.0-1.5 м байна. Голын эх нь Тариалан сумын ойролцоох уулнаас гарах бөгөөд Хархираа, Тээл, Гашуун гэсэн гурван гол болж салаалдаг. Голын суваг, үерлэх үедээ эзлэх талбай доошлох тусам улам өргөжиж салбарласаар голын үндсэн суваг нь танигдахаа болитол олон цутгал сувгууд болж хуваагддаг байна. 756 м өндөрт Тээл голын Увс нуур руу цутгадаг.

в. Улирлын чанартай урсац ба үерийн ус

283. Төслийн нутагт байгаа голуудын хаврын үер ихэвчлэн 4-р сарын дунд үеэс эхэлдэг бөгөөд 6-р сарын сүүлчээр оргил үедээ хүрэх ба нийтдээ 110-150 хоног үргэлжилдэг. Хаврын үерийн урсац нь Алтайн нурууны голуудын жилийн нийт урсацын 60-90 хувийг эзэлж байна. Голуудын үерлэх гол улирал нь зун бөгөөд учир нь хур борооны урсац Монгол Алтайн нурууны голуудаас буух шар усны үертэй нийлдэг ба эдгээр голууд нь цас, мөсний хайлсан усаар тэжээгддэг эсэхээс хамаардаггүй. Төслийн нутаг дахь гол мөрний урсацын хамгийн их, хамгийн бага болон дундаж түвшинг тооцоолсон бэлэн олдоц бүхий мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

284. Төслийн хүрээнд хамрагдаж буй буй таван хотоос Өлгий, Жаргалант, Улаангом нь огцом эгц энгэр хажуу бүхий өндөр уулсаар хүрээлэгдсэн газарзүйн онцлог байршилд оршдог тул зуны улиралд хүчтэй бороо орсны дараа үерийн усанд өртөх байдал элбэг. Тухайлбал 2016 оны 7-р сарын 10-ны өдрийн 30 минутын хугацаанд орсон хүчтэй борооны улмаас Өлгийд хүчтэй үер болж, хувийн болон нийтийн өмчид ноцтой хохирол учруулсан. 2018 оны 7-р сарын 14-16-ны хооронд болсон хүчтэй үерийн улмаас 530 өрхийн 2512 хүнийг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болж, хувийн болон нийтийн өмчид хохирол учирсан. 2018 оны 7-р сарын 4-ний өдөр орсон ширүүн борооны улмаас Жаргалантын зүүн хэсэг үерт автсан. Зүүн хэсэгт байх өндөр уулнаас буусан уснаас үүсэлтэй үерийн ус төвлөрсөн хог хаягдлын цэг, гэр хорооллын дундуур дайран өнгөрөхдөө хог хаягдлыг Буянт гол руу зөөж ургасан нь голын доошхи хэсэгт бохирдол үүсгэж улмаар улсын тусгай хамгаалалттай газар болох үзэсгэлэнт Хар-Ус нуурыг бохирдуулсан байна.

Table 39. Tab. 40 - Төслийн талбайн ойролцоох голуудын урсацын хүрэлцээт хэмжээ (м3/сек)

Хэмжилтийн станц/Он	2014			2015			2016			2017			2018		
	Д-ж	Х.и	Х.б	Д-ж	Х.и	Min	Д-ж	Х.и	Х.б	Д-ж	Х.и	Min	Д-ж	Х.и	Х.б
Ховд гол - Өлгий орчимд	62.9	342	33.8	65.6	302	41.2	77.5	401	39	66.4	296	35.7	80	387	41.2
Буянт* Чигэртэй голууд – Дэлүүн сумын орчимд	1.63	2.68	0.58	2.69	4.2	1.18	3.31	5.19	1.43	2.63	3.08	2.18	3.88	6.86	0.90
Буянт гол – Ховд аймагт	8.31	63	7.56	10.5	89.2	6.06	10.2	65.9	3.92	8.78	58.4	5.56	7.41	48.6	6.06
Хархираа гол – Тариалан сумд	1.93	16.1	0.75	2.18	13.26	0.57	3.166	23.21	0.3	2.55	9.25	1.18	2.2	7.96	0.87
Намир гол* - Өмнөговь сумын орчимд	0.88	1.27	0.5	0.88	1.27	0.5	0.88	1.27	0.5	0.5	1.27	0.5	0.88	1.27	0.5

Тэмдэглэл: * Д-ж: – Дундаж, Х.и: – Хамгийн их, Х.б: – Хамгийн бага. Эх сурвалж Монгол Улсын ЗГ. 2007 он. БОНУ. Улаанбаатар.

285. Монгол орны баруун бүс нутаг дахь голуудад байнгын урсац хэмжигч станц цөөхөн байдаг гэдгийг анхаарах нь зүйтэй. Тухайлбал, Хархираа гол дээр байрлах станц нь Тариалан сумын ойролцоох төслийн талбайгаас дээш хэсэгт байрладаг бөгөөд төслийн объектууд байрлаж буй голын доошхи хэсэг буюу цутгал голууд болох Тээл гол, Гашуун голд станц байдаггүй. Өмнөговь сумын хэмжигч станц нь Орлого голд цутгах Намир гол дээр байрладаг тул төсөл хэрэгжиж буй Орлогын голын урсацыг илэрхийлдэггүй. Нарийвчилсан зураг төслийн үе шатанд голын усны улирлын урсацыг (урсац татарсан нөхцөлд) төслийн хүрээнд нөлөөлөх голуудын байршилд тодорхойлох шаардлагатай.

с. Усны чанарын хяналт

286. АСХХОХ төслийн талбай дахь гадаргын усны чанарыг аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газраас авсан бэлэн буй мэдээлэл, АСХХОХ-ийн байгаль орчны багийн цуглуулж авсан эх дээжүүдийг ашиглан үнэлсэн. Төслийн голууд дахь болон төслийн талбай орчны гадаргын усны чанар маш сайн, усны чанарын стандартад нийцэж байгааг тэмдэглүүштэй. (Хүснэгт 41).

287. Увс аймагт усны чанарыг тогтоохдоо Гашуун гол дээр Улаангом хотоос дээш болон доош байрлах цэгээс авсан дээжийг ашигласан. Өлгий хот дундуур урсдаг Ховд голын усны чанарыг хотын дээд болон доод хэсгээс дээжилж авч үзсэн. Үүнтэй адилаар Буянт голын уснаас Жаргалант хотоос дээш болон доошхи хэсэгт дээж авч тодорхойлсон. 33-37-р зургуудад тухайн орон нутаг дахь усны чанарыг тоймлон харуулав.

Figure 32. Гашуун голын усны BOD₅, pH түвшин, Улаангом




Figure 33. Намир голын усны эрдэсжилт ба рН түвшин, Өмнөговь сум




Figure 34. Ховд голын усны эрдэсжилт ба pH түвшин, Өлгийд




Figure 35. Буянт голын усны эрдэсжилт, pH, BOD5 түвшин, Жаргалантад




Figure 36. Буянт голын усны эрдэсжилт ба рН түвшин, Дэлүүн сум, Баян-Өлгий аймаг




Table 40. Монгол улсын гадаргын усны чанарын стандарт

Үзүүлэлт	MNS 4586-98	
pH		6.5-8.5
DO	mgO/l	Not less than 6.4*
BOD	mgO/l	3
NH ₄ -N	mgN/l	0.5
NO ₂ -N	mgN/l	0.002
PO ₃ -P	mgP/l	9
PO ₄ -P	mgP/l	0.1
Cl	mg/l	300

Үзүүлэлт	MNS 4586-98	
F	mg/l	1.5
SO ₄	mg/l	100
Mn	mg/l	0.1
Ni	mg/l	0.01
Cu	mg/l	0.01
Mo	mg/l	0.25
Cd	mg/l	0.005
Co	mg/l	0.01
Pb	mg/l	0.01
As	mg/l	0.01
Cr	mg/l	0.05
Cr ⁵⁺	mg/l	0.01
Zn	mg/l	0.01
Hg	mg/l	0.1
Oil	mg/l	0.05
Phenol	mg/l	0.001
Active and washing substances	mg/l	0.1
Benzapyren	Mkg/l	0.005

* DO>6 mgO/l зуны улиралд, DO>4 mgO/l өвлийн улиралд

d. Усан дахь бактерийн шинжилгээ

41. Water bacteriology samples were taken by local professional team of experts that conducted environmental survey during 16-25 Sept 2019 period in upstream and downstream of rivers that flow through each of 5 ASDIP project sites. Tests were analyzed at accredited laboratories of Aimag Specialized Inspection Departments that are located in each of Aimag centers. Analysis were carried out using MNS900:2005, MNS ISO 9308-1-1998, MNS ISO 6461-2:1998 and MNS ISO 19250:2017 methodologies. Study defines the total number of bacteria abdominal microorganisms, anaerobe microorganisms and pathogens.

i. Увс аймаг, Улаангом

289. Хархираа бол Улаангомьн баруун талд байх Хархираа уулнаас эх авдаг үндсэн гол бөгөөд Улаангомоор дайрч урсдаг Гашуун голыг оролцуулсан олон гол болж салаалдаг. Зөвхөн 3-4 голын цутгалтай Тээл гол Увс нуурт хүрч цутгадаг. Бактерийн шинжилгээ хийх дээжийг Хархираа голын дээш хэсэг, Улаангомд Гашуун гол дээр болон Гүн бөх, Шар гэсэн, Цалгар, Хөндлөн голуудаас авсан. Хархираа голын бактерийн түвшинг дараах хүснэгтэд нэгтгэв.

Table 41. Хархираа болон түүний цутгал голуудын усны бактерийн түвшин, Улаангом

(Дээж авч шинжилгээ хийсэн огноо: 2019 оны 9-р сарын 23-30)

Дээжийн дугаар	Дээж авсан байршлын нэр	Үзүүлэлт		
		Бактерийн тоо	Гэдэсний бактери	Халуунд тэсвэртэй нян
1	Хархираа гол - Хүүхдийн зуслангийн орчим	54	<i>E.coli</i> - илэрсэн	илрээгүй
2	Хархираа гол – Цацаа ширэг	0	илрээгүй	илрээгүй
3	Гашуун голын дээд хэсэг	104	<i>E.coli</i> - илэрсэн	илрээгүй
4	Гашуун голын доод хэсэг	164	<i>E.coli</i> - илэрсэн	илрээгүй
5	Гүнбөх гол	95	<i>E.coli</i> - илэрсэн	илрээгүй
6	Шар гэсэн гол	80	илрээгүй	илрээгүй
7	Цалгар гол	65	<i>E.coli</i> - илэрсэн	илрээгүй
8	Хөндлөн	85	<i>E.coli</i> - илэрсэн	илрээгүй
9	Улаан-Уул горхи	18	илрээгүй	илрээгүй
10	Чулуут горхи	3	илрээгүй	илрээгүй

290. Өгөгдлөөс үзэхэд Гашуун, Гүнбөх, Цалгар, Хөндлөн голууд, мөн хүүхдийн зуслангийн дэргэдэх Хархираа голын эх хэсэг *E.coli*-ийн бохирдолтой байна. Гашуун голын дээшхи болон доош хэсэгт бактерийн тоо нь MNS900-2005 стандартад заагдсан хэмжээ болох 100-аас илүү гарч байна. Хархираа голын бусад цутгалд бактерийн хэмжээ зохих түвшинд байв. Бактерийн эх үүсвэр нь цэвэрлээгүй ахуйн бохир ус, бэлчээрийн мал аж ахуйгаас үүдэлтэй юм.

ii. Увс аймгийн Өмнөговь сум

291. Бактерийн шинжилгээний дээжийг Өмнөговь сумын төвөөр дайрч Хар нуур руу цутгадаг Намир гол дээр хоёр цэгээс авав (Хүснэгт 43).

Table 42. Намир голын усны бактерийн түвшин, Өмнөговь сумаас дээш болон доошхи хэсэг

(Дээж авч шинжилгээ хийсэн огноо: 2019 оны 10-р сарын 2-5)

Дээж авсан байршил, газар зүйн солбицол	Дээж авсан байршлын нэр			
	Бактерийн тоо 100 MNS 900- 2005	Бактерийн тоо 100 MNS 900- 2005	Халуунд тэсвэртэй нян Undetectable MNS ISO 6461-2:1998	Эмгэг төрүүлэгч Undetectable MNS ISO 19250:2017
Ховд гол, Өлгийгөөс дээш 47° 57' 58" 89° 53' 28"	85	<i>E.coli</i> илрээгүй	илрээгүй	100ml – т илрээгүй
Ховд гол, Өлгийгөөс доош 48° 57' 42" 89° 59' 42"	<100	<i>E.coli</i> - илрээгүй	илрээгүй	100ml – т илрээгүй

iii. Баян-өлгий аймгийн Өлгий сум

292. Ховд голын Өлгийгээс дээш болон доошхи хэсэгт буй бактерийн түвшинг Хүснэгт 44-д нэгтгэв. Өлгийгөөс доошхи усанд байгаа бактерийн тоо нь гадаргын усанд зөвшөөрөгдөх түвшинтэй ижил байв. Бүх үзүүлэлтүүд стандартын шаардлагад нийцсэн байлаа.

Table 43. Ховд голын усны бактерийн түвшин, Өлгийгээс дээш болон доошхи хэсэгт

(Дээж авч шинжилгээ хийсэн огноо: 2019 оны 10-р сарын 2-5)

Дээж авсан байршил, газар зүйн солбицол	Дээж авсан байршлын нэр			
	Бактерийн тоо 100 MNS 900- 2005	Бактерийн тоо 100 MNS 900- 2005	Халуунд тэсвэртэй нян Undetectable MNS ISO 6461- 2:1998	Эмгэг төрүүлэгч Undetectable MNS ISO 19250:2017
Ховд гол, Өлгийгөөс дээш 47° 57' 58" 89° 53' 28"	85	<i>E.coli</i> илрээгүй	илрээгүй	100ml – т илрээгүй
Ховд гол, Өлгийгөөс доош 48° 57' 42" 89° 59' 42"	<100	<i>E.coli</i> - илрээгүй	илрээгүй	100ml – т илрээгүй

iv. Баян-өлгий аймгийн Дэлүүн сум

293. Хүснэгт 45-д Дэлүүн сумд голын усан дахь нянгийн хэмжээ гадаргын усны стандартад нийцэж байгааг харуулав.

Table 44. Чигэртэй голын усны бактерийн түвшин, дэлүүн сумаас дээш болон доошхи хэсэгт

(Дээж авч шинжилгээ хийсэн огноо: 2019 оны 10-р сарын 2-5)

Дээж авсан байршил, газар зүйн солбицол	Дээж авсан байршлын нэр			
	Бактерийн тоо 100 MNS 900-2005	Gut floras Undetectable MNS ISO 9308-1-1998	Бактерийн тоо 100 MNS 900-2005	Pathogens Undetectable MNS ISO 19250:2017
Чигэртэй гол, Дэлүүн сумаас дээш 45° 50' 7" 90° 40' 54"	40	<i>E.coli</i> илрээгүй	илрээгүй	100мл – т илрээгүй
Чигэртэй гол, Дэлүүн сумаас доош 47° 49' 59" 90° 53' 28"	80	<i>E.coli</i> илрээгүй	илрээгүй	100m – т илрээгүй

v. ХОВД АЙМАГ ЖАРГАЛАНТ

294. Жаргалант дахь Буянт гол, алдар цуутай Богочын рашаан дахь бактерийн түвшин бага бөгөөд усны чанарын стандартад нийцэж байна.

Table 45. Буянт голын усны бактерийн түвшин, Жаргалант, Ховд аймаг

(Дээж авч шинжилгээ хийсэн огноо: 2019 оны 9-р сарын 18-20)

Дээж авсан байршил, газар зүйн солбицол	Дээж авсан байршлын нэр			
	Бактерийн тоо 100 MNS 900-2005	Гэдэсний бактери Undetectable MNS ISO 9308-1-1998	Халуунд тэсэртэй нян 100 MNS 900-2005	Эмгэг үүсгэгч Undetectable MNS ISO 19250:2017
Богочын рашаан 48.029487 91.6535	<100	<i>E.coli</i> илэрсэн	илрээгүй	25 мл – т илрээгүй
Буянт гол, Жаргалантаас дээш 47° 58' 29" 91° 34' 25"	<100	<i>E.coli</i> илэрсэн	илрээгүй	25 мл – т илрээгүй
Буянт гол, Жаргалантаас доош 47° 57' 27" 106° 49' 34"	<100	<i>E.coli</i> илэрсэн	илрээгүй	25 мл – т илрээгүй

е. **АСХХОХ-ийн голууд дахь хүнд элементүүдийн агуулга**

295. 2019 оны 9-р сарын 15-25-ны өдрүүдэд хийгдсэн байгаль орчны судалгааны үеэр АСХХОХ-ийн таван хотын төвөөс дээш болон доош хэсэгт хүнд элементийн дээж авсан ба MNS 230594-1995 аргачлалын дагуу хийгдсэн. Хот суурин газар тус бүрт хүнд элементийн агуулгыг тодорхойлох 2 дээж буюу нийт 10 дээж авсан. Улаанбаатар хотын магадлан итгэмжлэгдсэн “SGS IMME Mongolia” ХХК-ийн лабораторид ICP80T, IMS80T аргыг ашиглан металлын шинжилгээ хийлээ. Төслийн талбайн ойролцоох голуудын металлын хэмжээг Хүснэгт 47-д үзүүлэв.

296. АСХХОХ-т хамрагдаж буй нийт нутгийн хэмжээнд зөвхөн Увс аймгийн Улаангом дахь арьс шир боловсруулах үйлдвэрт л химийн хорт бодис хэрэглэдэг. Энэ үйлдвэрт малын арьс, боловсруулах зорилгоор хромыг (Cr₃) их хэмжээгээр хэрэглэдэг бөгөөд үйлдвэрийн хаягдал бохир уснаас авсан дээжид хийсэн лабораторийн шинжилгээний дүнгээс үзэхэд хром (нийт), хүнцэл, азот зэрэг хүнд металлын бохирдол өндөр байгаа нь харагдаж байна. Арьс шир боловсруулах үйлдвэрийн хаягдал бохир усан дахь хүнд металлын агууламжийг Хүснэгт 48-д үзүүлэв.

Table 46. АСХХОХ-ийн төслийн талбай дахь голуудын усан дахь хүнд металын агуулга

д/д	Дээж авсан байрлал	Дээж авсан огноо	Хүнд метал (µg/l)				Pb	Fe
			Ni	Mo	As	U		
1	Буянт гол, Жаргалантаас дээш N47°58'29"; E91° 34'25".	2019-9-17	0.6	2.8	1.27	1.44	<0.5	<50
2	Буянт гол, Жаргалантаас доош N48°6'2.44"; E91° 41'52.02".	2019-9-17	0.7	2.9	1.25	1.64	<0.5	<50
3	Богочын рашаан, Жаргалант N48°1'13"; E91° 39'12".	2019-9-17	2.8	8.0	1.40	14.4	<0.5	<50
4	Чигэртэй гол, Дэлүүн сумаас дээш N45°50'7"; E90° 40'54".	2019-9-18	<0.3	2.4	0.54	0.92	<0.5	<50
5	Чигэртэй гол, Дэлүүн сумаас доош N47°49'59"; E90° 43'55".	2019-9-18	<0.3	5.6	0.63	1.20	<0.5	<50
6	Ховд гол, Өлгийгөөс дээш N48°57'58"; E89° 53'28".	2019-9-20	<0.3	1.1	0.61	1.04	<0.5	<50
7	Ховд гол, Өлгийгөөс доош N48°57'42"; E89° 59'42"	2019-9-20	1.2	1.8	0.68	1.37	<0.5	<50
8	Намир гол, Өмнөговь сумын төвөөс дээш N49°6'28"; E91° 44'1"	2019-9-21	1.3	2.8	2.19	3.71	0.9	<50
9	Намир гол, Өмнөговь сумын төвөөс доош N49°6'38"; E91° 41'46"	2019-9-21	1.5	3.0	2.63	3.21	1.1	515
10	Гашуун гол, Улаангомоос доош N49°58'55"; E92° 4'45"	2019-9-23	2.5	2.2	1.91	3.08	<0.5	675
Монгол улсын гадаргын усны стандарт: MNS 4586:1998			10 µg/l or 0.01mg/l	250 µg/l 0.25mg/l	10 µg/l or 0.01mg/l	30* µg/l or 0.03 mg/l	10 µgG/l or 0.01mg/l	300** µg/l or 0.3mg/l

Remarks: * - US EPA Radionuclides Rule, 2000

** - US EPA National Primary Drinking Water Regulations, 2017

Table 47. Хаягдал бохир усан дахь хүнд металлын агуулга

(“Гурван булаг” ХХК Арьс ширний үйлдвэр, Улаангом, Увс аймаг *)

д/д	Дээж авсан байрлал	Дээж авсан огноо	Хүнд метал μG/l					Cr
			Ni	Mo	As	U	Pb	
1	Арьс ширний үйлдвэрийн хаягдал ус, Улаангом N49°59'5"; 4'22" h-930 m E92°	24 Sep 2019	68.1	3.4	78.4	3.04	7.2	882,029
Цэвэрлэсэн хаягдал усны чанарын стандарт: MNS 4943:2011			10 μg/l or 0.01mg/l	500 μg/l or 0.5mg/l	10 μg/l or 0.01mg/l	50 μg/l or 0.05mg/l	10 μg/l or 0.01mg/l	50 μg/l or 0.05mg/l

10. Гүний ус

297. Бүс нутгийн гүний ус нь янз бүрийн насны чулуулагт хуримтлагдсан байх бөгөөд тэдгээрийг нүх сүвийн болон ан цавын гэж ангилдаг. Нүх сүвийн гүний ус нь барьцалдаагүй тунамал чулуулагт хуримтлагддаг бөгөөд ан цавын гүний ус нь янз бүрийн насны тунамал, магмын болон хувирмал чулуулагт хуримтлагддаг. Неоцен ба Палеоцен чулуулаг дахь гүний ус нь гол төлөв хөдөлгөөнгүй бөгөөд гидравлик даралт харьцангуй өндөр байдаг бол ан цавын гүний ус нь ихэнхдээ phreatic бөгөөд өөр өөр геологийн насны хагармал чулуулгаас үүсдэг.

298. Гүний усны тархалт төслийн талбайд жигд бус байна (Зураг 38). Нутгийн хойноос урагш чиглэлд гүний усны нөөц улам ховордож, эрдэсжилт нь нэмэгддэг. Энэ нь юуны өмнө цаг уурын өөрчлөлт, түүний дотор хур тунадас багасч, агаарын температур нэмэгдэж байгаа болон нутгийн өмнөд хэсэг дэх ууршилттай холбоотой юм. Хур тунадас, конденсац, тектоник хагарал зэрэг нь тус бүс нутгийн гүний усны нөөц эргэн хуримтлагдахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

а. ГҮНИЙ УСНЫ ЧАНАР

299. Төслийн талбайн гүний усны чанарын талаархи мэдээллийг Хүснэгт 54-т үзүүлэв. Гүний усны бактерийн түвшинг дараах хүснэгтэд нэгтгэв.

Table 48. АСХХОХ-ийн төслийн талбай дахь гүний усны химийн үзүүлэлтүүд


Байрлал	Дээж авсан огноо	Дээжийн тоо (гүний худаг)	Хатуулаг, mg/l	Cl-, mg/l	NH4, mg/l	NO3, mg/l	Төмөр, mg/l	Suspended solids, mg/l	Ca, mg/l	Mg, mg/l	SO4, mg/l	pH
Жаргалант, Ховд аймаг	2019	12	1.76	11.69	0.04	9.5	0.11	156.2	26.8	3	–	7
Улаангом, Увс аймаг	2019	32	3.53	26.8	0.01	1.8	0.06	1.8	58.7	15.4	33	7.7
Өснөговь сум, Увс аймаг	2019	6	2.88	73.25	0.005	3.2	0.056	0.34	58.4	8.3	40.4	7.1

Өлгий, Баян-Өлгий аймаг	2019	69	3.26	45.25	0.12	0.4	0.039	–	42.1	18.2	0.78	7.5
Дэлүүн сум, Баян-Өлгий аймаг	2019	1	2.04	31.9	0.007	0.1	0.001	-	24	9.8	0.12	7.3
Үндэсний стандартын шаардлага: MNS ISO 10523, 6059 -2001; 7980-2003; 4818-1999; 4429, 4430, 4431-1997; 6271-2011			7	350	0.5	50	0.3	1000	100	30	100	6.5-8.5


Table 49. Төслийн талбай дахь гүний усны бактерийн түвшин

Байршил	Дээж авсан огноо	Дээжийн дугаар	Үзүүлэлтүүд		
			Бактерийн тоо	E.Coli	Эмгэг үүсгэгч
			MNS 900-2005: not above 100	MNS ISO 9308-1-1998: Undetectable	MNS ISO 19250:2017 Undetectable
Улаангом, Увс	2019	32	2*	2	-
Өлгий, Баян-Өлгий	2019	62	2	22	-
Жаргалант, Ховд	2019	12	0	0	-
Өмнөговь, Увс	2019	6	0	0	-

Figure 37. Төслийн талбайн гүний усны



Зураг 36 - н таних тэмдэг



11. Төслийн талбайн гүний усны

а. Хүнд элемент

300. 2019 оны 9-р сарын 16-25-ны өдрүүдэд хийгдсэн байгаль орчны судалгааны үеэр АСХХОХ төслийн талбайн хөрсөн дэх хүнд элементийн шинжилгээг хийсэн. Төслийн талбайн ойролцоох хөрсөнд хүнд элементийн бохирдлыг тодорхойлохдоо рентген флюоресцент төхөөрөмжийг ашигласан. Ихэнх газарт хүнд элементийн түвшин үндэсний хөрсний чанарын MNS5850:2008 стандартын шаардлагыг хангаж байгаа боловч зарим хазайлт байгааг доор тайлбарлалаа. Хүснэгт 55-т хөрсний чанарын үндэсний стандартыг үзүүлэв.

i. ЖАРГАЛАНТ, ХОВД АЙМАГ

301. Дор дурдсан хоёр байршилд хар тугалга, хром, цайр, хүнцэлийн түвшин (доорх диаграммуудыг үзнэ үү) бүгд Монгол улсын стандартад заагдсан хүлцэх, хортой болон аюултай агууламжуудын үзүүлэлтээс давсан байна. Цахилгаан станц дахь хар тугалгын хэмжээ нь хүлцэх агууламжаас 15-184%, хортой агууламжаас 79-190%-иар давсан байна. Зах зээлийн орчимд хар тугалга хүлцэх агууламжаас 57-155% давсан байна. Цахилгаан станц дахь цайрын хэмжээ хүлцэх агууламжаас 15-70%, хортой агууламжаас 44% давсан байна. Зах зээлийн орчимд цайр нь хүлцэх агууламжаас 5-92%, хортой агууламжаас 25-36%, аюултай агууламжаас 62-82% давжээ. Цахилгаан станц дахь хүнцэлийн хэмжээ нь хортой агууламжаас 2-62%, аюултай агууламжаас 139-178%-иар давсан байна. Цахилгаан станц дахь бохирдлын эх үүсвэр нь цахилгаан станцын үнсний хаягдал юм. Зах зээлийн орчим дахь бохирдлын эх үүсвэр нь ихэвчлэн автомашины тос, тосолгооны материалын жижиглэнгийн худалдаа, хаягдал металл худалдан авагчид байдаг бөгөөд тэд хуучин тосыг ихэвчлэн хөрс рүү шууд асгадаг байна.

Figure 38. Жаргалантын 2 байрлал дахь хөрсөн дэх хүнд метал






Figure 39. Худалдааны зах ба ДЦС-ын хөрсөн дэх хүнцлийн агуулга, Жаргалант



ii. Өлгий, Баян-өлгий аймаг

302. Өлгийд хэмжилт хийсэн 2 цэгт хар тугалга, хром, цайрын хэмжээ нь Монгол улсын стандартад заагдсан хүлцэх, хортой болон аюултай агууламжуудын үзүүлэлтээс давсан байна. Тус хотоор дайрч урсдаг Ховд голын дэргэд байрлах хаягдал төмрийн талбай дахь хар тугалга, цайрын агууламж асгарч хаягдсан техникийн тос, хатуу хог хаягдлыг шатаадгийн улмаас Монгол Улсын стандартад заагдсан хортой агууламжын хэмжээнээс 121-198 хувиар давсан байна. Зах зээлийн орчим дахь хэмжилтүүдээс үзэхэд автомашины сэлбэг хэрэгслийн худалдааны талбайн орчимд хромын түвшин нь үндэсний стандартад заагдсан хүлцэх асгууламжаас 12-89%-иар илүү байна.


Figure 40. Өлгий дэх бохирдолтой талбайн хөрсөн дэх хүнд метал



iii. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ДЭЛҮҮН СУМ

303. Баян-Өлгий аймгийн Дэлүүн суманд сургууль, сургуулийн дотуур байр, цэцэрлэг, хатуу хог хаягдлыг зайлуулах газар зэрэг автомашины хөдөлгөөн ихтэй цэгүүдэд хүнд металлын хэмжилтийг рентген флюоресцент (XRF) төхөөрөмжөөр гүйцэтгэсэн. Рентген флюоресцентийн үзүүлэлтээр сумын төвд хэмжилт хийсэн талбайд хүнд металлын бохирдол харьцангуй бага байгааг харуулав. Нэг тохиолдолд хар тугалгын агуулга нь үндэсний стандартад заагдсан хүлцэх агууламжаас 11%-иар давсан байна.

Figure 41. Дэлүүн сумын хөрсөн дэх хүнд метал



iv. Улаангом. Увс аймаг

304. Увс аймгийн Улаангом хотод хөдөлгөөн ихтэй нийтийн болон хувийн эзэмшлийн газруудад хүнд металлын хэмжилтийг рентген флюоресцент төхөөрөмжийн тусламжтайгаар хийсэн. Рентген флюоресцентийн үзүүлэлтээс харахад диаграммд заасан гурван хэсгийг эс тооцвол хэмжилт хийсэн ихэнх газрууд хүнд металлын бохирдол харьцангуй бага байна. Эдгээр гурван газрын өнгөн хөрсөнд хар тугалга, хром, хүнцлийн бохирдол Монгол Улсын стандартад заагдсан хүлцэх, хортой, аюултай агууламжаас хэтэрсэн нь тогтоогдсон. Цахилгаан станц болон түүний үнсний цэгийн орчмын өнгөн хөрсөн дэх хар тугалгын түвшин улсын стандартын хүлцэх агууламжаас 16-229%, хортой агууламжаас 33%, цайрын түвшин хүлцэх агууламжаас 0.9-45%, хортой агууламжаас 11%, хромын түвшин хүлцэх агууламжаас 2-5%, хүнцэл хүлцэх агууламжаас 290%, хортой агууламжаас 16-48%, аюултай агууламжаас 14-190%-иар тус тус давж байна. Арьс ширний үйлдвэрийн орчимд өнгөн хөрсөн дэх хромын бохирдол нь улсын стандартын хүлцэх агууламжаас 4-137%, хортой агууламжаас 19%, аюултай агууламжаас 7-57%-иар давж гарсан байна.

Figure 42. Хөрсөн дэх хүнд метал, Улаангом





Figure 43. Хөрсөн дэх хүнцэл, Улаангом



v. УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМ

305. Увс аймгийн Өмнөговь сумын сургууль, цэцэрлэг, сумын захиргааны барилга, зах зээлийн талбай зэрэг төвийн хэсгийн хөдөлгөөний ачаалал ихтэй газрууд болон сумын төвөөс хойд зүгт 35 км-т байдаг гар аргаар олборлодог уурхайн талбайд хүнд металлын хэмжилтийг рентген флюоресцент төхөөрөмжийн тусламжтай хийсэн. Төхөөрөмжийн үзүүлэлтээр сумын төвийн хэсэгт хүнд металлын бохирдол харьцангуй бага байгаа боловч уурхайн талбайн зарим хэсэгт хром, цайрын агууламж улсын стандартын хүлцэх хэмжээнээс давж байгааг харуулж байна (доорх диаграммыг үзнэ үү). Хромын түвшин хүлцэх агууламжаас 4-5%, цайрын түвшин 13%-иар давсан байна.

Figure 44. Хөрсөн дэх хүнд метал, Өмнөговь сум




Table 50. Хөрсний чанарын стандарт үзүүлэлт – хүнд металл

Элементүүд	MNS 5880 :2008			
	Хөрсний механик бүтэц			Зөвшөөрөгдөх хамгийн дээд хэмжээ, мг/кг
	Шавар	Шаварлаг	Элсэрхэг	
Pb	100	70	50	100
Cd	3	1.5	1	3
Hg	2	1	0.5	2
As	6	4	2	6
Cr	150	100	60	150
Cr ⁶⁺	4	3	2	4
Sn	50	40	30	50

Элементүүд	MNS 5880 :2008			
	Хөрсний механик бүтэц			Зөвшөөрөгдөх хамгийн дээд хэмжээ, мг/кг
	Шавар	Шаварлаг	Элсэрхэг	
Sr	800	700	600	800
V	150	130	100	150
Cu	100	80	60	100
Ni	150	100	60	150
Co	50	40	30	50
Zn	300	150	100	300
Mo	5	3	2	5
Se	10	8	6	10
B	25	20	15	25
F	200	150	100	200
CN	25	15	10	25

12. Мөнх цэвдэг


306. Мөнх цэвдэг бол дэлхийн царцдасын дээд давхарга дахь орчны температур нь хасах байдаг хөрс, чулуулаг болон газар доорх мөсний тархалт ба боломжит тархалт юм. Мөнх цэвдэгт хоёр давхарга байдаг: улирлын чанартай гэсч хөлддөг идэвхтэй үе давхарга, байнгын хөлдөлттэй буюу криолитын бүс. Дэлхийн дулаарал ба хүний үйл ажиллагааны нөлөө нь мөнх цэвдгийн гэсэлт, хайлалтыг эрчимжүүлдэг. Мөнх цэвдэг ингэж хайлж багасах нь усны гидрологид ихээхэн өөрчлөлт оруулж, дэд бүтцэд эвдрэл учруулж, экосистемд нөлөөлж болзошгүй юм. Термокарст нь цэвдэгийн гэсэлтээс үүссэн овон товон/хотгор гүдгэр газар болно.

307. Увс, Баян-Өлгий, Ховд аймгууд нь Алтайн нурууны бүсэд оршдог бөгөөд мөнх цэвдэг нь өндрөөс хамаарал бүхий таван бүсэд хуваагддаг: (i) үргэлжилж тархсан (ii) тасалданги байдалтай тархсан (iii) өргөн тархсан арал, (iv) ховор тархсан арал, (v) алаг цоог тархсан (дараах зураг):

- Үргэлжилж тархсан цэвдэг нь далайн түвшнээс 3000м-ээс дээш өндөртэй уулархаг нутагт тархсан байдаг Мөнх цэвдэгийн температур -1.50C -аас -2.50C хооронд хэлбэлзэж, 80-150метрийн зузаантай байна. Цэвдэгийн хамгийн доод температур -4 хэм хүрдэг ба зарим газарт цэвдэгийн зузаан нь 200-500 м хүрдэг.
- Тасалданги байдалтай цэвдэг Монгол-Алтайн нурууны баруун хэсэг, Ховд голын зарим өндөр хэсэгт өргөн тархсан байна. Мөнх цэвдэгийн температур -0.8-аас -1.5 хэм, зузаан нь 40-80 м байна. Цэвдэгийн хамгийн их зузаан нь 200 м байна.
- Өргөн тархсан арлын цэвдэг нь далайн түвшнээс дээш 2500-2800 м өндөрт байдаг. Мөнх цэвдэгийн температур -0.2-оос -0,8 хэм, зузаан нь 15-40 м байна. Цэвдэгийн хамгийн их зузаан нь 100 м байна.
- Ховор тархсан арлын цэвдэг далайн түвшнээс дээш 2000-2500 метрийн өндөрт орших гол мөрөн, нуурын хөндийд тааралдана. Цэвдэгийн температур -0.1-ээс -0.2 хэм, зузаан нь 5-15м байна.
- Алаг цоог цэвдэг нь горхи булгийн шаварлаг хөрсөнд тааралддаг. Мөнх цэвдгийн дундаж температур -0.0-ээс -0.1 хэм, дундаж зузаан нь 0.5м-ээс 5.0 м байна.

308. Төсөлд хамрагдаж буй таван талбайд цэвдэг байхгүй бөгөөд үүнийг төслийн талбай тус бүрт очиж танилцах үеэр инженерийн баг, зохих албаны хүмүүс баталсан болно.

Figure 45. Баруун бүсийн аймгууд дахь мөнх цэвдэгийн тархал




К. Экологийн нөөц

1. Баруун бүсийн аймгуудын ургамлан бүрхэвч

309. Төсөлд хамрагдаж буй баруун аймгуудын ургамлын төрлийг 31-р зурагт харуулав.

Figure 46. Баруун бүсийн аймгуудын ургамлын төрөл



i. Ан амьтан, биологийн төрөл зүйл

1. 310.Монгол Улс олон зүйлийн ан амьтантай бөгөөд 139 зүйлийн хөхтөн; 450 зүйлийн шувуу (нүүдэллэдэг 331, суурин амьдардаг 119); Мөлхөгч 22 зүйл; 6 зүйлийн хоёр нутагтан; загасны 76 зүйл бий. Монголын Баруун бүс нутаг нь ховор амьтан, ургамалаараа алдартай бөгөөд эдгээрийн ихэнх нь зөвхөн тухайн бүс нутагт амьдардаг бөгөөд дэлхий даяар ховордож зүйлүүд байна.


2. Гэрийн тэжээвэр амьтдын зэрлэг өвөг болох зарим зүйл Алтайн нуруунд байсаар байгаа юм. Үүнд:

- Ирвэс (*Uncia uncia*)
- Аргал угалз (*Ovis ammon*)
- Янгир (*Capra sibirica*),
- Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*)
- Хүдэр (*Moschus moschiferus*)
- Мануул (*Felis manul*)
- Хар сүүлт зээр (*Gazelle subgutturosa*)
- Хулан (*Equus hemionus*)
- Зэрлэг гахай (*Sus scrofa nigripes*)
- Хадны үен (*Martes foina*)
- Эрээн хүрэн (*Vormela peregusna*)

- Хандгай (*Cervus elaphus*)
- Алтайн хойлог (*Tetraogallus altaicus*)
- Нөмрөг тас (*Aegypius monachus*)
- Бүргэд (*Aquila chrysaetos*)
- Ёл (*Gypaetus barbatus*)
- Халбаган хошуут (*Platalea Leucorodia*)
- Хотон (*Pelecanus crispus*)
- Цагаан дэглий (*Egretta alba*)
- Гангар хун (*Cygnus cygnus*)
- Хар толгойт цахлай (*Larus ichthyatus*)
- Хар өрөвтас (*Ciconia nigra*);
- Африкийн галуу (*Anser cygnoides*)

311. Төслийн талбай нь бүхэлдээ Алтай-Саяны эко бүс ба Монгол Дагуурын экосистемд хамрагддаг (Зураг 30). Эдгээр бүс нутгууд нь Монгол Алтайн уулын тундраас Говийн цөл, Их монголын тал хээр хүртэл үргэлжлэх маш баялаг амьтны төрөл зүйлтэй: 360 төрлийн сээр нуруутан амьтад, үүнд 90 зүйлийн хөхтөн, 250 гаруй зүйлийн шувуу, 11 зүйлийн хэвлээр явагч, 8 зүйлийн загас, 2 зүйлийн хоёр нутагтан бий. Нэн ховордсон монгол бөхөнгийн (*tatarica mongolica*) тархалтыг Зураг 33-д үзүүлэв.9.

Figure 47. Алтай-Саяны экосистемийн байршил




Source: WWF.

<https://www.khanexpedition.com/en/post/khovd-aimag-flora.html>

Figure 48. Бөхөн зээрийн тархалт

Geographic range of Saiga tatarica (November 2017)



Source: WWF Mongolia, 2019

2. Экологийн хамгаалалттай нутаг дэвсгэр

312. Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд (1995 он) улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараахь ангилалд оруулжээ.

- Дархан цаазат газар
- Байгалийн цогцолборт газар
- Байгалийн нөөц газар
- Байгалийн дурсгалт газар

а. БАРУУН АЙМГУУД ДАХЬ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ


313. Баруун гурван аймагт байрлах дөрвөн төрлийн тусгай хамгаалалттай газар нутгийг доор дугаарлаж, Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зурагт лавлах зорилгоор орууллаа (Зураг 50).

Дархан цаазат газар

1. 1. **Говийн их дархан газрын Б хэсэг** (ДЦГ) нь БНХАУ-тай хиллэдэг баруун өмнөд хилээс наашхи Ховд (Булган, Үенч, Алтай сум), Говь-Алтай (Тонхил, Бугат сум) аймгийн нутгийн заагийн урд захын газрыг хамрах бөгөөд 6.5 сая га талбайг

(АСХХОХ-ийн талбайн гадна зүүн өмнөд хэсэгт байрладаг ДЦГ-ын А хэсгийг оруулаад) хамардаг. Энэ ДЦГ Алтайн нурууны өмнөд хэсэгт байх их говийн нэрээр нэрлэгддэг. ДЦГ 1975 онд байгуулагдсан бөгөөд 1991 онд олон улсын “Дэлхийн хүн ам ба шим мандлын нөөц газрын сүлжээ”-нд бүртгэгдсэн. Энэ нутаг мазаалай (*Ursus arctos gobiensis*), хавтгай (*Camelus ferus*), аргал угалз (*Ovis ammon*), Сибирийн янгир (*Capra sibirica*), цоохор ирвэс (*Uncia uncia*), хар сүүлт зээр (*Gazelle subgutturosa*), хулан (*Equus hemionus*), монгол бөхөнгийн (*Saiga borealis*) эх нутаг юм. Хамрах газар нутгийнхаа хэмжээгээр дэлхийн томоохон дархан газруудын 15-д жагсдаг.

Figure 49. Баруун аймгууд дахь хамгаалалттай газар нутаг



Source: MET, May 2019

Зургийн тэмдэглэгээ:

- Дархан цаазат газар
- Байгалийн цогцолборт газар
- Байгалийн нөөц газар

Баруун бүс нийт 10 төрлийн хамгаалалтанд авсан газар байдаг.

Увс нуурын ай сав газрын ДЦГ нь Увс аймгийн нутаг дэвсгэрт байрладаг дөрвөн хэсгээс бүрддэг: Үндсэн хэсэг болох Увс нуур - (Тэс, Давст, Малчин, Наранбулаг, Тариалан сумдын нутаг дэвсгэр), Цагаан шувуутын хэсэг (Сагил суманд), Түргэн уулын хэсэг (Түргэн, Тариалан, Бөхмөрөн, Ховд сумдын нутаг дэвсгэр), Алтан элсний хэсэг (Баруунтуруун суманд). Нийтдээ 755244 га газар, усыг хамардаг. Энэ бүсийн өвөрмөц экосистемийг хамгаалах зорилгоор 1993 онд хамгаалалтад авсан бөгөөд экосистемийн судалгаа хийхэд зориулсан Төв Азийн нутаг дэвсгэрийн эталон болжээ. 1997 онд Хүн ба биосферийн хөтөлбөрт, 2003 онд Дэлхийн өвийн сүлжээнд, 2004 онд Рамсарын гэрээнд бүртгэгдсэн. Мөн олон улсын геосфер ба биосферийн хөтөлбөрийн (IGBP) судалгааны хүрээнд хамрагдсан болно.

3. **Хөх сэрхийн ДЦГ** нь Дэлүүн сум, Ховд аймгийн Ховд сумын хилийн зааг нутагт оршдог. Анх 1977 онд Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум, Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт байгуулагдсан бөгөөд 75750 га газрыг хамардаг. Аргал угалз (*Ovis ammon*), Сибирийн янгирын амьдрах (*Capra sibirica*) чухал нөөц газар юм.

Байгалийн цогцолборт газар

4. **Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газар** (БЦГ) нь Монгол, баруун хязгаарыг БНХАУ, Орос улстай хиллэдэг баруун хилийн дагууд Баян-Өлгий аймгийн баруун 4 сумын (Цэнгэл, Улаан хус, Сагсай, Алтай) нутагт орших ба 656088 га газрыг хамардаг. Тус БЦГ-т хамгийн өндөр уулын оргилууд, баялаг ан амьтан бүхий энэхүү БЦГ нь 1996 онд байгуулагдсан.

5. **Сийлхэмийн нурууны БЦГ** нь (А ба Б хэсэгтэй) Орос улстай хиллэдэг хойд хилийн заагт, Баян-Өлгий аймгийн Улаанхус, Ногооннуур сумдын нутаг дэвсгэрт оршдог. Байгалийн үзэсгэлэнт газар, баялаг ан амьтныг хамгаалах зорилгоор энэхүү БЦГ-ыг 2000 онд байгуулсан бөгөөд 147875 га газар нутгийг хамардаг.

6. **Цамбагаравын БЦГ** нь Баян-Өлгий аймгийн зүүн хэсэгт байрлах бөгөөд Алтанцөгц, Баяннуур сум, Ховд аймгийн Эрдэнбүрэн сумдын нутагт нийт 113748 га талбайг хамардаг. БЦГ нь ирвэсийн (*Uncia uncia*) тоо толгой, амьдрах орчныг хамгаалах зорилгоор 2000 онд байгуулагдсан.

7. **Чигэртэйн голын ай савын БЦГ** нь Монгол, БНХАУ-ын хилийн дагуу, Баян-Өлгий аймгийн баруун хэсэг Дэлүүн сумын нутагт байрладаг. Мөнх цас, мөсний томоохон төвүүдээс эх аван урсаж байгаа гол горхийг хамгаалах, ургамал, амьтны аймгийн усан хангамжийг хангах зорилгоор 2012 онд байгуулагдсан бөгөөд 167191 га талбайтай.

8. **Мөнх хайрханы БЦГ** нь Баян-Өлгий, Ховд аймгийн хил дагуу байрладаг. Баян-Өлгий аймгийн Булган сум, Ховд аймгийн Үенч, Мөнх хайрхан сумдын нутаг дэвсгэрт орших 506094 га газар нутаг бүхий энэхүү байгалийн өвөрмөц газар нутаг, мөнх цаст уулсыг хамгаалах зорилгоор анх 2006 онд байгуулсан бөгөөд нутаг дэвсгэрийг нь 2011 онд нэмж өргөжүүлжээ.

9. **Хар-Ус нуурын БЦГ** нь Ховд аймгийн нутагт оршдог бөгөөд Мянгад, Дөргөн, Чандмань, Манхан, Буянт сумдын 852,995 га талбайг хамардаг. Хар-Ус, Хар, Дөргөн, Зэрэг дөрвөн нуур болон тэдгээрт цутгах гол горхи, хүрээлэн буй орчны өвөрмөц экосистем, ургамал, амьтныг хамгаалах зорилгоор 1997 онд байгуулсан.

10. **Мянган угалзатын БЦГ**-ыг (үгчилбэл мянган аргал угалзтай уул) үзэсгэлэнт газар, ховор болон нэн ховордсон ургамал, ан амьтдыг хамгаалах зорилгоор 2002 онд байгуулсан. Нийт 303774 га талбайг хамардаг бөгөөд 2011 онд Ховд аймгийн Цэцэг, Мөст, Алтай сумын нутгаас нэмж оруулан өргөжүүлсэн.

11. **Хан-Хөхийн нуруу ба Хяргас нуурын БЦГ** нь Увс аймагт 2000 онд байгуулагдсан бөгөөд Хан-Хөхийн нуруу ба Хяргас нуур гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Хоёр хэсэг хамтдаа Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан, Хяргас сумдын нутагт

байрладаг. Төрөл бүрийн өвөрмөц ландшафт, голын экосистем бүхий энэхүү БЦГ нь 221598 га талбайг хамардаг.

Байгалийн нөөц газар

12. **Дэвэл арлын БНГ** (Ховд голын Дэвэл арал) нь 2000 онд байгуулагдсан бөгөөд Баян-Өлгий, Увс аймгийн хилийн дагууд оршдог. Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Алтанцөгц, Увс аймгийн Ховд сумын 10618 га талбайг хамарсан энэхүү БНГ нь гургуул (*Phasianus colchicus* L.), зэрлэг гахай (*Sus scrofa nigripes*), минж (*Castoridae*) зэрэг амьтдын болон зэрлэг чацарганы ургамлын нөөц нутаг юм.

13. **Алтан Хөхийн нурууны БНГ** нь Увс аймгийн Өмнөговь, Ховд аймгийн Мянгад сумдын зааг нутагт оршдг. Байгалийн хосгүй үзэсгэлэнт газар, ургамал, амьтны олон төрөл зүйлийг хадгалах зорилгоор 2010 онд байгуулагдсан бөгөөд 90734 га талбайг хамардаг.

14. **Булган хангайн БНГ** нь Увс аймгийн Хяргас суманд байрладаг. 11407 га нутаг бүхий өвөрмөц үзэсгэлэнтэй экосистемийг хамгаалах зорилгоор 2012 онд байгуулсан.

15. **Тэс голын ай савын БНГ** нь Увс нуурын зүүн хэсэгт, Увс аймгийн хойд тал, Монгол Оросын хийлийн дагууд байрлана. Увс аймгийн Тэс сумд байх голын ай сав газрын өвөрмөц ландшафт, экосистемийг хамгаалах зорилгоор 2006 онд байгуулсан.

16. **Шарга Манхан ба Сутай уулын БНГ** нь бие биенээсээ 200 км зайтай байрладаг. Манхан хэсэг нь Ховд аймгийн Манхан, Буянт сумын нутагт, Шарга хэсэг нь Говь-Алтай аймгийн Шарга суманд (АСХХОХ-ийн төслийн талбайн гадна) байрладаг байна. БНГ-ын нийт нутаг дэвсгэр нь 396290 га бөгөөд гуравны нэг орчим нь Манханы нутагт оршино. Монгол бөхөнгийн амьдрах гол цөм орчныг (хамгийн сүүлчийн амьдрах нутаг нь болж буй) хамгаалах зорилгоор 1993 онд байгуулсан.

314. Баруун гурван аймагт байрлах дээрх тусгай хамгаалалттай газар нутгуудаас гадна Монгол Улсын Засгийн газар саяхан (2019 оны 7-р сард) экологийн эмзэг орчинд үйл ажиллагаа явуулж буй уурхайн олборлолтын үйл ажиллагааг зогсоож, улсын тусгай хамгаалалтад авах тухай тогтоол баталсан байна.

б. АСХХОХ ТӨСЛИЙН ТАЛБАЙ БОЛОН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

315. Баруун гурван аймаг дахь АСХХОХ төслийн таван талбай нь ямар ч тусгай хамгаалалттай газар нутагт ойрхон байдаггүй. Тухайн орон нутагт очиж ажиллах явцад байгаль орчны багийн зүгээс Ховд аймгийн Манхан, Мянгад сум дахь хоёр талбайг байгалийн нөөц болон цогцолбор газрын нутагт байрлаж байсан учир төслөөс хассан болно. Ялангуяа Манхан сум дахь талбай нэн ховордсон бөхөнгийн амьдрах нутаг тул онцгой ач холбогдолтой байлаа (Зураг 49).

316. Увс аймгийн Тариалан суманд төлөвлөж буй хоёр төрлийн услалтын системд зориулж дархан цаазтай газар болох Увс нуурт цутгадаг Хархираа-Тээлийн голоос ус татаж авна. Гэхдээ услалтын системүүдийн (Зураг 11-13) техник эдийн засгийн үндэслэлийн тооцоо болон Хархираа-Тээлийн голын улирлын урсацын горимын талаар олж авсан мэдээлэл нь эдгээр услалтын системүүд нь Увс нуурын экосистемд нөлөөлөхгүй байгааг харуулж байна. Үүнийг хойно VI бүлгийн нөлөөллийн үнэлгээнд дэлгэрэнгүй тайлбарлана.

L. Нийгэм-эдийн засгийн нөхцөл

1. Соёлын биет нөөц

317. Төслийн аймгууд дахь АСХХОХ-ийн таван талбайд ойролцоо нутаг дэвсгэрт буган чулуу, булш хиргисүүр, эртний хадны зураг, эртний оршуулгын газрын үлдэгдэл, мөргөл үйлдэх газар гэх мэт соёлын өв, нөөц байхгүй.

2. Socio-economic profiles of ASDIP project sites.

а. Увс аймаг, Улаангом

318. Увс аймгийн хойд хэсэгт орших Улаангом хот нь Улаанбаатар хотоос 1341 км зайтай. Хотын нутаг дэвсгэр нь 12 багт хуваагддаг.

Хүн ам

319. 2018 оны жилийн эцсийн байдлаар Улаангомд 8274 өрхийн 31279 хүн ам оршин сууж байна. Үүнээс 15722 нь эрэгтэй, 15891 нь эмэгтэйчүүд. Хүн амын жилийн өсөлт 1%. Увс аймагт дундаж наслалт 68.84 нас байгаа нь улсын дунджаас 1 насаар доогуур байна. Дундаж наслалт эрэгтэйчүүдэд 63.93, эмэгтэйчүүдийн хувьд 72.87 байна.

Боловсрол

320. Улаангом хотод 2851 хүүхдийг хамарсан 15 цэцэрлэг байдаг. Улаангомд нийт 8155 сурагч 431 багш бүхий 7 дунд сургууль байна. Увсын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ), Хөдөлмөрийн дээд сургуулийн салбар гэсэн нийт 1531 оюутан, 81 багш бүхий хоёр коллежтой.

Эрүүл мэндийн үйлчилгээ

321. Улаангом дахь улсын болон хувийн өмчийн оролцоотой эрүүл мэндийн 50 байгууллагад нийт 336 ажилтан байдгаас 126 эмч, 178 сувилагч, 80 гаруй техник, үйлчилгээний ажилчид бий. Хэвтэж эмчлүүлэх өвчтөнүүдэд зориулсан 250 орны хүчин чадалтай. Жилд 110000 өвчтөнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг.

Ажилгүйдэл, ядуурлын түвшин

322. Увс аймгийн нийт ажиллах хүчний тоо 49100 хүн, үүнд 3177 ажилгүй хүн багтдаг. Хөдөлмөрийн оролцооны түвшин 77.2%, ажилгүйдлийн түвшин 8.4% байна. Давст суманд??? 2018 оны 8-р сард 24 ажилгүй иргэн бүртгэгдсэнээс 13 нь эмэгтэйчүүд байна.

Эдийн засаг

323. Увс аймгийн ДНБ нь 130 сая долларын өртөгтэй, улсын хэмжээнд харьцангуй сайн хөгжсөн аймгуудын нэг юм. Аймгийн эдийн засгийн гол салбарууд нь мал аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэр, үйлчилгээний салбар, уул уурхай болно. 2017 онд тус аймагт 3.13 сая толгой мал тоологдсон. 9235 га талбайд улаан буудай, хүнсний ногоо, чацаргана тариалжээ.

Дэд бүтцийн нөхцөл

324. Улаангом нь Боршоо хилийн боомтоор Оросын хилийн Хандгайт боомттой хатуу хучилттай замаар холбогдсон. Ингэж холбогдсоноор худалдаа хийх, аялал хийхээр Оросын талаас хүмүүс ирж очих боломжтой байдаг. Улаангомд дулаан болон цахилгаан эрчим хүчээр хангадаг хоёр цахилгаан станц бий. Усан хангамжийг хотын дундуур урсдаг Ховд голоос авдаг. Айл өрхийн бохир усыг бохир ус цэвэрлэх байгууламж руу хаядаг боловч хуучирсан технологийн улмаас цэвэрлэгээний түвшин маш бага байдаг.

в. Увс аймгийн Өмнөговь сум

325. Увс аймгийн Өмнөговь сум аймгийн өмнөд хэсэгт Улаангомоос 154 км, Улаанбаатараас 1460 км зайтай оршдог. Сумын нутаг 5 багт хуваагддаг.

Хүн ам

326. 2018 оны жилийн эцсийн байдлаар Өмнөговь суманд 1155 өрхийн 4681 хүн ам оршин сууж байна. Үүнээс 2321 нь эрэгтэй, 2360 нь эмэгтэйчүүд. Хүн амын жилийн өсөлт 1%. Увс аймагт дундаж наслалт 68.84 нас байгаа нь улсын дунджаас 1 насаар доогуур байна.

Боловсрол

327. 2018 оны байдлаар Өмнөговь суманд 342 хүүхэд хүмүүждэг 1 цэцэрлэг байгаа бөгөөд тус цэцэрлэгт хүмүүжүүлэгч 6, туслах багш 6, сургуулийн өмнөх боловсролын 22 ажилтан, бусад 10 ажилтан ажиллаж байна. Өмнөговь суманд нийт 1070 сурагч, 59 багштай 3 ерөнхий боловсролын сургууль байдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээ

328. Omnogovi soum has total of 1 hospital, employing 336 employees which includes 126 doctors, 178 nurses and over 80 technical and service workers. Its capacity is 250 beds for in-patients. It offers health services to 110,000 patients each year. !!!!! Энэ үзүүлэлт суманд огт хамаарахгүй байна. Сумын эмнэлэг 2007 онд сум дундын эмнэлэг статуст шилжсэн, 3 их эмч, нийт 33 орон тоотойгоор ажилладаг. !!! Үүнийг интернэтээс ишлэв - орчуулагч

Ажилгүйдэл, ядуурлын түвшин

Увс аймагт нийт ажиллах хүч 49100 хүн байна. Хөдөлмөрийн оролцооны түвшин 77.2%, ажилгүйдлийн түвшин 8.4% байна. Давст?? суманд 2018 оны 8-р сард 24 ажилгүй иргэн бүртгэгдсэнээс 13 нь эмэгтэй оршин суугчид байна.

Эдийн засаг

Өмнөговь сумын эдийн засгийн эх үүсвэр нь голчлон мал аж ахуй байдаг. 2018 онд суманд 1000 гаруй малчин өрхөд нийт 233150 толгой мал тоологдсон. Энэ нь сумын нийт хүн амын 87-оос дээш хувь юм. 2018 онд Өмнөговь сум 113.7 га талбайд ихэвчлэн улаан буудай, хүнсний ногоо тарьж ашигласан байна.

Дэд бүтцийн нөхцөл

329. Өмнөговь сум нь Баян-Өлгий аймгийн Өлгий, Увс аймгийн Улаангом, Ховд аймгийн Жаргалант хотуудын дунд байрладаг. 2018 онд Өмнөговь суманд барилга, их засвар, засвар үйлчилгээнд 1.1 тэрбум төгрөг зарцуулжээ.

с. Ховд аймаг, Жаргалант

330. Ховд аймгийн Жаргалант нь аймгийн өмнөд хэсэгт Улаанбаатараас 1600 км зайтай байдаг. Жаргалант нь засаг захиргааны нэгж 12 багтай.

Хүн ам

331. 2018 оны жилийн эцсийн байдлаар Жаргалант 8200 өрхийн 30336 хүн амтай байв. Үүнээс 14816 нь эрэгтэй, 15520 нь эмэгтэй. Хүн амын жилийн өсөлт 1% байна.

Боловсрол

332. 2018 оны байдлаар Жаргалантад 3512 хүүхэд хүмүүждэг 28 цэцэрлэг ажиллаж байна. Эдгээр цэцэрлэгт нийт 122 багш, 69 туслах багш, 361 сургуулийн өмнөх боловсролын ажилтан, 170 ажилчид байдаг. Жаргалантад нийт 8649 сурагч, 438 багш бүхий 8 ерөнхий боловсролын сургууль байдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээ

333. Жаргалант нь нийт 59 эрүүл мэндийн байгууллага, 336 ажиллагсадтай, үүнд 176 эмч, 208 сувилагч орно. $(176+208=384???)$ Хэвтэж эмчлүүлэх өвчтөнүүдэд зориулсан 362 орны хүчин чадалтай. 2018 онд Жаргалант дахь эмнэлгүүд 15578 өвчтөнд үйлчилжээ.

Ажилгүйдэл, ядуурлын түвшин

334. Ховд аймгийн нийт ажиллах хүч 39627 хүн байгаагаас ажилгүй хүн 3337. Хөдөлмөрийн оролцооны түвшин 73.9 хувь, Ховд аймагт ажилгүйдлийн түвшин 8.4 хувь байна. Жаргалантад 2019 оны 9-р сард бүртгэлтэй ажилгүй 821 хүн байна.

Эдийн засаг

Ховд аймгийн ДНБ нь 146 сая ам.долларын өртөгтэй, улсын хэмжээнд харьцангуй сайн хөгжсөн аймгуудын нэг юм. Ховд аймгийн эдийн засгийн гол салбарууд нь мал аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэр, үйлчилгээний салбар, уул уурхай болно. 2018 онд Ховд аймагт 3.14 сая толгой мал тоологдсон. 2233.5 га талбайд улаан буудай, хүнсний ногоо, тарvas тариалжээ. Жаргалант 99000 толгой малтай байв.

Дэд бүтцийн нөхцөл

335. Жаргалант нь Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, хилийн боомт Булган, Байтагийг холбосон Мянганы замд байрладаг. Жаргалантыг дулаан болон цахилгаан эрчим хүчээр хангадаг хоёр цахилгаан станц ажилладаг. Хотын нь цэвэр усны хэрэгцээг Буянт голоос хангадаг. Ариутгах татуургыг хотын бохирын шугамаар суурьшлын бүсийн баруун талд байрладаг бохир ус цэвэрлэх байгууламж руу хаядаг боловч хуучирсан технологийн улмаас цэвэрлэгээний түвшин маш бага байна

d. Баян-Өлгий аймаг, Өлгий

336. Өлгий нь Баян-Өлгийн аймгийн төв хэсэгт, Улаанбаатар хотоос 1690 км зайтай оршдог. 13 багтай.

Хүн ам

337. 2018 оны жилийн эцсийн байдлаар Өлгийд нийт 8424 өрхийн 36930 хүн ам байв. Үүнээс 18176 нь эрэгтэй, 18754 нь эмэгтэй. Хүн амын жилийн өсөлт 1% байна. Баян-Өлгий аймагт дундаж наслалт 73.11 байна.

Боловсрол

338. Өлгий хотод 2018 онд 3991 хүүхэд хүмүүждэг 26 цэцэрлэг ажиллаж байлаа. Цэцэрлэгүүдэд нийт 131 багш, 116 туслах багш, 539 сургуулийн өмнөх боловсролын ажилтан, 292 бусад ажилчид байсан. Өлгий хотод нийт 9970 сурагч, 652 багш бүхий 14 ерөнхий боловсролын сургууль байдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээ

339. Өлгий дэх нийт 61 эрүүл мэндийн байгууллагад 355 ажилтан үүнд 158 эмч, 236 сувилагч, 24 техник, үйлчилгээний ажилчид байна. Хэвтэж эмчлүүлэх өвчтөнүүдэд зориулсан 250 орны хүчин чадалтай. 2018 онд 110000 өвчтөнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлжээ.

Ажилгүйдэл, ядуурлын түвшин

340. Баян-Өлгий аймгийн нийт ажиллах хүч 55772 хүн байгаагаас 7,014 нь ажилгүй. Хөдөлмөрийн оролцооны түвшин 70%. Баян-Өлгий аймагт ажилгүйдлийн түвшин 12.6 хувь байна.

Эдийн засаг

341. Баян-Өлгий аймгийн ДНБ 139 сая ам.доллар. Баян-Өлгий аймгийн эдийн засгийн гол салбарууд нь газар тариалан мал үржүүлэг, хөнгөн үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай юм. 2018 онд Баян-Өлгийд 2.17 сая толгой мал тоологдсон. 2316.4 га талбайд улаан буудай, хүнсний ногоо тариалжээ.

Дэд бүтцийн нөхцөл

342. Баян-Өлгий нь Орос улс, БНХАУ-тай хиллэдэг. Оросын хил рүү гарах Цагааннуур боомт нь жилийн туршид нээлттэй байдаг бөгөөд Казахстан руу зорчих хамгийн тохиромжтой зам юм. Өлгий сум нь Ховд, Увс аймгуудтай хатуу хучилттай замаар холбогддог. Өлгийд цахилгаан, дулаанаар хангах цахилгаан станц ажилладаг. Айл өрхийн бохир усыг бохир ус цэвэрлэх байгууламж руу хаядаг боловч хуучирсан технологийн улмаас цэвэрлэгээний түвшин маш бага байдаг.

е. Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум

343. Дэлүүн сум нь Баян-Өлгий аймгийн урд хэсэгт Улаанбаатар хотоос 1,692 км зайд оршдог. Сумын нутаг дэвсгэр засаг захиргааны 10 багт хуваагддаг.

Хүн ам

344. 2018 оны жилийн эцсийн байдлаар Дэлүүн суманд нийт 1662 өрхийн 7437 хүн ам байв. Үүнээс 3686 нь эрэгтэй, 3751 нь эмэгтэй. Хүн амын жилийн өсөлт 1%.

Боловсрол

345. Дэлүүн суманд 2018 оны байдлаар 260 хүүхдэд үйлчилдэг 1 цэцэрлэг байна. Тус цэцэрлэг нь 8 багш, 7 туслах багш, 30 сургуулийн өмнөх боловсролын ажилтан, 15 ажилчидтай. Дэлүүн суманд нийт 1445 сурагч, 110 багштай 3 ерөнхий боловсролын сургууль байдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээ

346. Дэлүүн сум нь 24 ажиллагсад бүхий 1 эмнэлэгтэй, үүнд 7 эмч, 7 сувилагч, техник, үйлчилгээний 10 ажилтан байна. Хэвтэж эмчлүүлэгчдэд зориулсан 29 орны хүчин чадалтай. 2018 онд 705 өвчтөнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн.

Ажилгүйдэл, ядуурлын түвшин

347. Баян-Өлгий аймгийн нийт ажиллах хүч 55772 хүн байгаагаас 7014 нь ажилгүй. Хөдөлмөрийн оролцооны түвшин 70%. Баян-Өлгий аймагт ажилгүйдлийн түвшин 12.6 хувь байна.

Эдийн засаг

Баян-Өлгий аймгийн ДНБ 139 сая ам.доллар. Баян-Өлгий аймгийн эдийн засгийн гол салбарууд нь газар тариалан мал үржүүлэг, хөнгөн үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай юм. 2018 онд Баян-Өлгийд 2.17 сая толгой мал тоологдсон. 2316.4 га талбайд улаан буудай, хүнсний ногоо тариалжээ.

Дэд бүтцийн нөхцөл

348. Дэлүүн сум нь Баян-Өлгий аймгийн төв Өлгий сум, Ховд аймгийн төв Жаргалант сумтай хэсэгчилсэн хатуу хучилттай замаар холбогддог. Дэлүүн суманд 2018 онд барилга, их засвар, засвар үйлчилгээнд 1.4 сая төгрөг зарцуулжээ.

ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

349. АСХХОХ-д зориулан боловсруулж, хэрэгжүүлсэн оролцогч талуудын зөвлөлдөх стратеги нь АХБ-ны *Хамгааллын бодлогын баримт бичигт* (2009) заасан шаардлагын дагуу эмэгтэйчүүд, ядуу хүн ам зэрэг нөлөөлөлд өртсөн болон эмзэг бүлгүүдэд төслийг боловсруулахад эрх тэгш оролцох боломж олгох үүднээс утга учиртай оролцоо, ил тод байдал, хүртээмжтэй байх зарчмуудыг тусгасан.

М. Оролцогч талуудыг тодорхойлох

350. Нөлөөлөлд өртсөн талуудыг ТОСК/БХБЯ болон байгаль орчин, нийгмийн багийн дэмжлэгтэйгээр тодорхойлж, оролцоог нь ханган ажилласан. Хэлэлцүүлэгт оролцсон талуудыг дурьдвал:

- АСХХОХ-д ТОСК/БХБЯ-ыг төлөөлөх төлөөлөгчид ;
- Нөлөөлөлд өртсөн гэр хорооллын оршин суугчдын төлөөлөл
- АСХХОХ-ны нөлөөнд шууд өртсөн ба/эсвэл сөрөг нөлөөлөлд өртсөн байж болох хүмүүс, үр шимийг өргөжүүлэх, нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг

тодорхойлоход оролцох сонирхол бүхий, туршилтын гудамж дагуух гэр хорооллын оршин суугчдын төлөөлөл;

- Аж ахуйн нэгжүүд, айл өрх, шашны бүлгүүдийн төлөөлөл;
- Нөлөөллийн үнэлгээ хийсэн эрх бүхий компани, АСХХОХ-ны инженер

351. Хэлэлцүүлэг явагдсан байршлууд, бүтцийг дараах 52 –р хүснэгтэд нэгтгэн харуулав.

Table 51. Summary of public consultations of affected persons and local government

No.	Уулзалтын огноо, үргэлжилсэн хугацаа	Байршил	Оролцогчдын тоо, жендер	Оролцогчдын нас	Оролцогчид
1	2019-10-2. Ү/Х - 3 цаг 16.00-19.00	Ховд аймгийн Жаргалант сум. Ховд аймгийн ЗДТГ-ын хурлын танхим	Нийт 118 оролцогч Эрэгтэй-37 Эмэгтэй-81	20-85	Үр шимийг хүртэгсэд болон нөлөөлөлд өртөж болзошгүй гэр хорооллын оршин суугчдын төлөөлөл Аймгийн засаг захиргааны байгууллагууд ТББ –ын төлөөлөл Тэтгэврийн иргэд
2	2019-10- 3 Ү/Х - 2 цаг 16.00-18.00	Сумын ЗДТГ	Нийт оролцсон-18 Эрэгтэй-7 Эмэгтэй-11		Орон нутгийн засаг захиргааны ажилтнууд Хүнсний ногоо тариалагчид
3	2019- 10- 4 ү/х - 2 цаг 11.00 -1 3.00	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын гэрлэх ёслолын төв	Нийт 164 оролцогч: Эрэгтэй- 131 Эмэгтэй-33	20-75	Аймгийн засаг дарга Орон нутгийн засаг захиргааны ажилтнууд Сумын иргэдийн төлөөлөл Тэтгэврийн иргэд
4	2019- 10- 5 ү/х - 2.3 цаг 17.00-19.30	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хурлын танхим	Нийт оролцогч – 101 Эрэгтэй- 61 Эмэгтэй-40	15-80	Иргэд- төслийн үр шимийг хүртэгсэд Нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхүүд Сумын засаг захиргааны ажилтнууд
5	2019 -10-7 ү/х - 2 цаг 11.00-13.00	Увс аймгийн Өмнөговь сумын ЗДТГ-ын хурлын танхим	Нийт оролцогч – 60 Эрэгтэй- 33 Эмэгтэй-27	20-75	Орон нутгийн засаг захиргааны ажилтнууд Сумын иргэдийн төлөөлөл Тэтгэврийн иргэд
6	2019- 10- 8 Ү/Х - 2 цаг 18.00-20.00	Увс аймгийн Улаангом хотын драмын театр	Нийт оролцогч – 123 Эрэгтэй- 59 Эмэгтэй-64	20-70	Аймаг, сумын засаг захиргааны ажилтнууд Гэр хорооллын оршин суугчид, төслийн үр шимийг хүртэгсэд Нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхүүд Хүнсний ногоо тариалагчид, хадланчид
			Нийт оролцогч- 584 Эрэгтэй- 328 Эмэгтэй-256		

N. Ерөнхий хэлэлцүүлгийн сэдвүүд

352. Дараах сэдвээр хэлэлцүүлэг хийсэн:

- Төсөл, төслийн зорилго, санал болгож буй үйл ажиллагааны танилцуулга;
- АХБ-ХБББ (2009): Байгаль орчныг хамгаалах шаардлагууд ба АСХХОХ-ийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл, нөлөөллийг бууруулах арга хэмжээ;
- АХБ-ХБББ (2009): Нүүлгэн шилжүүлэлтийн аюулгүй байдлын шаардлагууд, нөлөөлөлд өртөж болзошгүй хүн ам.
- Асуулт хариулт

1. Төслийн танилцуулга:

- Төсөлд хамрагдах газруудыг хэрхэн сонгосон
- Төслийн үе шат, үйл ажиллагааны жагсаалт
- Нөхөн олговрын арга хэмжээ, хөрөнгийн үнэлгээний арга
- Төлөвлөлтийн өмнөх үе шат ба барилгын ажлын төлөвлөгөө

2. Байгаль орчныг хамгаалах шаардлагууд ба тулгамдсан асуудлууд:

- АСХХОХ-ны хүрээнд байгаль орчныг хамгаалах бодлого, ХБББ-ийн зорилго
- АСХХОХ-тэй холбоотойгоор байгаль орчны хамгааллын бодлогын хамрах хүрээ
- АСХХОХ-н үйл ажиллагаанд байгаль орчны үнэлгээ яагаад шаардлагатай болох
- Байгаль орчны төлөвлөлт ба менежмент:
 - Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) гэж юу вэ? Ямар агуулга багтаасан байдаг вэ?
- Мэдээлэл ил тод байх:
 - Ямар мэдээлэл өгөх, энэ нь олон нийтэд яагаад хэрэгтэй вэ?
- Олон нийтийн хэлэлцүүлэг ба оролцоо:
 - орон нутгийн олон нийтийн оролцооны зорилго ба зайлшгүй шаардлага
- Гомдол барагдуулах механизм:
 - яагаад чухал болох, бүтэц, хэрхэн хэрэгжүүлдэг
- Хяналт шинжилгээ хийх ба тайлагнах
- Байгаль орчны тооцоолоогүй нөлөөлөл
- Биологийн олон янз байдлыг хадгалах, байгалийн нөөцийн тогтвортой менежмент
- Бохирдлоос урьдчилан сэргийлэх, багасгах
 - болзошгүй нөлөөлөл ба тооцоолсон бохирдол
 - бохирдлоос урьдчилан сэргийлэх, багасгах шаардлагатай арга хэмжээ
- АСХХОХ төсөл хэрэгжиж буй талбай дахь орон нутгийн иргэд, төслийн ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдал

АСХХОХ төсөл хэрэгжиж буй газрын соёлын биет дурсгал ба шаардлагатай хамгааллын арга хэмжээ.

О. Зөвлөлдөх журам

1. Discussion guide

353. Оролцогчдыг байгаль орчны асуудал, АСХХОХ-ийн тулгамдсан асуудлын талаар ойлголт чиглэл өгөх зорилгоор байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн жагсаалтыг (Хүснэгт 53) танилцуулсан. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн жишээ нь оролцогчдод байгаль орчин гэдэгт юу багтахыг ойлгоход тусалсан. Оролцогчид байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг өөрсдөө тодорхойлж, нэмж оруулах боломж олгосон.

Table 52. Хэлэлцүүлгийг чиглүүлэхэд ашигласан, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн талаарх жагсаалт .

• Ундны усны чанар, хүрэлцээ • Гадаргын усны чанар, хэмжээ • Гүний усны чанар, хэмжээ • Агаарын чанар • Уур амьсгал • Газар, хөрсний чанар • Гол, усны нөөц • Мод, ургамал • Газрын нөөц, ой мод, ашигт малтмал, хөрс	• Загас, шувуу, сүүн тэжээлтэн хуурай зэрэг хуурай газар, усны амьтад • Тусгай хамгаалалттай газар нутаг (байгалийн цогцолборт газар, дархан цаазат газар), • газар ашиглалт (хөдөө аж ахуй, загасны аж ахуй, ойн аж ахуй, усан зам, худалдааны болон бусад зорилгоор) • олон нийтийн аюулгүй байдал • олон нийтийн шилжилт хөдөлгөөн, хүртээмж • Соёлын биет өв (сүм дуган, хиргисүүр, хөшөө дурсгал)
---	--

354. Оролцогч талуудын хэлэлцүүлгийг чиглүүлэх үүднээс таван чөлөөт асуулт, мэдээллийн хүсэлт (Хүснэгт 54) тавьсан.

Table 53. Guiding questions and information requests for stakeholder consultations

1. АСХХОХ-н үр өгөөж юу байх вэ?
Үр өгөөж/ашиг тусыг дурдана уу.
2. АСХХОХ-тэй холбоотойгоор байгаль орчны талаар санаа зовниж буй асуудал таны хувьд бий юу?
АСХХОХ-тай холбоотойгоор байгаль орчны талаар санаа зовниж буй асуудлаа дурдана уу?
3. АСХХОХ-ийн **барилгын ажлын үе шаттай** холбоотойгоор байгаль орчны талаар санаа зовниж буй асуудал байна уу?
Барилгын ажлын үе шаттай холбоотойгоор байгаль орчны талаар санаа зовниж буй асуудлаа дурдана уу?
4. АСХХОХ-ийн **ашиглалтын үе шаттай** холбоотойгоор байгаль орчны талаар санаа зовниж буй асуудал байна уу?

Ашиглалтын үе шаттай холбоотойгоор байгаль орчны талаар санаа зовниж буй асуудлаа жагсаана уу?

5. Байгаль орчин, орон нутгийн ард иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд АСХХОХ-ийн зураг төсөл, үйл ажиллагааг өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна уу?

Байгаль орчин, орон нутгийн ард иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгахын тулд АСХХОХ –т оруулах шаардлагатай гэж үзэж байгаа өөрчлөлтүүдээ дурдана уу?

Р. Аймаг, сумын төвд хийсэн олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн

355. Дараах хүснэгтэд зөвлөлдөх уулзалтад оролцогчдын төсөл, нөлөөлөлд өртсөн орчинтой тусгайлан харьцуулж үзсэн үзэл бодол, асуудлыг нэгтгэн харуулав. Бүх зөвлөлдөх уулзалтын тэмдэглэл, уулзалтад оролцсон хүмүүсийн гарын үсгийг Хавсралт С-д оруулсан болно

Table 54. Төсөл хэрэгжих таван нутагт явагдсан нийтийн хэлэлцүүлгийн үеэр яригдсан гол асуудлын тойм

Санаа зовоосон асуудал	Орон нутаг	АСХХОХ блон зөвлөхүүдийн зүгээс өгсөн хариулт	Төслийн хариу арга хэмжээ
Айл өрхийн зуухнаас гарч буй утаа агаарыг бохирдуулж байна Ялангуяа хүрээлэн буй орчны бохирдол, хатуу хог хаягдлын менежмент хангалтгүй, иргэдийн хог хаягдлыг зайлуулахтай холбоотой сөрөг буруу зан үйл, дадал зуршил Гудамж талбайд траншейны нүхийг таглаагүй орхих зэрэг байдлаас болж явган зорчигчдын аюулгүй байдалд эрсдэл учирдаг	Ховд аймгийн Жаргалант сум	АСХХОХ гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүрэлдэхүүн хэсэг нь ус хангамж, дулаан, бохирын систем зэрэг үндсэн дэд бүтцийг бий болгох / сайжруулах замаар агаар, хөрс, усны бохирдлыг бууруулахад чиглэдэг Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ, хатуу хог хаягдлын цэгийг сайжруулах замаар хатуу хог хаягдлын менежментийг сайжруулна. Үүний зэрэгцээ эрүүл, аюулгүй амьдралын зөв дадал зуршлыг хэвшүүлэхийн тулд олон нийтийн ойлголт, мэдлэгийг сайжруулахад орон нутгийн засаг захиргааны зүгээс илүү анхаарах шаардлагатай байна.	Гэр хорооллын дахин төлөвлөлт нь дотоод орчны агаарын чанарыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлнэ. • АСХХОХ нь хотын агаар, усны бохирдлыг бууруулж, байгаль орчны чанарыг сайжруулна. • Барилгын үе шатны явцад явган зорчигч болон олон нийтэд сөрөг нөлөөлөл учруулахгүй байхад онцгой анхаарал хандуулах ба сайжруулсан дэд бүтэц, зам зэрэг нь явган зорчигчдын аюулгүй байдлыг ханган, илүү тав тухтай орчныг бий болгоно.
Хаврын тариалалтын үеэр Буянт голын усны нөөцийн асуудал, тариаланчдын хооронд өрсөлдөөний асуудал үүсдэг.	Ховд аймгийн Буянт сум	Буянт голоос ус хэрэглэгчдэд тулгамдаж буй усны хомсдолын асуудлыг харгалзан АСХХОХ-ын	Буянт голын урсгалыг өөрчлөн, талбай усжуулах

Санаа зовоосон асуудал	Орон нутаг	АСХХОХ блон зөвлөхүүдийн зүгээс өгсөн хариулт	Төслийн хариу арга хэмжээ
Хэрэв АСХХОХ-ны хөдөө аж ахуйн бүрэлдэхүүн хэсэг, ялангуяа Буянт голын дээд хэсэгт 500 га усалгаатай талбай байгуулвал хүнсний ногоо тарьдаг хүмүүс, голын дагуух экосистемийн хувьд усны хомсдол үүснэ. Бохир ус цэвэрлэх байгууламж хангалтгүй байгаагаас бохир усаа Буянт голд цутгаж, усны чанарт сөргөөр нөлөөлж байна.		судалгааны баг усалгаатай талбайн бусад хувилбаруудыг судалж байна. АСХХОХ нь бохир ус цэвэрлэх байгууламжийн үндэсний стандартыг хангахын тулд тус байгууламжийн технологийг сайжруулахад хөрөнгө оруулахаар төлөвлөж байна.	хувилбарыг төслөөс хассан. Жаргалант сумын бохир ус цэвэрлэх байгууламжийг төслийн хүрээнд шинэчлэн сайжруулна.
Сумын төвийн гүний худгуудын усны чанар муу байгаа нь хүүхдүүдийн шүдэнд муугаар нөлөөлж байна гэж үзэж байна. Зарим газрын малчдын хувьд үерийн улмаас маш их хүндрэл тулгарч байгаа тул үер их болдог газруудад уг төслийн хүрээнд гүүр барьж өгөх хүсэлт тавьж байв. Сумдад бэлчээрийн даац хэтэрч, цөлжилт нэмэгдсээр байгаа. Бэлчээрийн бүсэд ургасан модыг гэмтээх, сүйтгэх нь элбэг байдаг тул төслийн хүрээнд мод үржүүлэх, нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх хүсэлт тавьж байв.	Баян-Өлгийн аймгийн Дэлүүн сум	Ус хангамжийг сайжруулах Засгийн газрын санхүүжилттэй төсөл хэрэгжиж байгаа талаар сумын засаг дарга тайлбарлав. АСХХОХ-ын хөдөө аж ахуйн бүрэлдэхүүн хэсэг нь малчдад хөдөө, орон нутагт тогтвортой амьжиргаа бий болгох, мал сүргийн чанар, эрүүл мэндийг сайжруулах, малын тэжээл, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр харилцан уялдаатай олон ажлуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно.	Төслийн нарийвчилсан төлөвлөлтийн үе шатанд худгийн усны чанар, хэмжээнд үнэлгээ хийнэ. - Орон нутгийн бэлчээр ашиглагчдын бүлгээр дамжуулан эдгээр жижиг төслүүдэд бичил санхүүжилт олгоно. - Малын тоо толгойг цөөлж, чанаржуулах замаар бэлчээрийг нөхөн сэргээх нь АСХХОХ-ын агро бизнесийн бүрэлдэхүүн хэсгийн үндсэн зорилго юм.
- Өлгий хотод агаарын бохирдол бусад орон нутгуудтай харьцуулбал хамгийн их байгаа тул агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ эн тэргүүний зорилт болж байна. - Сонгогдсон багуудад барьж байгуулахаар төлөвлөж буй суурь дэд бүтцийг өргөтгөвөл бусад багийн оршин суугчдын аж амьдралд ч эерэгээр нөлөөлөх бөгөөд хүрээлэн буй орчны бохирдлыг	Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот	Аймаг сумын төвийг хөгжүүлэх АСХХОХ-н бүрэлдэхүүн хэсэг нь хүрээлэн буй орчны бохирдлыг (агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах) бууруулахад чиглэж байна. Төсөл нь 10 жилийн дараа болон түүнээс урт хугацаанд хүрээлэн буй орчны бохирдлыг дорвитой бууруулахыг зорьж байна.	Төслийн нарийвчилсан төлөвлөлтийн үе шатанд дулааны станцын үйл ажиллагааны нарийвчилсан судалгаа хийнэ. - АСХХОХ-н гэр хорооллын дахин төлөвлөлт нь дотоод орчны агаарын чанарыг сайжруулах болно. - Туршилтын төсөл хэрэгжүүлэхээр сонгосон багуудад гэр хорооллын дахин төлөвлөлт хийснээр агаарын чанар, амьжиргааны түвшинд гарсан эерэг зэрэг

Санаа зовоосон асуудал	Орон нутаг	АСХХОХ блон зөвлөхүүдийн зүгээс өгсөн хариулт	Төслийн хариу арга хэмжээ
бууруулахад ашиг тусаа өгөх болно. Одоо байгаа цахилгаан станцын хүчин чадал гэр хорооллын дулаан хангамжийн эрэлт хэрэгцээг хангахад хүрэлцэхгүй байх гэсэн санаа зовнилоо оролцогчид илэрхийлж байв.			өөрчлөлтийн үр шимийг бусад багуудад харуулж, түгээн дэлгэрүүлэхэд оршино. Төслийн хүрээнд одоо байгаа цахилгаан станц, холбогдох байгууламжуудыг шинэчлэн сайжруулна.
- Төслийн хүрээнд байгуулах ус хангамжийн дэд бүтэцтэй холбоотойгоор гүний усны хэрэглээ нэмэгдэж, нөөц багасхтай холбоотой санаа зовж буй асуудлууд - Нийтийн барилга байгууламж бүгд (цэцэрлэг, сургууль, дотуур байр, албан газрууд) бохирын шугамд холбогдсон тохиолдолд бохир усыг хэрхэн цэвэршүүлэх вэ? Төвлөрсөн цэвэрлэх байгууламж байх уу, эсвэл хувийн септик танк байх уу? - Саарал усыг мод услахад ашиглах, гүний усыг ашиглахгүй байх. - Барилгын ажлын үе шатанд төслийн хүрээнд тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах эсэх	Увс аймгийн Өмнөговь сум	АСХХОХ нь бохир ус цэвэршүүлэх байгаль орчин, эрүүл мэндэд ээлтэй шийдлүүдийг тодорхойлж, саарал ус болгон мод усалгаа, усжуулалтад ашиглах боломжийг бүрдүүлнэ. АСХХОХ-н байгаль орчны баг нь төслийн бүтээн байгуулалтын үе шатанд нэлээд хэмжээний тоосжилт үүсэхийг тогтоосон. Тоосжилт дарах үйл ажиллагаа, орон нутгийн ард иргэдийн болон ажлын байран дахь аюулгүй ажиллагааг хангах ажлыг хуурай улиралд хийхээр БОМТ-д тусгасан ба зохих хяналт шинжилгээ, хэрэгжүүлэх бүтэц, нөөцийг тогтооно. Төслийн бүтээн байгуулалтын явцад орон нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой асуудал үүсвэл авах арга хэмжээний төлөвлөгөө бий болгоно.	- Бүх хэрэглэгчдийг гүний болон гадаргын усаар тогтвортой хангах асуудал нь АСХХОХ-н чухал зорилт бөгөөд төслийн нарийвчилсан төлөвлөлтийн явцад нарийвчлан судлах болно. Аймаг, сумын төвүүдэд бохир ус цэвэршүүлэх шинэ байгууламжууд баригдсанаар нийтийн бүх барилга байгууламжийн бохир усыг төвлөрсөн байдлаар цэвэршүүлнэ. - Саарал усыг сум, аймгийн төвүүдэд усжуулалтад ашиглах нь зөв санаа бөгөөд төслийн зүгээс мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх болон засвар, үйлчилгээгээр дэмжлэг үзүүлнэ. - Тийм, тоосжилт бууруулах бодисыг (жишээ нь, ус, CaCl₂) барилгын ажил явагдаж буй бүх талбай болон зам дээр цацна.
Малын арьс шир зэрэг хатуу хог хаягдлаас үүссэн бохирдол. Улаангом хотод хог хаягдал цуглуулах, зайлуулах зохистой систем байхгүй бөгөөд хог хаягдлаа гудамжинд ил задгай хаядаг. Хатуу хог хаягдлын менежментийн зохистой тогтолцоо нэн шаардлагатай байна.	Увс аймгийн төв Улаангом	Хот суурин газрын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулна. Үүнд хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, зохих ёсоор зайлуулах зэрэг багтана. Хог хаягдлыг зайлуулахын өмнө хатуу хог хаягдлыг дахин ашиглах, дахин	Төслийн нарийвчилсан төлөвлөлтийн үе шатанд хийгдэж буй томоохон ажил бол хатуу хог хаягдлын менежментийн хэрэгцээ шаардлага буюу үнс, ахуйн хог хаягдал, малын хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах хэрэгцээ шаардлагыг судлах явдал юм.

Санаа зовоосон асуудал	Орон нутаг	АСХХОХ блон зөвлөхүүдийн зүгээс өгсөн хариулт	Төслийн хариу арга хэмжээ
Тээл голын ойролцоо 500 га усалгаатай газар тариалангийн талбай байгуулах төслийн төлөвлөсөн үйл ажиллагаа нь Увс нууранд цутгадаг голын эрэг дагуу хадлан хаддаг хүмүүсийн дунд голын усны хэрэглээний өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ.		боловсруулах, булах хэмээн ангилан ялгана. АСХХОХ нь төслийн усны хэрэглээ хэт ихсэх, хэрэглэгчдийн хооронд маргаан үл ойлголцол гарахаас сэргийлэх зорилгоор одоогийн усны хэрэглээтэй харьцуулан судалж, Хархираа (голын өөд), Тээл (гол уруудан) ус ашиглагчдад үнэлгээ хийнэ	АСХХОХ- н усжуулалтын эх үүсвэр болох бусад 3 голтой адилаар, Тээл голын усны бүх хэрэглэгчид, Увс нуурын ай савын тусгай хамгаалалттай газар нутгийн хэрэглэгчдийн усны хэрэглээг төслийн нарийвчилсан төлөвлөлтийн үе шатанд ул суурьтай судлах болно.

1. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН

356. Оролцогчид төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, холбогдох хууль тогтоомж, бодлогын талаар ойлголт, мэдээлэлтэй болсондоо талархал илэрхийлэв. Түүнчлэн оролцогчдод төслийн хүрээнд гомдол барагддуулах механизмыг (Н бүлэг) тайлбарлан, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний талаархи бусад асуултанд хариулах хүмүүсийн холбоо барих мэдээллийг өгсөн болно.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

357. Увс аймгийн төв Улаангом, Өмнөговь сумын төв, Баян-Өлгий аймгийн төв Өлгий, Дэлүүн сумын төв, Ховд аймгийн төв Жаргалант гэсэн 5 газарт АСХХОХ-ийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хөгжлийн дараахь үе шатуудаар авч үзэж тодорхойллоо. Үүнд:

- а) Барилга угсралтын ажил эхлэхийн өмнөх үе шат;
- б) Барилга угсралтын ажлын үе шат;
- в) Барилга угсралтын ажлын дараах үе шат.

358. Үнэлгээний энэхүү бүтцийг цаашид аймгуудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсруулахад зориулж сонгосон болно. Давхардал үүсэхээс зайлсхийхийн тулд аймаг, сумдын төслүүдэд гарч болзошгүй нийтлэг шинжтэй нөлөөллүүдийн үнэлгээг хамтад нь хийж, тайлбарласан болно. Ингэснээр АСХХОХ-ийн хөрөнгө оруулалтаас үүсч болзошгүй нөлөөллийг илүү нарийвчлалтай үнэлж дүгнэх, хэлэлцэж ярилцах, төслийн тодорхой нөлөөллийг тодруулах боломжийг олгодог.

Q. Гурван аймгийн төв, хоёр сумын төвд ирэх үр өгөөж

1. Амьдралын нөхцөл, гэр бүлийн эрүүл мэнд сайжрах

359. Зорилтот аймаг болон сумын төвүүдийн дэд бүтцийг олон талаар сайжруулсанаар тэнд оршин суугчдын амьдралын түвшинг бодитой дээшлүүлэхэд АСХХОХ-ийн 1-р ээлжийн цогц ач холбогдол орших болно. Аймаг, сумын төвд төсөлд хамрагдаж буй нутгийн иргэдийн амьдралын нөхцөл, гэр бүлийн эрүүл мэндийн нөхцөл сайжирсныг дараах үзүүлэлтээр илэрхийлнэ.

1. Аймгийн төвд уламжлалт гэрийг орчин үеийн, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцаар орлуулсанаар байшин доторх агаарын чанар сайжрах болно (жишээ нь нүүрс, мод түлэхтэй харьцуулахад PM2.5 буурах), нүхэн жорлонг орчин үеийн бие засах газар, ариутгах татуургаар сольж шинэчилсэнээр ходоод гэдэсний замын өвчлөл буурах болно.
2. Шугам сүлжээнд холбогдсон ундны ус хангамж
3. Бохир ус зайлуулах төвлөрсөн шугам болон төвлөрсөн цэвэрлэх байгууламж
4. Төвлөрсөн халуун ус ба халаалт
5. Цахилгаан эрчим хүчний хангамж сайжирна
6. Хатуу хог хаягдлыг зохион байгуулалттайгаар цуглуулж зайлуулах менежмент
7. Үерийн усны хамгаалалт, дренаж сайжирна
8. Сургууль, эмнэлэг, олон нийтийн төв зэрэг байгууламжуудад хүрэх нийтийн аж ахуйн үйлчилгээ сайжирна
9. Бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулсанаар гадаргын усны чанарт мэдэгдэхүйц ахиц гарна.

360. АСХХОХ-ийн хоёр дахь гол үр өгөөж нь аймаг, сумын төвүүдэд орчин үеийн агро-үйлдвэрлэлийн технологи, практикийг нэвтрүүлэх төслийн хөдөө аж ахуйн бүрэлдэхүүн хэсэг байна. Энэ нь агро-паркийн цогцолбор байх бөгөөд үүнд хорио цээрийн бүс, мал эмнэлгийн үйлчилгээ, мал төхөөрөх орчин үеийн үйлдвэр, судалгаа шинжилгээний төвүүд, усалгаатай тэжээлийн аж ахуй байх болно. Агро-үйлдвэрлэл ба бэлчээрийн менежментийн бүрэлдэхүүн хэсгүүдийн гол үр өгөөж нь:

1. Мах боловсруулах, савлах, хадгалах орчин үеийн технологи нэвтрүүлэх (НҮБ-ХХАБ 1988, ДЭМБ 1984), хог хаягдлын менежментийг зохистой болгох замаар байгаль орчны бохирдлыг мах боловсруулах өнөөгийн практикийн хэмжээнээс бууруулах;
2. Нэг дэх үр өгөөжөөс улбаалан, дотоодын болон олон улсын зах зээлд зориулж үйлдвэрлэх махны чанарыг сайжруулснаар урьд өмнө нь хүрч чадахгүй байсан өндөр ашигтай олон улсын зах зээлд гаргах махны экспортоос малчид, экспортлогчдын амьжиргааны орлогыг нэмэгдүүлэх;
3. Хоёрдахь үр өгөөжөөс улбаалан, малын тоо толгой буурсанаар бэлчээрийн даац хэтрэлт багасах ба улмаар бэлчээрийн чанар сайжирна;
4. Гуравдахь үр өгөөжөөс улбаалан, малаас гарах метаны хийн (CH₄) ялгарлыг бууруулж, нөхөн сэргээсэн бэлчээрт нүүрсхүчлийн хийн (CO₂) шингээлтийг нэмэгдүүлсэнээр улмаар төсөлд хамрагдаж буй Монгол орны баруун аймгуудын хүлэмжийн хийн ул мөрийг эрс бууруулах болно.

R. Нөлөөлөл болон бууруулах арга хэмжээ

1. Барилга угсралтын ажлын өмнөх шатны нөлөөлөл, хийгдэх үндсэн ажлууд

361. Барилга угсралтын ажил эхлэхээс өмнөх үе шатны нөлөөлөл нь газар чөлөөлөлт, болзошгүй албадан нүүлгэн шилжүүлэлт юм. Инженерийн шугам хоолой, барилга байгууламж, авто зам, голын эрэг, далангийн тохижилтыг хамруулсан шинэ, сайжруулсан дэд бүтцийг барьж байгуулах ажлын нөлөөгөөр хот суурин газарт газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэлт хийх болзошгүй шаардлага бий болдог. Шаардлагатай газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хэмжээг дараах хүснэгтэд нэгтгэв.

Table 55. Газар чөлөөлөх болон нүүлгэн шилжүүлэх ажлын тооцоот хэмжээ (ГЧНШ)

ГЧНШ-ийн нөлөө	Өртөж буй иргэд, ААН			Өртөж буй хашаа			
	Иргэд	ААН	Нийт	Бүрэн	Хагас	Нийт хашаа	Өртөж буй нийт талбай м2
Баян-Өлгий	5	2	7	1	6	7	1043
Увс	21	1	22		14	14	1138
Ховд	-	-	-	-	-	-	-
Нийт			29	1	20	21	2181

а. Усны хүрэлцээ

362. Барилга угсралтын өмнөх үе шатанд хийх гол ажлууд болон 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн нэг хэсэг нь усны хэрэглээ бүхий төслийн бүрэлдэхүүн хэсэг болох тэжээл тариалах талбайн усалтын систем, мал төхөөрөх үйлдвэр мөн түүнчилэн цаашид нэмэгдүүлэхээр төлөвлөж буй хот суурин газрын ундны усны хангамжид шаардлагатай гадаргын болон гүний усны олдоц, хүртээмжийг баталгаажуулах явдал юм. орон нутгийн гадаргын болон гүний усны баланс хэмжээг

(i) төслийн усны хэрэглээний шаардлагыг тогтвортой хангахуйц байх;

(ii) ус авч хэрэглэх цэгээс доошхи хэрэглэгчдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх гэсэн шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор ялангуяа урсгал татарч багассан үед тодорхойлох ёстой.

363. IV бүлэгт нэгтгэж үзүүлсэн төслийн талбайн ойролцоох голын хамгийн бага урсацыг (Хүснэгт 44) ус татах тухайн цэг болон голын салаа хэсгүүд дээр илүү нарийвчлалтай, улирлын бүрэн хэмжилт хийж баталгаажуулах мөн III бүлэгт дурдсан тэжээлийн ургамлын 500га болон 200га талбайг услахад шаардлагатай гэж тооцоолсон $0.315\text{ м}^3/\text{сек}$, $0.126\text{ м}^3/\text{сек}$ хэмжээ нь тогтвортой байх эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Түүнчилэн III бүлэгт тусгагдсан агро паркийн (мах боловсруулах үйлдвэр, ХЦБ г.м.) төрөл бүрийн хөрөнгө оруулалтын усны нийт тооцоолсон хэмжээг баталгаажуулах ёстой бөгөөд орон нутгийн гүний болон гадаргын усны бага урсацтай харьцуулах нь зүйтэй.

364. Шинэ цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэсэн усыг нийлүүлэх голуудын улирлын хамгийн бага урсацыг тогтоож тодорхойлох нь мөн чухал. Аймаг, сумын төв, агро паркийн шинэ цэвэрлэх байгууламжуудаас гарах цэвэрлэсэн ус олон улсын стандартад нийцсэн байх (жишээ нь ОУСК-БОЭМААУ 2007) боловч уг усыг нийлүүлэх тухайн цэгээс доош байх хэсэг орчны усны чанарын стандартыг хангаж буй эсэх, нийлсэн ус холигдох бүсийн хэмжээ урсгалын дагууд хэр хол хүрэх эсэхийг тогтоох зорилгоор тухайн голын усны хамгийн бага урсацыг тооцох шаардлагатай.

б. Нарийвчилсан зураг төсрийн дуусгах

42. Барилга угсралтын өмнөх үе шатанд хийгдэх томоохон ажил бол бүх дэд бүтэц, агробизнесийн төслийн бүрэлдэхүүн хэсгийн нарийвчилсан инженерийн зураг төслийг боловсруулж дуусгах явдал юм. Нарийвчилсан зураг төсөл нь ТЭЗҮ-ийн загвартай хамт тодруулж чадаагүй төслийн бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн талаархи шинэ ойлголтыг өгөх болно. БОМТ-ийг шаардлагатай бол бүрэлдэхүүн хэсгүүдийн нарийвчилсан загвартай хамт шинэчилнэ.

с. БОМТ-г шинэчлэх Р

366. Барилга угсралтын өмнөх үе шатанд хийгдэх эцсийн үйл ажиллагаа бол гурван аймгийн БОМТ-г шинэчлэх явдал юм. Эцсийн зураг төслөөс гарах нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээг бүхэлд нь зөв удирдан зохион байгуулах үүднээс дэд бүтэц, агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нарийвчилсан зураг төслийг тусгах зорилгоор энэхүү стандарт үйл ажиллагааг гүйцэтгэдэг.

Барилга угсралтын ажлын үе шат дахь болзошгүй нөлөөлөл

367. Хөтөлбөрийн 1-р ээлжид хамрагдаж байгаа төслийн бүрэлдэхүүн хэсгүүд нь тусгай хамгаалалттай газар нутагт эсвэл зэрлэг ан амьтдын амьдрах орчинд эсвэл тэдгээрийн ойр орчимд байрлахгүй бөгөөд (АХБ-ХБББ 2009) мөн энд ховор болон нэн ховордсон ан амьтад байхгүй. Харин Ховд аймгийн Манхан, Мянгад суманд байсан төслийн анхны хоёр байршилд экологийн хувьд эмзэгт тооцогдох эдгээр гурван нөхцөл аль аль нь багтаж байсан тул Байгаль орчны багийн зүгээс эдгээр байршлыг Хөтөлбөрийн 1-р ээлжээс хассан болно.

368. Аймаг сумын төвд болон төвөөс зайдуу байрлах агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдэд дэд бүтцийн барилга байгууламж шинээр барих болон сэргээн шинэчлэх (тухайлбал: ундны ус, халуун ус, цахилгаан, харилцаа холбоо, бохир ус зэрэг инженерийн шугам сүлжээ зам, барилга байгууламж, ус зайлуулах хоолой, голын эрэг далангийн тохижилт, усан хангамжийн суваг) явцад гарах нөлөөлөл нь голчлон барилгын ажлын үед үүсч байдаг богино хугацааны тасалдал, нөлөөллүүд байх болно. Эдгээрийг доор нэгтгэж тайлбарласан болно.

d. ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛААС ҮҮСЭХ НИЙТЛЭГ НӨЛӨӨЛЛҮҮД

369. Аймаг төв, сумын төвүүдэд хийгдэх барилгын ажлын улмаас үүсэх нийтлэг нөлөө, саад нь дараах байдлаар илэрнэ: нийтийн тээврийн хөдөлгөөнийг хаах, эсвэл багасгах; цахилгаан хангамжийн тасалдал; бизнес болон амралт чөлөөт цагийн үйл ажиллагаа тасалдах; газар шорооны ажил, хүнд даацын ачааны машин, тоног төхөөрөмжийн ашиглалтаас үүсэх сул тоос шороо; тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний улмаас үүсэх хөрсний бохирдол; оршин суугчид болон ажиллагсдын осол, гэмтлийн эрсдэлүүд; замын хөдөлгөөний түгжрэл болон осол, гэмтэл нэмэгдэх; хөрсний элэгдэл, гол горхины урсгалын дагуу лаг тунах; хэсэгчилсэн талбайд түр зуур үүсч болзошгүй ус зайлуулах сувгийн бөглөрөл болон ус халих асуудлууд. Барилгын ажилчдын байрлах хотхоноос хатуу хог хаягдал, ахуйн бохирдол гарч таарах бөгөөд мөн явуулын ажилчдаас үүдэлтэй болзошгүй халдварт өвчин, нийгмийн асуудал гарч болох талтай. Эдгээр богино хугацааны нөлөөлөл, хангамжийн тасалдал нь барилгын ажлын явц дараалал, аймаг сумын төвын хаана хийгдэж байгаа байршил зэргээс хамаараад янз бүрийн хэмжээ түвшинтэй байх болно.

370. Барилга угсралтын үе шатанд хот суурин газарт машин механизмын тоо болон тэдгээрийн хөдөлгөөн нэмэгдэж оргил ажлын үед талбайн ойр орчимд бүр илүүтэй байх болно. Барилгын ажилд хэрэглэх элс хайрга, зуурсан ба хэлбэржсэн бетон, мод, тоосго, шугам хоолой, шил болон бусад барилгын материалуудыг зөөх машин механизмуудаас үүдэж тээврийн хөдөлгөөн ихэснэ. Гурван аймгийн төв, хоёр сумын төв рүү зөөвөрлөж хүргэх материалын тооцоог нарийвчилсан зураг төсөл боловсруулах хүртэл хүлээх ёстой.

371. Гарч болох дуу чимээний болон тоос шорооны цар хэмжээг одоогоор тааварлаж хэлэх боломжгүй. Гэхдээ төслийн талбайд очиж ажилласан байдлаас үзэхэд ялангуяа хоёр сумын төвд зуны хуурайшилттай үед байнгын хүчтэй байдаг салхинд барилга угсралтын ажил, машин механизмын хөдөлгөөнөөс үүсэх тоосны хэмжээ их байх магадлалтай.

i. Нөлөөллийг бууруулах нийтлэг арга хэмжээ

372. АСХХОХ-ийн үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй нөлөөллийг бууруулах барилгын менежментийн нийтлэг арга хэмжээг дор харуулав. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь барилгын менежментийн стандартын шилдэг туршлага, практик аргуудыг дагаж мөрдөх бөгөөд дэд бүтцэд (усан хангамж, ариутгах татуурга, харилцаа холбоо, эрүүл мэнд, аялал жуулчлалын байгууламжуудын элементүүд, зам, хог хаягдлын менежмент) зориулсан ДБ/ОУСК-ийн БОЭМАНУ-д (2007) нийцсэн байна. Нөлөөллийг бууруулах арга хэмжээг аймгуудын БОМТ-д нарийвчлан тусгасан болно.

1. Газар шорооны ажил явагдаж байгаа задгай газарт хашаа барьж, явган хүний зам эсвэл авто машин зорчих хэсэг дэх нүх сувгийг хучиж битүүлсэн байх ёстой.
2. Соёлын холбогдолтой олдвор, эд хөрөнгөтэй холбоотой соёлын олдворын менежментийн төлөвлөгөө байх шаардлагатай.
3. Бүх таван төв суурин дахь соёлын төвүүдийн үйл ажиллагааг бодитоор тасалдуулахаас сэргийлсэн нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.
4. Барилгын ажил хийгдэж байгаа эсвэл барилгын машин механизм ажиллаж байгаа замын бүх хэсэгт үүсэж буй тоос шороог багасгах зорилгоор тогтмол чийглэж байх үүрэгтэй ажилтныг томилж ажиллуулах хэрэгтэй.
5. Үүсэх дуу чимээг бууруулахын тулд барилга угсралтын бүх машин механизмыг зохих эрэмбэ дараагаар ажиллуулах мөн аль болох шөнө ажиллуулахгүй байх нь зүйтэй.
6. Барилга угсралтын машин механизм болон нийтийн тээврийн хэрэгслүүд дагаж мөрдөх хурдны хязгаарлалтын тэмдэг байрлуулж, дагаж мөрдөх.
7. Боломжтой тохиолдолд олон нийтийн замд саад учруулалгүйгээр барилгын машин механизмд зориулсан өөр зам эсвэл түр зуур ашиглах эгнээ гаргах нь зүйтэй.
8. Зам дагуух мод, бусад ургамлуудыг хамгаалах шаардлагатай ба мод буулгахыг аль болох багасгах нь зүйтэй.
9. Дэд бүтцийн хэсгүүдэд газар гаргах зориулалтаар буулгасан мод тус бүрийн оронд шинээр 3 мод тарих шаардлагатай.
10. Гэр хорооллын дахин төлөвлөлт хийж, орон сууц болон техникийн хэсэг барьж тохижуулах багууд дахь хашаануудад ухаж гаргах хөрс нь бохирдсон эсэхийг магадлах зорилгоор одоогийн болон хуучин ашиглалтын байдлыг хянаж тодруулах хэрэгтэй. Хашааны нүхэн жорлон болон түүний орй орчмын бохирдсон хөрсийг одоо байгаа хогийн цэгт эсвэл орон нутгийн байгаль орчны холбогдох газруудаас заасан байршилд зайлуулан булах нь зүйтэй.
11. Газар шорооны бүх ажлын эргэн тойронд эсвэл суваг шуудуу дагуу голын эргийн үерийн усны шуудуу, голын дагуух ил хэсэг болон бусад үерийн ус зайлуулах далан шуудууны эргэн тойронд хөрс бохирдох ба гадаргуугийн усанд лаг тунах, хөрсөнд элэгдэл үүсэхээс сэргийлж шавар шүүгч хөшиг хийх юм уу давхар налуу гаргаж өгөх шаардлагатай.
12. Олноороо ирэх явуулын ажилчдын урсгалыг багасгах, нийгмийн өвчний тархалтыг багасгах болон нутгийн оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулахаас сэргийлж аль болох орон нутгийн ажилчдыг авч ажиллуулах хэрэгтэй.
13. Түр ажилчдад зориулсан байрууд нь ахуйн хог хаягдлыг цуглуулах зохих байгууламж, мөн нийтийн эзэмшлийн газар болон гадаргуугийн уснаас хол зайдуу газарт байрлуулсан зохих тооны нүхэн жорлонтой байх нь зүйтэй.
14. Айл өрхийн хашаа болон нийтийн эзэмшлийн газраас хол зайд түлш шатахуун хадгалах зориулалтын талбайг бий болгон, тодорхой тэмдэглэгээ тавих хэрэгтэй.
15. Барилга угсралтын ажлаас олон нийт, ажилчдад үзүүлэх нөлөөллийг багасгахын тулд одоо мөрдөгдөж буй Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн

тухай хууль тогтоомж, бодлогыг дагаж мөрдөх шаардлагатай. Түүнчлэн эдгээр хууль дүрэмд нэмэлт болгож Дэлхийн Банк/ОУСК-ийн БОЭМААУ-ийг (2007) мөн дагаж мөрдөх ёстой.

16. Аймгийн байгаль орчны газраас АСХХОХ-д ашиглах карьер, шороон ордуудад урьдчилан зөвшөөрөл авсан байх ёстой. Ашиглалтын явцад карьер, шороон ордыг хашаагаар хашиж, ашиглалт дууссаны дараа аюулгүй болгож, ургамлан бүрхэвч ургатал нөхөн сэргээлт хийсэн байх шаардлагатай.
17. Элс, хайрга, чулуу зэрэг материалыг барилгын талбай руу болон талбайгаас зөөвөрлөхдөө ачааны машины тэвшийг хучсан байх ёстой.
18. Тоос шороо босч, элэгдэл үүсэхээс сэргийлж гэр хорооллын дахин төлөвлөлт хийх багуудад хашааны дагуух замд түр хугацаанд ашиглах элс эсвэл бусад дүүргэгч материалыг уртасгасан хугацаагаар овоолж ашиглахаас татгалзах, хучлагаар бүтээх юм уу байнга норгож байх хэрэгтэй.
19. Орон нутгийн ямар ч гол горхиноос элс олборлож болохгүй.
20. Түлш шатахуун бөөнөөр хадгалахдаа битүү бетон дэвсгэр дээр байрлуулах ба айл өрхийн хашаа болон ажилчдын байрнаас хол зайтай байлгах ёстой. Түлш шатахуун агуулах талбай, хадгалах савнуудад тодорхой тэмдэглэгээ хийсэн, хамгаалагдсан мөн гэрэлтүүлэгтэй байх шаардлагатай. Ажил гүйцэтгэгчид шатахуун ба газрын тос асгарахаас сэргийлэх онцгой байдлын төлөвлөгөөг бэлтгэсэн байх ёстой.

**е. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЯВЦ
ДАХЬ ОНЦЛОГ НӨЛӨӨЛӨЛ БА СӨРӨГ
НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ**

Гурван аймгийн төвд (Улаангом, Өлгий, Жаргалант)

Хашаан дахь байшинг буулгах, талбайг нөхөн сэргээх

373. Гэр хорооллын дахин төлөвлөлтөд оролцохоор шийдсэн хашаа эзэмшигчдийн хувьд хашаан дахь байшин болон бусад модон хийцүүдийг буулгах нь бохирдлын асуудал үүсгэхгүй гэж үзэж байна. Хашаан дахь байшингуудад асбест гэх мэт хортой материал байхгүй. Уламжлалт гэрийн ихэнх хэсэг эсгий байдаг бол байшин нь модоор хийгдсэн байдаг. Дахин боловсруулж болохуйц материалыг БХБЯ-наас??? зөвшөөрөгдсөн хогийн цэг дээр хаяж, бусад барилгын материалтай хамт хадгална. Ялангуяа хашаа эзэмшигчээс төсөлд хамрагдаагүй бусад айл өрхөд зарж борлуулж чадахгүй нүүрсний үлдэгдэл, зуух, халаагуур болон бусад хэрэгслийг нэгтгэн цуглуулж, байгаль орчны газраас зөвшөөрсөн хогийн цэгт зайлуулна.

374. Хашаан дахь жорлонг буулгах ажлыг Улаанбаатар хотод АХБ-наас хэрэгжүүлж буй Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төслийн мөрдөж буй журмын²³ дагуу гүйцэтгэнэ. Жорлонгийн модон байрыг хашаан дахь байшингийн хамт буулгаж зайлуулна. Жорлонгийн хашлага хаалтыг эвдэн буулгаж, нүхийг шороогоор дүүргэх замаар бохирыг байгалийн задралд оруулна. Ойр орчмын хөрсийг ГХХХОДХ-ийн 1-р төсөлд хэрэглэсэнтэй адил арга техник ашиглан бактер устгагч шүршиж халдваргүйжүүлэх ба талбайгаас ухаж авч, зайлуулах шаардлагатай бүх хөрсийг орон нутгийн байгаль орчны газраас зөвшөөрсөн хогийн цэг рүү тээвэрлэж зайлуулна.

²³ АХБ, 2016 он. Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл, Буцалтгүй тусламж 49113-001

Гурван аймгийн төв ба Өмнөговь, Дэлүүн сумдын төв

Найдвартай бөгөөд тогтвортой усан хангамж

375. Төслийн бүх 5 хэсгийн айл өрх, аж ахуйн нэгжүүд ундны усаа ойрхон байдаг ус түгээх цэгээс авдаг бөгөөд гол төлөв гэр, аж ахуйн нэгж рүүгээ өөрсдөө явганаар зөөдөг. Гэр бүлд хүүхдүүд ихэнхдээ ус зөөж авчрах үүрэгтэй байдаг.

376. Дэд бүтцийн барилгын ажил, гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх явцад өрхийн энэхүү үндсэн чухал ажил тасалдахгүй байх нь чухал юм. Өдөр тутмын эсвэл долоо хоногийн усаа зөөх үедээ хүүхэд, эхчүүд барилгын талбайн хажуугаар аюулгүй, чөлөөтэй явах боломжтой байх ёстой. Барилгын талбайн нийт хэсэг болон явган хүний зам хооронд тусгаарласан хамгаалалтын хашлага хийж одоо байгаа явган хүний замыг хамгаална. Хүмүүсийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай тохиолдолд ус зөөхөд зориулсан түр зуурын, хамгаалалттай маршрутыг бий болгох ёстой. Түүнчилэн барилгын ажлаас шалтгаалж гэр хороолол дахь ус түгээх цэгүүдэд ус хүргэх ажилд саад учруулж болохгүй.

Асфальт, бетон зуурмагийн үйлдвэр

377. Асфальт, бетон зуурмаг үйлдвэрлэх түр цехүүдийг хот суурин газрын дэд бүтцийн ажилд ашиглах болно. Энэхүү цехүүд нь тухайн газар, орон нутгийн хувьд хүрээлэн буй орчины бохирдлын эх үүсвэр болдог. Элс, бусад агрегат түүхий эд материалын овоолгоос үүсэх салхи, усны элэгдэл (тоос шороо, лаг хурдас) болон зуурмаг үйлдвэрлэх, хүнд даацын тэргээр зөөвөрлөх явцад үүсэх байнгын чимээ шуугиан, хөдөлмөр хамгааллын эрсдэл зэрэг асуудлууд үүснэ. Түүхий эдийг зохисгүй хэрэглэх, хадгалахаас үүдэж цемент дэх бэхжүүлэгч химийн бодис болон асфальт хийх материал дахь нүүрсустөрөгч нь (газрын тос, шингэлэгч зэрэг) хөрсний болон гадаргын усны бохирдол үүсгэж болзошгүй.

378. Түр цех байгуулах, ажиллуулах, эцсийн байдлаар буулгаж зөөх ажлыг гүйцэтгэхдээ ийм ажилд хэрэглэдэг сайн туршлагын аргуудыг хэрэгжүүлэх ёстой. Гүйцэтгэгч нь БХБЯ-ны хяналтын дор Дэлхийн Банк/ОУСК-ийн Байгаль орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдамжийн (ОУСК-БОЭМААУ 2007) 1) цемент, шохой үйлдвэрлэх, 2) Барилгын материал олборлох; 3) Газрын тосны жижиглэнгийн сүлжээ гэсэн олон улсын дүрэм журмыг баримтлах ёстой. Саяхан батлагдсан АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн (USEPA 2014) Бетон зуурмагийн үйлдвэрлэх практикийн журмыг мөн ашиглаж болно.

Хангамжид үүсэх тасалдал

379. Аймаг, сумын төвүүдэд дэд бүтэц, шугам сүлжээг засварлах, өргөтгөх ажлын явцад оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдийн хангамжид тасалдал үүсэх нь дамжиггүй. Орон нутагт гарах саад бэрхшээлийг багасгахын тулд боломжтой бол тухайн үед нөөц болон туслах төхөөрөмж ашиглах болно.

Улаангом

Нуурын эргийн дагуу үерийн хамгаалалтын даланг сайжруулах

380. Уулнаас буух уруйн үерээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улаангомьн баруун урд байх 5.0 км шороон даланг шинэчлэн сайжруулна. Далангийн хойд төгсгөлийн хэсгийг орон нутгийн ундны усан хангамж, усжуулалтад зориулсан жижиг нуур үүсгэхэд ашиглана. Нуурт лаг тунах, даланд элэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд далан дээр ажиллах хэсгүүдийн хооронд лаг шавар шүүгч хөшиг юм уу давхар налуу байрлуулахад онцгой анхаарах хэрэгтэй.

Өмнөговь сумын төв

Хогийн цэгийг тохижуулах

381. 1-р ээлжийн төлөвлөгөөгөөр салхинд их хэмжээгээр хийсэн тархаж буй хог хаягдлыг битүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор Өмнөговь суманд (мөн аймгийн төвүүд болон Дэлүүн сум) байгаа хогийн цэгийг цэвэрлэх, хашаа барихаар төлөвлөсөн боловч сумын захиргаанаас сумын ундны усны эх үүсвэр болдог гүний усны түвшинг харгалзан үзэлгүйгээр хогийн цэгийн хөрсийг малтаж ухсан байна. Энэ төслийг гүний ус бохирдуулсан асуудалд оруулахгүй байх үүднээс хогийн цэгээс шалтгаалсан гүний усны бохирдол үүсэхгүй гэдгийг баталгаажуулахын тулд усны түвшнийг тогтоох шаардлагатай.

Өлгий

Үерээс хамгаалах голын эргийн бэхэлгээ

382. Жил бүр хаврын шар усны үерт автагддаг байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Өлгий хотод Ховд голын эргийн 1250м хэсгийг сэргээн засварлаж сайжруулна. Мөн Улаангомд хийгдсэн ажилтай ижлээр голын усанд лаг тунах, даланд элэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд далан дээр ажиллах хэсгүүдийн хооронд лаг шавар шүүгч хөшиг юм уу давхар налуу байрлуулахад онцгой анхаарах хэрэгтэй.

2. Барилга угсралтын ажлын үе шат

а. Шинэ болон сайжруулалт хийх дэд бүтэц

Гэр хорооллын дахин төлөвлөлт

383. Дээр дурдсанчлан гурван аймгийн төвд орчин үеийн төвлөрсөн халаалт, угаалгын өрөө бүхий гэр хорооллын дахин төлөвлөлт хийх ажлын үр өгөөж нь хамрагдаж буй айл өрхүүдийн амьдралын нөхцөл ихээхэн сайжирч байгаа явдал юм. Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц барьснаар үр ашиг муутай нүүрс, мод түлдэг зуухыг халах ба ингэснээр хашааны айлын үүсгэж байсан нүүрстөрөгчийн ул мөрийг эрс багасгана.

384. Гэхдээ барилга байшингийн нягтрал нэмэгдсэнээр амьдралын нөхцөлд үзүүлэх бусад нөлөөллүүд болон асуудлууд үүсч болзошгүй. Нэгж талбайд оногдох гэр бүлийн нягтрал нэмэгдэж, нэг дор амьдрах өрхийн тоо нэмэгдэж болзошгүй нь шинээр баригдаж буй орон сууцны ашиглалт, эзэмшилтэй холбоотой үүсч болох нийгэм, гэр бүлийн асуудлуудад орно. Бусад болзошгүй асуудлууд нь шинэчлэгдсэн, орчин үеийн инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, эрчим хүчний хэмнэлттэй барилгын технологи зэргээс урган гарч болох юм.

Ундны усны тогтвортой хангамж

385. Төслийн хувьд үүсэж болзошгүй нөлөөлөл бол хэт их хэрэглээнээс шалтгаалж усны хомсдол үүсэх явдал юм. Нэмэлт насос ашиглаж эсвэл худгаас татсан өргөтгөж сайжруулсан усан хангамжийн сүлжээгээр дамжуулан аймаг, сумын төвүүдэд хүргэхээр төлөвлөж буй ундны усан хангамж тогтвортой байх ёстой. Усан хангамжийн эх үүсвэрийг хэмжээ, чанарын хувьд найдвартай байх байдлыг нь тогтоох үүднээс зураг төслийн нарийвчилсан шатанд гүний болон гадаргын уснаас хангах эсэхээс үл хамааран хүртээмжтэй байх эсэхийг нь шалгаж баталгаажуулах шаардлагатай. Уур амьсгалын өөрчлөлтөөс бүс нутгийн усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг харгалзан ундны усны хангамжийн ирээдүйн тогтвортой байдлын талаар мэдэж байх нь чухал болно.

Агаарт бохирдуулах бодис гаргах

386. Төслийн зүгээс учирч болзошгүй нөлөө нь хоёр аймгийн төв Улаангом, Жаргалантын агаарын бохирдол нэмэгдэх явдал юм. Төсөлд холбогдох одоо ажиллаж буй хоёр дулааны станцын өргөтгөлийг ялгарах утааны чанарыг сайжруулах арга хэмжээ оруулалгүйгээр төлөвлөсөн байсан. Нүүрсээр галладаг дулааны станцуудын шинэчлэлт өргөтгөл нь одоо гарч буй утааны ялгаруулалтыг (CO₂, NO_x, Sox) ихэсгэж болзошгүй. Эдгээр дулааны станцууд нь одоогийн байдлаар үндэсний болон олон улсын утааны хийн найрлагын стандартыг хангаж чадахгүй байна. Энэ нь 2-р ээлжийн төлөвлөлтөөр дээрх хоёр дулааны станцын утаа цэвэрлэх технологийг ОУСК-БОЭМААУ (ДЭМБ) дахь үйлдвэрийн утааны хийн найрлагын стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай гэсэн үг юм.

b. Агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсэг

i. Тогтвортой усан хангамж

(i) Гадаргын ус

387. Агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгийн нөлөөлөл нь зарим агро-үйлдвэрлэлийн хэсгүүдэд усны хомсдол үүсэж болзошгүй бөгөөд улмаар тухайн байршлаас доош орших ус хэрэглэгчдэд усны хомсдол бий болгох явдал юм. Тухайлбал байгаль орчны асуудлаарх олон нийтийн зөвлөлдөх уулзалтын үеэр төлөвлөж буй тэжээлийн ургамал тариалах усалгаатай 500га талбай руу Жаргалант орчимд Буянт голоос ус татаж өгөх нь Мянгад суманд одоо тулгараад буй усны хомсдолын бэрхшээлийг улам хурцатгана гэж Ховд аймгийн Усны сав газрын захиргаанаас мэдэгдсэн. Иймд Ховд аймгийн төв Жаргалантын дэргэдэх тэжээлийн ургамал тариалах усалгаатай тариалангийн талбайг төслийн 1-р ээлжээс хассан болно.

388. Тиймээс шинээр байгуулах 250 га (сумын төв), 500 га (аймгийн төв) хадлан, тэжээлийн аж ахуйн усжуулалтад зориулж ойролцоох голоос авч хэрэглэх нийт усны хэмжээг 0.126 м3/сек болон 0.314 м3/сек гэж тооцсоныг (Бүлэг ?) нарийвчилсан зураг төслийн шатанд батлах шаардлагатай. Энд голоос татах шаардлагатай усны хэмжээг гаргахдаа 1-2 км үргэлжлэх усжуулалтын сувгийн дагуух усны ууршилтын хэмжээг нэмж тооцох ёстой.

389. Үүний нэгэн адил 40-р хүснэгтэд үзүүлсэн усалгааны схемийн ойролцоо буй голын хамгийн бага урсацын талаарх мэдээллийг суваг татах буюу ус авах тухайн цэг дээрх голын улирлын урсацын нарийвчилсан хэмжилтээр дахин баталгаажуулах шаардлагатай байна. Хүснэгт 40-д өгөгдсөн 2018 оны урсацын өгөгдлийг ашиглаж тооцсон 500 га тэжээлийн аж ахуйд шаардлагатай услалтын тооцоо нь голын ойролцоо байгаа усны урсгалын хэмжсэн бага урсацын 35%-ийг эзэлж байна.

Тариалан сумын услалтын систем

390. Тариалан суманд төлөвлөж буй хоёр төрлийн услалтын системийн (Зураг 11 - 13) тогтвортой усан хангамжийг баталгаажуулах шаардлагатай. Ялангуяа Тээлийн голын Увс нуурт цутгах доод хэсгийн орчим байрлах 500га тариалангийн талбайг онцгойлон анхаарч үзэх шаардлагатай. Хархираа голоос ус татаж нөөцлөх төслийн талаар Тариалан сумд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчид болон дотоодын гидрологичийн ??? хэлсэнээр Тээлийн голын доод хэсэг нь зуны бага хэмжээний урсац болон газар тариаланд хэт их авч авч ашигладгаас шалтгаалж зуны саруудад ширгэдэг тул Увс нуурт хүрч чаддаггүй байна. Иймд 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн үе шатанд услалтын системийг усаар хангалттай хангаж чадах эсэхийг тогтоох зорилгоор эцсийн байдлаар тогтоосон голоос суваг татах цэг дээрх урсацын хамгийн бага хэмжээг тодорхойлох шаардлагатай.

391. Гэхдээ 2018 онд инженерийн компани БОАЖЯ-ны гэрээгээр Тариалан сум дахь Хархираа-Тээлийн голын улирлын урсацад хэмжилт хийсэн бөгөөд хэмжилтийн дүнгээс үзэхэд голын хавар-зуны сар тутмын урсгалаас авахаар тооцож буй 3% -ийн урсацын хэмжээ тогтвортой бөгөөд нь голын дундаж урсацтай харьцуулахад харьцангуй бага байна. Иймд Хархираа-Тээлийн голоос ус татаж нөөцлөх төслийг цаашид шалгаж үзэх нь үндэслэлгүй болж байна.

Гүний ус

392. Услалтын системтэй нэг адилаар, төслийн талбай дахь гүний усны хүрэлцээ, агро паркард төлөвлөж буй мах боловсруулах үйлдвэр, хорио цээрийн бүсэд хэрэглэхээр тооцсон усны хэрэгцээнээс үүсч болзошгүй нөлөөлөл зэргийг нарийвчилсан зураг төслийн үе шатанд гүний усны боломжит нөөцөд тулгуурлан тодорхойлох шаардлагатай.

Гидро-геологийн судалгаа

393. Иймд 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн үе шатанд хийх гол ажил бол эцсийн байдлаар тогтоосон голоос суваг татах цэг дээрх урсацын хамгийн бага хэмжээг гидрологийн үнэлгээ хийж тодорхойлох, мөн түүнчилэн голоос доош орших хэрэглэгчдийн нийт хэрэглээний хэмжээг тогтоох явдал юм. Үүнтэй адилаар агропаркийн байгууламжуудад болон тухайн талбайн орчим дахь бусад хэрэглэгчдийн хэрэглэх гүний усны нөөц хангалттай байгаа эсэхийг тогтоохын тулд гидрогеологийн судалгаа хийх шаардлагатай байна. Ингэж нийлүүлэн тооцох нь төлөвлөж буй усалгаатай тариалангийн болон бусад хэрэглээ, ус ашиглагчдын хувьд голоос усыг тогтвортой авч хэрэглэх хэмжээг тодорхойлох болно.

ii. Тариалан сумын услалтын системээс Увс нуурын дархан цаазат газарт үзүүлэх нөлөө

394. Хэдэн мянган жилийн турш Увс нуурт цутгаж байгаа нийт голуудын улирлын урсац нь нуур болон түүний ойр орчмын ус, намгархаг газрын өвөрмөц эко системийг тодорхой хэмжээнд бүрдүүлж өгсөн байдаг. Маш өвөрмөц экосистем түүний нэг хэсэг болох амьтан, ургамлыг хамгаалахын тул нь Увс нуурыг дархан цаазат газар болгосон. Иймд нуурт цутгадаг голоос ус татаж хэрэглэх нь АХБ-ХБББ-т (2009) заасны дагуу тухайн бүс нутгийн хамгаалалтын ач холбогдолд нөлөөлж болзошгүй юм. Гэхдээ техник эдийн засгийн судлагааны шатанд байгаа хоёр төрлийн услалтын системийн хэмжээ болон Хархираа-Тээлийн голын доод хэсгийн талаар олж авсан мэдээллээс үзэхэд хоёр услалтын систем нь Увс нуурын экосистемд нөлөөлөхгүй болохыг харуулж байна.

395. Нэгдүгээрт, Тариалан суманд болсон олон нийтийн хэлэлцүүлэгт оролцогчид болон Тээлийн голын доод хэсгийг судалсан үндэсний гидрологичийн зүгээс гол зуны улиралд ширгэж, Увс нуурт хүрдэггүй гэдгийг тодорхой мэдээлсэн. Үүнээс үзэхэд Тээлийн гол хуурай улиралд Увс нуур руу цутгахгүй бол услалтын системүүдэд зориулж голоос ус татах нь нууранд нөлөө үзүүлэхгүй.

396. Хоёрдугаарт, Хархираа-Тээлийн голын 4-р сараас 8-р сарын урсацаас авч хуримтлуулах 3%-ийн хэмжээ нь үндсэн голын урсацтай харьцуулахад маш бага хэмжээ юм (Хүснэгт 11). Түүнчилэн 500 га тариалангийн талбайд зориулсан услалтын системд авахаар тооцож буй $0.315 \text{ м}^3/\text{сек}$ хэмжээ нь Хархираа-Тээлийн голын услалтын системд хэрэглэхээр төлөвлөж буй 3%-ийн хэмжээтэй ойролцоо байна. Иймд 1-р ээлжийн техник эдийн засгийн үндэслэлийн тооцооноос харахад Тариалан сум дахь услалтын хоёр системд зориулсан усны хэрэглээ нь Увс нуурт тун бага нөлөөлөх юм уу эсвэл огт нөлөөлөхгүй гэдгийг харуулж байна

S. Өдөөгдсөн болон хуримтлагдсан нөлөөлөл

397. Өмнө дурдсанчилан АСХХОХ-өөс гарах хамгийн гол хуримтлагдах нөлөөлөл бол хотын дэд бүтэц, нийтийн аж ахуйн үйлчилгээг иж бүрэн сайжруулснаар төсөлд хамрагдсан орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшин дээшлэх явдал юм. Түүнчилэн гэр хорооллын дахин төлөвлөлтөөс үүдэж гарах өдөөгдсөн нөлөөлөл нь гэр бүлийн хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулсанаар хувь хүний болон гэр бүлийн эрүүл мэндийн байдал дээшилж улмаар гэр хорооллын нийгэм, эдийн засгийг бэхжүүлэх явдал болно.

398. АСХХОХ-өөс үзүүлэх өөр нэг эерэг өдөөгдсөн нөлөө бол ирээдүйд малын тоо толгойг багасгаснаар сэргээн сайжруулсан бэлчээрт хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх, малаас ялгарах метаны (CH_4) хийг бууруулах гэсэн хоёр хэлбэрээр уур амьсгалын өөрчлөлтийг багасгахад хувь нэмэр оруулах явдал юм.

399. Төслийн болзошгүй сөрөг хуримтлагдах нөлөө нь төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн усны хэрэглээнээс шалгаалж одоо байгаа усны хомсдлыг улам хурцатгах юм уу эсвэл шинээр нэмж хомсдол үүсгэх асуудал болно. Төлөвлөж буй услалтын системийн усны хэрэглээ болон голын усыг газар тариаланд ашиглаж буй өнөөгийн байдал нь голоос доош орших хэрэглэгчдэд хомсдол үүсгэж болзошгүй. Үүнтэй адил агро паркууд дахь мах болон бусад бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр зэрэг агро-үйлдвэрлэлийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн гүний усны хэрэглээ нь ахуйн хэрэгцээ болон тариаланчид зэрэг бусад хэрэглэгчдийн хувьд хуурай улиралд гүний усны хомсдол үүсгэж болох талтай юм.

T. 1-р ээлжийн одоо байгаа байгууламжууд

400. 1-р ээлжийн техник эдийн засгийн үндэслэлээр Улаангом, Өлгий, Жаргалантад байгаа бохир ус цэвэрлэх байгууламж (БУЦС) болон нүүрсээр ажилладаг дулааны станцуудыг *“одоо байгаа байгууламжууд”* гэж авч үзэж байна (АХБ-ХБББ 2009). 1990 оноос өмнөх Зөвлөлтийн технологи нь зураг төслийн дагуу ажиллахгүй, үндэсний болон ОУСК-БОЭМААУ-ын байгаль орчныг хамгаалах стандартад нийцэхгүй болсон тул 1-р ээлжид хийгдэх бохир ус цуглуулах, цэвэрлэх системийг нийтэд нь сайжруулах ажлын хүрээнд гурван аймгийн төв дэх бохир ус цэвэрлэх байгууламжийг солих буюу бүрэн шинэчлэнэ. Тиймээс одоо байгаа цэвэрлэх байгууламжийг *шинэчлэх энэхүү арга хэмжээний* (АХБ-ХБББ 2009) дүнд АСХХОХ-ийн 1-р ээлжээр шинэ эсвэл бүрэн шинэчилсэн байгууламжуудтай болох юм.

401. Гурван аймгийн төвийн дулааны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ажлын хүрээнд зөвхөн станцын усны эргэлтийн насосыг шинэчлэх ба бусад төхөөрөмж, байгууламж хамрагдахгүй. Орон нутагт ажиллах үед ДС-уудын операторуудтай хийсэн ярилцлагын үеэр эдгээр станцуудаас гарах утааны найрлага нь үндэсний стандартад нийцдэггүй, тиймээс ч утааны найрлагын чанарын олон улсын ОУСК-БОЭМААУ (2007) стандартад нийцэхгүй байна гэж тогтоосон. Тиймээс одоо байгаа ДС-уудад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн шатанд тодорхойлж, 2-р ээлжээр хэрэгжүүлэх болно. Нарийвчилсан зураг төслийн үе шатанд тодорхойлж, 2-р ээлжээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь ДС-ын хувьд "засах арга хэмжээ" (АХБ-ХБББ 2009) болно.

U. Уур амьсгалын өөрчлөлт

402. АХБ, Уур амьсгалын ногоон сан, Монгол улсын Засгийн газрын уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн хөтөлбөрүүдэд АСХХОХ-ийн зүгээс дараахь арга хэлбэрээр хувь нэмэр оруулна: (i) уур амьсгалын өөрчлөлтөд тогтвортой байхуйц болгон шинэчлэн сайжруулж буй дэд бүтцээр дамжуулан аймаг, сумын төвүүдийн уур амьсгалын нөлөөлөлд өртөх эмзэг байдлыг бууруулах замаар өөрчлөлтөд дасан зохицох, (ii) мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан улам ихээр доройтох төлөвтэй байгаа бэлчээрт дасан зохицуулах, (iii) ирээдүйд сэргээгдэх бэлчээрийг ашиглан нүүрстөрөгчийн хийг шингээх болон метаны ялгаралтыг бууруулах, (iv) усны нөөцийн менежментийг сайжруулах; (v) эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, аймаг, сумын төвүүдэд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах замаар хот байгуулалтын салбараас нөлөөллийг бууруулахад хувь нэмэр оруулах. Төслийг санхүүжүүлэхээр Уур амьсгалын ногоон санд (УАНС) явуулсан хүсэлтэд АСХХОХ-ийн Уур амьсгалын эрсдлийн үнэлгээг тусад нь боловсруулсан. Энэхүү үнэлгээнд тусгагдсан гол тодорхой нөлөөллийг дараах байдлаар нэгтгэн харуулав.

- Нийт 369200 хүн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн үйл ажиллагааны үр өгөөжийг хүртэнэ (хөтөлбөрт хамрагдсан аймгийн хүн амын тоогоор тооцно). Уур амьсгалын өөрчлөлтөд илүүтэй дасан зохицсон хот суурин, сайжруулсан бэлчээр, тоос шороо багатай цэвэр агаар, хүрэлцээ сайтай усны нөөц зэрэг үр өгөөжийг аймгуудын хүн ам хүртэх болно.
- Хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнд нийтдээ **112.3 сая тнCO₂-экв** нүүрстөрөгчийн хийг хэмжээг бууруулах ба энэ нь дараахь зүйлүүдээс бүрдэнэ:
 - бэлчээрийн хөрсөнд нүүрстөрөгчийг шингээх замаар хөрөнгө оруулалтын ашиглалтын хугацаанд **94.0 сая.тн-СО₂-экв** хийн хэмжээг бууруулна. Энэхүү тооцоог АХБ-ны судалгаагаар гаргаж авсан консерватив коэффициент болон хөрсний нүүрстөрөгчийн тэнцвэрийг сэргээх үргэлжилсэн процессыг харгалзаж авч үзсэн таамаглалд үндэслэж хийсэн. УАНС-д явуулсан Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээнд өгсөн тооцоолол нь IPCC аргачлалд²⁴ суурилсан болно.
 - Малын тоог бууруулсантай уялдаж метан хий болон азотын ислийн хэмжээг **17.2 сая.тн-СО₂-экв** хэмжээгээр багасгана.
 - Хот суурин газрын эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч ашиглах замаар хөрөнгө оруулалтын ашиглалтын хугацаанд **1.1 сая.тн-СО₂-экв** хийн ялгарлыг бууруулна.

403. АСХХОХ-т зориулж Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээнд холбогдох баримт бичгийг (УАӨҮ-ХББ) тусад нь боловсруулсан. Энэ баримт бичгийг төслийн инженерийн багийн хийж гүйцэтгэсэн дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдийн цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох зардлын тооцоо болон УАНС-д явуулсан Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээнд тулгуурлаж боловсруулсан болно.

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох чиглэлээр авах арга хэмжээний зардал

²⁴ The ASDIP calculations are very conservative. Our estimate equals 4 tCO₂/hectare over the project's lifetime. The recently approved GCF project in Kyrgyz Republic (FP116) also contained a rangeland management component, with an estimate mitigation of more than 23 tCO₂/hectare over the project's lifetime.

404. Төслийн 1-р ээлжийн аймаг, сумын төвүүдэд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн зарим дэд бүтцийн хөрөнгө оруулалтын зардлын өсөлт 309,035 ам.доллар, хотын суурингийн ус зайлуулах системийн хувьд 4,851,143 ам.доллар, үерийн хамгаалалтад 202,900 ам.доллар, хатуу хог хаягдлын менежментийн хувьд 89,647 ам.доллар тус тус байна.

ХУВИЛБАРЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

405. 1-р ээлжийн төслийн шийдлийн үндсэн хувилбарууд нь дараахь байдалтай байна. Үүнд : (i) “Ээлжгүй” хувилбар; (ii) аймаг, сумын төв дэх хотын дэд бүтэц юм уу агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгийн аль нэгийг хасах, (iii) агро паркийн барилга байгууламжуудыг нэгтгэх эсвэл салангид байх, (iv) агро-үйлдвэрлэлийн зарим бүрэлдэхүүн хэсгийн байршлын хувилбар.

406. Дэд бүтэц сайжруулахгүй тохиолдолд иргэдийн амьдрал, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулж чадахгүй болох тул “ээлжгүй” хувилбарыг шууд авч үзэлгүй орхисон. Агро бизнесийн өртгийн сүлжээг сайжруулахгүйгээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өнөөгийн чанар муутай байдал, бэлчээрийн даац хэтрэлт хэвээр үлдэх бөгөөд малын тоо толгой бууруулсанаар малаас гарах метаны хийн (CH₄) ялгарлыг бууруулах, бэлчээрийг сэргээн сайжруулсанаар хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлж үүнээс үүдэн нүүрстөрөгчийн хийн нийт ялгаралтыг бууруулах зэрэг үр дүнгүүд мөн гарахгүй болох юм. 1-р ээлжийг хэрэгжүүлсэнээр бий болох үр өгөөж нь төслийн хэрэгжилтийн болзошгүй сөрөг нөлөөллөөс хамаагүй илүүтэй байх болно.

407. Аймгийн төвүүд дэх дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгийг хасах хувилбар нь төвүүдийн амьдралын нөхцлийг сайжруулж чадахгүй болгоход хүргэж улмаар агро-үйлдвэрлэлийн хэсэгт хийгдэх ажлуудыг саатуулах болно. Мөн агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хасах хувилбар нь “ээлжгүй” хувилбартай нэг адил сөрөг нөлөөтэй байх болно.

408. Мах боловсруулах, хадгалах үйлдвэр, малын хашаа саравч, лаборатори, мал эмнэлгийн үйлчилгээ, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр зэрэг агро паркийн бүрэлдэхүүн хэсгүүдийг аймгийн төвийн хэмжээнд тараан байрлуулахаар тооцож байсан анхны хувилбар төлөвлөгөөг орхиж эдгээрийг нэг газарт буюу Хорио цээрийн бүсэд төвлөрүүлсэн нь тэдгээрийн дэд бүтцийн хангамж, хог хаягдлын менежментэд шаардагдах зардлыг их хэмжээгээр багасгаж хэмнэсэн.

409. Экологийн хувьд эмзэг нөхцөл бүхий Ховд аймгийн Манхан сум дахь Хар-Ус нуурын БЦГ, мөн Мянгад сумын нутаг дахь нэн ховордсон бөхөнгийн нутагладаг нөөц газруудад учирч болзошгүй нөлөөлөл мөн түүнчилэн усны нөөц, тариалангийн ургамлын ургах өдрийн тоо зэрэг нөхцлүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр агро-үйлдвэрлэлийн бизнесийн зарим бүрэлдэхүүн хэсгүүдийн (агропарк, услалтын систем) байршлыг өөрчилсөн буюу бүрмөсөн хассан болно..

ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

V. Мэдээллийн ил тод байдал

410. АСХХОХ-ийн хэрэгцээ, сонголт, ойлголтыг тодруулах зорилгоор айл өрхүүдийг өргөн хүрээнд хамруулсан хэлэлцүүлэг, судалгааны талаар АСХХОХ-ийн нийгэм, санхүүгийн чиглэлийн үзүүлэлт болгон тусад тайлан бэлтгэсэн. Эдгээр хэлэлцүүлэг нь хашаа эзэмшигчид болон нөлөөлөлд өртсөн бусад талууд, иргэдэд мэдээллийн ил тод байдлыг

тогтмол хангах алхмуудыг тодорхойлсон. Дээр дурдсан байгаль орчны талаархи бие даасан олон нийтийн хэлэлцүүлэг нь нийгмийн чиглэлээр цуглуулсан өргөн хүрээтэй мэдээлэлд нэмэгдэж орж байна.

411. Нийгмийн чиглэлээр цуглуулсан дээр дурдсан мэдээллүүдийг тогтмол шинэчлэхийн зэрэгцээ төслийн бэлтгэл шатанд биечлэн уулзаж болон бичгээр холбогдсон бүх оршин суугчид болон оролцогч талууд сонирхсон тохиолдолд монгол хэл дээрх БОТБҮ-тэй чөлөөтэй танилцах боломжтой байна. Хамгийн наад жишээ нь БОТБҮ-ний хураангуйг монгол хэлнээ орчуулж нөлөөлөлд өртөгч бүх этгээдүүдэд тараана. БОТБҮ-г БХБЯ/ТХН-ийн болон БОАЖЯ-ны цахим хуудас, тэдгээрийн харъяа УБ дахь болон аймгийн төвүүд дээрх байранд байршуулна

412. Дээрхийн адилаар оролцогч талуудын хэлэлцүүлгийн тэмдэглэлийг онцлон оруулсан АСХХОХ-ийн бүхий л тайлангууд, орчны хяналт шинжилгээний тайлан, БХБЯ/ТХН-ээс гаргасан БОМТ-ний хэрэгжилтийн талаарх тайлангуудыг дээр дурдсан цахим хуудсууд болон байгууллагууд дээр мөн байршуулна. БОТБҮ-г мөн АХБ-ны цахим хуудсанд байршуулна. Дэд бүтэц, агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төсөл хэрэгжих явцад болон хэрэгжиж дууссаны дараа БХБЯ/ТХН-ээс ирүүлсэн байгаль орчны болон БОМТ-ний талаарх бүх тайлангуудыг АХБ-ны цахим хуудсанд байршуулна.

413. АСХХОХ дэх олон нийтийн оролцоо болон сонирхлыг тодорхойлох, сонирхлын түвшин болон төрлийн талаар ойлголт авах үүднээс олон нийтийн зүгээс хүссэн мэдээллийн төрөл болон давтамжид мониторинг хийнэ. Үүнд ТХН-ийн боловсруулах байгаль орчны хяналт шинжилгээний тайлан хамаарна. Цахим хуудасны ашиглалтыг буюу цахим хуудсанд хандсан хандалтын тоо болон баримт мэдээлэл хүссэн хүсэлтийн тоонд мөн мониторинг хийнэ.

W. Гомдол барагдуулах механизм (ГБМ)

414. Төслийн нийгэм болон байгаль орчны гүйцэтгэлийн талаархи санал, гомдлыг хүлээн авч үнэлэх, тэдгээрийг шийдвэрлэх ажлыг хөнгөвчлөх зорилгоор төслийн онцлог бүхий Гомдол барагдуулах механизмыг бий болгоно. ГБМ (Зураг 51) нь төсөлтэй холбоотой нийгмийн болон хүрээлэн буй орчны асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн хурдан шуурхай, ил тод байдлыг бий болгох зорилготой. Төслийн бүх агентлагууд ГБМ-ын тухай мэдээлэлтэй байж, ирсэн аливаа санал гомдлын талаар ТХН-д мэдээлнэ.

415. Аймгийн төвүүдэд байх ТХН-үүдэд төсөлтэй холбоотой нийгэм, байгаль орчны талаарх санал, гомдлыг хүлээн авах, барагдуулахад түлхэц үзүүлэх ГБМ-ыг байгуулж хариуцан ажиллуулна. Аймгийн төвүүдэд байх ТХН-ээс Өмнөговь болон Дэлүүн сумдын төвд сумдын хэмжээнд яг ижил ГБМ-ийг хэрэгжүүлэх үүрэгтэй ГБМ-ийн ажилтнуудыг томилж ажиллуулна. ГБМ нь жендерийн баримжаатай, соёл уламжлалын хувьд зохистой, бүх оролцогч талуудад хүртээмжтэй бөгөөд аливаа дарамт залхаалтаас ангид, үнэ төлбөргүй ойлгомжтой, ил тод үйл явцыг ашиглан нөлөөлөлд өртсөн этгээдүүдийн асуудлыг шуурхай шийдвэрлэнэ. ГБМ нь үндэсний хууль эрх зүйн тогтолцоонд хандах эрхэд садаа болохгүй.


416. Олон нийттэй зөвлөлдөх уулзалтын үеэр нөлөөлөлд өртөж буй иргэд оршин суугчдад ГБМ-ыг танилцуулах ба мөн энэ талаар гурван аймаг, хоёр сумын төвын оролцогч мэдээлнэ. Ямарваа нэг асуудал гомдол гарсан тохиолдолд аймаг, сумын төв бүрт дараах байдлаар 3 хүртэлх үе шаттай арга хэмжээ авна:

- Эхний шат (7 хоногоос хэтрэхгүй): Барилгын ажлын явцад санал гомдол гарсан бол гомдол гаргагч нь асуудлыг гэрээт гүйцэтгэгч, ХХН-ийн ГБМ-ын ажилтнууд, Төсөл хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөхүүд (ТХХТЗ) эсвэл олон нийтийн төлөөлөгчид хандан тавьж болно. ГБМ-ын талаар төсөлд хамрагдах бүх байгууллагууд мэдэж байх ёстой бөгөөд, аливаа санал гомдлыг ХХН-ийн ГБМ-ын ажилтнуудад нэн даруй

мэдээлэх хэрэгтэй. Хэрэв уг асуудал нөлөөлөлд өртсөн иргэн болон гүйцэтгэгчийн хооронд шууд шийдвэрлэгдсэн бол гомдлын дагуу нэмэлт арга хэмжээ авах шаардлагагүй. Гэхдээ энэ тухай аймаг/сумын төв дэх ХХН дээр байх ГБМ-ын бүртгэлд бичиж тэмдэглэнэ.

- 2-р шат (15 хоногоос хэтрэхгүй): Хэрэв асуудал аймгийн төслийн нэгж дээр шийдэгдээгүй бол Улаанбаатар дахь ХУН-ийн иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний албанд шийлжүүлэх ба БХБЯ-ны ГЗБГЗЗГ, ХХААХҮЯ, МУХБ-ны ХУК зүгээс оролцох болно. ХУН-ийн нэг цэгийн үйлчилгээний албаас хариуг хоёр долоо хоногийн дотор өгч, болсон бүх үйл явцын талаар тэмдэглэл хөтлөнө.
- 3-р шат (15 хоногоос хэтрэхгүй): Асуудал шийдэгдээгүй хэвээр байгаа бол ХУН нь шийдэлд хүрэх зорилгоор гомдол гаргагчийн зөвшөөрөлтэйгээр БХБЯ болон холбогдох олон нийтийн төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулна. Хэрэв асуудлыг огт шийдвэрлэж чадахгүй бол холбогдох дээд шатны байгууллагад шилжүүлнэ. БХБЯ нь ХУН-ийн дэмжлэгтэйгээр асуудлын явцыг 1-3 дахь шатны аль нэгд байхад нь АХБ-д мэдээлж болох боловч 3-р шатанд хүрсэн тохиолдолд нэн даруй мэдээлэх ёстой.

Figure 50. Гомдол барагдуулах механизм



БХБЯ-Барилга, хот байгуулалтын яам, ГМГЗЗГ- Газрын менежмент, геодези, зураг зүй

417. *Олон нийт* – олон нийтэд чиглэсэн мэдээлэл түгээх, сурталчлах өргөн хүрээтэй арга хэмжээ авах замаар гомдол барагдуулах механизмын талаар олон нийтийн дунд ойлголт өгнө. Ядуу, эмзэг өрхүүд гомдол барагдуулах журам, эрх үүргийнхээ талаар ойлголт авч танилцах, улмаар ХХН-д энэ чиглэлээр хандах, тэдний гомдлыг барагдуулахад хяналтын зөвлөхүүд (CS1) дэмжлэг үзүүлэх боломжоор хангах үүднээс төсөл хэрэгжүүлэх нэгжийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтан болон олон нийтийн хөгжлийн зөвлөх (CS -3) нь олон нийтийг хамарсан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулна.

418. *Гомдол гаргагч* нь гомдол/санал барагдуулах саналын маягтыг БХБЯ-ны Иргэдэд үйлчлэх нэг цэгийн албанд өгөх, дуудлага хүлээж авах төвүүдэд утсаар мэдээлэх, цахим болон энгийн шуудангаар илгээх, иргэдэд үйлчлэх төвийн өргөдөл гомдлын системд бүртгүүлэх зэргээр гомдол/саналаа уламжлах олон төрлийн уян хатан боломжоор хангагдана.

419. Барилгын ажлын үе шатанд хүмүүс санал, асуудлуудаа бичгээр хүргүүлэхдээ ашиглах цаг уурын нөлөөнөөс хамгаалагдсан санал гомдлын хайрцгуудыг барилгын талбай, нийгмийн үйлчилгээний одоогийн барилга байгууламжууд, багийн байранд байрлуулна.

420. Гомдол/өргөдөл гаргагчийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл, өргөдлийг хүлээж авсан огноо, асуудал үүссэн газрын байршил, асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар нягт нямбай тэмдэглэж баримтжуулна. Байгаль орчин, нийгмийн хамгааллын талаарх өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь барагдуулах асуудлыг ХХН-ийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтан бүхэлд нь хариуцна.

1. Бүртгэл хөтлөх.

421. Өргөдөл гомдлыг хүлээж авсан өдөр, гомдлын агуулга, залруулахаар зөшилцсэн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлсэн огноо, гарсан эцсийн үр дүнгийн талаарх бүх

бүртгэлийг сумын төв дэх ХХН ба ГБМ-ын ажилтан хөтөлж, хадгална. Бүртгэгдсэн болон шийдвэрлэгдсэн өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн үр дүнг ХХН-ийн байр, БХБЯ-нд дэлгэж мэдээлэх ба тэдний цахим хуудсанд нийтлэн мэдээлэхийн зэрэгцээ АХБ-нд хагас жил тутам хүргүүлэх хяналт шинжилгээний тайланд тусгана

2. Авсан сургамжийг тогтмол нягталж баримтжуулах.

422. Амйгийн төслийн нэгж дэх ХХН-ийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтан нь ХУН-ийн (БХБЯ-ны ГЗБГЗЗГ) болон МУХБ-ны ХУК-иас ирүүлэх мэдээллийг ашиглаж төслийн талбай бүрд ГБМ хэрхэн хэрэгжиж байгааг тогтмол нягталж, уг механизмийн үр дүн, ялангуяа гомдол гарахаас сэргийлэх, тэдгээрийг шийдвэрлэхтэй холбоотой төслийн чадавхийн талаархи мэдээллийг бүртгэлжүүлж хөтөлнө.

БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХИ, СУРГАЛТЫН ШААРДЛАГА

423. Одоогийн байдлаар аймгийн БОМТ-г хэрэгжүүлэх үүрэг бүхий хамтран ажилладаг түншүүдийн байгаль орчны үнэлгээ, менежментийн чиглэлээрх туршлага, чадавхи дутмаг байна. Ялангуяа ХУН (ГЗБГЗЗГ), МУХБ-ны ХУК, аймгийн төслийн нэгжийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, сургалтад хамруулах шаардлагатай байна. 1-р ээлжийн төслийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөх (ТХХТЗ) нь шаардлагатай тохиолдолд ХУН, МУХБ-ны ХУК, аймгийн төслийн нэгжийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан төлөвлөгөө гаргаж сургалт явуулна. Сургалтын зорилго нь барилгын гүйцэтгэгчдийн зүгээс БОМТ-г хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавихын тулд төслийн захиалагч болон хэрэгжүүлэгч агентлагуудын чадавхийг бэхжүүлэхэд оршино.

3. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хөтөлбөр

424. 1-р ээлжээр хйгдэх ажлын нэг хэсэг нь өргөтгөж шинэчлэх буюу шинээр ашиглалтад орох БУЦБ, дулааны станц, ус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын операторуудын чадавхийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах нь асуудал юм. Мөн түүнчилэн агро паркийн шинэ байгууламжууд, мал төхөөрөх үйлдвэрийг хамарсан чадавхийг дээшлүүлэх, сургалт хийх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Шинэ байгууламжуудад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ажилчдын аюулгүй ажиллагааны сургалт, хөтөлбөр нэвтрүүлэх нь онцгой ач холбогдолтой. Тоног төхөөрөмжийн ашиглалтыг хариуцах операторуудад зориулсан сургалт явуулах болон үйлдвэрийн аюулгүй ажиллагааны шаардлага нь АСХХОХ-ийн байгаль орчны зээлийн баталгааны нэг хэсэг болно. Аюулгүй ажиллагааны төлөвлөгөөг аймгийн БОМТ-нд оруулсан онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулах болно.

425. БОМТ-г хэрэгжүүлэх талаар сургалт явуулахдаа хоёр сэдэвчилсэн чиглэлийг авч үзэх шаардлагатай. Эхний чиглэл нь дэд төслүүдийн байгаль орчин ба нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөлөлд голлож чиглэсэн байгаль орчны менежментийн зарчмуудын тухай, хоёр дахь нь БОМТ-нд тусгайлан зааж оруулах АХБ болон МУ-ын ЗГын байгаль орчны хамгааллын шаардлагуудын талаар байх нь зүйтэй.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

426. Дэд бүтцийн олон төрлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүтээн байгуулалтын үе шатанд барилгын ажлаас үүсэх нөлөө саадыг багасгахын тулд барилгын ажилд стандарт практик арга хэмжээ болон нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа ахуйн хэрэглээний усыг ус түгээх цэгээс гар аргаар зөөвөрлөх практикийг барилгын ажлын үед сайтар анхаарч хамгаалах ёстой бөгөөд ингэснээр аливаа өрхийн усан хангамж ямар ч үед тасрахгүй байх ёстой.

427. АСХХОХ-ийн дэд бүтэц, агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүд нь тусгай хамгаалалттай газар нутаг, ан амьтдын амьдрах орчин, ховор эсвэл ховордсон ан амьтанд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Энэ гурван экологийн мэдрэмтгий шинж чанарыг агуулсан Ховд аймгийн Манхан, Мянгад сум дахь төслийн байршлуудыг эхний сонголт шигшилтээр хассан болно. Мөн Увс аймгийн Тариалан сумын Хархираа-Тээлийн гол дээр төлөвлөсөн хоёр төрлийн услалтын системийн техник эдийн засгийн үндэслэлийн судалгаагаар эдгээр байгууламж нь Увс нуурын хамгаалалттай газар нутагт нөлөөлөхгүй гэж тодорхойлсон.

428. Төсөлд хамрагдаж буй орон нутгийн бүх хэрэглэгчдэд усны нөөц хангалттай байх шаардлагын үүднээс төслийн усны хэрэгцээ болон усны эх үүсвэрийн хүртээмжийг ялангуяа усалгаатай хадлан тэжээлийн тариалан, агро паркийн байгууламжуудад онцгойлон анхаарал хандуулах замаар нарийвчлан тодруулах шаардлагатай.

429. АСХХОХ-т зориулж боловсруулсан аймгийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийг бууруулах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөг багтаасан бөгөөд АСХХОХ-ийн байгаль орчны менежментэд шаардагдах байгууллагын үүрэг хариуцлага, чадавхын шаардлагыг зааж өгсөн болно. Төслийн эцсийн бүрэлдэхүүн хэсгээс үүсч болзошгүй нөлөөллийг бүрэн шийдвэрлэж чадахуйц байлгахын тулд нарийвчилсан зураг төслийн үе шатанд БОМТ-г хянаж шинэчилж байх шаардлагатай.

430. АСХХОХ-ийн 1-р ээлжийн ТЭЗҮ-ийг төсөлд хамрагдаж буй нутаг орны талаархи олдоц бүхий мэдээлэлтэй хамтруулан авч үзэх нь АСХХОХ -ийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн цар хүрээг тодорхойлоход хангалттай байх болно гэж БОТБҮ-гээр дүгнэж байна. АСХХОХ-ийн нэг буюу хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгийн төлөвлөлтөд мэдэгдэхүйц ноцтой өөрчлөлт гарахгүй, нарийвчилсан зураг төслийн явцад гарч ирэх усны нөөцийн талаархи мэдээлэлд усны хомсдолын асуудал байна гэж тодорхойлогдохгүй мөн хүрээлэн буй орчны болон нийгмийн талаарх шинэ эмзэг асуудал гарч ирэхгүй тохиолдолд АСХХОХ нь байгаль орчны зүгээс В ангилалд хэвээр үлдэх бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ) хийгдэх шаардлагагүй болно.

ХАВСРАЛТ А: АСХХОХ-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ

**ХОТ БАЙГУУЛАЛТ
ХУУДАС 1/5**

Байгаль орчны түргэвчилсэн үнэлгээний (БОТҮ) шалгах хуудас

Заавар:

- (i) Тус төслийн баг нь төслийн байгаль орчны ангиллыг дэмжихийн тулд энэхүү шалгах хуудсыг бөглөнө. Байгаль орчны ангиллын маягтад тус шалгах хуудсыг хавсарган Байгаль орчин, хамгааллын хэлтэс (БОХХ) рүү илгээн, БОХХ-ийн дарга болон нийцлийн ахлах ажилтнаар батлуулна.
- (ii) Энэхүү шалгах хуудас нь байгаль орчны тулгамдаж буй асуудалд төвлөрнө. Нийгмийн хэмжигдэхүүнийг зохих хэмжээгээр харгалзан үзсэн байхын тулд мөн АХБ-ын (а) сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт ба уугуул иргэдийн шалгах хуудас, (б) ядуурлыг бууруулах гарын авлага, (в) зөвлөлдөх ба оролцоог хангах ажилтнуудад өгөх удирдамж болон (г) жендэрийн шалгах хуудас зэргийг харгалзан үзнэ.
- (iii) **“Нөлөөллийг бууруулах ажил хийгдээгүй” тохиолдол гэж үзэн асуултанд хариулна уу. Ингэснээр боломжит нөлөөллийг тодорхойлох зорилготой. Аливаа урьдчилан төсөөлсөн нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэлэлцэхдээ “тайлбар” хэсгийг ашиглана уу.**

Улс/төслийн нэр:
Салбар:

MON (49430): Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
(I шатлал)
Хот байгуулалт

Шалгах асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
А. Төслийн хамрах газар			
Төсөл хэрэгжүүлэх газар			
▪ Хүн ам нягт суурьшсан?		✓	
▪ Бүтээн байгуулалтын үйл ажиллагаа ихтэй?		✓	
▪ Байгаль орчны эмзэг нутаг дэвсгэртэй хөрш залгаа эсвэл дотор нь байрладаг?			
• Соёлын өвийн дурсгалт газар	✓		Баруун кластерт Казак үндэстний цөөнхийн соёлын газар байж болзошгүй.
• Тусгай хамгаалалттай газар нутаг	✓		Ховд хотын зүүн хил нь дархан цаазат “Хар ус нуур”-ын орчмын буфер бүсийн баруун хилийн нутаг дэвсгэрээс 20 км-ын зайд оршдог. Улаангом хотын зүүн хойд хил нь байгалийн цогцолбор газар болох “Увс нуур”-ын баруун хилээс 25 км-ын зайд байрладаг.
• Намагт газар	✓		Баруун кластерт харъяалагдах Ховд хотын залгаа намагт газартай. Бусад газрын ойр орчимд намагт газар байхгүй.
• Ой мод		✓	
• Голын ай сав		✓	
• Тусгай хамгаалалттай газрын буфер бүс	✓		Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай дээрхийг үзнэ үү.

Шалгах асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
• Биологийн олон янз байдлыг хамгаалах тусгай газар нутаг		✓	Хот суурингийн кластертэй залгаа биологийн олон янз байдалт чухал газар байхгүй болно.
• Далай, тэнгисийн булан		✓	
Б. Байгаль орчинд үзүүлэх боломжит нөлөөлөл Тус төсөл нь дараах нөлөөллийг үүсгэх үү? Үүнд:			
• Холбогдох ариун цэврийн байгууламж ба хог хаягдлыг зайлуулах системийн тогтвортой байдал, хотын бусад үйлчилгээнд харилцан хамаарах байдалд үүсэх нөлөөлөл		✓	Төсөлд хамрагдсан газрууд зохистой ариун цэврийн байгууламж ба хог хаягдал зайлуулах байгууламжгүй байна. Тус төслийн оролцоотойгоор тохирох ариун цэврийн байгууламж болон хог хаягдлыг зайлуулах системийг байгуулна.
• Хотын хүн амын хурдацтай өсөлт, арилжааны болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эргэн тойрны байгаль орчинд доройтол, хог хаягдлын хэмжээ нэмэгдэж хүний гараар бүтсэн болон байгалийн системүүд хэт ачааллалтай болсон, эдгээр системийн менежмент хийх хүчин чадал хэтэрсэн эсэх		✓	Төслийн оролцооны үр дүнд хот суурингийн кластерт хүрэн буй орчны нөхцөл байдал сайжирна.
• Газар, эко систем (т: намагт газар, онгон дагшин газар нутаг, эргийн бүс, цэвэр усны сан ба ой)-ийн доройтол үүссэн эсэх		✓	Тус төслийн дэд бүтэц нь газрын доройтол цааш нэмэгдэхийг зогсоох ба хүрээлэн байгаа орчны экосистемийг тогтворжуулна.
• Иргэдийг өөр байршил руу шилжүүлэх эсвэл сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт хийх эсэх	✓		Дэд бүтэц байгуулах тул иргэдийг өөр байршил руу шилжүүлэх эсвэл сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт бага хэмжээнд байна. Дэд бүтцийн үр шим сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг үр нөлөөллөөс хамаагүй их байна.
• Ядуу иргэд, эмэгтэйчүүд ба хүүхэд, уугуул иргэд эсвэл бусад эмзэг бүлэгт ялгавартай нөлөөлөл үүсэх эсэх		✓	Тус төсөл нь нийгмийн эмзэг, өртөмтгий бүлгийн амьдрах нөхцөлд эерэгээр нөлөөлнө.
• Соёлын биет хөрөнгийн доройтол, соёлын өв ба аялал жуулчлалын орлогын алдагдал үүсэх эсэх		✓	Соёлын биет хөрөнгөд хор хөнөөл учруулахгүй ба төслийн сайжруулсан дэд бүтцийн үр дүнд аялал жуулчлалын орлого нэмэгдэнэ.
• Нам дор газар, үерийн усанд автах газар болон эгц уул зэрэг газарт зөвшөөрөлгүй оршин суух хүмүүс, орлого багатай иргэд, бохирдолтой үйлдвэрлэлийн улмаас эрүүл мэндийн аюул, эрсдэлд өртөж болзошгүй эсэх		✓	Газрын зөвшөөрөлгүй болон орлого багатай иргэдэд сөрөг нөлөөлөл үүсэхгүй.
• Усны нөөцийн асуудал (т: усан хангамжийн хомсдол, бууралт, гадаргуугийн ба газрын доорх усны чанар муудах, хүлээн авах усны бохирдол) үүсэх эсэх		✓	Тус төсөл усан хангамж, усны чанарт эерэг нөлөөлөл үүсгэх ба ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
• Хотын утааны ялгарлаас болж агаарын бохирдол үүсэх эсэх	✓		Барилгын ажлын явцад богино хугацаанд агаарын бохирдлоос зайлсхийх боломжгүй. Төслийн ажлын талбайн ойролцоо амьдрах хүн амд үүсэх агаарын бохирдлын сөрөг

			нөлөөлийг бууруулах хяналт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
Төслийн барилгын ажил, угсралтын явцад хими, биологийн бодит аюулын улмаас ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдалтай холбоотой эрсдэл үүсэх эсэх		✓	Төслийн барилгын ажил, угсралтын явцад ажлын байрны ноцтой эрсдэл гарна гэж тооцоогүй. Эрүүл ахуй, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх ба төслийн нийт хугацаанд үр дүнтэй хяналтыг системийг хэрэгжүүлнэ.

**ХОТ БАЙГУУЛАЛТ
ХУУДАС 3/5**

Шалгах асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
Борооны улирлын үед газар малтлагын улмаас зам хаагдах, түр зуурын үерт автах эсэх		✓	Хагас хуурай бүсэд ийм тохиолдол бага. Гол, горхины ойролцоо төслийн байршил байх тохиолдолд ийм нөхцөл үүсэхээс зайлсхийх зохих арга хэмжээг авна.
Барилгын үйл ажиллагааны дуу чимээ, тоосжилт үүсэх эсэх	✓		Барилгын ажлын явцад түр хугацаанд дуу чимээ, тоосжилт гарна. Эдгээр сөрөг нөлөөг багасгах зорилгоор төслийн БОМТ ба гүйцэтгэгчийн БОМТ-г боловсруулах бөгөөд орон нутаг, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
Барилгын материал, хог хаягдал тээвэрлэх үед замын хөдөлгөөний түгжрэл үүсэх эсэх		✓	Төсөлд хамрагдах кластер замын хөдөлгөөн багатай тул түгжрэл үүсэхгүй.
Барилгын ажлын улмаас түр зуурын шавар лаг үүсэх эсэх		✓	Төслийн талбай хагас хуурай бүсэд орших учир ийм нөлөөлөл үүсэхгүй.
Орчны, ахуйн болон ажлын байрны бохирдол, дулааны урвуу байдал болон утааны улмаас олон нийтийн эрүүл мэндэд аюул үүсэх эсэх		✓	Төслийн үйл ажиллагаанаас ийм төрлийн аюул үүсэхгүй.
Усны хомсдол, доройтол үүсэх эсэх		✓	Төслийн үйл ажиллагааны улмаас усны хомсдол, доройтол үүсэх магадлал бага.
Гүний усыг хэт хэрэглэснээр газрын хөрсний суулт үүсгэн, гүний усны түвшин багасах, давсжилт үүсэх эсэх		✓	Сөрөг нөлөөлөлгүй.
Хог хаягдлыг зохисгүй хаясны улмаас хөрс, гүний усны бохирдол үүсэх эсэх		✓	Сөрөг нөлөөлөлгүй. Гэвч төслийн үйл ажиллагааны үр дүнд хог хаягдлыг зайлуулах системийг сайжруулахад эерэг үр дүн гарна.
Усны бохирдлын улмаас орчны тав тух алдагдах, загасны нөөц ба далайн нөөцийн хомсдол болон эрүүл мэндийн асуудал үүсэх эсэх		✓	Сөрөг нөлөөлөлгүй.
Төслийн барилга, үйл ажиллагааны явцад хүн амын томоохон шилжилт хөдөлгөөний улмаас нийгмийн дэд бүтэц, үйлчилгээ (т: усан хангамж, цэвэрлэх байгууламжийн систем)-ний ачаалал нэмэгдэх эсэх		✓	Төслийн кластер дэх хүн амын нягтрал бага учир сөрөг нөлөөлөлгүй. Гэвч төсөл үндсэн дэд бүтцийг сайжруулах тул орон нутгийн иргэд төслийн үр шимийг хүртэнэ.
Хэрэв өөр бүс эсвэл орноос ажилчид ажиллуулбал нийгмийн зөрчил үүсэх эсэх		✓	
Төслийн үйл ажиллагаа, барилгын ажлын явцад тэсэрч дэлбэрэх материал, шатахуун болон химийн бусад бодисыг тээвэрлэх, хадгалах, ашиглах эсвэл устгах үед орон		✓	Төсөлд тэсэрч дэлбэрэх материал ашиглагдахгүй. Төслийн явцад шатахуун болон барилгын химийн бодисыг дотоодын ба олон улсын зааварчилгаа, барилгын БОМТ-ний дагуу зохицуулна.

нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл үүсэх эсэх			
Осол ба байгалийн аюулын улмаас иргэдийн аюулгүй байдалд эрсдэл үүсэх эсэх, төслийн бүтцийн элемент эсвэл бүрэлдэхүүн хэсгүүдийг төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдэд нээлттэй байлгах эсэх, тэдгээрийг үл мөрдсөний улмаас төслийн барилгын ажил, ашиглалт, ашиглалтыг зогсоох үед иргэдэд гэмтэл үүсгэх эсэх		✓	Ийм эрсдэлээс сэргийлэхийн тулд аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө болон асал, аюулын менежментийн төлөвлөгөө бэлтгэх ба төсөл хэрэгжүүлэгчид зохих ёсоор хэрэгжүүлнэ.

ХОТ БАЙГУУЛАЛТ
ХУУДАС 4/5

Уур амьсгалын эрсдэлийн урьдчилсан үзлэгийн шалгах хуудас

Улс/төслийн нэр : MON (49430): Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (I шатлал)

Салбар : Хот байгуулалт

Дэд салбар : Хот, эдийн засаг, нийгмийн дэд бүтэц, байгууламж

Газар/хэлтэс: БОХХ/ЗАГ

Шалгах асуултууд		Оноо	Тайлбар ¹
Төслийн байршил, зураг төсөл	Төслийн байршилд үер, ган, шуурга, хөрсний нуралт зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдэл бүхий уур амьсгалын нөхцөл нөлөөлөх магадлалтай эсэх	0	Цаг агаарын эрс тэс нөхцөл нь төслийн дэд бүтцэд нөлөөлөх магадлал бага.
	Төслийн зураг төсөл (гүүр барих газрыг суллах г.м)-д гидро-цаг уурын ямар нэгэн үзүүлэлт (т: далайн түвшин, голын усны оргил түвшин, усны найдвартай түвшин, салхины оргил хурд)-ийг харгалзан үзэх хэрэгтэй эсэх	1	Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас төслийн бүрэлдэхүүнд боломжит нөлөөлөл бий болгохоос сэргийлж, гидрологийн үзүүлэлтийг дахин шалгах шаардлага гарч болзошгүй.
Материал, засвар үйлчилгээ	Цаг уурын одоогийн ба цаашдын нөхцөл (т: зуны халуун, өвлийн хүйтэн өдрүүдийн хоорондох чийгшилийн түвшин, температурын зөрүү давамгайлах, салхи, чийгшлийн усны цаг уурын үзүүлэлтэд илрэх байдал) төслийн үр дүнгийн хугацаанд төслөөс оруулах орц (т: барилгын материал)-ын сонголтонд нөлөөлөх магадлалтай эсэх	1	Төслийн үр дүнд нөлөөлж болох эрсдэлийг бууруулахын тулд барилгын материалын чанар, төслийн дэд бүтцийн засвар, үйлчилгээний давтамж зэрэг асуудлыг дахин нягтлах шаардлага гарч болзошгүй.
	Цаг агаарын одоогийн болон цаашдын нөхцөл, холбогдох эрс тэс үзэгдэл төслийн үр дүнгийн засвар үйлчилгээний ажил (хуваарь, зардал)-д нөлөөлөх магадлалтай эсэх	1	
Төслийн үр дүнгийн гүйцэтгэл	Цаг агаар, уур амьсгалын нөхцөл, холбогдох эрс тэс үзэгдэл төлөвлөсөн ажлын хугацааны туршид төслийн үр дүн (т:усан цахилгаан станц)-ийн гүйцэтгэл (т: цахилгааны жилийн үйлдвэрлэл)-д нөлөөлөх магадлалтай эсэх	1	Зарим судалгаа, материалаас үзвэл Монгол оронд уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж байгаа тул төслийн үр дүнд нөлөөлж болзошгүй.

Асуулт ба хариултын оноог доор харуулав:

Хариулт	Оноо
Магадлалгүй	0
Магадлалтай	1

Их магадлалтай	2
----------------	---

Хариултын оноог нэмэхэд 0 гарч байвал бага эрсдэлтэй төсөл гэж үзнэ. Хэрэв бүх хариултыг нэмэхэд хариу нь 1-4 гарч, нэг ч асуулт 2 онооны хариулт аваагүй тохиолдолд төслийг дунд зэргийн эрсдэлтэй ангилалд оруулна. Нийт онооны нийлбэр 5 ба түүнээс дээш (бүх хариултанд 1 оноо өгсөн) гарсан эсвэл нэг асуултанд 2 онооны хариулт өгсөн тохиолдолд өндөр эрсдэлтэй төсөл гэж ангилна.

¹ Хэрэв боломжтой бол төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн уур амьсгалын нөхцөлд эмзэг мэдрэмтгий байдлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгөх хэрэгтэй. Үүнд тухайлбал: дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдийн зураг төслийн стандартад уур амьсгалын үзүүлэлтүүдийг хэрхэн тусгасан, уур амьсгалын гол үзүүлэлтүүд, далайн түвшний өөрчлөлт төслийн байршил, зам, барилгын материалын сонголт ба төлөвлөлт, гүйцэтгэл болон төслийн үр дүнгийн засвар, үйлчилгээний зардал, төлөвлөлтөнд хэрхэн нөлөөлөх тухай нарийвчилсан мэдээлэл орно.

ХОТ БАЙГУУЛАЛТ
ХУУДАС 5/5

Анхны үнэлгээний дүн (Бага, Дунд, Их): Дунд

Бусад санал: Монгол орны эрс тэс цаг агаар, уур амьсгалын өөрчлөлтийн үйл явц эрчимтэй явагдаж, улам бүр анхаарад татаж байгаатай холбогдох эрсдэлээс үндсэндээ шалтгаалж, тус төслийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөх дунд зэргийн эрсдэлтэй гэж үзэж байна.

Бэлтгэсэн: Шотаро Сасаки, Байгаль орчны ахлах мэргэжилтэн, БОХХ

ХАВСРАЛТ В: АСТБХХОХ –Т ХАМААРАЛТАЙ ҮНДЭСНИЙ ЧАНАРЫН СТАНДАРТУУД

Дугаар	Стандартын мэдээлэл
MNS 6298:2011	Шинэ дулааны цахилгаан станц, дулааны станцын яндангаар агаар мандалд хаях утааны найрлага дах агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга.
MNS 5919:2008	Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга
MNS 17.5.1.18:1983	Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллгаагаар эвдэрсэн газрын ангилал
MNS 17.5.1.19:1992	Байгаль орчны хамгалаал. эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага.
MNS 3473:1983	Байгаль хамгаалал. газар, газар ашиглалт, нэр томъёо, тодорхойлолт
MNS 17.5.13:1980	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
MNS 17.0.0.06:1979	Байгаль орчныг хамгаалах стандартын систем. Үндсэн дүрэм
MNS 5914:2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
MNS 5918:2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
MNS 17.2.0.07:1979	Агаар бохирдуулагчид ба түүний ангилал
MNS 17.2.1.17:1980	Агаар бохирдуулагч бодисын нэр томъёо, тодорхойлолт
MNS 4585:2016	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага
MNS 3383:1982	Байгаль хамгаалал Агаар мандал Бохирдлын эх үүсвэр, нэр томъёо тодорхойлолт.
MNS 5885:2008	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
MNS 3113:1981	Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Агаарыг бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавих ерөнхий шаардлага.
MNS 17.2.3.16:1988	Хот суурин газрын агаарын чанарт хяналт тавих шаардлага
MNS 6063:2010	Агаарын чанар - Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ
MNS ISO 14064-2:2015	Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж
MNS 3384:1982	Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага
MNS 17.1.1.10:1979	Ус ба ус ашиглах нэр томъёо, тодорхойлолт
MNS 4047:1988	Байгаль орчныг хамгаалах Усан мандал Гадаргын усны чанарыг хянах журам

Дугаар	Стандартын мэдээлэл
MNS 3342:1982	Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага
MNS 6148:2010	Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
MNS ISO 5667 13 2000	Усны чанар - Дээж авах 13-р бүлэг : Бохир ус болон цэвэрлэх байгууламжийн лагаас дээж авах заавар.
MNS 0899:1992	Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба эрүүл ахуйн шаардлага.
MNS 0900:2005	Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
MNS ISO 5667:1:2002	Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар.
MNS ISO 5667-3:1999	Усны чанар – Дээжлэх – Хэсэг 3: Дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж.
MNS ISO 5667:6:2001	Усны чанар. Дээжлэлт. 6-р хэсэг: Гол, горхины уснаас дээж авах заавар.
MNS 4943:2015	Усны чанар: Хаягдал усны ерөнхий шаардлага
MNS BS 8525-1:2015	Саарал усны систем. Ерөнхий шаардлага.
MNS ISO 5667-10:2001	Усны чанар. Дээжлэлт. 10-р хэсэг: Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж.
MNS ISO 5667-7:2002	Усны чанар. Дээж авах. 7-р хэсэг. Уурын зуухны ус болон уураас дээж авах заавар
MNS 6561:2015	Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус.
MNS 5666:2006	Усны биологийн шинж чанарын шинжилгээ. Бохир усны цэвэрлэх байгууламжийн идэвхт лагийг тодорхойлох шинжилгээний арга.
MNS 4288:1995	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага.
MNS 3297:1991	Хөрс. “Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ”
MNS 5850:2008	Хөрсний чанар: Хөрсний бохирдуулагч бодисын зөвшөөрөгдсөн түвшин
MNS 3298:1991	Хөрсний чанар: Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
MNS 3985:1987	Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүдийн нэр төрөл.
MNS 2305:1994	Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
MNS 4968:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага.
MNS 4994:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
MNS 5147:2002	

Дугаар	Стандартын мэдээлэл
	Хөдөлмөрийн аюулгүй байдал Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгаан статик орон. Ажлын байрны хүчлэгийн зөвшөөрөх түвшин.
MNS 5150:2002	Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа.
MNS 5146:2002	Хөдөлмөрийн аюулгүй байдал Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй байдал Хамгаалах газардуулга, тэлэлт.
MNS 5145:2002	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа.
MNS 5002:2000	Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
MNS 0012.4.005:1985	Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд
MNS 4244:1994	Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага.
MNS 5390:2004	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Цахилгааны галын аюулгүй байдал.
MNS 6458:2014	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах ерөнхий шаардлага
MNS 3474:2003	Ургамал хамгаалал. Нэр томъёо, тодорхойлолт.
MNS 5344:2011	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага.
MNS 5872:2008	Цахилгаанаар хангагчаас Хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага
MNS 5043:2011	0.10 МВт - 3.15МВт хүртэл чадалтай халаалтын зуух. Техникийн ерөнхий шаардлага
MNS 5041:2001	100 кВт хүртэл чадалтай ус халаах зуух: Техникийн ерөнхий шаардлага.
MNS 5045:2001	Хатуу түлшээр ажиллах ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага.
MNS 5643:2006	25-2500 кВ·А чадалтай, 10 кВ хүртэл хүчдэлтэй иж бүрэн трансформаторын дэд өртөө.
MNS 4084:1988	Нарны энергиэр ус халаах төхөөрөмж /СНАРВ-П СС/ Ерөнхий техникийн шаардлага.
MNS 5207:2011	Шилэн кабелийн суурилуулалт, техникийн шаардлага

Дугаар	Стандартын мэдээлэл
MNS AASHTO 86:2005	Бетонон суваг, үерийн ус зайлуулах хоолой Техникийн шаардлага.
MNS ISO 24511:2012	Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ. Ариутгах татуургын барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал.
MNS ISO 24512:2012	Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ – Ус хангамжийн барилга, байгууламжийн ашиглалтын менежмент
MNS 5682:2006	Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага.
MNS 4597:2014	Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
MNS 4759:2014	Авто замын гэрлэн дохио. Техникийн ерөнхий шаардлага
MNS 4596:2014	Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
MNS 5342:2007	Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага.

Монгол улсын байгаль орчны чанарын тодорхой стандартууд

В-1: Гадаргын усны чанарын стандарт

Parameter	MNS 4586-98	
pH		6.5-8.5
DO	mgO/l	not less than 6&4 *
BOD	mgO/l	3
NH ₄ -N	mgN/l	0.5
NO ₂ -N	mgN/l	0.002
NO ₃ -N	mgN/l	9
PO ₄ -P	mgP/l	0.1
Cl	mg/l	300
F	mg/l	1.5
SO ₄	mg/l	100
Mn	mg/l	0.1
Ni	mg/l	0.01
Cu	mg/l	0.01
Mo	mg/l	0.25
Cd	mg/l	0.005
Co	mg/l	0.01
Pb	mg/l	0.01
As	mg/l	0.01
Cr	mg/l	0.05
Cr ⁶⁺	mg/l	0.01
Zn	mg/l	0.01
Hg	mg/l	0.1
Oil	mg/l	0.05
Phenol	mg/l	0.001
Active and washing substances	mg/l	0.1
Benzapyren	Mkg/l	0.005

* DO >6 mgO/l for summer time and DO >4 mgO/l for winter time

В-2 Дуу, шуугианы стандарт

Receptor	MNS 4585:2007		EHS Guidelines (Guidelines for Community Noise, World Health Organization (WHO), 1999)	
Residential, institutional, educational	07:00 - 23:00	60 dB(A)	07:00 - 22:00	55 dB(A)
	23:00 - 07:00	45 dB(A)	22:00 - 07:00	45 dB(A)

B-3: Гүний усны чанарын стандарт

Parameter	MNS 900:2005		WHO Guidelines for Drinking Water Quality, Fourth Edition. 2011	
Na ⁺	mg/l	200		None established
K ⁺	mg/l	200		None established
Ca ²⁺	mg/l	100		-
Mg ²⁺	mg/l	30		-
SO ₄ ²⁻	mg/l	500		None established
HCO ₃	mg/l	-		-
CO ₃ ²⁻	mg/l	-		-
Cl	mg/l	350	mg/l	5
P	mg/l	0.7-1.5		-
Br		-		None established
Test, by mark	mg/l	2		-
Color	degree	20°		None proposed
Odor	mark	2		-
pH		6.5-8.5		None established
Electric Conductivity Y S/st		-		-
General Minerals		1000		-
Hardness	mg-eqv/l	7		None established
Acidity potential	mB			-
Solid remains	g/l	1		-
NH ₄	mg/l	1.5		None established
NO ₃	mg/l	50	mg/l	50
NO ₂	mg/l	1	mg/l	3
PO ₄	mg/l	3.5		-
As	mg/l	0.01	mg/l	0.01
Fe	mg/l	0.3		None established
Pb	mg/l	0.03	mg/l	0.01
Ni	mg/l	0.02	mg/l	0.07
Cr	mg/l	0.05	mg/l	0.05
Cu	mg/l	0.1	mg/l	2
Zn	mg/l	5		None established
Mn	mg/l	0.1		None established
Cd	mg/l	0.003	mg/l	0.003
Hg	mg/l	0.0005	mg/l	0.006
B	mg/l	0.5	mg/l	2.4
Ba	mg/l	0.7	mg/l	0.7
Mo	mg/l	0.07		None established
Se	mg/l	0.01	mg/l	0.04
E.coli or thermotolerant coliform bacteria		-		Must not be detectable in any 100 ml sample.

MNS 900:2005, Drinking Water Hygienic Requirement and Quality Control is the standard used for groundwater supply, which is the source for drinking water supply in Mongolia.

В-4: Орчны агаарын чанарын стандарт

Parameter	MNS 4585:2007		EHS Guidelines. World Health Organization (WHO). Air Quality Guidelines Global Update, 2005)	
SO ₂	24-hour	20	24-hour	125 (Interim target-1) 50 (Interim target-2) 20 (guideline)
	10 minute	500	10 minute	500 (guideline)
NO ₂	1-year	30	1-year	40 (guideline)
	24-hour	40	24-hour	-
	20-min	85	1-hour	200 (guideline)
PM ₁₀	1-year	50	1-year	70 (Interim target-1) 50 (Interim target-2) 30 (Interim target-3) 20 (guideline)
	24-hour	100	24-hour	150 (Interim target-1) 100 (Interim target-2) 75 (Interim target-3) 50 (guideline)
PM _{2.5}	1-year	25	1-year	35 (Interim target-1) 25 (Interim target-2) 15 (Interim target-3) 10 (guideline)
	24-hour	50	24-hour	75 (Interim target-1) 50 (Interim target-2) 37.5 (Interim target-3) 25 (guideline)
CO	Average in 1 hour	30g/m3	No standard	

Interim targets are provided in recognition of the need for a staged approach to achieving the recommended guidelines.

В-5 Хөрсний чанарын стандарт

Parameter	MNS 5850 :2008			
	Soil Mechanical Composition			Maximum Acceptable Amount
	Clay	Loamy	Sandy	
Pb	100	70	50	100
Cd	3	1.5	1	3
Hg	2	1	0.5	2
As	6	4	2	6
Cr	150	100	60	150
Cr ⁶⁺	4	3	2	4
Sn	50	40	30	50
Sr	800	700	600	800
V	150	130	100	150
Cu	100	80	60	100
Ni	150	100	60	150
Co	50	40	30	50
Zn	300	150	100	300
Mo	5	3	2	5
Se	10	8	6	10
B	25	20	15	25
F	200	150	100	200
CN	25	15	10	25

Table A-6: Дулааны станцын яндангаар агаар мандалд хаях утааны найрлага дах агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Guideline	Parameter (in mg/Nm ³)			
	MNS 6298:2011		EHS Guidelines *	
SO ₂	mg/m ³	400 urban 600 remote areas	mg/Nm ³	2000
NO _x	mg/m ³	450-1,100 based on volatile coal	mg/Nm ³	650
PM	mg/m ³	50-200	mg/Nm ³	50-150
Dry Gas Excess O ₂ content	-	-	%	6

* Small Combustible facilities Emission Guidelines (3MWth-50MWth) - for Boilers using solid fuel

MWth - Megawatt thermal

Nm³ is at one atmospheric pressure, 0°C.

ХАВСРАЛТ С: ИРГЭД ОЛОН НИЙТТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ (БҮРЭН ЭХЭЭР)

1. Ховд аймгийн Жаргалант төвд 2019 оны 10-р сарын 2-ны өдөр иргэд, олон нийттэй хийсэн уулзалт хэлэлцүүлгийн тэмдэглэл:

Олон нийттэй хийсэн уулзалт, хэлэлцүүлгийн үед авсан фото зургууд



- Ер нь орчны бохирдол, ялангуяа агаарын бохирдол, гудамж талбай тоос шороо ихтэй, ахуйн хог хаягдлаар дүүрсэн зэрэг нөхцөл байдал маш муу. Гудамж талбайн цэвэрлэгээ дутмаг, зам талбайн хувьд зарим хэсэг хатуу хучилтай ч ихэнхидээ шороон замтай, явган хүний зам гарцыг тогтоосон зүйл байдаггүй;
- Хүрээлэн буй орчны бохирдол, хог хаягдал, хогийн цэгийн нөхцөл байдал үнэхээр хүнд, хог хаягдал тухайлбал: шил сав зэрэг хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах, ер нь хог хаягдлыг цуглуулж, ангилан дахин боловсруулах шаардлагатай;
- Аймгийн төв зэрэг төв суурин газар амьдардаг хүмүүс хариуцлагатай байх, тухайлбал: хог хаягдлаа гудамж талбайд бус, зориулалтын цэгт цуглуулж, зайлуулдаг байх, АСТБХХОХ зэрэг төсөл, хөтөлбөрт идэвхитэй оролцож, тэдгээрийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэн, иргэд, оршин суугчдын сайн сайхны төлөө гэсэн сэтгэлтэй байх чухал;
- АСТБХХОХ-ийн гэр хорооллын бүтээн байгуулалтын бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар илүү сайн тайлбарлаж, ойлголт өгөх хэрэгтэй, төсөл хөтөлбөр хаана, хэрхэн хэрэгжих, төсөл иргэдийн өмчилдөг хашааны газрыг орон сууцаар солих уу, гэр хорооллын иргэд төсөлд хэрхэн оролцох зэргийг илүү сайн тодорхой болгох хэрэгтэй байна.
- Алаг Толгой багийн гэр хорооллыг төслийн туршилтын газарт хэрхэн сонгосон, төслөөр хийгдэх дэд бүтэц зөвхөн Алаг Толгой багт уу эсвэл аймгийн төвийн хэмжээнд байх уу?
- Цаашид гэр хороололд өөрсдийн өмчилдөг хашааны газартаа үргэлжлэн амьдрах хүсэлтэй хүмүүс хэрхэн хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарих, ер нь төсөлд хэрхэн оролцож болох;
- Ховд аймагт ийм томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжиж, оршин суугчдад ашиг тусаа өгөх гэж байгаад баяртай байна. “Хашаандаа тухтай амьдарцгаая” “Эко 00” зэрэг төсөл, санаачлагууд ч байдаг. Энэ бүх төсөл санаачлага аймгийн иргэд оршин суугчдад ашиг тус өгөхийн төлөө байдаг гэдгийг бид сайн ойлгож байна. Нөгөө талаар хүмүүс бид өөрсдөө хариуцлагатай байх хэрэгтэй байна. Жишээлбэл, “эко 00” хүлээн авсан хүмүүс тэдгээрийг бүрэн, зөв зохистой ашиглахгүй байна. Иргэд олон нийт, орон нутгийн удирдлагы аль аль хүн бүрийн сайн сайхны төлөө, Ховд хотоо илүү сайхан болгохын төлөө эдгээр төсөлд санаачлагыг идэвхитэй дэмжин оролцдог байх хэрэгтэй байна;
- Алаг толгой багийн 8-р цэцэрлэг төвлөрсөн усан хангамж, дулааны шугамд холбогдоогүй, иймд энэ цэцэрлэг дэд бүтцийн сүлжээнд холбогдох чухал байна;
- Орон нутгийн удирдлагын зүгээс дэд бүтцийн үндсэн шугам сүлжээ орсон газруудын өрхүүдийг шугам сүлжээтэй холбоход өргөтгөл хийж дэд станци/түгээлтийн станци барих хэрэгтэй байгаа талаар ярьж байсан, тэгэхээр АСТБХХОХ-ийн хүрээнд өрхүүдийг дэд бүтцийн сүлжээнд холбоход шаардлагатай дэд станц/түгээлтийн станцуудыг барих хэрэгтэй;
- Алаг толгой багийн зарим гудамжинд 2-3 жилийн өмнө дулаан, усан хангамжийн шугам хоолой тавигдсан, энэ газрын оршин суугчид шугам сүлжээтэй холбож өгөх хүсэлтээ аймгийн удирдлагуудад тавьж байсан ч удирдлагууд санхүүжилт дутагдалтай учир айл өрхүүдийг холбож чадахгүй байгаа талаар мэдэгдэж байсан. Иймд АСТБХХОХ-ийн хүрээнд эдгээр хэсгийн айл өрхийг төвлөрсөн сүлжээнд холбох хүсэлт тавигдсан. Энэ нь зөвхөн тэнд амьдарч байгаа айл өрхүүдэд төдийгүй агаарын бохирдол, хүрээлэн буй орчны бусад бохирдлыг бууруулахад тустай юм. Хэдийгээр олон хүн тэтгэвэрт гарч тэдний орлого багасч байгаа ч, хэрэв төсөл хэрэгжиж эхлэх бол хүмүүс хөнгөлөлттэй зээл авч, орон байрынхаа нөхцлийг сайжруулахыг зорих болно;
- Гэр хорооллын гудамжуудад гэрэл тавьж эхэлж байна, энэ ажлыг өргөжүүлэн илүү олон газар тавьж, зөв зохистой ашигладаг болох хэрэгтэй байна, зарим хэсгийн гэрэлтүүлэг ажиллахгүй байгаа;
- Гэр хорооллын зарим гудамжинд дэд бүтцийн дулаан/ус/бохирын шугам зэрэг үндсэн дэд бүтэц орсон байгаа, зарим газар траншейны нүхүүдийг таг хаалтгүй онгорхой орхисон байдаг, онгорхой нүх байх нь явган хүн/хүүхэд төдийгүй автомашинд маш аюултай, иймээс аюулгүй байдлыг хангаж, эдгээрийг засах шаардлагатай;

- Хатуу хучилттай авто замын нэлээд хэсэг үер ус (цас мөс хайлж борооны ус)-ны улмаас эвдэрсэн, эдгээрийг засах шаардлагатай байна;
- Алаг Толгой багийг төслийн туршилтын газраар сонгосон, харин малчины хорооны нөхцөл илүү муу тоосжилт ихтэй байдаг. Төсөл иймэрхүү газрыг хамгийн түрүүнд сонгох байсан юм. Төсөл нэгэнт Алаг толгойг сонгосон болохоор, дараагийн ба хоёр дахь шатанд энэ газрыг сонгох хэрэгтэй;
- Ер нь иймэрхүү төслүүд сургалт семинар, уулзалт зэрэгт нилээд их мөнгө зарцуулдаг. Харин энэ төслөөс үүний оронд бодит хөгжлийн үйл ажиллагаанд илүү хөрөнгө оруулаасай гэж хүсч байна;
- Рашаант багт халаалт маш муу хуучны орон сууцнууд байдаг, энэ жил дулааны шугам хоолойг шинэчилж, өргөтгөх ажил хийж байна. Энэ орон сууцны оршин суугчдаас нэгдүгээр давхарын 2-3 өрх энэ төсөлд хамрагдаж, одоо амьдарч байгаа орон байрныхаа нөхцлийг сайжруулах санхүүгийн дэмжлэг авч болох эсэх;
- Энэ төсөлд төрийн орон сууцны корпораци /ТОСК/ яаж оролцох, ямар боломж, үр өгөөж санал болгох;
- Хэдийгээр зарим хүмүүс төслийн талаар сайн ойлголтгүй байгаа ч ер нь хүн бүр төслийн талаар ерөнхий мэдээлэлтэй, төслийг дэмжиж байгаа. Гэр хороололд өдөр дутам гал түлэх, түлээ бэлтгэх, үнс цэвэрлэх, усаа авч амьдарч чадахгүй өндөр настан хүмүүс олон байдаг, тэд ихэнхидээ хүүхдүүдээсээ хамааралтай байдаг. дэд бүтцэд холбогдоогүй гэр хороололд амьдардаг хувьд нь байнга байдаг. Иймд, өндөр настан зэрэг тодорхой хэрэгцээтэй нийгмийн бүлэгт зориулсан байр орон сууц төслийн хүрээнд байх хэрэгтэй.

2. Ховд аймгийн Буянт суманд хийсэн иргэд олон нийттэй хийсэн уулзалт хэлэлцүүлгийн тэмдэглэл:

Он сар өдөр, цаг: 2019-10-3, 4-6 PM

Газар: Ховд аймгийн Буянт сумын ЗДТГ-ын хурлын танхим

Оролцогчид: Буянт сумын хүнсний ногоо тариалагчид 18 хүний (7 эрэгтэй, 11 эмэгтэй) Үүнд сумын ИТХ-ын дарга, сумын Засаг даргын орлогч, Газар тариалангийн мэргэжилтэн, багийн Засаг дарга болон ногоо тариалагчид оролцов.

Оролцогчдод АСТБХХОХ төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг товч танилцуулга хийсний дараа, дараах асуултуудыг тавьсан:

- Сумын эдийн засгийн үндсэн үйл ажиллагаа
- Гол эрхэлдэг бизнес, ногоо тариалдаг хэдэн хүн байдаг
- Хүнсний ногоо тарьж ургуулдаг хэдэн газар байдаг
- Гол худалдан авагч/хэрэглэгчид
- Хүнсний ногоо тариалагчдын ашигладаг усны гол эх үүсвэр
- Буянт голын ус ашиглагчдын хувьд ногоо тариалагчдад ямар сорилтууд тулгардаг

Дараах мэдээллийг цуглуулав:

- Буянт сум 5 багтай (баг засаг захиргааны хамгийн бага нэгж), 4 багийн эдийн засгийн үндсэн үйл ажиллагаа мал аж ахуй, 1 баг сумын төвд байдаг, голлон хүнсний ногоо (төмс, хүнсний ногоо, тарвас, амтат гуа зэрэг жимс жимсгэнэ) тарьдаг.
- Албан ёсоор бүртгэлтэй 300 хүнсний ногоо тарьдаг хүмүүс байдаг, мөн 300 орчим хүн албан ёсны бүртгэлгүй хүнсний ногоо тарьдаг.
- Буянт сумын статистик мэдээгээр Ховд аймгийн төвөөс доод хэсэгт орших *Буянт* голын эрэг дагуу 678.9 га газарт хүнсний ногоо, 8,153 га газарт өвс тэжээл тариалдаг.
- Буянт сумын ногоочид Ховд аймгийн хэмжээнд тарьдаг хүнсний ногооны 80%, өвс хадлангийн 80%-ийг бэлтгэж, бүтээгдэхүүнээ зэргэлдээх 5 аймаг, Улаанбаатар хотод худалдаж борлуулдаг. Тус аймгийн хүнсний ногоо тарьдаг хүмүүсийн 20% Ховд суманд, 10% (Ховд аймгийн төвийн баруун хэсэг), Мянгад сум 5% орчим, мөн Буянт голоос усаа авдаг. Булган (Хятадын хилтэй ойр, нэлээд урагш байрладаг).

- Буянт, Ховд, Мянгад сумдын хүнсний ногоочид бүхэлдээ Буянт голын уснаас хамааралтай, тэд гүний ус ашигладаггүй, тэдний хэлж байгаагаар тус сав газарт гүний ус ховор. Ховд аймагт бэлтгэдэг өвс хадлангийн 80%-ийг Буянт сумаас хангадаг.
- Хүнсний ногоочдод дараах бэрхшээл сорилт тулгардаг:
 - Хүнсний ногоо тарьдаг улиралд гадаргын усны хомсдол 4-р сарын дундаас 6, 7-р сар хүртэл үргэлжилдэг. Талбайгаа услах асуудлаар ногоочдын дунд өрсөлдөөн их гардаг, ус ашиглах эрхтэй холбоотой маргаан ихтэй, тэдний нэлээд хэсэг нь талбайгаа устай байлгах үүднээс олон шөнө манаж өнгөрөөдөг. Урт удаан хугацаанд маргалдсны эцэст тэд голын урсгалыг талбайдаа хуваарилах хуваарь гаргадаг болсон. Өөр нэг онцолж байсан зүйл бол ногоо тарьдаг улиралд Буянт гол Ховд гол хүрэхээ больсон талаар хэлж байсан. Ховд гол Хар-Ус нуур (ТХГН, ховор, ховордсон шувуудын байрших газар болдог)-т цутгадаг. Үнэн хэрэгтээ бол энэ голын ус бүхэлдээ усжуулалтанд ашиглагддаг. Буянт сумын ногоо тарьдаг газруудад гараар суваг шуудуу гаргаж голын усыг татдаг. Ногоочид, орон нутгийн албаны хүмүүс бүгд хэрэв энэ төслөөр усжуулалтын ажиллагаа хийгдэх бол голын адгийн ус хэрэглэгчид ногоо тарьдаг улиралд усгүй болж усны хомсдолд орно гэдгийг хэлж байсан.
 - Буянт голын усны нөөцийн өрсөлдөөнөөс гадна сумын ИТХ-ын дарга Нэргүй, Оргих нар Ховд аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн ус цэвэршүүлэх хүчин чадал хангалтгүйгээс бохир ус Буянт голд орж байгаад санаа зовж буйгаа илэрхийлж байсан.

Ер нь бүгд хавар ногоо тарих үеэр төслөөр усжуулалтын ажил хийх нь усны хэт хомсдол үүсгэж болзошгүй талаар санаа зовж байсан, тэд Мянгад сумын төвийн ойролцоо орших Ховд голын савд усалгааны төслийг хэрэгжүүлэх бол цаашид Буянт голын адаг орчмын хэрэглэгчидтэй усны маргаанд орохгүй зайлсхийж болно гэдгийг зөвлөсөн. Уулзалтын үеэр зураг авч, оролцогчдын нэр, нас, хүйс, холбоо барих дугаар, гарын үсгийг авч тэмдэглэлд хавсаргав.

Хурлын үед авсан фото зургууд





3. Баян-Өлгий аймгийн Дэлүүн суманд 2019 оны 10-р сарын 4-ний өдөр иргэд олон нийттэй хийсэн уулзалт хэлэлцүүлгийн тэмдэглэл

Уулзалтанд Дэлүүн сумын төвийн оршин суугчид, малчид, хөдөө аж ахуй, хадгаламж зээлийн хоршооны төлөөлөгчид, бэлчээр эзэмшигчдийн бүлэг, төрийн албан хаагчид гэх зэрэг 160 гаруй иргэд оролцлоо. Төрийн албан хаагчдын дунд Баян-Өлгий аймгийн засаг дарга, Дэлүүн сумын засаг дарга нар байв. Оролцогчид дараах санал, зөвлөгөө, асуултууд тавьлаа.

- Ер нь иргэд АСТБХХОХ-ийг маш их дэмжиж, АХБ, Баян-Өлгий аймаг, Дэлүүн сумын засаг захиргаанд энэ төслийг санаачлан хэрэгжүүлэх гэж байгаад талархаж байгаагаа илэрхийлсэн. Ахмад настай хэд хэдэн хүн төслөөр алслагдсан хөдөө орон нутагт амьдрах таатай нөхцөл бүрдүүлэхийг зорьж байгаад талархалаа илэрхийлж, тэдний үр хүүхэд, хойч үеийнхэнд үр өгөөжөө өгөх зүйл болж байгааг онцолсон.
- Төсөл үйлчилгээний гол дэд бүтэц шугам сүлжээг шинээр бий болгох, одоогийн байгаа сүлжээг сайжруулахад хөрөнгө оруулалт хийж, цэцэрлэг, сургууль, эмнэлэг зэрэг төрийн үйлчилгээний байгууллагын барилга байгууламжийн шугам сүлжээг сайжруулж, өргөтгөнө гэж ойлгож байна. Гэхдээ сургуульд хүүхдүүдэд хэрэгтэй компьютер, хөгжмийн зэмсэг, урлаг, англи хэлний анги танхимын техник хэрэгсэлд хөрөнгө оруулахгүй. Сургуулийн компьютер гэхэд нэлээд хуучирсан, бараг 10 гаруй жил ашигласан, хэрэглээнээс гарсан, хүчин чадал маш бага, мөн хөгжмийн зэмсэг байдаггүй. Иймд төсөлд анги танхимын техник хэрэгсэл, хөгжмийн зэмсгүүдэд хөрөнгө оруулбал хүүхдүүдийн сурч боловсроход хэрэгтэй. Англи хэл, хөгжмийн анги танхим байхгүй, техник хэрэгсэл хуучирсан.
- Сумдын гэр хорооллыг дулаан, ус, бохирын шугам хоолой сүлжээнд холбон, гэр хорооллыг хөгжүүлэх шаарлагатай байна. Энэ талд төсөл ямар нэг ажил хийх үү?
- Төслийн багийнхан суманд хэд хэдэн удаа ирж ажилласан, сургууль дээр очсон. Сургуулийн барилга байгууламжийг сайжруулах, урлаг, хоолны танхим, дотуур байрны орчныг сайжруулах шаардлагатай талаар нэлээд ярилцсан. Энэ зүйлүүдийг хийхээр төлөвлөсөн үү.
- 300 хүүхдийн дотуур байр нэн тэргүүнд хэрэгтэй байна. Дараа жил үүнийг барих уу? лслагдсан газрын малчид хүүхдүүдээ сумын төвд тухтай дотуур байранд байлгахыг үнэхээр хүсч байна.
- Талнуур орчим 1,2,3,10-р багуудын малчид зуны бэлчээр, зуслантай. Дулааны улиралд энд гол үерт автан, шавартай болж, хүрч очиход хүндрэлтэй байдаг. Төсөл малчдад дэмжлэг үзүүлэн энэ гол дээр гүүр барьж чадах уу?
- Багуудын нэг Чирэгтэйд 100- аад малчин өрхийн зуны бэлчээр болон зуслан үерт автдаг ба шавар шалбаагнаас болж энд хүрч очиход хүндрэл учирдаг. Иймд малчдад туслан гүүр барих боломжтой эсэхийг асуусан.

- Сумын төвийн урд байрлах Буянт гол дээр модон гүүр байдаг ч хуучирч, муудсан, малчдын аюулгүй, баталгаатай нөхцлийг хангахад тусалж төслөөр бетонон гүүр барих боломжтой юу?
- Сумын байгаль, хүрээлэн буй орчны нөхцөл байдал доройтсоор байна. Тухайлбал: бэлчээр талхлагдаж, цөлжиж байна ойн талбай багасч байна, зарим нь уртаараа 10 км, залуу зулзган модыг мал идэж, ойд зөвхөн хөгшин эсвэл унасан мод үлдэж байна, ойн цэвэрлэгээ хийхгүй байна. Иймд ойн талбайг шинжлэх ухааны арга аргачлалаар хамгаалж, тэлэх шаардлагатай байна.
- Дэлүүн суманд хүүхдийн эрүүл мэндийн үзлэг хийхэд тэдний дунд шүдний өвчлөл их гэсэн үр дүн гарсан, энэ нь сумын хүн амын хэрэглэдэг ундны усны чанартай холбоотой гэж тогтоосон. Сумын оршин суугчдыг чанартай ундны усаар хангах хэрэгтэй байна.
- Сумын төвийн оршин суугчид эрүүл, тав тухтай орчинд амьдрахыг хүсч байна. Зарим өрх хашаандаа худагтай ч хэрэглэж байгаа усны чанар сайн биш байна. Иймд төслөөр сумын төвийн гэр хорооллын өрхүүдийг шугам сүлжээгээр чанартай, цэвэр усаар хангаж, ус цэвэршүүлэх боломжит технологи, байгууламжаар хангахыг хүссэн. Энэ нь оршин суугчдын хувьд нэн тэргүүний асуудал болж байна. Сумын төвийн гэр хорооллын өрхүүдийг шугам сүлжээгээр чанартай усаар хангах бүрэн боломжтой гэж үзэж байна. Сумын засаг захиргаанаас усан сан, гэр хорооллын өрхүүдийг шугам сүлжээтэй холбох техникийн нарийвчилсан зураг төслийг гаргуулсан.
- Түүнчлэн, сумын оршин суугчдын дунд давсны хэрэглээ өндөртэй улмаас эрүүл мэндийн асуудал ихтэй. Энэ нь давс ихтэй цай уудагтай нэг талаараа холбоотой ч махыг муутгахгүй, урт удаан хугацаанд хадгалах зорилгоор хэт их давсалж хэрэглэдэгтэй зарим талаараа холбоотой. 7, 8-р сар хүртэл мал гаргадаггүй бөгөөд хадгалах байгууламж хомс учраас махыг 12-7-р сар хүртэл удаан хугацаагаар давслан хадгалж хэрэглэдэг. Тиймээс сумын оршин суугчдад агуулах шаардлагатай байгаа юм.
- Хүүхдийн цэцэрлэгт ногоо хадгалах зориулалтын агуулах байхгүй. Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн хүнс, хүнсний ногоо хадгалах зориулалтын байгууламж хамгийн чухал байна.
- Сургууль цэцэрлэг, дотуур байр, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа өвчнүүдийн бүх хоол хүнснийг сумын гаднаас авч ирдэг. Иймд эдгээр байгууллага болон цаашид сумын нийт ард иргэдийн хүнсний хангамжид тустай жижиг хүнсний үйлдвэрлэлтэй болоход төслөөс дэмжлэг үзүүлж болно. Жишээлбэл, цагаан идээний/эсвэл талх нарийн боовны үйлдвэрлэл байж болно.
- Толбо сумаас Дэлүүн сум хүртэл хатуу хучилттай зам тавих боломжтой эсэх.
- Өмнөх хэдэн жил Дэлүүн суманд өвөлжилт хүндэрч, малын өвс тэжээлийг алс хол аймгуудаас татсан. Иймд төслөөс малчдад усалгаатай, хамгаалалт бүхий хандлангийн талбайтай болоход дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Энэ нь малчдын амьжиргааг дээшлүүлэхэд үнэхээр тустай байх болно.
- АСТБХХОХ нь 3 үндсэн шатаас бүрдсэн 10 жилийн хөтөлбөр гэж ойлгож байгаа, иймд эхний шатанд төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлж, тэдгээрийг хэрэгжүүлж байх хооронд сумын иргэд малчид төсөлд тусгах саналаа ирүүлж, хэрвээ боломжтой бол дараа дараагийн шатанд хэрэгжүүлж болох юм.
- Төсөл хэрэгжиж эхлэхээр Дэлүүн сумын иргэд, малчид, удирдлага Монгол улсын хөгжилд хувь нэмрээ оруулан, сумаа загвар сум болгон, бусад сумдад үлгэр жишээ сум болгохыг төлөө хичээнгүйлэн ажиллах болноо гэдгийг цохон тэмдэглэсэн.

Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлгийн үеэр авсан зарим зургууд



4. Баян-өлгийн аймгийн Өлгийн суманд 2019 оны 10-р сарын 5-ны өдөр хийсэн олон нийтийн уулзалтын тэмдэглэл

Уулзалтанд 100 гаруй оролцогчид ирсэн, энэ нь тооцоолж байснаас бага хүмүүс хүрэлцэн ирсэн. Энэ нь нэг талаар 2019 оны 10-н сарын 5-наас 6-ны хооронд Өлгий суманд “Бүргэдийн баяр” болсонтой холбоотой. Энэ нь аялагч жуулчдын анхаарлыг ихэд татдаг, олон нийтийн чухал арга хэмжээний нэг юм. Өлгий сумын оршин суугчдын нэлээд хэсэг энэ арга хэмжээнд оролцож, үзэж, зохион байгуулж, урлагийн үзүүлбэр тоглолт үзүүлж, хоол хүнс, бэлэг дурсгалын зүйлс худалдаж оролцсон. Иймд уулзалтанд оролцогчдын тоо цөөн байсан. Уулзалтанд Баян-Өлгий аймгийн төвийн оршин суугчид, малчид, хөдөө аж ахуй, хадгаламж зээлийн хоршооны төлөөлөгчид мөн төр захиргааны албаны хүмүүс байсан. Орон нутгийн удирдлагын дунд Өлгий сумын Засаг даргын тамгын газрын дарга, Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа хот төлөвлөлтийн газрын дарга нар хүрэлцэн ирсэн. Оролцогчдын зүгээс дараах санал, хүсэлт, асуултыг тавьсан.

- Ер нь оролцогчид АСТБХХОХ, төсөл алслагдсан баруун аймгийн нэг Баян-Өлгий аймагт хэрэгжих гэж байгаад талархлаа илэрхийлсэн. Оршин суугчид алслагдсан баруун аймгуудыг хөгжүүлэх цаг нь болсон гэдгийг санал нэгтэй илэрхийлсэн.
- Төсөл аймгийн төвийн оршин суугчдын тав тухтай амьдрахад тустай дулаан, ус, бохирын шугам сүлжээ зэрэг суурь дэд бүтцийг сайжруулах хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөн дэмжлэг үзүүлж байгаа нь хамгийн чухал байна. Энэ нь оршин суугчдын ирээдүйн амьдрал, залуу үеийн амьдралд нэн тустай байна.
- Төслийн бүтээн байгуулалт/барилгын ажилд өрсөлдөөнт тендэрээр явагдах уу? Энэ төсөл эсвэл аймгийн захиргаа байх уу? Барилгы ажилл олон компани оролцох байх, тухайлбал зам эсвэл дэд бүтцийн мэргэжлийн компаниуд орох байх. Нээлттэй, ил тод байдлын асуудал тавигдах байх, заримдаа ийм ажил тендэрээр нээлттэй, ил тодоор явагддаг, заримдаа тийм биш байдаг. Төслийн барилгын ажил явагдах үед тухайн газрын оршин суугчид барилгын

ажилд давхар чанарын хяналт хийх шаардлага гардаг. Өлгийн дулаан, ус, бохирын шугам зэрэг дэд бүтцийг 1978 онд эхэлж 7 жил барьсан байдаг. Энэ чанарын хатуу хяналт шаардлагын үр дүнд суурь дэд бүтэц чанартай сайн хийгдэж одоо хүртэл сайн хэвээр байгаа юм.

- Тэтгэвэрт гарсан барилгын/дэд бүтцийн, байгаль орчны мэргэжилтнүүд байгаа, эдгээр хүмүүс АХБ-ны санхүүжилттэй баригдаж саяхан дууссан босоо тэнхлэгийн замын ажилд оролцсон (2019 оны намар саяхан дууссан), мөн байгаль орчны үнэлгээ, бусад хяналтын ажлуудад оролцож ажиллаж ирсэн. Эдгээр хүмүүс оршин суугчдын хамт ажлын чанрыг хяналтанд ажиллана.
- Төслийг АХБ санхүүжүүлнэ гэж ойлгож байгаа, харин энэ нь техникийн тусламж, буцалтгүй тусламж эсвэл зээл үү гэдэг нь тодорхойгүй байна. Үүнийг тодруулж өгнө үү?
- Төсөл хэрэгжих гэр хорооллын нэгэнд 13-р баг орж байгаа гэж ойлгож байна, тэгэхээр төсөл энэ багийн суурь дэд бүтцийг бүхэлд бий болгоно гэсэн үг үү? Гэхдээ туршилтын газар болохоор төслийн эхний шатанд зөвхөн сонгосон гудамжид гол чиглэх үү? Тус багийн бусад гудамжууд яах вэ, хэрэв бусад гудамж хамрагдах бол ямар хугацаа, төлөвлөгөө байгаа вэ?
- Зорилтод 5-р болон 13 -р багийн гэр хорооллын дэд бүтцийг энэ төслөөр шийдэх үү, тэгвэл бусад гэр хороолол яах вэ, тэдгээрт дэд бүтэц, зам бий болох уу, эдгээр хэсэг хэрхэн хөгжих вэ? Төслийн хугацаа, хамрах хүрээг тодруулж өгнө үү?
- Одоогоор гэр хорооллын хашаанд ундны усны худаг, нүхэн жорлон, хоорондоо 10 хүрэхгүй метрийн зайд зэрэгцэн оршдог. Энэ нь ундны ус бохирдож, улмаар дотор эрхтний өвчлөл үүсдэг. Төслөөр стандартад нийцсэн, найдвартай усан хангамж, бохирын татуурга шугам хоолой бий болно. Энэ нь зөвхөн сонгосон 13-р болон 5-р багуудад бус аймгийн төвийн бусад багуудад бий болно. Тэгвэл одоогийн байгаа бохирын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж цаашид нэмэгдэх бохир усанд хангалттай байж чадах уу? Эдгээр асуудлыг гэр хорооллын дахин бүтээн байгуулалт, цэвэр ба бохир усны асуудлын хамт зэрэгцүүлэн авч үзэх хэрэгтэй байна. Өлгийд шинэ цэвэрлэх байгууламж барих талаар өмнө төлөвлөж байхад энэ талаар ярилцаж байсан, гэсэн ч одоогоор хийгдсэн зүйл байхгүй байсаар байгаа юм. Энэ төслөөр энэ асуудлыг шийдэх байх гэж найдаж байна.
- Хотын хойно Ховд голын гүүрээс цааш 6-р, 9-р, 10-р багууд байрладаг. Төслийн зорилтот 5-р болон 13-р багуудын гэр хорооллуудтай харьцуулахад эдгээр баг ус, бохирын шугам, дулааны дэд бүтэцгүй. Төсөл хотын энэ хэсэгтэй зэрэгцүүлэн эдгээрийг эхлүүлж болохгүй юу? Хэрэв энэ хэсэг дэд бүтцийн сүлжээгээр хангагдвал аймгийн төвийн төвийн төв хэсэгт ирэх дарамт буурч болно. Жишээлбэл газрын үнэ буурах, ачаалал төвлөрөл давхар буурна. Үүнийг төслийн хэрэгжилтэнд авч үзэх хэрэгтэй.
- Голын хойно орших 6-р, 9-р, 10-р багуудын асуудал чухал, аймгийн захиргаа бүр анхнаас энэ хэсэгт дулааны станци шинээр барих саналыг тавьж байсан. Төслийн 2-р шат бус бүр 1-р шатанд авч үзэх хэрэгтэй юм. Энэ нь тухайн багуудын оршин суугчдад амьдрах таатай нөхцөл бүрдүүлэхээс гадна орон сууцны шинэ хороолол хөгжүүлэх боломжтой юм. Төслөөр орон сууцны шинэ хороолол хөгжүүлэх бий болгохыг зорьж байгаа болохоор одоогийн хуучин дулааны станци цаашид нэмэгдэх дулааны хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй.
- Шинэ бүтээн байгуулалт хийгдэх болохоор дулааны хэрэгцээ нэмэгдэнэ, тэгэхээр нэгээс ч илүү дулааны станци хэрэгтэй болж болно.
- Бий болгосон суурь дэд бүтэц, байгууламжийг үр ашигтай ашиглах үүднээс өөр нэмэлт орон сууц барих хэрэгтэй болж болно.
- Аймгийн төвийн агаарын бохирдол улам бүр нэмэгдэж, магадгүй Улаанбаатар хотоос дор болж болно. Иймд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нэн даруй авах хэрэгтэй. Төслийн хүрээнд Улаанбаатарт хийгдэж байгаатай адил утаагүй түлш үйлдвэрлэх, хангах арга хэмжээг авч болох уу?
- Нүүлгэн шилжүүлэлтийн тухайд нөхөн төлбөр ямар байх? нөхөн төлбөр нь зах зээлийн үнэд үндэслэж, бүрэн нөхөн төлнө гэж ойлгож байгаа. Үүнийг хэрхэн хийх вэ, хэрэв нөлөөлөлд өртөх хүмүүс зах зээлийн үнээс илүү өндөр нөхөн төлбөр эсвэл нөхөн төлбөрийн бүрэн үнэлгээ шаардах бол яах вэ? Төслийн зорилтод газрын нэг 5-р баг, энэ “А” бүсэд байна, энэ бүсэд газрын үнэ харьцангуй өндөр байдаг.

- Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа хийгдэнэ, тийм болохоор нөлөөлөлд өртөх өрхүүд эсвэл сөрөг нөлөөлөл гарахгүй байж болно. Үнэлгээ шудрага байх ёстой, тэгэснээр газар өмчлөгч, эзэмшигчдэд нөхөн олговрыг зөв олгож болно.
- Хэрэв хашааны газар өмчлөгч, эзэмшигчид газраа төслийн бүтээн байгуулалтанд оруулахыг хүсэхгүй бол тэдний газрыг авах боломжгүй болно. Иймд нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн үнэлгээ, судалгааг нарийвчлан явуулах, ингэснээр газар олж авах, нүүлгэн шилжүүлэх боломжтой болж, төслийн ажил урагшилна.
- Хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төсөл малын түүхий эд жишээ нь хонины арьс нэхий боловсруулах үйлдвэр барьж болох уу.
- Аймгийн төвд улсын ба орон нутгийн төсвийн санхүүжилтээр зам барих зэрэг хөгжлийн үйл ажиллагаа байдаг. Төсөл өөрийн үйл ажиллагааг орон нутгийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагаатай уялдуулж зохицуулах хэрэгтэй. Ингэснээр давхцал гарахгүй. Төслийн ажлыг өмнө хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтыг тасалдуулан явуулах ёсгүй.
- Төсөл хэрэгжүүлэхэд өмнө тооцоолж/хүлээж байгаагүй хүндрэл гарч болно. Иймд эдгээр хүндрэлийг даван туулах, хэрэгжилтийг амжилттай явуулахын тулд холбогдох аймгийн засаг захиргааны удирдлага, ажилтан, оршин суугчдын дэмжлэгийг бүрэн авах хэрэгтэй байдаг.

Өлгий суманд хийсэн олон нийтийн уулзалтын үеэр авсан зарим зураг





5. Увс аймгийн Өмнөговь суманд 2019 оны 10-р сарын 7-ны өдөр олон нийттэй хийсэн уулзалт

Увс аймгийн Өмнөговь суманд хийсэн олон нийтийн уулзалт хэлэлцүүлэг тус сумын ЗДТГ-ын Иргэний танхимд болов. Уулзалтанд Увс аймгийн Засаг даргын тамгын газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын төвлөлттийн хэлтэс, Өмнөговь сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, Өмнөговь сумын төвийн оршин суугчид, малчид, засаг захиргааны албаны хүмүүс бүхий нийт 60 гаруй хүн оролцсон. Оролцогчдын зүгээс дараах санал, хүсэлт, асуултуудыг тавьсан.

-
- Ер нь оролцогчид АСТБХХОХ тус суманд тэр дундаа аймгийнхаа хэмжээнд хөтөлбөр хэрэгжих анхны сум болсонд баяртай байна. Төсөл хот, төв суурин, гэр хорооллын хөгжил, дэд бүтэц, хөдөөгийн хөгжил – хөдөө аж ахуй, малын өвс тэжээл, бэлчээрийн удирдлага, малчдын хөгжил гээд олон талыг хамарсан гэж ойлгож байна.
- Оролцогчдын зарим төсөл сум болон түүний оршин суугчдыг дэмжинэ гэдгийг онцолж байсан. Нөгөө талаар тэд сумын төвийн оршин суугчид, малчид төслийг дэмжин, идэвхитэй оролцсноор гол үр шимийг сум, түүний оршин суугч иргэд хүртэнэ гэдгийг онцолж байсан.
- Төсөл эхлэх бол эхлээд аймгийн төв Улаангомд эхэлж, дараа нь Өмнөговь суманд эхлэх үү эсвэл зэрэг эхлэх үү?
- Төсөл яаж хэрэгжих вэ? Төслийн хүрээнд жагсаасан бүх үйл ажиллагаа жишээ нь: сургууль, дотуур байр, эмнэлэг зэрэг байгууллагуудын нөхцлийг сайжруулах ажиллагаа бүгд хэрэгжих үү эсвэл жагсаасан үйл ажиллагаанаас нэн тэргүүний гэснийг хэрэгжүүлэх үү, хөрөнгө оруулалтын зарим хэсгийг орхих, эсвэл өөр бусад байгууламжид оруулах зэргээр түүний цар хүрээнд өөрчлөлт орох уу, хэрэгжилтийн дараалал жишээ нь: эхлээд сургууль, дараа нь дотуур байр, дараа нь эмнэлэг зэргээр дараалах уу?
- Улсын ба төрийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийн бохир усны систем хэрхэн/яаж ажиллах, цэвэрлэх байгууламж/станци бүхий төвлөрсөн шугам сүлжээтэй байх уу эсвэл тусдаа бие даасан бохир усны татуурга, нүх/сав байгууламжтай байх уу? Бусад сумдыг улсын байгууллагуудын бохир усны шийдэл ямар байдаг вэ? Тэд төвлөрсөн системтэй байдаг уу эсвэл бие даасан тусдаа нүх/савтай байдаг уу? Хариултыг бусад зарим сумдын жишээ: өөрсдийн байгууламж нүх/савтай, бохироо соруулж зайлуулдаг машинтай, бохирыг төвлөрсөн цэгт хүргэдэг гэдгээр тайлбарласан.
- Сумын төвийн хүмүүст жорлонг хэрхэн зөв ашиглах талаар мэдээлэл сурталчилгаа явуулах чухал байна. Эмнэлэгт зарим хүмүүс дотор жорлон ашиглахдаа хатуу хог хаягдлаа суултуурт хийж бөглөрөл, эвдрэл үүсгэж байсан тохиолдол байсан. Иймд сумын иргэдэд нийтийн үйлчилгээний байгууллагын жорлонг хэрхэн зөв ашиглах талаар тодорхой ойлголт чиглэл өгөх нь чухал байна.
- Сумын төвийн төв замыг саяхан хатуу хучилттай болгосон, энэ үеэр тоос шороо үүсч, замын хөдөлгөөний чиглэл өөрчлөгдсөн.
- Гүний усны ашиглалттай холбоотой асуудал гарч байсан. Төсөл эхлэхээр албан байгуулга, магадгүй цаашид гэр хорооллын өрхүүд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдохоор усны хэрэглээ нэмэгдэж болно. Энэ нь усны нөөцийн хэмжээг багасгаж болзошгүй. Сүүлийн үед ашиглаж байгаа гүний худгийн усны чанар муудаж, усны бойлер, ахуйн саванд давсны тунадасжилт үүсэх болсон. Урьд өмнө ийм байгаагүй, энэ нь газрын доорх усны эх үүсвэр багасч, ус

давсжих хандлагатай болж байгааг харуулж байж болно. Иймд төслөөс гүний усны эх үүсвэр, нөөц, чанрын талаар нарийвчилсан судалгаа хийж, гүний ундны усыг хэмнэлттэй ашиглах асуудлыг авч үзэх хэрэгтэй.

- Тэгвэл гэр хорооллын хөгжил ямар байх вэ? Улаангомьн гэр хороололтой адил байх уу? Эрүүл мэнд, эрүүл ахуйн, нүхэн жорлонгийн үнэр мөн нүүрсний утаа санаа зовоосон гол асуудал болж байна. Өвөл сумын төвд ойролцоогоор 550 – 600 орчим өрх, тэдний шатаасан нүүрсний утаа хэдийн бохирдол үүсгээд эхэлсэн, ялангуяа хүйтний улиралд өглөө оройдоо утаа их байдаг. Тэгсэн ч гэр хорооллын хөгжлийг аймгийн төвтэй адил авч үзэх хэрэгтэй.
-

Өмнөговь суманд хийсэн олон нийтийн уулзалтын үеэр авсан зарим зураг



6. Увс аймгийн Улаангом суманд 2019 оны 10-р сарын 8-нд олон нийттэй хийсэн уулзалт

Увс аймгийн Улаангом суманд уулзалтыг аймгийн драмын театрт хийлээ. Нийт 120 гаруй хүн оролцсны дотор тус сумын оршин суугчид, малчид, засаг захиргааны албаны хүмүүс оролцсны дотор Увс аймгийн ЗДТГ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Улаангом сумын Засаг дарга байсан. Оролцогчдын зүгээс дараах санал зөвлөгөө, асуултуудыг тавьлаа.

- Ер нь оролцогчид АСТБХХОХ хэрэгжих болсонд талархаж, төслөөр хэрэгжих хөрөнгө оруулалт аль болох урт хугацааны дараагийн 20-30 жилд хамаарах стратегийн хөгжлийн асуудалд чиглэсэн байх хэрэгтэй гэсэн саналуудыг хэлсэн.
- Төсөл яг хэзээ эхэлж, гэр хорооллыг хөгжүүлэх зэрэг ажлууд хэрэгжиж эхлэх?

- Малын түүхий эдийг байгальд шууд хаяж байгаагаас хүрээлэн буй орчинд бохирдол үүсэх болсон. Жишээ нь: малын толгой, шийр, гэдэс дотор, арьс ширийг шууд хаяж байна. Хонины арьс нэхийг гэдэс/өлөнтэй хамт түүхий эдийн худалдаа эрхлэгчи худалдан аваад дараа нь арьсыг шууд хаядаг.
- ЖДҮ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үү? Ялангуяа, малын толгой, шийр, гэдэс дотор, яс зэрэг бүтээгдэхүүнийг боловсруулахтай холбоотой үйлдвэрлэлд. ЖДҮ-ийн сангаас зээл авахад хүндрэлтэй. Албаны хүмүүс ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээл авах талаар үнэн зөв мэдээлэл өгдөггүй. Хэдийн шаардлагатай баримт бичгүүдийг өгсөн байсан ч ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлийн зорилтот үр шим хүртэгчид хүрч чаддаггүй. Шууд хаяж байгаа малын түүхий эд боловсруулах бүтээгдэхүүн гаргах боломж ЖДҮ-д нэлээд их байдаг. Хэрэв төслөөс ЖДҮ хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийг танилцуулж, авах боломжтой болгож өгөх бол юуны өмнө ил тод, шудрага байх журам, тус зээл олгох албыг бий болгох хэрэгтэй юм.
- Малаас хаях юу ч байдаггүй, бүх л эд эрхтэн хэсэг, бүр мал нядласны дараа түүний ялгадасыг авч малын цустай хольж, хатаан малын тэжээл хийхэд ашигладаг. Мөн малын гэдэс/өлөнг эм эсвэл дархлааны нэмэлт бүтээгдэхүүн зэрэгт ашиглаж болно.
- Дулааны станиц-1-ээс овоолго үнс гарсан байна, хүмүүс блок, хашаа, гараж зэрэгт ашиглахыг зорьдог ч шавар/элстэй гээд блокт ашиглах боломжгүй байна. Түүнчлэн нутгийн иргэд үнэтэй үр худалдан авч хүнсний ногоо тарьдаг, гэсэн тариаланч дэр төр засгийн олон албаны хүмүүс ирж, төрөл бүрийн зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл зэргийг шаарддаг. Ховдоос хүнсний ногоог илүү хямд үнээр авч болохоор байна. Иймд хүмүүс жижиг бизнес, үйлдвэрлэл эрхлэхэд төрөл бүрийн асуудалтай тулгардаг. Төсөл эдгээр асуудлыг авч үзэн, жижиг бизнес эрхлэхийн хүсч байгаа хүмүүст хялбар болгох арга замг эрэлхийлэх хэрэгтэй юм. Мөн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид мэргэжлийн хүмүүстэй уулзаж, өөрсдийн бизнестээ зөвлөгөө авах хэрэгтэй.
- Тэжээлийн үйлдвэрлэлд зориулан талбайг усжуулахад усны эх үүсврийг хэрхэн бий болгох? Гүний худаг байх уу эсвэл Тээл голыг ашиглах уу? Тээл гол орчимд усалгаатай хадлан, хүнсний ногоо тарих зэрэг хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс байдаг. Төслөөр усжуулалтын ажиллагаа эхлэсний дараа голын ус эдгээр усны хэрэглэгчдэд хангалттай байх эсэх, Усжуулалтын талбайн заагийг хаагуур тогтоох, тухайн тогтоосон талбай орчмын хүмүүс уг ажиллагаанаас үр ашиг хүртэх эсэх? Хүмүүс мал маллаж, өвс хадлан бэлтгэж, хүнсний ногоо тарьж амьжиргаагаа залгуулахдаа Тээл голыг гол түшиглэдэг, ер нь гол хамаардаг. Хэрэв эдгээрт ямар нэг сөрөг нөлөө үзүүлэх бол тэдний амьжиргааг тогтворжуулах арга хэмжээ авах эсэх.
- Өмнө 2007-2008 онд АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг бүхий үүнтэй адил төсөл байсан, төсөл хөдөө аж ахуйн хоршоод байгуулагдан ажиллахыг дэмжиж байсан. Ер нь 10 гаруй өрх нийлж, өөрсдийн хөрөнгөө нийлүүлж хоршоо байгуулж хамтран ажиллах хэлбэрт орж, зарм аж ахуйн ажиллагааг ч эхлүүлсэн. Гэхдээ аажимдаа тариалалт хийж байсан 30-40 га талбай зөвхөн нэг хүний өмч болж, үлдсэн өрхүүд бүр 1 га газар ч үгүй хоцорсон. Тэгэхээр энэ шинэ төсөл ийм жишээгээр дуусахгүй байх хамгийн чухал. Үүний тулд журам, үйл явц маш тодорхой, шудрага байх, төслийн үр шим зорилтот бүлэгт хүрсэн байх ёстой.
- Тэжээл үйлдвэрлэх зорилгоор усжуулалт хийхийг нэлээд дэмжиж байна. Увст хүмүүс царгас/алфа алфа тарьдаг. Үүгээр тэжээсэн мал хурдан, илүү тарга тэвээрэг авдаг. Иймд энэ ургамлыг усжуулалттай талбайд тарих нь зүйтэй.
- Гэр хорооллын бүтээн байгуулалтын санаа одоо илүү тодорхой болж дэмжлэг авч байна.
- Гэр хорооллын бүтээн байгуулалтын төсөл хашааны газар өмчлөгч, эзэмшигчдэд маш ойлгомжтой, үр өгөөжтэй байх ёстой, төсөл оролцогч хүмүүсийг газаргүй, орон байргүй үлдээхгүй эсвэл зарим нэг хэсэг нь бусдын төлсөн төлбөр дээрээс ашиг хүртээд явж болохгүй.
- Гэр хорооллын бүтээн байгуулалтын төсөл 4-р багаас эхлэнэ. Тус багт 4-р сургууль байрладаг, сургуулийн В байр 1985 оноос хойш ашиглагдаж байгаа, 240 хүүхдийн хүчин чадалтай. Ашиглаж эхлэснээс хойш тус хичээлийн байранд бүрэн хэмжээний

/капитал засвар үйлчилгээ хийгдээгүй. Энэ төслөөр хичээлийн “В” байранд бүрэн хэмжээний засвар үйлчилгээ хийх үү.

- Одоогоор аймгийн төвд халаалт, усны суурь сүлжээ хийгдэж байна. Зарим газар энэ ажил удаан хийгдэж байгаа, энэ нь магадгүй мэргэжлийн бус компани ажилчид хийж байгаатай холбоотой байж болно. Төсөл эхлэхээр энэ асуудлыг авч үзэх хэрэгтэй, ажлыг цаг хугацаанд нь мэргэжлийн компани/ажилчдаар хийлгэдэг байх хэрэгтэй.
- Аймгийн төвд бохир ус цуглуулж, зайлуулах стандарт систем байхгүй. Хог хаягдлыг хаа сайгүй хаядаг, гудамж талбай ч хог ихтэй болж байна. Иймд хог цуглуулах, зайлуулах зөв оновчтой арга ажиллагаа / жишээ нь: хог хаягдлын тогтолцоо байх хэрэгтэй.

Улаангом суманд хийсэн олон нийтийн уулзалтын үеэр авсан зарим зураг



Зургаан уулзалтын оролцогчдын нэр, холбоо барих утас, гарын үсгийн жагсаалт нэлээд урт байсан болохоор тусад гаргасан.

7. Увс аймгийн Тариалан, Наранбулаг сумдад 2020 оны 4-р сарын 29-30 болон 5-р сарын 1-нд олон нийттэй хийсэн уулзалт

Хятадад анх 2020 оны 1-р сард дэгдэн, улмаар дэлхий нийтийг хамраад байгаа корона вирусын улмаас Монгол Улсын Засгийн газар 2020 оны 2-р сараас эхлэн вирусын тархалтыг хязгаарлах зорилгоор нэг дор 5-аас дээш хүн цугларах олон нийтийн аливаа арга хэмжээ, хурал цугралтыг хориглосон. Энэ бодлого нь төслийн олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг явуулах хэвийн нөхцөлд сорилт бий болгосон. Иймд боломжит аргын нэг бол оролцогчидтой нэг нэгээр уулзан санал асуулгын судалгаагаар санал бодлыг авах байсан юм.

Мэргэжлийн үндэсний гидрологичийг авч ажиллуулан Хархираа гол, түүний цутгал Тээл голын ус хэрэглэгчид, усны хамгаалалд хамаарах төслийн асуудлаар мэргэжлийн санал дүгнэлт гаргуулсан. Хархираа гол, түүний цутгал Тээл гол Тариалан сумын нутаг дэвсгэрийн нэлээд зайд урсдаг, судалгаанд оролцогчдын ихэнхи (78 хүн) Тариалан сумаас, хамгийн цөөн (4 хүн) Наранбулаг сумаас байлаа. Наранбулаг нь Тариалан сумын зүүн талд зэрэгцэн оршдог сум юм. Нийт 82 хүн 2020 оны 4-р сарын 29-30 болон 5-р сарын 1-нд зохион байгуулсан санал асуулгын судалгаанд хариулт өгч оролцсон. Судалгаанд оролцогчдын ихэнхи нь тариаланчид, хадланчид, ногоочид, малчид байснаас гадна эмнэлгийн ажилтнууд/эмч, дунд сургуулийн багш нар байна. Мөн байгаль орчны байцаагч, нийгмий хамгааллын мэргэжилтэн, санхүүгийн хэлтсийн дарга зэрэг орон нутгийн засаг захиргааны албаны хүмүүс оролцож, санал асуулгыг бөглөсөн.

Санал асуулгын хуудас 12 асуулт, нэмэлт саналын хэсэгтэй. Нарийвчилсан асуулт, судалгааны үр дүнг энэ хэсгийн төгсгөл дэх хүснэгтэд оруулсан болно.

Судалгаанд оролцсон хүмүүсийн ихэнхи (72%) усны хамгааллын төслийн талаар сайн ба тодорхой хэмжээнд мэддэг байна.

Нийт 82 хариулт өгсөн хүний 51 хүн (74%) Хархираа голын ус хэрэглэгч, 18 хүн (26%) нь Тээл голын ус хэрэглэгч байна.

Голын усыг ямар зорилгоор ашигладаг тухай асуултанд 69 хүн (38%) усыг хадлан авахад, 46 хүн (25%) мал услахад, 35 хүн (19%) тариалан/үр тариа, тэжээл тарихад, 34 хүн (18%) жимс жимсгэнэ, хүнсний ногоо тарихад ашигладаг гэсэн байна.

Хариулт өгсөн хүмүүсийн 46% (38 хүн) зуны улиралд Тээл голын урсац Увс нуурт хүрдэггүй, учир нь нутгийн иргэд түүний байгаа усны тариалан/үр тариа, тэжээл, жимс, жимсгэний мод, хүнсний ногоо тарихад татчихдаг гэсэн байна.

Хариулт өгсөн хүмүүсийн 43% (35 хүн) Тээл гол заримдаа Увс нуурт хүрдэг гэсэн бол зөвхөн 2 хүн голын урсац нуурт хүрдэг, 7 хүн голын урсац нуурт хүрдэг эсэхийг мэдэхгүй гэж хариулсан байна.

Увс нуурын экосистем Хархираа, Тээл голоос хамаардаг эсэх асуултад хариулт өгсөн хүмүүсийн 34% ба 27 хүн Увс нуур Хархираа (Тээл) голоос шууд хамаардаг, 20% ба 16 хүн тухайн нуурын экосистем Хархираа (Тээл) голоос хамаардаггүй, 31% ба 25 хүн гол үерлэсэн үед түүний ус Увс нуурт хүрдэг, үүгээрээ Увс нуурын экосистемд нөлөөлдөг, 15% ба 12 хүн энэ асуултад хариулж мэдэхгүй гэсэн байна.

Төлөвлөж буй төслийн хүрээнд Тээл голын усыг хашиж, усны 3%-ийг 5-р сараас 9-р сарын хооронд хадгалах бол танай гэр бүлийн болон нутгийн бусад иргэдийн амьдралд сайнаар эсвэл муугаар нөлөөлөх үү гэсэн асуултанд оролцогчдын 51% энэ нь эерэгээр нөлөөлнө, 21% нөлөөлөхгүй, 15%

мэдэхгүй гэж хариулсан байна. Мөн 13% энэ нь Тээл голын усны хамгаалалт ямар нэг байдлаар сөргөөр нөлөөлнө гэсэн байна.

Орон нутгийн байгаль орчны асуудлын талаар 1. Гадаргын усны хомсдол (36%), 2. Малын тоо хэт өндрөөс бэлчээрийн доройтол, талхагдал (22%), 3. Хатуу хог хаягдлын асуудал (19%) ба байгаль орчны бохирдол (11%) гэсэн байна.

Төслийн зүгээс Тээл голын загас, түүний ойролцоо газрын биологийн олон янз байдалд нөлөө үзүүлнэ гэж санаа зовж байгаа эсэх асуултанд нийт оролцогчдын 73% санаа зовохгүй байна гэсэн бол зөвхөн 4% төслийн нөлөөллийн талаар санаа зовж байна гэсэн ч яаж гэдгээ тайлбарлаагүй байна.



Төслөөс орон нутгийн эдийн засгийн үйл ажиллагаа, нутгийн иргэдэд нөлөө үзүүлэх эсэх талаар оролцогчдын 71% (72 хүн) нутгийн иргэдийн амьжиргаанд эерэгээр нөлөөлнө, 21% (21 хүн) орон нутгийн эдийн засгийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө гэсэн байна. Нэг хүн сөргөөр нөлөөлнө гэсэн ч яаж гэдгийг тайлбарлаагүй байна. 7% нөлөө үзүүлнэ гэдгийг сайн хэлж мэдэхгүй гэжээ.

Төсвийн үйл ажиллагаанд хандах хандлагын талаарх асуултанд оролцогчдын 88% (70 хүн) төслийг дэмжиж байна 6% дэмжихгүй байгаа ба дэмжих эсэхээ мэдэхгүй гэсэн байна.

Нэмэлт саналын хэсэгт дараах саналуудыг өгсөн байна:


- Усны хамгааллын асуудалд хандаж байгаад талархлаа илэрхийлээд энэ нь нутгийн иргэдийн сайн сайхан байдал, тэдний үр тариа/тэжээлийн тариалан, үйлдвэрлэл, хадлан, хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэл болон бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.
- Энэ нь уламжлалт газар тариалан, үйлдвэрлэлийг дэмжинэ.
- УАӨ нэмэгдэж байгаа болохоор нутгийн иргэд усыг үр ашигтай ашиглаж хэрэглэдэг байх хэрэгтэй.
- Усан сан, ус хадгалах байгууламжид мал, хүүхэд унах эрсдлээс хамгаалсан байхад тэдгээрийн зураг төсөлд анхаарлаа хандуулах.
- Суваг шуудуу, ус хадгалах байгууламжийн зураг төсөл, барьж байгуулах ажлыг сайн чанартай, удаан хугацаанд найдвартай ашиглагдахаар хийх хэрэгтэй.
- Дэд бүтцийн зураг төсөл гаргах, барьж байгуулахдаа үер усны хамгаалал, усны хөрсөнд нэвчих, алдагдахаас хамгаалсан элементүүдийг оруулж өгсөн байх.
- Дэд бүтцийг барьж байгуулж байхдаа ландшафтын өнөөгийн нөхцлийг өөрчилж, хөндөхгүйгээр аль болох хэвийн нөхцлийг хадгалсан байх.
- Орон нутгийн ус хэрэглэгчид, малчдыг газрын нөөцийг сэлгээтэй ашиглах, ус хамгаалах асуудлаар сургалт явуулах хэрэгтэй.

Судалгаанд хамрагдсaдын насны бүлэг		СУДАЛГААНД ХАМРАГДСАДЫН НАСНЫ БҮЛЭГ <table><thead><tr><th>Насны бүлэг</th><th>Хүний тоо</th><th>Хувь</th></tr></thead><tbody><tr><td>50-59</td><td>27</td><td>33%</td></tr><tr><td>30-39</td><td>18</td><td>22%</td></tr><tr><td>40-49</td><td>18</td><td>22%</td></tr><tr><td>over 60</td><td>7</td><td>9%</td></tr><tr><td>20-29</td><td>7</td><td>8%</td></tr><tr><td>10-19</td><td>4</td><td>5%</td></tr><tr><td>no info</td><td>1</td><td>1%</td></tr></tbody></table>	Насны бүлэг	Хүний тоо	Хувь	50-59	27	33%	30-39	18	22%	40-49	18	22%	over 60	7	9%	20-29	7	8%	10-19	4	5%	no info	1	1%
Насны бүлэг	Хүний тоо	Хувь																								
50-59	27	33%																								
30-39	18	22%																								
40-49	18	22%																								
over 60	7	9%																								
20-29	7	8%																								
10-19	4	5%																								
no info	1	1%																								
Судалгаанд хамрагдсaдын хүйсийн харьцаа		СУДАЛГААНД ХАМРАГДСАДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА <table><thead><tr><th>Хүйс</th><th>Хүний тоо</th><th>Хувь</th></tr></thead><tbody><tr><td>men</td><td>56</td><td>68%</td></tr><tr><td>women</td><td>26</td><td>32%</td></tr></tbody></table>	Хүйс	Хүний тоо	Хувь	men	56	68%	women	26	32%															
Хүйс	Хүний тоо	Хувь																								
men	56	68%																								
women	26	32%																								

Судалгаанд хамрагдсадын боловсролын түвшин		СУДАЛГААНД ХАМРАГДСАДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН <table border="1"><thead><tr><th>Education Level</th><th>Count</th><th>Percentage</th></tr></thead><tbody><tr><td>high</td><td>27</td><td>33%</td></tr><tr><td>secondary</td><td>28</td><td>34%</td></tr><tr><td>no info</td><td>9</td><td>11%</td></tr><tr><td>student</td><td>3</td><td>4%</td></tr><tr><td>no educated</td><td>2</td><td>2%</td></tr><tr><td>vocational education</td><td>2</td><td>3%</td></tr><tr><td>college</td><td>6</td><td>7%</td></tr><tr><td>elementary</td><td>5</td><td>6%</td></tr></tbody></table>	Education Level	Count	Percentage	high	27	33%	secondary	28	34%	no info	9	11%	student	3	4%	no educated	2	2%	vocational education	2	3%	college	6	7%	elementary	5	6%
Education Level	Count	Percentage																											
high	27	33%																											
secondary	28	34%																											
no info	9	11%																											
student	3	4%																											
no educated	2	2%																											
vocational education	2	3%																											
college	6	7%																											
elementary	5	6%																											
Судалгаанд хамрагдсадын яс үндэс		СУДАЛГААНД ХАМРАГДСАДЫН ЯС ҮНДЭС <table border="1"><thead><tr><th>Ethnic Group</th><th>Count</th><th>Percentage</th></tr></thead><tbody><tr><td>khoton</td><td>55</td><td>67%</td></tr><tr><td>durvud</td><td>14</td><td>17%</td></tr><tr><td>bayad</td><td>6</td><td>8%</td></tr><tr><td>no info</td><td>5</td><td>6%</td></tr><tr><td>khalkh</td><td>1</td><td>1%</td></tr><tr><td>darkhad</td><td>1</td><td>1%</td></tr></tbody></table>	Ethnic Group	Count	Percentage	khoton	55	67%	durvud	14	17%	bayad	6	8%	no info	5	6%	khalkh	1	1%	darkhad	1	1%						
Ethnic Group	Count	Percentage																											
khoton	55	67%																											
durvud	14	17%																											
bayad	6	8%																											
no info	5	6%																											
khalkh	1	1%																											
darkhad	1	1%																											

Судалгаанд
хамрагдсaдын
ажил
эрхлэлтийн
байдал

СУДАЛГААНД ХАМРАГДСАДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ



Асуулт 1: XVII-XVIII зуунд ашиглагдаж байсан хуучин суваг сэргээн босгох, ус хуримтлуулах талаар НМWM 2 дэд төсөл (цаашид "төсөл") талаар мэдэх үү?	1. Тийм...37% 2. Бага зэрэг мэднэ...35% 3. Мэдэхгүй байна...28%	A-1 Тийм, 30, 37% Бага зэрэг мэднэ, 29, 35% Мэдэхгүй, 23, 28%
Асуулт 2а: Та Хархираа эсвэл Тээлийн голын усыг хэрэглэдэг үү?	1. Хархираа...20% 2. Тээл...7%	A-2A Хархираа, 51, 74% Тээл, 18, 26%

Асуулт 26: Та голын усыг юунд ашигладаг вэ?	1. Хадлан бэлтгэх...27% 2. Жимс, хүнсний ногоо...14% 3. Газар тарайлан болон тэжээлийн ургамал...14% 4. Мал услах...18% 5. бусад...0% 6. ашигладаггүй...0%	A-2Б <table border="1"> <caption>А-2Б: Голын усыг юунд ашигладаг вэ?</caption> <thead> <tr> <th>Ашиглах зориулалт</th> <th>Тоо</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хадлан бэлтгэхэд</td> <td>69</td> <td>38%</td> </tr> <tr> <td>Жимс, хүнсний ногоо</td> <td>34</td> <td>18%</td> </tr> <tr> <td>Газар тарайлан болон тэжээлийн ургамал</td> <td>35</td> <td>19%</td> </tr> <tr> <td>Мал услах</td> <td>46</td> <td>25%</td> </tr> <tr> <td>бусад</td> <td>0</td> <td>0%</td> </tr> <tr> <td>ашигладаггүй</td> <td>0</td> <td>0%</td> </tr> </tbody> </table>	Ашиглах зориулалт	Тоо	Хувь	Хадлан бэлтгэхэд	69	38%	Жимс, хүнсний ногоо	34	18%	Газар тарайлан болон тэжээлийн ургамал	35	19%	Мал услах	46	25%	бусад	0	0%	ашигладаггүй	0	0%
Ашиглах зориулалт	Тоо	Хувь																					
Хадлан бэлтгэхэд	69	38%																					
Жимс, хүнсний ногоо	34	18%																					
Газар тарайлан болон тэжээлийн ургамал	35	19%																					
Мал услах	46	25%																					
бусад	0	0%																					
ашигладаггүй	0	0%																					
Асуулт 3: Таны туршлага, мэдлэгээс харахад Тээл гол Увс нуур хүрэхээс өмнө зун Тариалангаас доош ширгэдэг үү?	1. Увс хүрнэ...2% 2. Хүрэхгүй байна...46% 3. Заримдаа...43% 4. Мэдэхгүй байна...9%	A-3 <table border="1"> <caption>А-3: Таны туршлага, мэдлэгээс харахад Тээл гол Увс нуур хүрэхээс өмнө зун Тариалангаас доош ширгэдэг үү?</caption> <thead> <tr> <th>Хариулт</th> <th>Тоо</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хүрэхгүй</td> <td>38</td> <td>46%</td> </tr> <tr> <td>Заримдаа</td> <td>35</td> <td>43%</td> </tr> <tr> <td>мэдэхгүй</td> <td>7</td> <td>9%</td> </tr> <tr> <td>Увс хүрнэ</td> <td>2</td> <td>2%</td> </tr> </tbody> </table>	Хариулт	Тоо	Хувь	Хүрэхгүй	38	46%	Заримдаа	35	43%	мэдэхгүй	7	9%	Увс хүрнэ	2	2%						
Хариулт	Тоо	Хувь																					
Хүрэхгүй	38	46%																					
Заримдаа	35	43%																					
мэдэхгүй	7	9%																					
Увс хүрнэ	2	2%																					

Асуулт 4: Зуны аль сард Тээлийн гол ширгэдэгийг та хэлж чадах уу? (олон сонголттой)	1. 5 сар...14% 2. 6 сар...25% 3. 7 сар...29% 4. 8 сар...19% 5. 9 сар...5% 6. Бүх саруудад...8%	A-4 Бүх сар, 13, 8% 5 сар, 22, 14% 6 сар, 40, 25% 7 сар, 46, 29% 8 сар, 30, 19% 9 сар, 8, 5%
Асуулт 5: Танай нутагт байгаль орчны тулгамдсан ямар асуудал байна вэ?	1. Гадаргын усны хомсдол...36% 2. Гүний усны хомсдол...8% 3. Усны бохирдол...11% 4. Хог хаягдал...19% 5. Бэлчээрийн доройтол...22% 6. Химийн бохирдол...2% 7. Бусад...2%	Химийн бохирдол, 4, 2% Бусад, 3, 2% Гадаргын усны хомсдол, 64, 36% Гүний усны хомсдол, 15, 8% Усны бохирдол, 19, 11% Хог хаягдал, 35, 19% Бэлчээрийн доройтол, 39, 22%

Асуулт 6: Увс нуурын “экосистем” Хархираа, Тээл голын уснаас хамаардаг гэж та бодож байна уу?	1. Шууд хамааралтай...34% 2. Хамааралгүй...20% 3. Үер болох бүрт...31% 4. Мэдэхгүй байна...15%	A-6 Мэдэхгүй байна, 12, 15% Шууд хамааралтай, 27, 34% Хамааралгүй, 16, 20% Үер болох бүрт, 25, 31%
Асуулт 7: 5-р сараас 9-р сар хүртэл Тээл голын 3% -ийг сарниулж, хадгалах төлөвлөгөөг НМWN хийхээр төлөвлөж байгаа нь танай гэр бүл, танай нийгэмд сайн нөлөө үзүүлнэ гэж бодож байна уу?	1. Сайн...51% 2. Муу...13% 3. Нөлөөлөхгүй...21% 4. Мэдэхгүй байна...15%	A-7 Мэдэхгүй, 11, 15% Сайн, 39, 51% Муу, 10, 13% Нөлөөгүй, 16, 21%

Асуулт 8: Төсөл хэрэгжсэнээр Тээлийн голын усны нөөцөд ямар нөлөө үзүүлэх талаар үнэлгээ өгнө үү?	1. Эерэг...4% 2. Бага зэрэг эерэг...30% 3. Нөлөөгүй...42% 4. Бага зэрэг сөрөг...18% 5. Сөрөг...6%	A-8 <table><thead><tr><th>Хариулт</th><th>Тоо</th><th>Хувь</th></tr></thead><tbody><tr><td>Эерэг</td><td>3</td><td>4%</td></tr><tr><td>Бага зэрэг эерэг</td><td>25</td><td>30%</td></tr><tr><td>Нөлөөгүй</td><td>35</td><td>42%</td></tr><tr><td>Бага зэрэг сөрөг</td><td>15</td><td>18%</td></tr><tr><td>Сөрөг</td><td>5</td><td>6%</td></tr></tbody></table>	Хариулт	Тоо	Хувь	Эерэг	3	4%	Бага зэрэг эерэг	25	30%	Нөлөөгүй	35	42%	Бага зэрэг сөрөг	15	18%	Сөрөг	5	6%
Хариулт	Тоо	Хувь																		
Эерэг	3	4%																		
Бага зэрэг эерэг	25	30%																		
Нөлөөгүй	35	42%																		
Бага зэрэг сөрөг	15	18%																		
Сөрөг	5	6%																		
Асуулт 9: Төслийн орон нутгийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх гол нөлөө юу гэж та бодож байна вэ? (Олон сонголттой)	1. Орон нутгийн иргэдэд тустай...21% 2. Иргэдийн амьжиргааг дэмжинэ...71% 3. Сөрөг...1% 4. Мэдэхгүй байна...7%	A-9 <table><thead><tr><th>Хариулт</th><th>Тоо</th><th>Хувь</th></tr></thead><tbody><tr><td>Орон нутгийн иргэдэд тустай</td><td>21</td><td>21%</td></tr><tr><td>Иргэдийн амьжиргааг дэмжинэ</td><td>72</td><td>71%</td></tr><tr><td>Мэдэхгүй</td><td>7</td><td>7%</td></tr><tr><td>Сөрөг</td><td>1</td><td>1%</td></tr></tbody></table>	Хариулт	Тоо	Хувь	Орон нутгийн иргэдэд тустай	21	21%	Иргэдийн амьжиргааг дэмжинэ	72	71%	Мэдэхгүй	7	7%	Сөрөг	1	1%			
Хариулт	Тоо	Хувь																		
Орон нутгийн иргэдэд тустай	21	21%																		
Иргэдийн амьжиргааг дэмжинэ	72	71%																		
Мэдэхгүй	7	7%																		
Сөрөг	1	1%																		

Асуулт 10: Тээл гол болон түүний эргэн тойрон дахь загасны биологийн олон янз байдалд төслөөс нөлөөлнө гэж үзэж байна уу?	1. Тийм...4% 2. Үгүй...73% 3. Мэдэхгүй байна...23%	A-10  Тийм , 3, 4% Мэдэхгүй, 19, 23% Үгүй , 59, 73%	
Асуулт 11: Малын тоо болон усны хэрэглээ нэмэгдсэнээр хуримтлагдах нөлөөлөл үүснэ гэж та бодож байна уу?	1. Тийм...10% 2. Үгүй...65% 3. Мэдэхгүй байна...25%	A-11  Тийм, 8, 10% Мэдэхгүй, 20, 25% Үгүй, 51, 65%	

Асуулт 12: Энэ төсөл дээр та ямар байр суурьтай байгаа вэ?	1. Дэмжих...88% 2. Дэмжихгүй...6% 3. Мэдэхгүй байна...6%	A-12 Дэмжихгүй, 5, 6% Мэдэхгүй, 5, 6% Дэмжих, 70, 88%	
Асуулт 13: Нэмэлт саналууд	• Өнгөрсөн хугацаанд + усны хэрэглээ нэмэгдсэн • Эерэг талтай: Өсөн нэмэгдэж буй боловч усалгаатай бэлчээрийг эргэлтэд оруулж ашиглах малчидад хэрэгтэй • Эерэг: шаардлагад нийцсэн барилгын ажил хэрэгтэй. Байгалийн гамшгаас сайн хамгаалах • Ашиглагдаагүй бэлчээр, усны нөөцийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой • Иргэдийн сайн сайхан байдалд маш эерэгээр ханддаг. Усны нөөц нэмэгдсэнээр газар тариалангийн үйлдвэрлэл, бэлчээр ашиглалтыг дэмжинэ. • Эерэг талтай: ашиглагдаагүй бэлчээр ашиглагдах, малчдын хадлан бэлтгэх нөөцийг хэмнэх, малын тариалангийн бүсэд малын хэт их ашиглалтад орсноос малчид ба газар тариалан эрхлэгчдийн хоорондын зөрчил багасч байна. • Хүн бүр усны нөөцтэй болохыг хүсдэг. Голын савыг хадгалах нь хүний эрүүл мэндэд тустай тул бүх хүмүүс үүнийг дэмжих ёстой. Амжилт хүсье! • Өмнө нь олон хүмүүс газар тариалангийн үйлдвэрлэл, орлоготой байсан. Энэхүү төсөл хэрэгжсэнээр жимсний мод тарих, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжтой юм. Эдгээр газрууд усгүй тул бэлчээр ашиглаагүйгээс малчид ашиглагдаагүй бэлчээр ашиглаж ашиг хүртэх болно. • Ус хамгаалах төслийн хэрэгжилт нь орон нутгийн хөгжилд дараахь ач тустай: газар тариалангийн үйлдвэрлэл, бэлчээрийн даац нэмэгдэх замаар орон нутгийн иргэд давуу талтай болно • Бүх бэлчээрийг бүрэн ашиглах, газар тариалан эрхлэх боломж, усны хомсдол зэргийг арилгана		

	• Хэрэв төсөл хэрэгжүүлэх юм бол усан сан руу мал, хүн унахаас сэргийлж усан санг хамгаалах хэрэгтэй. Үерийн эсрэг арга хэмжээг бэхжүүлэх шаардлагатай байна • Усны хадгалалт нь газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, усны хүртээмжийг нэмэгдүүлэх, усны хомсдолыг багасгах замаар орон нутгийн иргэдийн амьжиргаанд тусалдаг. • Төсөл нь нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, байгаль орчныг хамгаалахад эерэг нөлөө үзүүлж, орлогын уламжлалт эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд тусална • Уламжлалт газар тариалан, мал аж ахуй эрхлэх боломж. Хүмүүс, малын ундны усны хэмжээ нэмэгддэг. Усны нөөц ба усыг зохистой ашиглах боломжтой болно • Усны суваг сэргээх ажлыг би дэмжиж байгаа • Төсөл нь амьжиргааг сайжруулахад туслах болно. Усны хамгаалалт зайлшгүй шаардлагатай • Төсөл нь уламжлалт газар тариалангийн үйлдвэрлэлд орон нутгийн иргэдийн амьдрал ахуйд эерэгээр нөлөөлнө • Төсөл хэрэгжсэнээр малчид, газар тариалан эрхлэгчдийн хооронд хаврын улиралд усны асуудлаар маргаан шийдвэрлэх болно • Усны хүрэлцээ, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийн талаар маргаан гарахгүй • Сумын төвөөс доош бүх талбайнууд хадлан бэлтгэдэг. Хадланг наймдугаар сар, 9-р сард авах боломжтой • Уур амьсгалын өөрчлөлт эрчимжиж байгаа тул усыг алдагдалгүйгээр ашиглах, усыг байгаль орчинд ээлтэй байдлаар ашиглах, орон нутгийн эдийн засаг, бэлчээрийн усжуулалтад ашиглах шаардлагатай • Малын унаж, хог хаягдал орохгүйн тулд усан санд хамгаалах хашаа шаардлагатай • Төслийг өндөр чанартай, ландшафтад бага нөлөөтэйгээр хэрэгжүүлэхийг зөвлөж байна • Хүнд машин механизмыг бага ашиглахыг хичээ, илүү их гар ажиллагаатай ажиллуулаарай • Төсөл нь анхны ландшафтын үзэмжийг хадгалах, өмнөх шигээ экологийн тэнцвэрийг хадгалах шаардлагатай • Усны сувгийг чанарын өндөр түвшинд барих • Усны суваг нэмэгдэж, усны хамгаалалт сайн арга хэмжээ болж байна • Энэ нь нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих болно • Төсөл нь ус гадагшаа алдахаас зайлсхийх ёстой • Төсөл нь нутгийн иргэдэд маш их тустай • Үерийн хамгаалалт нь зайлшгүй шаардлагатай • Энэ нь газар тариалан, хүнсний ногоо тариалахад нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлнэ • Усны нөөцийн менежмент нь усны нөөцийн хувьд өндөр ач холбогдолтой тул шаардлагатай байна • Хүмүүс, мал аж ахуй, газар тариалангийн ундны усны хангамж сайжирсантай холбоотой төслийн эерэг нөлөө үзүүлнэ • Энэ нь орон нутгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно
--	--

	• Үерийн асуудал байнга гардаг тул үерээс хамгаалах шаардлагатай байна. Газар тариалан, тэжээлд ашигладаг суваг нь газрын доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай • Зөвхөн усалгааны сувгийг ашиглана уу. Чанартай байх шаардлагатай (өмнөх нь чанаргүй байсан) • Хөдөө аж ахуй, малчид, бэлчээрийн менежментэд маш эерэг нөлөө үзүүлнэ • Усны хуримтлал бий болгож, хуримтлагдсан усыг цаашдын үйл ажиллагаанд ашиглах. Үерийн болзошгүй эмзэг газрыг хамгаалах. Хуримтлагдсан усыг аялал жуулчлал, ойжуулалтад ашиглах. Хөдөө аж ахуйд үүнийг бүү ашигла • Хавар, намрын улиралд 30 га бэлчээрийг ашиглах эерэг талтай. 300 га хуучин өвс бэлтгэх газрыг нөхөн сэргээх, ашиглах боломжтой • Үерээс илүү сайн хамгаалах хамгаалалт хэрэгтэй • Зөвхөн бэлчээрт ашиглах • Хархираа голын эхийг нэгтгэх арга хэмжээг санхүүжүүлэх шаардлагатай • Хөдөө аж ахуйд Тээл голын ус их хэмжээгээр ашиглагддаг тул усны хомсдол бий болдог. Бидэнд усны хуримтлал хэрэгтэй • Наранбулаг сумын 300 га газар тариалангийн газарт ус хуримтлуулах шаардлагатай • Тээл голд ус хуримтлуулах хэрэгтэй • Одоогийн топологийг хадгалахад анхаарлаа төвлөрүүлж томоохон суваг бий болгон, усны хуримтлал бий болгож, борооны усыг ашиглах,
--	---

